



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ҮЙН ЭРТӨМ ШИНЖЛЭГЭЭ, СУДАЛГАА, ОЮУЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ дээдлэх ЁС

- Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж буй онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл
- Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ тогтоох
- Хуулийн этгээд эрүүгийн гэмт хэргийн субъект болох нь: харьцуулсан эрх зүйн зарим асуудал
- Хэвлэл мэдээлэл ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцлал

Сэтгүүлийн зөвлөл

Сэтгүүлийн зөвлөлийн дарга

С.Сүхбаатар

Хууль зүйн доктор, дэд профессор
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч

Гишүүд:

Б.Амарсанаа

Хууль зүйн доктор,
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Олон улсын эрх зүйн тэнхимийн багш

Г.Банзрагч

Хууль зүйн доктор,
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш

Д.Зүмбэрэлхам

Хууль зүйн доктор,
Төрийн албаны зөвлөлийн дарга

Ч.Энхбаатар

Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
Удирдлагын академийн
Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч

Ц.Эрдэнэболд

Хууль зүйн доктор,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Олон улсын эрх секторын эрхлэгч

Дугаарыг эрхэлсэн:

С.Алтантуяа

Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

Эрхлэн гаргагч:



Редакцийн хаяг:

Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,

Сүхбаатарын талбай-7

Утас: 312513, 99083007

Факс: 315735

Вэб сайт: www.legalinstitute.mn

И-мэйл хаяг: altantuya.s@legalinstitute.mn

Хууль зүйн үндэсний хүрээлэн

Улсын бүртгэлийн дугаар: 279

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Цуврал 30

2010 он, Есдүгээр сар

№3

АГУУЛГА

ХУУДАС

Эрдэм шинжилгээ, онол, арга зүй

Үндсэн хуулийн хэм хэмжээг ердийн шүүхээс хэрэглэх онолын зарим асуудал

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Р.Очирбал

5

Монгол Улсын төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдлыг тогтоох зарим асуудал

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Долгорсүрэн

13

Хэвлэл мэдээлэл ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцлал

ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд

27

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудал

ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Энх-Амгалан

37

Гадаад орнууд дахь дотоод худалдааны эрх зүйн зохицуулалтын төлөв байдал

ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Ж.Соёлмаа

52

Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээ болох нь

ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Халиунаа

58

Судалгааны тайлан

Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан
Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ тогтоох

65

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

83

Үзэл бодол, эргэцүүлэл

Өв хүлээн авах эрхийн зарим асуудал

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир

111

Students Note	
Ethics of Parliament Members and Legal Regulation	
B.Turbold, Student, School of Law, National University of Mongolia	123
Statistic	133
The 100th Anniversary of the Justice Sector	142
Law Term	145
News and Events	147

ХҮҮЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ҮНДСЭН ХУУЛИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ЕРДИЙН ШҮҮХЭЭС ХЭРЭГЛЭХ ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

1. Үндсэн хуулийг бид хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн эрх мэдлийг хуваарилах онолын үзэл санааны үүднээс төрийн байгууллагын тогтолцооны зохист харьцааг бий болгож, төр ба ард түмний хоорондын үндсэн суурь харилцааг зохицуулагч тулгуур хууль хэмээн тодорхойлдог.

Эдүгээ Үндсэн хуулийн хэм хэмжээг зөрчсөн, түүний агуулгыг алдагдуулсан ямар ч эрх зүйн хэм хэмжээ оршин тогтнох эрхгүй бөгөөд Үндсэн хуулийн хэм хэмжээ бүр заавал биелэгдэж байх нь Үндсэн хуультай төрийн гол илрэл болдог. Тиймээс ч Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлд Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино хэмээн хуульчилсан болно.

ОХУ-ын ХЗШУ-ны доктор Б.С.Эбзеевийн бичсэнээр Үндсэн хуулийн заавал үйлчлэх шинж нь 1. Үндсэн хууль нь нийгмийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн актуудын үндсэн эх сурвалж нь болж, 2. Тухайн эрх зүйн харилцааг зохицуулж байгаа хэм хэмжээний акт нэг бүртэй харилцан хамааралтай байдагт орших бөгөөд Үндсэн хууль үйлчилж байх нь хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах үндсэн баталгаа болдог.¹

Үндсэн хууль заавал үйлчлэх шинжтэй хэдий ч түүний хэм хэмжээг ердийн шүүхээс хэрэглэх эсэх асуудал манай улсын хувьд сайтар судлагдаагүй, судлаачдын дунд нэг мөр болоогүй ойлголт бөгөөд ердийн шүүхээс эрх зүйн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэх эрх олгосон зохицуулалт манай улсын эрх зүйн тогтолцоонд байхгүй. Гэвч Үндсэн хуулийн хэм хэмжээ нь заавал үйлчлэх шинжтэй тул түүний хэм хэмжээг ердийн шүүх шууд хэрэглэх ёстой гэсэн үзэл хандлага эрдэмтэн, судлаачдын дунд түгээмэл байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан



Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Р.Очирбал

¹ Б.С.Эбзеев "Прямое действие и непосредственное применение конституций российской федерации – гарантия прав и свобод человека и гражданина" *"Интернет – журнал. Право и управление: XXI век. № 1 (1). 2007*

шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болох учир Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэх эрхтэй болох нь ойлгомжтой.

Харин ердийн шүүхээс иргэн, эрүү, захиргааны гэх зэрэг салбар эрх зүйн маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн нэгж заалтыг шууд хэрэглэн маргааныг шийдвэрлэх үү? эсхүл Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд бусаар хэрэглэх үү?

II.Ердийн шүүх Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэх эрхгүй

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 50.3-т “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй” хэмээн заасан бөгөөд энэ заалтын агуулгад Үндсэн хуулийн хэм хэмжээг ердийн шүүх шууд хэрэглэх гэхээсээ илүүтэйгээр бусад хуулийг хэрэглэхдээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгана гэсэн агуулга тод илэрч байна.

Ердийн шүүх Үндсэн хуулийг шууд хэрэглэх эрхтэй эсэхийг тодорхойлохын тулд бид

1. Үндсэн хууль нийгмийн ямар төрлийн харилцааг зохицуулдаг вэ?;

2. Ердийн шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг маргаан ямар онцлогтой вэ? гэсэн асуултад анхаарлаа хандуулах ёстой.

Үндсэн хууль нь нийгмийн гэрээний онолын агуулгаараа төр ба иргэд хоорондын үндсэн суурь харилцаа түүнчлэн төрийн эрх мэдлийн байгууллага, институтээс өөр хоорондоо хэрхэн харилцахтай холбоотой харилцааг зохицуулдаг. Өөрөөр хэлбэл түүхийн туршид бүрэлдэн тогтсон төрийн хэмжээгүй эрх дархыг хязгаарлах, төртэй харилцах харилцаанд ард түмэн өөрсдөө байж болох эрх ашгийг хамгаалахын тулд Үндсэн хуулийг бий болгосон. Үндсэн хуулийн зохицуулах харилцааны нэг талд ард түмэн гэсэн нийтлэг оршихуй, нөгөө талд төрийн эрх мэдлийн байгууллагууд байдаг онцлогтой. Тэгвэл Үндсэн хуулийн эрх зүйн субъектүүдийн хооронд үүссэн нийтлэг зохицуулалтай эрх зүйн харилцааг ердийн шүүх шийдвэрлэх үү гэдгээс хамааран ердийн шүүх Үндсэн хуулийг шууд хэрэглэх үү гэсэн асуултад онолын үүднээс хариулт өгч болно.

Ердийн шүүхийн харьяалан шийдвэрлэх ямар ч хэрэг, маргаан нийтлэг шинжийг агуулдаггүй (ердийн шүүх ард түмэн хийгээд төр хоорондын эсхүл төрийн эрх мэдлийн байгууллага хооронд үүссэн маргааныг шийдвэрлэдэггүй). Өөрөөр хэлбэл ердийн шүүх ердийн эрх

зүйн харилцааны субъектүүдийн хооронд үүссэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг бол харин Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн эрх зүйн харилцааны субъектүүд хооронд үүссэн Үндсэн хуулийг зөрчсөнтэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг.² Тиймдээ ч Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн байгууллага, институттэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хуулийг шууд хэрэглэдэг.

Үндсэн хууль нь улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, төрийн эрх мэдлийн байгууллага, институт хоорондын харилцааг уялдуулан зохицуулах гэх зэрэг дээд түвшний харилцааг зохицуулдаг тул иргэд хоорондын нэгж харилцааг зохицуулах хүртлээ нэр хүнд нь унаж болохгүй гэсэн шүүмжлэлийг зарим улсын эрдэмтэн судлаачид өгсөн нь бий.

Гэхдээ ердийн шүүхээс Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэх нь тухайн улс ямар эрх зүйн бүлд хамаарч байгаа эсэх, шүүхийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, зорилтоос ихээхэн хамаарна. Англосаксоны эрх зүйн бүлийн ихэнх улс оронд Үндсэн хуулийн хяналтыг ердийн шүүх хэрэгжүүлдэг тул тэрээр Үндсэн хуулийн хэм хэмжээг хэрэглэх боломжтой. Тухайлбал: АНУ-ын Пенсильвания мужийн шүүхээс түүх соёлын дурсгал бүхий газарт барилга барих эрх олгосон эрх бүхий байгууллагын зөвшөөрөл нь хүчинтэй байх эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэж байсан бөгөөд тухайн маргааныг шийдвэрлэхэд түүх соёлын дурсгалт газар, соёлын өв хөрөнгийг хэрхэн хамгаалах талаарх харилцааг хуулиарнарийвчлан зохицуулаагүй байсан байна. Иймд тухайн барилга барих зөвшөөрөл хүчин төгөлдөр байх эсэх нь түүх соёлын дурсгалт газар гэсэн ойлголттой салшгүй холбоотой байсан нь мужийн дээд шүүхээс Үндсэн хуулийн дараах заалтыг шууд хэрэглэн маргааныг шийдвэрлэхэд хүргэсэн байна. АНУ-ын Пенсильвания (Pennsylvania) мужийн Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д зааснаар “Хүн бүр цэвэр агаар, цэнгэг ус болон байгалийн дархан цаазат байдал, шинжлэх ухаан, түүх соёлын болон байгалийн гоо зүйг мэдрэх, үнэлэх эрхтэй. Пенсильвания-ийн баялаг бол бүх хүн хийгээд ирээдүй хойчийн нийтийн өмч мөн. Энэхүү бүх нийтийн өмч болох байгалийн баялагийн үр ашгаас хүн бүр хүртэх эрхтэй.”³

Ром-Германы эрх зүйн бүлийн зарим улс оронд ердийн шүүх нь Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэх тохиолдол мөн байдаг. Тухайлбал, ОХУ-ын Дээд шүүхийн бүх шүүгчдийн хуралдаанаас батлан гаргасан “Шүүн таслах ажиллагааны үед шүүхээс ОХУ-ын Үндсэн хуулийг хэрэглэх тухай” 1995 оны 8 дугаар тогтоолд зааснаар

² Rainer ARNOLD: Report “Review by the constitutional courts of proceeding before ordinary courts applying community law: Experience of Federal Constitutional court of Germany”. [http://www.venice.coe.int/docs/2006/CDL-JU\(2006\)026-e.pdf](http://www.venice.coe.int/docs/2006/CDL-JU(2006)026-e.pdf)

³ András Sajó “Limiting government: an introduction to constitutionalism”, English edition 1999 by Central European University press, Budapest, Hungary 43-45

ердийн шүүх нь дараах тохиолдолд Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэж болно.⁴

- Үндсэн хуульд заагдсан хүний болон иргэний эрх, эрх чөлөө, үүрэг болон бусад нөхцөлийн талаарх харилцааг зохицуулсан нэмэлт зохицуулалт шаардлагагүй бөгөөд нарийвчилсан зохицуулалт байхгүй нөхцөлд;

- ОХУ-ын Үндсэн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө Холбооны улсын нутаг дэвсгэрт үйлчилж байсан хууль тогтоомж Үндсэн хуультай зөрчилдвөл;

- ОХУ-ын субъект болон субъектүүдийн батлан гаргасан эрх зүйн хэм хэмжээний акт Холбооны Улсын хуулийг зөрчвөл гэх мэт.

Манай улсын хувьд ердийн шүүх Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэх эрхгүй бөгөөд тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хууль, хэрэв тийм хууль байхгүй бол Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхээр хуульд заасан.

Ердийн шүүх Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэх эрхгүй хэдий ч хэрэг маргааныг шийдвэрлэх бүртээ хэрэглэх гэж буй аливаа хуулийн заалт нь Үндсэн хуулийн агуулга, үзэл санаанд нийцэж байгаа эсэхийг шалгах замаар түүний хэм хэмжээг шууд бусаар хийсвэр байдлаар байнга хэрэглэж байдаг.

III. Ердийн шүүх Үндсэн хуулийг хэм хэмжээг шууд бусаар хэрэглэнэ

Ердийн шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд хэрэглэх эрхгүй боловч түүний заалтыг шууд бусаар хэрэглэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэх гэж байгаа хууль нь Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг сайтар шалгаж зөвхөн Үндсэн хуульд нийцсэн хуулийг хэрэглэж байгаагаар Үндсэн хуулийн хэм хэмжээний шууд бус хэрэглээ илэрнэ.

- Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулийг хэрэглэнэ”, 12.2-т “Шүүх Үндсэн хуульд нийцээгүй, хэрэг, маргаан гарах үед хүчин төгөлдөр болоогүй, албан ёсоор нийтлэгдээгүй хуулийг хэрэглэхгүй”;

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйл 10.1 “Шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль,

⁴Постановление Пленума Верховного Суда РФ от 31.10.1995 № 8

“О НЕКОТОРЫХ ВОПРОСАХ ПРИМЕНЕНИЯ СУДАМИ КОНСТИТУЦИИ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ ПРИ ОСУЩЕСТВЛЕНИИ ПРАВОСУДИЯ”

түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн хүчин төгөлдөр бусад хуулийг хэрэглэнэ.”

Дээрх заалтуудаас үзэхэд ердийн шүүх нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хэрэглэх гэж буй хууль нь Үндсэн хуультай нийцсэн эсэхийг заавал шалгах бөгөөд энэ нь шүүх эрх мэдлийн байгууллага Үндсэн хуулийн институт болохынхоо хувьд хэрэгжүүлэх ёстой чиг үүрэг болно. Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс ердийн шүүх нь 1. Эрх зүйн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх (нийгмийн өмнө хүлээх чиг үүрэг), 2. Эрх зүйн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах (Төрийн эрх мэдэл хуваарилах онолын дагуу Үндсэн хуулиар хүлээсэн чиг үүрэг) чиг үүрэгтэй. Учир нь хуулийн хэм хэмжээний агуулгыг хянах үүргийг эрх зүйт төрдшүүх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлдэг.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч Г.Гаджиев: Үндсэн хууль нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан тулгуур хууль бөгөөд хүний эрх, эрх чөлөөний талаарх харилцааг холбооны хууль тогтоомжоор нарийвчлан тодорхойлсноор Үндсэн хуулийн шууд үйлчлэх шинж илрэх бөгөөд харин эрүү, иргэний, захиргааны хэргийн шүүх тэдгээр нарийвчлан тодорхойлсон хуулийг хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэж байгаагаар Үндсэн хуулийн хэрэглэгдэх шинжнь илэрнэ хэмээн бичсэн байна.⁵

Энэ нь Ром-Германы эрх зүйн тогтолцооны үндсэн шинж болох Үндсэн хуулиар малгайлуулсан бичмэл эрх зүйн акт, нийгмийн харилцааг зохицуулдагтай шууд холбоотой ба шүүхээс хэрэглэх гэж байгаа хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах нь хууль хэрэглээний баталгааны орчинг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Хэдийгээр ердийн шүүх нь эрх зүйн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ эрх зүйн хэм хэмжээний актуудын Үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх хууль ёсны байдлыг шалгах үүрэгтэй хэдий ч энэ чиг үүргээ өнөөдрийг хүртэл хэрхэн хэрэгжүүлж ирсэн нь анхаарал татсан асуудлын нэг юм. Манай улсын процессын бүхий л хуульд зааснаар шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар саналаа гаргах талаар зохицуулсан байдаг.

Гэтэл Үндсэн хууль хүчин төгөлдөр үйлчилсэн цагаас хойших нийт 18 жилийн хууль хэрэглээний шүүхийн практикт анхан болон давж заалдах шатны шүүхээс хүчин төгөлдөр аливаа нэг хууль Үндсэн хуультай нийцэхгүй байна гэсэн үндэслэлээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдол гараагүй байна.⁶

⁵ Г.Гаджиев "Непосредственное применение судами конституционных норм" <http://www.lawmix.ru/comm/8673/>

⁶ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Улаанбаатар хот, 2007-55 дахь тал

Харин Монгол Улсын дээд шүүх 2006 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, мөн онд Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулахаар хандаж байсан байна.

Үндсэн хуулийн цэц байгуулагдсан цагаас хойш 2009 оны сүүл хүртэлх хугацаанд нийт 117 маргаан шийдвэрлэсэн бөгөөд эдгээрээс зөвхөн 4 маргааныг төрийн байгууллага албан тушаалтны хүсэлтээр (УДШ-2, Ерөнхийлөгч 2) үлдэх 113 хэргийг иргэдийн өргөдөл, мэдээллээр хянан шийдвэрлэсэн байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад ердийн шүүхээс хэрэглэх гэж байгаа хууль тогтоомжийн Үндсэн хуульд нийцсэн хууль ёсны байдлыг хянан шалгах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна хэмээн дүгнэх бүрэн үндэслэлтэй.

Ердийн шүүхээс идэвхгүй хяналт хэрэгжүүлж байгаа шалтгаан, нөхцөл нь:

1. Шүүх нь хууль тогтоомжийн Үндсэн хуульд нийцээгүй байдлыг тогтоохдоо тухайн тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэрэглэх хуулийн хүрээнд авч үздэг тул нийгмийн харилцааны объектив нөхцөл бүрдээгүй байж болно. Өөрөөр хэлбэл, тухайн хуулийн заалтыг хэрэглэх хэрэг маргаан нийгэмд гарахгүй байх нөхцөлд хуулийн хууль ёсны байдлыг шүүх хянах боломжгүй;

2. Шүүхэд хэвшин тогтсон хуулийг төсөөтэй хэрэглэх практикийн нөлөөлөл хүчтэй байхыг үгүйсгэхгүй;

3. Шүүх тодорхой төрлийн хэрэг, маргааныг тухайн тохиолдолд амжилттай шийдвэрлэхэд анхаарч хэм хэмжээний шууд бус хяналт хэрэгжүүлэх талаарх Үндсэн хуулийн чиг үүргээ орхигдуулсан байж болох.

Дээрх үндсэн шалтгаан, нөхцөлийг дэлгэрүүлэн авч үзвэл:

1. Нийгмийн харилцааны объектив нөхцөл бүрдээгүй гэх шалтгааны хувьд байж болохыг үгүйсгэхгүй ч Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаанд анализ хийсэн судалгаанаас арай өөр дүгнэлтийг судлаачийн хувьд өгөхөөр байна. Учир нь Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлэсэн нийт хэрэг маргааны 20 нь буюу 17.1 хувь нь ИХШХШ тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөнтэй холбоотой маргаан эзэлж байх бөгөөд эдгээрээс 9 нь Үндсэн хууль зөрчсөн нь цэцийн шийдвэрээр тогтоогдсон. Гэтэл шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ өдөр тутам байнга хэрэглэдэг, мөрдлөг болгодог дээрх хуулиудын хэм хэмжээний хууль ёсонд нийцээгүй, Үндсэн хуультай зөрчилдсөн байдлыг жирийн иргэд

олж илрүүлээд эрх бүхий байгууллагад нь хандсан байхад шүүх эрх мэдлийн тогтолцоонд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхээс нэг ч удаа зохих байгууллагад хандаж байгаагүй нь шүүхээс Үндсэн хуулийн хяналтын чиг үүргээ умартсан гэх дүгнэлтийг хийхэд хүргэж байна. Тухайлбал:

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3 “Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдлийг цагаатгах тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гаргана”, мөн зүйлийн 396.4 “бусад эрхийг сэргээлгэх тухай өргөдлийг тухайн иргэнд эрхийг нь тайлбарласан хуудсыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор гаргаж болно”;

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж байхад 3 өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана” гэх заалтууд нь иргэдийн гаргасан өргөдөл, мэдээллээр Үндсэн хууль зөрчсөн болох нь Үндсэн хуулийн цэцээр тогтоогджээ. Гэтэл эрүүгийн хэргийг шийдвэрлэх явцад гэм хорын асуудал, бүрэлдэхүүнтэй шүүх хурлаас шийдвэр гаргахад шүүгчдийн санал зөрвөл хэрхэх тухай асуудал бий болоход дээрх зохицуулалт нь түгээмэл, давтамжтай хэрэглэгддэг.

2.Ердийн шүүхээс хэрэг маргааныг магадлан шийдвэрлэх явцад хэм хэмжээний актууд хоорондын зөрчилдөөн олонтаа тохиолддог бөгөөд хэм хэмжээний зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэх талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай бий. Харин Үндсэн хуулийн хэм хэмжээг зөрчсөн хуулийн заалт шүүхээс хууль хэрэглэх явцад илэрвэл алтан дунджийг баримтлах буюу хэрэглэхээс татгалзах, ижил төсөөтэй хэм хэмжээг хэрэглэх замаар зөрчилдөөнийг даван туулах зэрэг нь Үндсэн хуулийг зөрчсөн тухайн акт цаашид нийгмийн харилцааг зохицуулах улмаар бусад шүүхэд хэрэглэгдэх нөхцөл бүрдэх юм. Шүүх нь хэрэглэх гэж буй хуулиа Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг шалгах нь бүх шүүгчдийн хувьд үүрэг байхаар хуульчилсан бөгөөд процессийн хууль тогтоомжид зааснаар шүүх нь хуулиуд хоорондоо зөрчилтэй гэх үндэслэлээр хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс татгалзах эрхгүй тул Үндсэн хуулийг зөрчсөн хуулийн хэм хэмжээ илрэх бүрд шүүгч нь энэ талаарх саналаа зохих байгууллагадаа уламжилдаг байх нь шүүхийн хяналтын чиг үүрэгт чухал ач холбогдолтой.

Гэтэл 2007 онд Улсын дээд шүүхээс хэвлэн гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбарт(албан бус) хуулийн 10 дугаар зүйлийг тайлбарлахдаа “Шүүх нь өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлж, иргэний хэргийг хянан шийдвэрлэхдээ эрх

зүйн хэм хэмжээний актуудын хууль ёсны байдлыг хянах үүрэгтэй. Шүүх нь тэдгээрийн Үндсэн хууль, хуульд нийцээгүй байдал илэрвэл, хууль зүйн дээд хүчин чадалтай актыг хэрэглэнэ. Хэрэв шүүхийн хэрэглэж буй хуулиас өөр тухайн хэрэг, маргааныг зохицуулсан хууль байхгүй тохиолдолд уг хууль Үндсэн хуультай нийцэхгүй бол шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар саналаа гаргана” хэмээжээ. Дээрх тайлбарын агуулгаас үзвэл ердийн шүүхээс хэм хэмжээний зөрчилдөөнийг олж илрүүлээд эхний ээлжинд хууль зүйн дээд хүчинтэй актыг хэрэглэх замаар зөрчилдөөнийг даван туулах, хэрэв ийм боломж байхгүй нөхцөлд энэ талаар УДШ-д саналаа гаргахаар ойлгогдож байна. Гэтэл энэ мэт практикаас Үндсэн хуулийн хэм хэмжээ хууль зүйн дээд хүчин чадалтай бөгөөд заавал биелэгдэх шинж алдагдах улмаар Үндсэн хуулийг зөрчсөн хэм хэмжээ амь бөхтэй нийгмийн харилцааг зохицуулах, хэрэгжих нөхцөл бүрдэх юм.

Энэхүү өгүүллийн зорилго нь үндсэн хуулийн хэм хэмжээг ердийн шүүхээс хэрхэн, ямар арга замаар хэрэглэх талаарх онолын үндэслэлийг дэвшүүлэх, өнөөгийн Үндсэн хуулийн хэрэглээний байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, зарим тулгамдсан асуудлын шалтгаан нөхцөлийг тодорхойлоход чиглэгдсэн бөгөөд судлаачийн хувьд:

- Үндсэн хуулийг шүүхээс хэрэглэх аргыг шууд болон шууд бус хэмээн ангилан үзэж, ангилал тус бүрийн онолын үндэслэлийг гаргаж, ердийн шүүхээс Үндсэн хуулийг шууд бусаар, хийсвэр байдлаар сэтгэхүйн түвшинд хэрэглэнэ гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Мөн өнөөгийн ердийн шүүхийн хууль хэрэглээний практикт Үндсэн хуулийн хэм хэмжээг шууд бусаар хэрхэн хэрэглэж байгаа байдалд үнэлэлт өгөн, Үндсэн хуулийг шууд бусаар хэрэглэх үүргээ шүүх ямар шалтгаанаар хэрэгжүүлэхгүй байгааг тодорхойлон гаргахад чиглэгдсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ТОГТООХ ЗАРИМ АСУУДАЛД

Оршил болгон өгүүлэх нь

Монгол Улсын 1992 оны дөрөвдүгээр Үндсэн хуулийн үзэл баримтлал, бодлого, эрх зүйн шинэтгэлийн дагуу Төрийн албанд холбогдох нийгмийн харилцааг дагнан зохицуулсан Монгол Улсын хууль 1994 онд батлагдан гарч, 1995 онд мөрдөгдсөнөөс хойш нэгэнтээ 15 жил өнгөрчээ.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурал 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн, боловсронгуй болгон нэмэлт хийж, баталсан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байна.

Дээрх хугацаанд Төрийн албаны хуульд олон удаагийн нэмэлт, өөрчлөлт орсны нэг томоохон хэсэг нь УИХ-ын хэлэлцэж баталсан 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулийн өөрчлөлт гэж хэлж болно.

Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгын гол онцлог нь нийгмийн хөгжлийн тухайн үеийн ололт, эрх зүйн практик хэрэглээ, хууль зүйн шинжлэх ухааны төлөвлөлийн хүрсэн түвшинд тулгуурлан хийсэн шинэтгэлийн үр дүн байсан бол 2008 оны нэмэлт, өөрчлөлт нь төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангах; төрийн жинхэнэ алба, албан хаагчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох; төрийн жинхэнэ албан хаагч улс төржихгүй, төвийг сахиж, зөвхөн төр, засагтаа үйлчилж, ард түмний тусын тулд ажиллах; Төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээг өргөтгөх зэрэг цогц арга хэмжээг тусган хэрэгжүүлснээрээ бусад нэмэлт, өөрчлөлтүүдээс ялгагдах юм.

"Төрийн алба"-ыг Франц, ХБНГУ-д болон бусад зарим оронд нийтийн алба, нийтийн албаны эрх зүй; Их Британи, АНУ-д иргэний алба; ОХУ, Япон, болон бусад оронд Төрийн алба¹ гэсэн нэр томъёогоор хууль зүйн ном зохиолд авч үзэж, зарим нь захиргааны эрх зүйн төрөл-хэсэг, голлох институтын нэг² эсхүл эрх зүйн дэд салбар хэмээн тайлбарласаар ирэв.



Хууль зүйн
шинжлэх ухааны
доктор, профессор
Ж.Долгорсүрэн

¹ Административное право зарубежных стран. Учебник. Под ред. А.Н.Козырина и М.А.Шатиной.-М., Спарк. 2003. 91-128. 240-252. 309-311. 342-353. 375-377. 427. Старилов Ю.Н. Публичное право.-М. 1996 и др. "Административное право России.-3-е изд. перераб и доп.-М. Юнити-Дана. 2008.-559 с" сурах бичигт "ОХУ-ын төрийн иргэний албаны үндэс" гэсэн бүлэг бий. 180-217 дахь тал.

² С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Нэмж засварласан 2 дахь хэвлэл.-УБ., 2008. 412 дахь тал.

Монгол Улсын хувьд сурах бичиг, гарын авлага, сургалтын хөтөлбөртөө гол төлөв төрийн алба, зохиогчийн хувьд сүүлийн үеэс өөрийн зарим бүтээлдээ³ нийтийн албаны эрх зүй нь Монголын Улсын захиргааны эрх зүйн дэд салбар хэмээн бичсэн нь бий.

“Төрийн албан хаагч”-ийн тухайд бол наад зах нь гурван үзэл бодлоор авч үзэж болох юм. Нэг дэх нь, төр-эрх зүйн талаасаа төрийн албан хаагч-төрийн “зарц” (түүний байгууллагын), төрийн чиг үүрэг хэрэгжүүлэгч, нийгэм, төрийн бүтээгдэхүүн мөн, хоёр дахь нь, эрүүгийн эрх зүйн үүднээс төрийн албан хаагч бол эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх онцгой субьект, албан тушаалтан мөн; гурав дахь, нь захиргааны эрх зүйн үзэл бодлоор төрийн албан хаагч тусгай засаглах, зохион байгуулан захирах бүрэн эрхтэй, хууль хамгаалан хэрэгжүүлэх, захиргааны эрх зүйн санкц хэрэглэх чиг үүрэгтэй засаглалын төлөөлөгч гэж үзэж байна.

**Нэг. Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын ойлголт,
үндсэн шинж, бүтэц**

Төрийн албан хаагчийг өргөн, явцуу хоёр утгаар авч үзэж болно. Өргөн утгаар нь зөвхөн төрийн эрх мэдлийн байгууллагад төдийгүй, нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийн өмчийн үйлдвэр, албан газар, байгууллагад төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчийг хамруулан ойлгоно.

Төрийн албан хаагчийг явцуу утгаар нь төрийн албан тушаал, өөрөөр хэлбэл зөвхөн төрийн эрх мэдлийн (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн) байгууллагад албан тушаал эрхэлж байгаа этгээд гэж ойлгож болох юм.

Төрийн аль ч албан хаагчийн эрх зүйн байдлын онцлог нь төрийн албан хаагчаас төрийн зорилт, чиг үүрэг, бүрэн эрхээ биелүүлэн хэрэгжүүлэх өвөрмөц чанартай нөхцөлдөн ... жишээлбэл цэргийн ба иргэний алба, татварын алба, дипломат алба, салбарын захиргааны үйл ажиллагаа зэрэг төрийн албаны янз бүрийн төрөл-тусгай шинжээр тодорхойлогдоно.⁴

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал нь эрх, үүргийн нийлбэр цогц, хариуцлага болон бусад бүрэлдэхүүн хэсэг, шинжийг өөртөө багтаасан хэд хэдэн элементүүдийн нарийн төвөгтэй, иж бүрэн төрөл-хэсэг мөн.⁵

³ Ж.Долгорсүрэн. Монгол Улсын захиргааны эрх зүй. Ерөнхий анги. Сэдэвчилсэн гарын авлага. УБ. 2008. 150-158 дахь тал. Үүний урьд 2001 онд МУИС-ийн ХЗС-ийн “Эрх зүйн онол, практик. арга зүй, мэдээллийн цуврал” сэтгүүлийн №4-5-д ийнхүү бичигдсэн өгүүлэл буй.

⁴ Старилов Ю.Н. Курс общего административного права. В 3 т.п. государственная служба. Управленческие действия. Правовые акты управления. Административная юстиция.-М. Издательство “Норма”. 2002. С 35.

⁵ Габричидзе.Б.Н., Чернявский.А.Т. Курс административного права Российской Федерации В трех частях Учебник

“Төрийн алба ба түшмэлийн албаны онол”, “Эх орны (төрийн албаны) түүх”, “Төрийн албаны тухай хууль тогтоомж”, “Эдийн засгийн тогтолцоон дахь түшмэлийн алба”, “Гадаад орны төрийн алба (Франц, ХБНГУ, Их Британи, АНУ, БНХАУ)”, “Төрийн албаны шинэтгэл”,

“Төрийн албан хаагчийг бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх нь” гэсэн 7 бүлэг бүхий улс төр судлал, эрх зүй, эдийн засаг, түүх, гадаадын зарим орны төрийн албаны судлалын тойм, шинэтгэл, боловсрол зэрэг өргөн хүрээтэй асуудлаар оюутан, докторант, уншигч, судлаачдад зориулсан иж бүрэн хандлагатай бүтээл ч бас сонирхол татна.⁶

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал нь төрийн албан тушаал эрхэлж, албан үүрэг гүйцэтгэж, эрх эдлэхтэй холбогдон гарсан хууль тогтоомж, түүнд нийцэж гарсан эрх зүйн тодорхой актаар зохицуулагдана.

Монгол Улсын Үндсэн хуульд төрийн албанд холбогдох дам эх сурвалж олон байгаа ч Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2, 3-т: “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан баримталж, ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”⁷ гэсэн ганцхан эх сурвалж-зүйл бий.

Төрийн албан хаагчийн эрх байдлыг хууль тогтоомжоор тогтоогдон баталгаажсан эрх, эрх чөлөө, үүрэг, хязгаарлалт ба хориглолт, албан хаагчийн хариуцлага зэрэг нөхцөл байдлыг өөртөө бий болгохтой холбон үзэж байна.

Өөрөөр хэлбэл, төрийн албаны харилцааг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгоно. Төрийн албаны харилцаа өөрчлөгдөх бүрт албан хаагчийн эрх зүйн байдал нь жишээлбэл, албанд орох, халагдах, огцрох, иргэний харьяаллаа алдах, тэтгэвэрт гарах зэрэгт дагаад өөрчлөгдөнө.

Монгол Улсын 1994 оны Төрийн албаны хуулиас өмнө төрийн алба, төрийн албан хаагчийн ойлголтын талаар хууль тогтоомжид ямар нэг тодорхойлолт байгаагүй. Харин 1994 оны болон 2002 оны шинэчилсэн найруулгад төрийн албан тушаалын ангилал, төрийн ямар албан тушаалд аль нь хамаарахыг нэг бүрчлэн заасан нь бий.

Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

⁶ Государственная служба (Комплексный подход): Учеб. Пособие. Руководители авторского коллектива А.В. Оболонский, А.Г. Барабашев. -2-е изд. -м.: Дело. 2000. -440с.

⁷ Монгол Улсын Үндсэн хууль –УБ. 1992. 22 дах тал

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, Төрийн албаны хуулиар зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

“Монгол Улсын төрийн албаны хууль”-ийн 11 дүгээр зүйлд “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ”⁹ гэж заажээ.

Төрийн албан хаагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа нь дараахь үндсэн шинжийг өөртөө агуулна. Үүнд:

- Төрийн удирдан зохион байгуулах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг;
- Албан хаагчийн ажлын зорилго, агуулга нь төрийн зорилт, чиг үүргийг практикт биелүүлэх ажиллагаа;
- Тусгайлан бэлтгэгдсэн төрийн албан хаагч эзэмшсэн мэргэжлийнхээ үндсэн дээр ажиллана;
- Төр төлөөлөн, түүний нэрийн өмнөөс албан тушаалын үүрэг гүйцэтгэж, үүнийхээ төлөө улсаас цалин хөлсөөр хангагдана;
- Төрийн албаны харилцааны ихэнх нь захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана гэх мэт.

Бидний бодлоор бол төрийн албан хаагчийн онолын зарим тодорхойлолт, эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийн төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын агуулгын бүтцийг бүлэглэн ангилбал:

1. Төрийн албан тушаал ба албан хаагчийн засаглан захирах эрх мэдэл;
2. Албан тушаалын үүрэг, эрх;
3. Хуулиар тогтоосон хязгаарлалт, хориглолт; 4. албан хаагчийн ажиллах баталгаа;
5. Урамшил ба хариуцлага гэсэн өөр хоорондоо харилцан холбоотой цогцолбор шинжтэй ажиллагаа хэмээн томъёолж байна.

Хоёр. Төрийн албан тушаал ба албан хаагчийн засаглан захирах эрх мэдэл

Төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдал нь төрийн байгууллагын эрх хэмжээнээс үүсмэл. Хамгийн гол нь төрийн албан тушаал юм.

Албан тушаал нь төрийн тухайн байгууллагын зохион байгуулалтын

⁹ “Төрийн мэдээлэл”. 2002.. №28-аас тодруулан үзнэ үү.

үндсэн нэгж, төрийн албаны анхны бүрдүүлбэр хэсэг юм. Төрийн албан хаагч төрийн аль нэг байгууллагад тодорхой албан тушаал эрхлэн, албан тушаалын зорилт, чиг үүргийг бүрэн эрхийн хүрээнд өдөр тутам гүйцэтгэдэг. Тухайн албан тушаалд ажлын шаардлагаас хамааран төрийн хичнээн албан хаагч ажиллахыг орон тоогоор тогтооно.

Төрийн албан хаагчийн албан тушаалын чиг үүргээ хэрхэн, амжилттай гүйцэтгэх нь түүний засаглан захирах эрх мэдэлтэй шууд холбоотой. Иймд албан тушаал, албан тушаалын засаглах бүрэн эрх нь өөр хоорондоо харилцан хамааралтай, албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлдог үндсэн асуудал юм.

Албан тушаал нь засаглах эрх мэдэл, албан үүрэг, эрхийн тодорхой хэмжээг тогтооно. Тэгэхээр төрийн албан тушаал эрхэлсэн албан хаагч бүхэн засаглан захирах бүрэн эрхийг эдлэхгүй. Төрийн үйлчилгээний албан хаагч, багш, эрдэм шинжилгээний болон захиргааны туслах ажилтан гэхэд захиран засаглах бус, сургах, судалгаа хийх, хүнд үйлчлэх зэрэг үүрэг хүлээж, түүндээ зохицсон эрх эдэлнэ.

Төрийн албан хаагчийн дотор төрийн жинхэнэ албан хаагч илүү өргөн эрх мэдэлтэй, төрийн зорилт, чиг үүрэг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Үүнээс үүдэлтэй Төрийн албаны хуулийн 5.1-д төрийн улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний гэж ангилан, мөн зүйлийн 5.2-т төрийн захиргааны болон тусгай албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал, хуулийн 11.2-т албан тушаалын энэ ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэжлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэж заасан билээ.

Төрийн албан тушаалын тодорхойлолт хуульд байхгүй боловч 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зохих тодотгол хийгдсэнийг хэлэх нь зүйтэй.

Тухайлбал, “Төрийн албаны тухай хууль”-ийн 7.1-д Төрийн захиргааны албан тушаалд “... төрийн бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг ...” бүхий албан тушаал хамаарна; мөн хуулийн 8 дугаар зүйлийн 1-д төрийн тусгай албан тушаалд “... үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн дэг журам хамгаалахтай холбогдсон” албан тушаал хамаарна; мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д төрийн үйлчилгээний албан тушаалд “... төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад” туслах чиг үүрэг бүхий албан тушаал хамаарна гэх мэтээр албан тушаалын зориулалтыг тодруулан заажээ.

Гурав. Төрийн жинхэнэ албан хаагчийн үүрэг гүйцэтгэлийн тухайд

Төрийн жинхэнэ албан хаагчид төрийн захиргааны болон тусгай албан тушаал эрхэлсэн албан хаагч багтах бөгөөд "Төрийн албаны тухай хууль"-ийн 7.1-д заасан төрийн захиргааны зарим албан тушаалыг дурдвал:

- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх, Үндсэн хуулийн цэц, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, хуульд өөрөөр заагаагүй бол тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн удирдах ба гүйцэтгэх албан тушаал,
- Төрийн албаны Зөвлөлийн орон тооны гишүүн; ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал гэх мэт;

Хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн тусгай албан тушаалын заримаас нэрлэвэл:

- Үндсэн хуулийн Цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;
- Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Үнэт цаасны хорооны дарга, Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;
- Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга;
- Дипломат ажилтан;
- Дэвсгэт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гал түймэртэй тэмцэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч гэх мэт.

Төрийн аль ч албан хаагчид эрх зүйн байдлын үндсэн элемент нь үүрэг хүлээх явдал. Үүрэг нь албан тушаалын үндэс, үйл ажиллагааны агуулга. Төрийн албан хаагчийн олон янзын үүргийг: 1. албаны

нийтлэг, 2. албан тушаалын, 3. мэргэжлийн, 4. хязгаарласан гэж хуваан үзэж болно.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар төрийн жинхэнэ албан хаагчид хамааралтай албаны нийтлэг үүрэг нь:

- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

- эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах;

- төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

- Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;

- Албан тушаалтны хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

- Төрийн албан тушаалд томилогдмогд өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээ өгч байх гэх мэт.

Төрийн жинхэнэ албан хаагч дээрх нийтлэг үүргээс гадна өөрийн эрхэлж байгаа албан тушаалаас хамааран албан тушаалын болон мэргэжлийн онцлог шинжийг агуулсан үүрэг гүйцэтгэнэ. Эдгээр үүрэг нь хуулиар тогтоогдсон байх ба зарим тохиолдолд хуульд нийцүүлэн тухайн салбарын эрх бүхий албан тушаалтан нарийвчлан тогтоож болно.

Төрийн албан хаагчийн албан тушаалын үүрэг нь эрхэлж буй албан тушаалтайгаа холбоотой. Иймд албан тушаал бүрт янз бүр байна.

Нэг байгууллагад ижил албан тушаалд ажиллаж байгаа хүнд байгууллагын захиргаа нь албаны зарим үүргийг ажлын байрны тодорхойлолтод өөр өөрөөр тусган тогтоож болно.

Монголын гаалийн байгууллагаар төлөөлүүлэн авч үзвэл албан тушаалын, мэргэжлийн өөр өөр үүргийг гүйцэтгэнэ. Гаалийн төв байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооны дарга, тухайн байгууллагынхаа үйл ажиллагааг бүхэлд нь удирдан зохион байгуулдаг бол гаалийн улсын байцаагч хууль тогтоомж түүнд нийцсэн эрх зүйн актын хүрээнд албаны хяналт, хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэнэ.

“Гаалийн тухай Монгол Улсын хууль”-ийн 274¹ дүгээр зүйлд зааснаар Гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагчийн гүйцэтгэх албан тушаалын болон мэргэжлийн зарим үүргээс дурдвал:

¹ “Төрийн мэдээлэл”, 2008. №23

- гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хийхдээ төр, байгууллага, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, албан тушаалаа урвуулан ашиглахгүй, хэтрүүлэхгүй байх;

- гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн хууль бус үйлдэл (эс үйлдэхүй)-ийн талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлэх гэх мэт.

Төрийн албан хаагчийн мэргэжлийн үүрэг нь тухайн байгууллагын тодорхой албан тушаалын үүргээс илүү өргөн утга агуулгыг илэрхийлнэ. Жишээлбэл, Цагдаагийн байгууллагын ямар ч албан тушаалын албан хаагч өөрийн хариуцдаггүй нутаг дэвсгэрт, тухайлбал нийслэлийн өөр дүүрэг, эсвэл орон нутагт гэмт хэрэг, золгүй тохиолдол, осол гарсантай тааралдсан бол тухайн цаг үед нь холбогдох байгууллагад мэдээлэх, эмнэлгийн өмнөх бололцоотой тусалцаа үзүүлэх, хүний амь нас аврах, уг аюулыг таслан зогсоох гэх мэт үүргийг хуулиар хүлээлгэсэн байдаг.

Дөрөв. Төрийн жинхэнэ албан хаагчийн эдлэх эрхийн тухай товчхон...

Төрийн албан хаагчийн эрх нь хуулиар хүлээсэн үүргээ өдөр тутам биелүүлэх, түүний хэрэгжилтийг хангах нөхцөл бололцоо юм. Ийм эрхийг үүргийн нэгэн адил ерөнхийд нь албаны нийтлэг, албан тушаалын болон мэргэжлийн гэж гурав хуваан үзэж болох юм.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрхийг “Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлд дараах байдлаар тусгажээ.

- Төрийн тухайн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтыг албан ёсоор гаргуулан авах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах;

- Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн талаар харьяалах дээд шатны удирдах ажилтны үнэлгээг зөвшөөрөх, эс зөвшөөрөх;

- Цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатныхаа албан тушаалтанд амаар буюу бичгээр тавих;

- Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалынхаа ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуйгаа гардан эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох гэх мэт.

Гаалийн улсын байцаагчийн тухайд дээр дурдсан нийтлэг эрхээс

гадна Гаалийн тухай хуулийн 274 дүгээр зүйлд зааснаар эрхэлж буй албан тушаалтайгаа холбоотой дараах эрх эдэлнэ.

- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, бүрдүүлэлт хийх;

- Гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийг хангуулах;

- Гаалийн бүрдүүлэлттэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагын байр, агуулахад нэвтрэн орж үзлэг тооллого хийх, тэдгээрийн данс, бүртгэлийг шалгах;

- гаалийн болон бусад татвар ногдох барааг нуусныг гэрчлэх баримт, материалыг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс түр хугацаагаар хураах, эсхүл хуулбарлуулан авах;

- гаалийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх гэх мэт.

**Тав. Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын
хязгаарлалт ба хориглолт**

Хязгаарлалт гэдгийг тодорхой үйл ажиллагаа явуулах, хийхийг хоригломо гэсэн утгаар ойлгож болох юм. Энэ нь эс үйлдэлд ч нэгэн адил хамаарах ба төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа хугацаанд хууль тогтоомж дахь тухайн хэм хэмжээ үйлчилнэ.

“Нийтийн албан хаагчийн гол үүрэг нь албаны үүргээ шударгаар биелүүлэх явдал юм. Энэ үүргээ хэрэгжүүлэхэд албан хаагчид хүлээлгэж болох тодорхой хязгаарлалтыг хасамгүй гэж үздэг”.¹⁰

Хуулиар тогтоосон зарим хязгаарлалт, хориглолт нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хясан боогдуулсан хэрэг биш. Харин төрийн жинхэнэ албан хаагчийн ажлыг үнэнч шударгаар үр нөлөөтэй гүйцэтгэх нөхцөлийг хангах, иргэдэд түүний итгэх итгэлийг улам нэмэгдүүлэх, албан тушаалаа урвуулан ашиглах, хэтрүүлэхээс сэргийлэх чухал ач холбогдолтой.

“Монгол Улсын Төрийн албаны тухай хууль”-ийн 15 дугаар зүйлд зааснаар төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглохоор тусгажээ. Үүнд:

- албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох;

- ажил хаялт болон төрийн байгууллагын хэвийн үйл

¹⁰ Административное право зарубежных стран/ Учебник. Под ред. А.Н.Козырина и М.А.Шатиной.-М., Спарк. 2003. С 118.

ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

- албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх;

- нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх;

- хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хувь нийлүүлсэн аж ахуйн нэгжийг гардан удирдах, тэдгээрийн удирдах зөвлөлийн болон захиргааны гишүүн байх;

- хувийн ашиг сонирхлын үүднээс дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө үүрэг хүлээх, санхүүгийн болон бусад туслалцаа авах; гэх мэт.

Гаалийн улсын байцаагчийн тухайд Төрийн албаны тухай хуульд дурдсанаас гадна Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 275 дугаар зүйлд зааснаар дараахь үйл ажиллагаа явуулахыг хоригложээ. Үүнд:

- улс төрийн намын гишүүн байх;
- өөрийн нь гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүмүүсийн гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, эсхүл уг үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх;
- энэ хуульд зааснаас бусад мэдээлэл шаардах, иргэдэд чирэгдэл учруулах, бусдад давуу байдал олгох зэргээр ялгаварлах гэх мэт.

Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэхтэй нь холбоотой албан хаагчийн эрх зүйн байдалд иймэрхүү хязгаарлалт хийсэн, хориглосон заалт салбарын бусад хуулиудад бий. Харин төрийн албан хаагчийн эрх зүйн байдалд хийх хязгаарлалт, хориглолт нь зөвхөн тухайн албаны үүрэг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай байхаас бус, хүний түгээмэл эрхийг хязгаарласан, дордуулсан байж үл болно.

Зургаа. Төрийн албан хаагчийн баталгаа

Төрийн албан хаагчийн баталгаа нь төрийн албан тушаал эрхэлж буй бүх хүнд нэгэн адил хамааралтай. “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа” гэсэн нэгэн бүлэг асуудал “Монгол Улсын төрийн албаны тухай хууль”-иар баталгаажин мөрдөгдөж байна.

Төрийн албан хаагчийн нийтлэг болон нэмэгдэл батлагааг эдийн засгийн, нийгмийн, эрх зүйн, зохион байгуулалтын гэх мэтээр дотор нь хуваан үзэж болох юм. “Төрийн албаны тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 1-д баталгааг зориулалт, шинж байдал, эх үүсвэр, онцлог

зэргийг харгалзан цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж гэж төрөлжүүлэн тус бүрийг тусгайлан авч үзжээ.

Эдийн засгийн баталгаанд албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс, албаны болон онцгой нөхцөлийн, цол зэрэг, зэрэг дэвийн нэмэгдэл, зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зохих хэсгийг нөхөн авах зэрэг хамаарна.

Нийгмийн баталгаанд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах, ээлжийн амралт эдлэх, төрийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, зохих хувь, гэр бүлийн нь болон асрамжид байдаг хүмүүст олгох уналга, тээврийн зардал, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг авах, нийгмийн даатгалаас олгох тэтгэмжээс гадна гэр бүлийг дэмжиж хуульд заасан тусламж үзүүлэх гэх мэтийг оруулж болно.

Эрх зүйн гэдэгт дээр дурдсан баталгаа хууль зүйн утгаараа хамаарахын зэрэгцээ төрийн албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд болон албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх зэрэг хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас түүний ажиллаж байгаа төрийн байгууллага нь хамгаалах үүрэг хуулиар хүлээдэг. Энэ нь эрх зүйн баталгааны тод жишээ юм.

Төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд “Монгол Улсын Төрийн албаны тухай хууль”-ийн 27.2; 30.2-т заасан дараахь нэмэгдэл баталгаагаар хангагдана. Үүнд:

- Төрийн албаны тухай хуульд 25 дугаар зүйл, 26.1.3-т зааснаас бусад тохиолдолд төрийн албанаас халагдахгүй байх;
- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;
- Төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр) -ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр) -ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ,

мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан нь шалгаруулж авах;

- Төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгоно;

- Төрийн албанаас чөлөөлөгдсөн тохиолдолд 6 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж, үүргээ гүйцэтгэхтэй холбогдон амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь 3 жилийн албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тусламж олгох гэх мэт.

Эцэст нь тэмдэглэхэд дээрх баталгаа нь төрийн албан хаагчийн хуульд заасан үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, нийгэм ахуй, эдийн засаг, эрх зүй, сэтгэл зүйн бүрэн бодит хамгаалалтыг бүрдүүлсэн байдгаараа чухал ач холбогдолтой.

Долоо. Төрийн жинхэнэ албан хаагчийн урамшуулал, хариуцлага

Урамшуулал нь хүний ухамсар, сонирхлоор дамжин, төрийн албан хаагчаас болон бусад хүнээс ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд нөлөөлөх чухал арга хэрэгсэл юм. “Монгол Улсын төрийн албаны тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлд төрийн албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ үр бүтээлтэй биелүүлж амжилт гаргасан гавьяа зүтгэлийг нь үнэлж, төрийн байгууллагын захиргаа мөнгөн шагнал өгөх, эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах, Засгийн газар ба төрийн дээд байгууллагад шагнуулахаар тодорхойлох, 1,5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшал олгох зэрэг заалт бий.

Хариуцлага нь өндөр шаардлага, зохион байгуулалттай ажиллах, албаа сахилгатай гүйцэтгэх харилцан уялдаатай нөхцөлийг бүрдүүлэгч төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдлын бүтцэд хамгийн нөлөөтэй, нэг салшгүй хэсэг, хууль ёс, сахилгыг бэхжүүлэх чухал хэрэглүүр юм.

Төрийн захиран засаглах бүрэн эрхээ хэтрүүлэх, эсхүл албаны үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй тохиолдолд эрх зүйн зөрчилд үзэн,

хууль зүйн хариуцлага хүлээлгэнэ.

Төрийн жинхэнэ албан хаагчид хүлээлгэх хууль зүйн хариуцлагын гол төрөл нь сахилгын шийтгэл юм. Сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл нь сахилгын зөрчил гаргаж албаны үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн гэм буруутай төрийн жинхэнэ албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол “Монгол Улсын Төрийн албаны тухай хууль”-ийн 26 дугаар зүйлд заасан сахилгын дараахь шийтгэлийн аль нэгийг эрх бүхий албан тушаалтан шууд удирдах албан тушаалтан, түүнийг томилсон дарга ногдуулна.

- сануулах;
- албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

Сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй бөгөөд харин сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

Сахилгын нэг төрлийн шийтгэлийг давхцуулан ногдуулахгүй ба төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээлгэхгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хуулиар хориглосон заалтыг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болно.

Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч удаа дараа (2 ба түүнээс дээш) албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон, Монгол Улсын харьяатаас гарсан бол түүнийг төрийн жинхэнэ албанаас хална.

Төрийн жинхэнэ албан хаагч “Монгол Улсын Эрүүгийн хууль”-ийн тусгай ангид заасан албаны үүрэгтэйгээ холбоотой, эсхүл бусад гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх нь цөөнгүй бий.

Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийг зөрчиж, захиргааны зөрчил гаргасан, гэм буруутай, хугацаат цэргээс бусад төрийн жинхэнэ албан хаагчид тухайн хуульд зааснаар эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэл ногдуулна.

Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай Монгол Улсын хууль” (2002 он)¹¹-д зааснаар албан үүргээ гүйцэтгэж байх

¹¹ “Төрийн мэдээлэл”. 2002 он. №

үедээ цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан гэм буруутай цэргийн албан хаагч учруулсан бодит хохиролын хэмжээгээр нь эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

Төгсгөлийн оронд

Төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдал нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, эдгээрт нийцэж гарсан хууль тогтоомжийн бусад актаар нарийвчлагдан тодорхойлогдох ойлголт болох нь харагдаж байна.

Төрийн албан тушаал, албан хаагчийн засаглан захирах эрх мэдэл, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, эрх зүйн байдлын хязгаарлалт ба хориглолт, ажиллах нөхцөл, баталгаа, хүлээх хууль зүйн хариуцлага зэрэг ухагдахуун нь тус бүртээ онолын үндэс, хууль тогтоомжийн хэрэглээнд зохих судалгаа, нотолгоо хийхийг шаардсан, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтоох үндсэн элемент хэмээн үзэж болно.

Төрийн албан тушаалын болон албан хаагчийн ангиллын дотор төрийн жинхэнэ албан тушаал, албан хаагч нь засаглан захирах талаар илүү эрх мэдэлтэй, тэр нь хууль зүйн зохицуулалтаас илэрхий харагдаж байгааг тухайлан тэмдэглэе.

Гэхдээ төрийн улс төрийн болон үйлчилгээний албан хаагчийн эрх зүйн зарим байдлыг орхигдуулалгүй, нэгэн адил авч үзсэн болно. Нөгөө талаар байгууллага, ажилтнаа засаглах талаасаа бус, удирдан захирах, зохион байгуулах үүрэг гүйцэтгэдгийг бас үгүйсгээгүй.

Төрийн албаны эрх зүйн зохицуулалтад төрийн жинхэнэ албан хаагчийн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг, захиргааны эрх зүйн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж гүнзгийрүүлэн судлах зайлшгүй шаардлага хэвээр хадгалагдаж буй нь эргэлзээгүй.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ БА ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНЫ НУУЦЛАЛ

Өнөөдөр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хамгаалах ёстой нууцлалын талаар нэгдсэн ойлголт байхгүйгээс хэн дуртай нь мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд шийдвэрдэгдэн шалгагдаж буй эрүүгийн хэргийн талаархи мэдээллийг нийтэд цацаж, байгууллага, хувь хүний нууцад халдан гэм хор учруулж, хуулийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад болж байна.

Цаг үеийн өнгө байдлыг үзэхэд эрүүгийн хэрэг шийдвэрлэж буй субъект, тэдний удирдах албан тушаалтнуудаас байцаан шийтгэх ажиллагааны нууцлал зохих баримтыг задруулан тухайн хэргийг шийдвэрлэхэд ихээхэн хүндрэл, бэрхшээл учруулж байгаагаас гадна эрэн сурвалжлах сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өрсөлдөөнөөс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын мэдээ баримтыг хамгаалах, нууцлах шаардлага зүй ёсоор урган гарч иржээ.

Олон нийтэд мэдээлэгдэж байгаа эрүүгийн хэргийн талаархи мэдээлэл, нотлох баримт, түүнийг шийдвэрлэж байгаа процесс, хувь хүн, байгууллагын нууцлалыг хэрхэн хамгаалах, ямар арга хэрэгсэл ашиглах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хуулийн байгууллагахоорондоо хэрхэн харилцах, нууцлал задруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага гээд олон асуудал тодорхойгүй байгаа нь тулгамдсан асуудал мөн гэж үзлээ.

Хэвлэл мэдээлэл гэж чухам юуг хэлэх талаар нэгдсэн ойлголт байхгүй боловч нийтэд хүрч байгаа байдлаар нь дараахь байдлаар ангилж болох юм гэж судлаачийн зүгээс үзэж байна.

1. Өдөр тутмын, долоо хоног, сар, улирал тутмын сонин, сэтгүүл (хэвлэл буюу биет мэдээлэл);

2. Радио, зурагт, кабелийн телевиз(дуу-дүрст мэдээлэл);

3. Интернет орчин буюу үндэсний мэдээллийн портал сайт, барез сайт, блог, админууд (цахим мэдээ буюу биет бус) гэсэн хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүрдэж байгаа бөгөөд

Дээрх хэрэгслээр дамжуулан тараагдаж байгаа эрүүгийн хэргийн мэдээ баримт нь нууцлал зохих эсэх талаар гаргасан дүгнэлт, энэ талаар бүртгэгдэж, шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй байна.

ХЗХДЯ-ны Хууль Зүйн бодлогын газарт боловсруулж буй Олон



ХЗУХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрлэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд

нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төслөөс үзэхэд ... "олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл" гэж тогтмол хэвлэлийн газар, радио, телевиз, кино, гэрэл зураг, цахим хуудас, өдөр тутмын дүрс мэдээллийн нэвтрүүлэг, нийтлэл, тогтмол мэдээлэл тараах бусад хэлбэр¹ хэмээн тодорхойлохыг оролджээ. Энэ нь чухамдаа оносон тодорхойлолт мөн эсэх талаар хэвлэл, мэдээллийн салбарын мэргэжилтнүүдээс санал дэвшүүлээгүй байна.

**Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцыг чандлан хамгаалах,
нийтэд мэдээлэх талаар хяналт тавих**

Эрүүгийн хэргийн материалтай² зөвхөн тухайн хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулж буй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хэрэгт хяналт тавьж буй прокурор харьцах бөгөөд эрүүгийн хэргийн талаархи нууцлалыг чанд хадгалах үүрэгтэй байдаг.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтууд зөвхөн гарсан хэргийн бодит үнэнийг тогтоох ажиллагаа байдаг тул нийтэд мэдээлэх шаардлагагүй байхад хэргийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тараах явдлыг гаргуулахгүй, төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой материалыг задруулахгүй байх үүргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хэрэгт хяналт тавьж буй прокурор хариуцдаг. ЭБШХ, Прокурорын байгууллагын тухай хуульд зааснаар эрүүгийн хэргийн материалыг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр нийтэд мэдээлдэг байна³.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч улсын болон хувь хүний нууцад хамаарахгүй, гэмт хэрэг үйлдсэн арга хэрэгслийг сурталчилсан шинжгүй, бусдын нэр хүндийг гутаах зорилгогүй, гэм буруутай гэж шууд буруутгаагүй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг ЭБШХ-ийн 189 дүгээр зүйлийн 189.1-д заасны дагуу гагцхүү прокурорын зөвшөөрснөөр, түүний бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдсэн эсэхэд прокурор хяналт тавина. Эрүүгийн хэргийн дараахь материалыг нийтэд мэдээлэхийг хориглодог. Үүнд:

- Хүчирхийлэл, аллага, садар самууны холбогдолтой эрүүгийн хэргийн материал;
- Гэмт хэрэг үйлдсэн арга, хэрэгслийг нарийвчлан заасан мэдээлэл;
- Төр, байгууллага, хувь хүний нууцтай холбогдох материал;
- Тухайн хэргийн талаархи гүйцэтгэх ажиллагаатай холбогдох

¹ Тус хуулийн төсөл хэлцүүлгийн шатандаа явж байгаа бөгөөд санал авч эцэслэн боловсруулах ажил дуусаагүй байна.

² Материал гэдэг үг нь эрүүгийн хэргийн нотлох баримт, мэдээ сэлтийг илэрхийлж чадахгүй бөгөөд биет мэдүүлэг, тэмдэглэл зэрэг агуулгыг илэрхийлдэг.

³ Прокурорын байгууллагын тухай хууль. 29 дүгээр зүйл. Прокурорын зөвшөөрөл.

материал;

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явц дахь хэрэг илрүүлэх, нотлох баримт цуглуулах зэрэг ЭБШ ажиллагаатай холбогдох материал;

- Тухайн хэрэгт цугларсан шалгагдаж нотлогдоогүй баримт, эргэлзээтэй нотлох баримтын талаар;

- Хохирогч, гэрч болон бусад оролцогсдын овог нэр, хаяг.

Өнөөгийн байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн нууц хадгалалт хамгаалалт, хэргийн тухай нийтэд мэдээлэх талаар Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар баталсан журмыг мөрддөг⁴.

Гэтэл практикт сэжигтэн яллагдагчтай холбоотой эрүүгийн хэргийн баримтыг гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай нотлогдоогүй байхад нь цацах, мэдээлэх явдал нэн түгээмэл байна. Ялангуяа тухайн өдөрт гарсан эрүүгийн хэрэгтэй холбоотой мэдээллийг өдөр тутмын телевиз, хэвлэлийн хэрэгслүүдэд тэр дор нь мэдээлэх, дуу-дүрс бүхий бичлэгийг нь цацах, олон нийтэд хүргэх зэрэг хувь хүний нууцлалтай холбоотой баримтыг цацаж, халдашгүй эрхийг нь зөрчиж байна. Үүнд:

1. Нууцын халдашгүй эрх⁵;

2. Нэр төрийн халдашгүй эрх зөрчигдөж байгаа бөгөөд

Шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагчийн хувийн нууцлал бүхий мэдээ баримтыг тарааснаас болж нэр хүндэд нөлөөлж, ажлаасаа халагдах болон сургуулиасаа хөөгдөх зэрэг сөрөг үр дагаварыг амсаж, хувь хүний нууцтай холбоотой сэтгэцийн өвчин эмгэг зэрэг зүйлс ил болж сэтгэл санаа нэр хүндээрээ хохирох явдал гарсаар байгаа талаар нэг биш иргэн гомдол гаргасан боловч нэгийг ч шийдвэрлээгүй байна.

Гэтэл эсрэгээр хохирогчийн сурган хүмүүжүүлэгчээр оролцож байгаа сургуулийн ниймгийн ажилтан, эсвэл өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч нь мөн хуулиар эрх ашгаа хамгаалуулж байгаагтээгдийн нууцыг тарааснаас болж сэтгэл зүйн сөрөг үр дагаварыг амсаж, гэрч хохирогчийн аюулгүй байдалд нөлөөлж, ахин гэмт хэргийн хохирогч болсон жишээ баримт нэг бус.⁶

Мөрдөн байцаах байгууллагад шалгагдаж байгаа байгууллагын нэр хүндэд тухайн хэрэгтэй нь холбогдуулан халдаж, илт үндэслэлгүй мэдээ баримт тарааж, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд саад учруулдаг. Үүний улмаас бизнесийн нэр хүнд нь унах, ашиг орлогоо

⁴ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн нууц хамгаалалт, хадгалалт, хэргийн тухай нийтэд мэдээлэх талаар мөрдөх журм. Улсын ерөнхий прокурорын 2004 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 154 тоот тушаалын 1 дүгээр хавсралт.

⁵ "Хүний хувийн нууц нь халдашгүй эрх мөн бөгөөд зөвхөн тухайн этгээдийн нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж үзэн өөрийнхөө талаарх мэдээллийг нууцлахыг хэлнэ" хэмээн судлаач Х.Эрдэнэбат "Хүний халдашгүй эрх" (2002он) нэг сэдэвт бүтээлдээ томъёолжээ.

⁶ 2010 онд Ёсвер үеийнхний хөгжлийн төвийн баримтжуулсан кейст бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн тухай мэдээллийг тухайн байцаан шийтгэх ажиллагаанд сурган хүмүүжүүлэгчийн хувир оролцсон нийгмийн ажилтан сургуулийн хүүхдүүдийн дунд задалснаас хохирогч хүүхэд сэтгэл санаа нь гутарч, орон гэр амьдарч багаа ахуй орчноосоо дайжжээ.

алдах гэх мэт олон сөрөг үр дагавар амсдаг.

Эдгээр тохиолдолд хэрхэх вэ гэдэг асуудал зүй ёсоор тавигдана. Үүнийг Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай, болон Байгууллагын нууцын тухай хуулиар зохицуулж болох боловч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч биш харин мэдээллийг тараасан сэтгүүлч, нийтлэл бичигч байсан тохиолдолд дээрх асуудал яригдана.

Дээр дурдсан хувь хүний болон байгууллагын нууцын зарим асуудал нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд хамгаалагдаж байгаа тохиолдолд “байцаан шийтгэх ажиллагааны нууцалвбал зохих мэдээ баримт” хэмээн үзэж болох юм гэсэн дүгнэлтийг судлаачаас хийж байна.

Харин Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд эрх эдэлж үүрэг хүлээн оролцож байгаа оролцогчдоос эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулсантахиолдолд Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйлд заасан гэмт хэрэг хэмээн үздэг. Учир нь дээрх субъектүүдээс эрүүгийн хэргийн мэдээ баримттай танилцах, харьцах эрхтэй байдаг бөгөөд сэтгүүлчдийн хувьд дам мэдээллийн эх үүсвэрийг оролцогчдоос олж авсан байдаг онцлогтой юм.

Өнөөдөр энэ төрлийн хэргийг шалгаж, шийдвэрлэхэд нөлөөлж байгаа тодорхой хоёр ойлголт бий. Практикт иргэд болон сэтгүүлчдийн дунд хэрэглэж хэвшсэн “эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууц” хэмээх ойлголтыг Эрүүгийн хуульд⁷ “эрүүгийн мэдээ, баримт” харин ЭБШХ-д⁸ “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материал” гэж зөрүүтэй томъёолсон байна. Гэтэл эрүүгийн хэргийн нэгдсэн тоо бүртгэлийн зааварт “эрүүгийн хэргийн мэдээ” гэдгийг хуульд зааснаас өөрөөр тайлбарлаж, ЦЕГ-ын МДШТ-өөс гаргаж байгаа статистик, тоо мэдээ, бүртгэл маягт зэргийг хамааруулсан байна. Тус зааврын “3.1.7.-д “Гэмт хэргийн мэдээ” гэж гэмт хэргийн цахим мэдээллийн сангаас тогтсон үзүүлэлт, аргачлалаар боловсруулсан гэмт хэргийн, сэжигтэн яллагдагчийн, хохирогч иргэн, байгууллагын, бүртгэгдсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн, түдгэлзүүлсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн тухай тоон мэдээллийг хэлнэ гэжээ. Харин дээрх агуулгыг УЕП-ын 2004 оны 154 дугаар тогтолын хавсралтад “.. цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг гарсан тухай болон гэмт хэргийн талаархи дүн шинжилгээний мэдээлэл хийхэд хамаарахгүй” хэмээн мөн л зөрүүтэй тайлбарлажээ.

Үүнээс үзэхэд тус хуулийн 257 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектын бүрдэл хэсэг халдлагын зүйлийг ахин тодорхой хуульчлах хэрэгтэй байгаа нь илэрхий ажиглагдлаа.

⁷ Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйл.

⁸ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 189 дүгээр зүйл.

⁹ ЦЕГ. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн заавар. 2009 он 12 дугаар сарын 24-ний өдөр.

Практикт энэ төрлийн гэмт хэргийн шалгаж шийдвэрлэсэн баримт байхгүй байгаа бөгөөд цөөн хэдэн тохиолдолд ЭБШХ-ийн 77 дугаар зүйлд заасны дагуу "байцаан шийтгэх ажиллагааны журам зөрчсөн" хэмээн үзэж албаны дарга торгож шийдвэрлэсэн баримт бий. Угтаа бол энэ нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан батлан даалт болон бусадүндэслэл, журмыг зөрчсөн үед авах арга хэмжээ юм.

Хууль тогтоогчоос Эрүү болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг батлахдаа баримталсан гол үзэл санаа нь процессын хуульд заасан хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын материалыг задруулахгүй талаарурьдчилан сануулж, зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал юм. Гэтэл дээрх заалтуудаас харахад "материал", "мэдээ, баримт" хэмээн зөрж томъёолсноос хуулийн заалтуудын уялдаа холбоо алдагдаж, хэрэгжих боломжгүй болсон байна. Энэ нь бүр 1996 оноос өмнө болон дараах Эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх хуулиудын өөлчлөлтөд яг энэ хэлбэрээр тусгагдаж ирсэн уламжлалтай.

Прокурорын зөвшөөрлөөр эрүүгийн хэргийг олон нийтэд мэдээлэхэд эрүүгийн хэргийн мэдээ баримтад дараахь шаардлага тавигддаг. Үүнд:

- Эргэлзээгүй нотлогдсон;
- Хэргийг цаашид шалган шийдвэрлэхэд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байх.

Тухайн үед гарч байсан Эрүүгийн хуулийн тайлбарыг¹⁰ үзэхэд "хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зөвшөөрөлгүйгээр задруулж болохгүй баримтад: сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрч бусад оролцогчдын мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, ЭБШ ажиллагаагаар тогтоогдсон бусад нотлох баримтуудаас гадна хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл, түүнчлэн мөрдөн байцаах байгуулагад дуудагдсан хувь хүний тухай мэдээллүүд орно" гэжээ. Энэ тайлбараас хойш бүтэн 20 гаруй жилийн хугацаанд энэ гэмт хэргийн талаарх ойлголт, үзэл баримтлал өөрчлөгдсөнгүй иржээ.

Эрүүгийн эрх зүйн хувьд гэмт хэргийн бүрэлдэхүүний дараахь шинжүүд байдаг:

Субъект: Эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулахгүй байх сангуулга авсан байцаан шийтгэх ажиллагааны оролцогч;

Объектив тал: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцыг задруулж, саад учруулсан байх буюу эрүүгийн хэргийн мэдээ, баримтыг тараасан идэвхтэй үйлдэл;

Объект: Эрүүгийн байцаан шийтгэх буюу хэрэг бүртгэх мөрдөн байцаах, прокурор, шүүх байгууллагын хэвийн үйл ажиллагаа;

Субъектив тал: Гэм буруугийн шуудболон шууд бус санаатай хэлбэр

¹⁰ Ж.Авхаж нар. "БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар". 1989 он. 257 дахь тал.

гэсэн шинж зайлшгүй байж гэмээн Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйл болох Эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулах гэмт хэргийн бүрэлдхүүн болно. Энэ гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг бөгөөд хор уршиг шаарддаггүй онцлогтой.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 310 дугаар зүйлд “Мөрдөн байцаалт явуулж байгаа субъект, мөрдөн байцаагч, прокурорын зөвшөөрөлгүйгээр хуулиар үүрэг хүлээсэн этгээд Эрүүгийн хэргийн мэдээ, баримтыг задруулсан бол...” хэмээн тодорхойлжээ. Тус хуульд “даных” гэдэг үгээр тодохойлон заасан бөгөөд үүнийг манайд мэдээ, баримт хэмээн орчуулжээ.¹¹

Германы Эрүүгийн хуулийн 353 дугаар зүйлийн d-д Шүүнтаслах ажилагааны явцад хэргийн мэдээ, баримтыг задруулах (Unlawful disclosure of facts sub judice) тухай хуульчилсан гол агуулга нь шүүхийн шатнаас өмнө тухайн хэлэлцэж буй хэргийн талаар албан хаагчаас зөвшөөрөлгүй олон нийтэд мэдээлсэн нь хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд саад учруулсан бол нэг жил хүртэл хорих ял шийтгэхээр заажээ.

Тэгвэл Англо Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад “Confidentiality in investigation” хэмээн томъёолдог бөгөөд зөвхөн хохирогч, гэрчийн бусад оролцогчийн аюулгүй байдалд чиглэсэн агуулгаар оруулсан байх нь бий.

Байгууллагын нууцын тухай хууль: Байгууллагын нууцын тухай хуулийн гол агуулга нь байгууллага өөрийн “нууц” гэж үзэж болох зүйлээ нууцалж, түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлагын тухай байдаг. Хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ¹² гээд энэхүү нууцыг Улсын Их Хурал хуулиар тогтоон баталгаажуулахаар заажээ.

Ардчилсан нийгмийн үндсэн зарчимд хуулийн этгээд, аль нэг байгууллага нь иргэдээс ямар нэг мэдээлэл нууцлах, жагсаалт гаргах ёсгүй бөгөөд үүнийг зөвхөн хуулийн хүрээнд шийдвэрлэдэг. Гэтэл өнөөдөр Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд нийтэд мэдээлэх хориглох материалын жагсаалтыг Прокурорын байгууллагаас батлан гаргаж хэрэгжүүлж байна. Зүй нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар дээрх агуулгыг тодорхойлон гаргах ёстой бөгөөд нэг байгууллагын гаргасан журмаар гэмт хэрэг мөн эсэхийг шийдвэрлэхээр байгаа нь Эрүүгийн хуулийн “Хууль ёсны зарчим”¹³-д харшилж байна.

Түүнчлэн гадаадын дийлдэнх орны туршлагыг судлан үзэхэд¹⁴ мөрдөн

¹¹ Ю. Кручин. Орос-Монгол, Монгол-Орос орчин үеийн хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. 2006 он, 79 дэх тал.

¹² Байгууллагын нууцын тухай хуулийн 3.4 дүгээр зүйл.

¹³ МУ-ын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлд “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцож, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлно” гэжээ.

¹⁴ Германы Мэдээллийн эрх чөлөөний хуульд “Хэрэв мэдээллийг задгалсан нөхцөлд ... мөрдөн байцаалтын

байцаалтын шатанд хамгаалвал зохих мэдээллийг хуульдаа тусгайлан заадаг.

Эрүүгийн хэргийн архив:

Үүнээс гадна шалгагдаж дуусан эрүүгийн хэргийн мэдээ баримтыг хэрхэн нууцлаж бас ил болгох вэ гэдэг асуудал тулгарч байна. Одоогоор эрүүгийн хэргийн архивт байгаа материалтай харьцах 2 журам үйлчилж байна. Үүнээс үзэхэд¹⁵ шүүхийн шийдвэр, таслан шийдвэрлэх тогтоол (шийтгэх тогтоол), хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас хэрэгсэхгүй болгосон тогтоол, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоол, магадлал, захирамжийг хуулбарлан авч болохоор байна.

- Эрүүгийн хэргийн төв архив, Нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын салбар архивт—2000 төг;

- Аймгийн прокурорын газрын салбар архивт—500 төг.

- Иргэдээс хандаж болох ганцхан үндэслэл нь судалгаа шинжилгээний, ажил хийх зориулалтаар эрүүгийн хэргийн баримттай танилцаж болох баямар нэг байгууллагын тодорхойлолт бүхий албан бичиг шаарддаг¹⁶ байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Энэхүү өгүүллийн тухайд энэ төрлийн харилцааг эрүүгийн бус иргэний журмаар тогтоох бодлого, эрх зүйн үндэс байж болох эсэх, сэтгүүлчийн эрх ашгийг хамгаалах талаар судлаачдын дурдсан бодлогыг бид давхар авч үзэх хэрэгтэй. Олон улсын сэтгүүлчдийн эрэн сурвалжлах чиг хандлага нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцад шууд хамаарах хүчин зүйлүүд болох:

- Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаа;

- Сэтгүүлчийн ажиллагаанд саад хийсэн үйлдэл;

- Сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлахтай холбоотой асуудал;

- Редакцийн болон сэтгүүлчийн өөрийн цензур гэх мэт хууль зүйн биш сэтгүүл зүйн салбарт хэрэглэгддэг ойлголт, ухагдахуунууд¹⁷-тай зөв холбон ойлгох хэрэгтэй юм.

Энэхүү зураглалаас (Зураг 1) үзэхэд эрүүгийн хэргийн талаар мэдээллийг олохын тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчийн эрх ашиг, хуулийн байгууллага, албан тушаалтны эрх ашигтай шууд


үйл ажиллагаа зэрэгт хохирол учрахаар байвал...” гэж ялган зааглажээ.

¹⁵ Улсын ерөнхий прокурорын 2006 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тушаалаар баталсан “Эрүүгийн хэргийн төв болон салбар архиваас иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, өмгөөлөгчдөд үйлчилгээ үзүүлэх” талаар гаргасан журам.

¹⁶ Глоб интернэшнл “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө” судалгааны тайлан. 2006 он.

¹⁷ Доктор Ч.Базар “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжлийг дэмжсэн эрх зүйн болон үйл ажиллагааны орчин бүрдүүлэх арга зам” бодлогын судалгааны тайлан. 2010 он.

Зурал 1



үйлдлийг сэтгүүлч өөрийн ур чадвараар сурвалжилж, нотлон бичих явдал.

Хуулийн байгууллагаас байцаан шийтгэх ажиллагааны эх сурвалжаа нууцалж чадалгүйгээр түүнийг нь сэтгүүлч ашиглан бичсэн байлаа гэхэд буруутган харьцах нь үндэслэлгүй юм. Угтаа хуулийн байгууллага өөрөө л байцаан шийтгэх ажиллагааны нууцлалын хүрээгээ ойлгомжтой байдлаар томъёолон гаргаж, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах журам гаргаж, харилцан дагаж мөрдвөл ийм асуудал гарахгүй.

Эсрэгээр сэтгүүлчид хуулийн байгууллагыг эрүүгийн хэргийн нийтэд илэрхий хүртээж болох мэдээллийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцлалын дор мэдээлэхээс цааргалдаг, сурвалжлагчдыг хөөдөг, ямарваа хэргийг мөрдөх явц дэндүү хаалттай, түүнчлэн хэрэг мөрдөгдөх явцадхүний эрх зөрчигдвөл түүнийг мэдээлж, олон нийтэд хүргэх ямар ч боломжгүй" гэж сэтгүүлчид шүүмжилдэг.

Нэг нь нууцлах гэж нөгөө нь ил болгох гэдэг энэ үйл явц нь нийгмийн эрүүл үзэгдэл мөн боловч гарцаагүй эрүүгийн хэргийг шийвэрлэхэд нууцлах шаардлагатай нотлох баримт болон нууцлал бүхий зүйлийг хэн хэн нь маргаангүйгээр зөв ойлгоод нийтэд мэдээлэхгүй байх нь өнөөдрийн тухайд тулгамдаад байгаа гол асуудал юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж юу болох эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцлал зохих мэдээ, баримт гэж юу болох талаар ямар нэг төсөөлөлгүй байж аль нэг талыг буруутган шүүмжилж хуулийн байгууллагын, сэтгүүл зүйн салбарын нэр хүндийг ч тэр уландаа гишгэх нь мэргэжлийн ёс зүйд нийцэхгүй.

Мэдээлэлд хяналт тавих хяналтын талаар хууль тогтоомжид тусгахдаа "төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй"¹⁸ гэсэн байна. Монголд шүүхээс өмнө шүүх дээр сэтгүүлчдээс эх сурвалжаа илчлэхийг шаардах нь энгийн үзэгдэл юм. "Хэн энэ мэдээллийг өгсөн бэ?" гэж шаарддаг. Эх сурвалжаа илчлэхийг шаардаж буй субъект нь гол төлөв цагдаа, шүүхийн байгууллага байдаг

¹⁸ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйл.

бөгөөд өмнө нь ийм дарамтад өртсөн сэтгүүлчидэнэ тухай мэдээлэхээс айдаг байна.

Дэлхий даяар гаргадаг сэтгүүлчдийн хорооны тайланд Монгол Улсад цагдан хяналт (цензур)-ыг хуулиар хориглосон ч ил болондалд хэлбэрээр байгааг дурдаж “Улс төрч, албан тушаалтан, албан хаагчид Эрүүгийн хууль, Иргэнийхуулийн заалтуудыг цензур болгон ашиглах нь түгээмэл байна. Монголын сэтгүүлчид өнөө хэр төрийн байгууллага, албан тушаалтан, албан хаагчдаас мэдээлэл олж авч чадахгүй, төрийн байгууллагын бичигбаримтыг олж үзэх боломжгүй байна.” гэжээ.

Дүгнэлт

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцалбал зохих мэдээ баримт, материал гэх ойлголт Эрүүгийн хуульд ч тэр Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиудад зөрүүтэй байна.

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэгт юуг ойлгох талаар хуулийн байгууллага байтугай хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд тодорхойгүй байна.

- Хуулийн байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд саад учруулж, шалгаж байгаа эрүүгийн хэргийн баримт, сэлтийг зөвшөөрөлгүй тараасан, нийтэд мэдээлсэн үйлдэлд хариуцлага тооцохгүй байгаа ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хувь хүн болон байгууллагын нууцыг хэрхэн хамгаалах энэ нь байцаан шийтгэх ажиллагаанд ямар хамааралтай байх талаар эрх зүйн орчин байхгүй байгаа нь гэрч, хохирогч болон бсуад оролцогчдийн аюулгүй байдал, нэр төр, алдар хүнд, нууцын халдашгүй эрхэд гэм хор учруулж байна.

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцлалтай холбоотой баримт сэлт, мэдээ, мэдээллийг хамгаалж байгаа Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйл хэрэгжихгүй байна. Практикт тус хуулийн заалтыг ЭВША-нд оролцогчдод урьдчилан сануулахгүй байгаа нь үүнтэй шууд холбоотой юм.

Савал

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцалбал зохих мэдээ, баримт гэдэг нь угтаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хамгаалах ёстой хувь хүн болон байгууллагын нууц бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамааралтай дараахь зүйлүүд хамаарна:

- Эрүүгийн хэрэгт авагдсан нотлох баримт, тайлбар, мэдүүлэг, тогтоол, шийдвэр, шинжээчийн дүгнэлт, прокурорын яллах дүгнэлт, шүүхийн тэмдэглэл, шүүхийн шийтгэх тогтоол;

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд баримталж буй тактик, стратеги тухайлбал, цаашид авах арга хэмжээ, баримталж буй чиглэл, төлөвлөгөө удирдамж;

- Гэрч хохирогч болон бусад оролцогчдын талаарх хувийн нууц, байгууллагын нууц нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хамаарах бол авч үзэх.

2. Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдхүүний объект болон халдлагын зүйл болох эрүүгийн хэргийн мэдээ баримт, ЭБШХ-ийн 187 дугаар зүйлд заасан эрүүгийн хэргийн материал гэсэн зөрүүтэй ойлголтыг нэг мөр болгож “эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанынууцалбал зохих мэдээ, баримт” хэмээн томъёолон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд энэ талаарх үндэслэл, журмыг тодорхой оруулах.

3. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төсөлд хэлэлцэгдэж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэсэн ойлголтыг эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгах.

4. ЭБША-нд оролцогчдод ЭХ-ийн 257 дугаар зүйлийг урьдчилан сануулж хэвших.

5. Хэвлэл мэдээллийн байгууллага, хууль сахиулах байгууллага хоорондоо эрүүгийн хэргийн талаар мэдээлэх журам бий болгон дагаж мөрдөх гэх мэт саналыг дэвшүүлж байна.

Дээрх санал нь хэдийгээр хууль тогтоогчдын анхаарах асуудал мэт боловч өнөөдөр ЭБША-нд төрийг төлөөлөн оролцож байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарт шууд хамааралтай юм. Өнөөдөр ЭБША-нд оролцож төлөөлүүлэгчийн болон өөрийн эрх ашгийг төлөөлөн оролцож байгаа оролцогчдын зүгээс эрүүгийн хэргийн мэдээ баримтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж байцаан шийтгэх хэвийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа нь нууц биш. Түүнчлэн сэтгүүлчдээс ямарваа нэг дуулиан шуугиан бүхий эрүүгийн хэргийн талаар өөрсдийн таамгаар дүгнэн бичиж байгаа нь олон нийтэд хуулийн байгууллагын талаар сөрөг хандлага үүсэхэд хүргэж байна. Чухамдаа хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хуулийн байгууллагаас үр дүнтэй хамтан ажиллаж чадвал хуулийн байгууллагын үйл ажиллагааны талаар зэрэг төсөөлөл бий болдог онцлогтойг мартаж болохгүй юм.

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД НЭГДЭН ОРОХОД СУДАЛГААТАЙ ХАНДАХ АСУУДАЛ

Нэг. Асуудлын шалтгаан буюу өнөөгийн практик

Олон улсын эрх зүйн улс орнуудын харилцааг улс төрөөс ангид үр дүнтэй зохицуулах хэрэгсэл төдийлөн болж чадахгүй байгааг анхааралдаа авч, орчин үеийн гадаад бодлогын чиг хандлага, олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх, үзүүлэх нөлөөг бэхжүүлэх зорилгоор өөрийн орны эрх ашиг буюу хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлдэл хийж, үүсэх үр нөлөө нь гадаадад болон дотооддоо зөрчил гаргахгүй байх үүднээс олон улсын гэрээнд нэгдэх асуудалд судалгаатай хандах (өөрөөр хэлбэл судалгаанд үндэслэн, зохих бэлтгэл арга хэмжээ авч байж нэгдэн орох) шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Аливаа гэрээнд нэгдэн орсон улс Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 27 дугаар зүйл¹-ийн дагуу ямар нэгэн шалтгаан заалгүйгээр тухайн гэрээг заавал биелүүлэх үүрэгтэй байдгийг тэргүүн ээлжинд онцолдог. Харин үүргээ биелүүлнэ гэдэг нь зохих арга хэмжээг авна гэсэн үг. Иймд нэгдэн орохоос өмнө үүнийг урьдчилан судлах нь зайлшгүй. Үүргээ биелж үлж чадах чадахгүйгээ эхлээд тооцолно гэсэн үг. Хэдийгээр түүхэн улсын эрх ашгийн үүднээс судлаад нэгдэх ёстой гэж үзсэн ч цаана нь дахиад нарийн судлагдахуун байгааг мөн судлах нь чухал юм.²

Олон улсын гэрээ байгуулж байгаа Монгол Улсын практикаас үзэхэд тал бүрийн мэдээлэл, судалгаа хангалтгүйн дээр гэрээнд нэгдэх тооны хойноос хөөцөлдөх хандлага нэлээд газар авсан байдаг гэж дүгнэж болохоор байна. Аливаа гэрээнд нэгдэх асуудалд үндэслэл, судалгаа муутай хандсаны улмаас ямар нэг байдлаар харшилдах, зөрчилдөх асуудлыг үүсгэсэн үр дагаварт хүрдэг.

УИХ-аар олон улсын гэрээнд нэгдэн орох асуудлыг хэлэлцсэн протоколуудыг судлахад дараахь нийтлэг дутагдал илэрч байна. Үүнд:

¹ Оролцогч улс гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтыг баримтлан зааж үл болно. Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцид Монгол Улс 1988 онд нэгдэж орсон.

² "Монгол Улсын нэгдэн ороогүй гэрээний судалгаа" сэдэвт судалгааны ажилд МУИС-ын ХЗС-ын багш докторант М.Мөнхбатаас өгсөн чиглэл, зөвлөмж.



ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан
Б.Энх-Амгалан

- Гэрээнд нэгдэн орсноор үүсэх үр дагавар;
- Гэрээнд нэгдэн орох хууль зүйн үндэслэл, бусад хуульд өөрчлөлт орох эсэх;
- Тухайн гэрээнд нэгдэн орсон бусад улс орны байдал, хандлага;
- Тухайн гэрээнд нэгдэн ороогүй бусад улсын хандлага, шалтгаан;
- Нэгдэн орсноор үүсэх зардал, татварын асуудал зэргийг олон улсын гэрээг соёрхон батлах хуулийн төсөлд хангалттай тусгаагүй байна.

Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи саналыг тусгах ёстой боловч энэ ажлыг хангалтгүй гүйцэтгэж байгааг 1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын “Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх” чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын дэд хэсгийн тайланд тусгасан дүгнэлтэндээ дараахь тодорхой жишээг иш татсан байна.

“УИХ-ын 2006 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлийн хэсгээс:

С. Ламбаа:- ... байсхийгээд л нэг конвенц ороод ирнэ. Тэгээд дараа нь бид нар хууль тогтоомждоо өөрчлөлт хийнэ гээд л өргөн бариад байх юм. Ер нь одоо конвенцид элсэхтэй холбогдуулаад энэ конвенцийн дагуу ийм ийм хуульд ингэж өөрчлөлт оруулна гэсэн юм хамт орж ирж хэлэлцэгдэж болдоггүй юм уу.... өөрөөр хэлбэл энэ конвенцийг батлаад гаргачихна. Тэгээд нөгөө хуулиуд нь хэзээ ч өргөн баригдах юм билээ. Ер нь бол бид нар нэг цогцолбороор нь иж бүрэн юмыг авч үздэг тэр тогтолцоог хэзээ бүрдүүлэх юм бэ. Ингэж болдоггүй юм уу. ... конвенцоо дагасан хууль эрх зүйн тэр өөрчлөлтүүдээ давхар оруулаад ирдэг. Тэгээд нэг мөсөн яриад ингээд гаргах бололцоо байдаггүй юм уу.... “

Дээрх тэмдэглэлээс үзэхэд олон улсын гэрээг соёрхон батлахдаа тухайн гэрээг хэрэгжүүлэх ажлыг урьдаас төлөвлөхгүйгээр батлуулдаг нь харагдаж байгаа³ ба гэрээнд нэгдэн орохдоо судалгаатай ханддаггүйг давхар баталж байна.

Дүгнэж хэлэхэд аливаа гэрээнд нэгдэхдээ тухайн гэрээний агуулга, хэлбэрийг голлон танилцуулсан байх боловч өөрийн орны хэрэгцээ шаардлага, онцлог, тулгарах асуудал, бэрхшээл, шийдвэрлэх арга

³ “Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх” чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын дэд хэсгийн тайлан”. УБ. 2007 он, 34 дэх тал.

замыг харгалзсан талын судалгаа бага, үндэслэл муутай ханддаг байдал ажиглагдлаа.

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудлыг хуульд хэрхэн зохицуулсан ба хэрхэн хэрэгжиж байгааг олон улсын олон талт гэрээний хувьд тухайлан авч үзье.

Хоёр. Холбогдох хуулийн зохицуулалт, түүний хэрэгжилтийн байдал

Олон улсын гэрээг соёрхон батлах асуудлыг Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай 1993 оны хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай 2001 оны хуулийн холбогдох заалтыг баримтлан шийдвэрлэдэг.

Доктор, профессор Б. Чимид “Олон улсын гэрээ байгуулахад Монгол Улсын хувьд баримтлах онцгой зарчим бол Үндсэн хуулийн давуу байдал (примат)-ыг хангах явдал юм.”⁴ хэмээн тэмдэглэсэн байна.

МУ-ын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-д “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, Аравдугаар зүйлийн 3-д “МУ-ын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Аравдугаар зүйлийн 4-д “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.”, Арванзургаадугаар зүйлийн 14-д “МУ-ын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэсэн заалтууд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний эрх зүйд хэрэглэхтэй холбогдсон гол үзэл баримтлал болдог. Нэгтгэж хэлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн 10-р зүйлд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх, олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх тухай заалтууд тусгагдсан байна. Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэдгийг мөн хуульчлан баталгаажуулсан. Эдгээр үзэл баримтлал нь олон улсын гэрээнд нэгдэн орохдоо хариуцлагатай хандах, нэгэнтээ нэгдэн орсон тохиолдолд үүргээ заавал биелүүлэх ёстой болох учир судалж, ухаалаг шийдвэр гаргах тухай гүн утгыг агуулж байна.

Олон улсын гэрээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу, олон улсын гэрээг соёрхон батлуулах саналыг Засгийн газраар хэлэлцүүлэхэд олон талт гэрээний хувьд уг саналыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаараа

⁴ “МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуулийн шинжлэх ухаан, практикийн тайлбар” судалгааны тайлан дахь доктор, профессор Б. Чимидийн тус хуульд хийсэн тайлбар, 2009 он.

эсхүл гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн гэрээгээр зохицуулж буй асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран Засгийн газарт өргөн мэдүүлдэг. Тусгай газрын даргын хувьд олон улсын гэрээг соёрхон батлуулах саналыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн гишүүнтэй зөвшилцөн Засгийн газарт өргөн мэдүүлсэн тохиолдол одоогоор практикт гараагүй байна. Цаашдаа ч ийм тохиолдол гарахгүй болов уу.⁵

“Хууль, Улсын Их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль”-ийн дагуу олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийг боловсруулан УИХ-д өргөн барихдаа бусад хуулийн төсөл өргөн барих журмыг мөн баримталдаг. Тус хуулийн 7 дугаар зүйлийн дагуу хууль санаачлагч нь төслийг боловсруулахдаа холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн судлаач, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулж болох тухай заажээ. Үүнээс үзэхэд олон улсын гэрээг соёрхон батлах хуулийн төслийг судалгаанд үндэслэж боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн “Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд заасанчлан, хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдний засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи саналыг тусгах, мөн тус хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль болон МУ-ын олон улсын гэрээний заалттай уялдсан байх шаардлагыг хуулийн төсөлд тусгах талаар заасан зэргийг харгалзан үзэхэд судалгаатай хандах тал дээр эрх зүйн ерөнхий зохицуулалт байгаа боловч практикт хэрэгжихгүй байна.

Холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлж, олон улсын гэрээнд нэгдэхэд судалгаатай хандахын тулд дараахь асуудлыг анхаарах шаардлагатай байна.

Гурав. Судалгаатай хандах асуудал

• Олон улсын гэрээг соёрхон батлахаар хэлэлцэх журмын асуудал

Олон улсын гэрээг соёрхон батлахаар Улсын Их Хурлаар хэлэлцэх журам нь хууль хэлэлцэж батлах журамтай адил байдаг ба үүнийг хэлэлцүүлэг нь ижил журмаар болдог учраас хэмээн тайлбар хийдэг.

⁵ МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуульд шинжлэх ухаан, практикийн тайлбар хийх судалгааны тайлан дахь доктор Б.Алтангэрэлийн тус хуульд хийсэн тайлбар. 2009 он.

Гэтэл ийм байдлаар олон улсын гэрээг соёрхон баталж байгаа нь цаг үрсэн, илүү ажиллагаа гэдэг нь практикт ажиглагдаж, улмаар шүүмжлэлд өртөж байгаа тул гэрээг соёрхон батлах журмыг хууль хэлэлцэж баталдгаас өөр хялбар журмын дагуу хэрэгжүүлэх бодит шаардлага мөн гарч байна.⁶ Олон талт гэрээний хувьд бүр ч хялбар журмаар хэлэлцүүлэх бололцоо бий. Нэгэнт олон улсын хурлаар хэлэлцэж баталсан гэрээнд нэгдэн орж байгаа болохоор тийм гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал гарахгүй нь ойлгомжтой. Харин уг олон талт гэрээний заалтын дагуу тайлбар хийж болох бол тухайн гэрээний зарим заалтаар үүрэг хүлээхгүй тухайгаа мэдэгдсэн тайлбартайгаар нэгдэж болно. Ийнхүү талуудын тохиролцож гарын үсэг зурсан хоёр талын болон олон улсын хурлаар хэлэлцэгдэж батлагдсан олон талт гэрээг соёрхон батлах журмыг хууль хэлэлцдгээс арай хялбар журмын дагуу хэлэлцэж байх шаардлага зүй ёсоор гарч байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.⁷ МУИС-ын ХЗС-ын багш докторант М.Мөнхбат “Хууль тогтоогч нь тухайн гэрээнээс өөрийн улсын ашиг сонирхолыг хамгаалах, гэрээний үүргээ хэрхэн биелүүлэх асуудлаа л хэлэлцэх ёстой. Иймд хуулиас өөр хэлэлцэх журам байх нь зохимжтой.” хэмээн үзэж байна. Тэгвэл ийнхүү хэлэлцэж батлахын тулд судалгаатай хандах явдлыг туйлын чухалд тооцож, хэрэгжүүлснээр амжилттай үйл хэрэг болох юм.

Өөрөөр хэлбэл, нэгэнтээ олон улсын хэмжээнд хэлэлцэж баталсан гэрээ конвенцийг дангаар нь судлахаасаа илүү өөрийн улс орны тухайд онцгойлсон үзэл баримтлалаар хандаж, үүргээ хэрхэн биелүүлэхээ хариуцлагатай судлах зарчмын асуудал тавигдах учиртай.

• Олон улсын гэрээ байгуулахад тавигдах хариуцлагын асуудал 1993 оны Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийг батлах үеийн хууль тогтоох байгууллагын үйлдсэн протоколуудтай танилцаж судлахад тус хуулийн төсөлд гаргасан ганц санал буюу УИХ-ын гишүүн С.Нарангэрэлээс “Олон улсын гэрээ байгуулагчдад хүлээлгэх хариуцлага” гэсэн томъёоллоор хуулийн 7 дугаар бүлэгт бие даасан зүйл болгон “Монгол Улсын үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдалд илтэд харшилсан олон улсын гэрээ байгуулсан эрх бүхий МУ-ын албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэсэн заалт нэмж оруулах санал байсан боловч тухайн үед хүлээж аваагүй байна. Иймдээ ч одоогийн мөрдөгдөж байгаа хуульд хариуцлагын талаар “хууль тогтоомж зөрчин байгуулсан олон улсын гэрээг хүчингүй болгох” тухай тус хуулийн 23 дугаар зүйлд заасан заалт нь нэгэнт зөрчилтэй байгуулсан олон улсын гэрээг **хэн хүчингүй болгох** талаар заасан болохоос хариуцлагагүй хандсан

⁶ “МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуульд шинжлэх ухаан, практикийн тайлбар хийх” судалгааны тайлан дахь доктор Б.Алтангэрэлийн тус хуульд хийсэн тайлбар. 2009 он.

⁷ Мөн тайланд.

буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар заагаагүй орхисон байдал үүсгэсэн.

Хэрвээ хариуцлагын тогтолцоог бүрдүүлэн хуульчилж өгвөл тухайн гэрээ конвенцид нэгдэн орохдоо хариуцлагатай байх явдлыг анхаарахад чухал ач холбогдолтой болно. Хариуцлагатай байхын тулд судалгаатай хандах явдал аяндаа бий болон хэвших сайн үр дагаварт хүрнэ.

• Нэгдэн орох олон улсын гэрээний судалгаанд харгалзах шалгуур асуудал

Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийг богино хугацаанд хэлэлцэн батлахын тулд өмнө шатанд нарийн судлах бөгөөд түүндээ тулгуурлан үндэслэлийг нь бодитой, чанартай гаргах ажиллагааг хэрэгжүүлэн хэвшүүлэх шаардлагатай байна.

Дээрх асуудлыг анхаарах хэрэгцээ тулгамдаж байгааг судлаачид дэвшүүлсээр байна. Тухайлбал, ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын “МУ-ын нэгдэн ороогүй олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн судалгаа” сэдэвт судалгааны ажлынхаа үр дүнд, МУ-ын нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзах шалгуур боловсруулсныг зарим гэрээ конвенц-ийн жишээн дээр тайлбарлая.

Монгол Улс нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзах шалгуур

1. Гэрээний албан ёсны нэр, монгол нэр, товч танилцуулга, батлагдсан огноо

Энэ нь олон улсын гэрээ конвенцийн албан ёсны нэрийг баримтлан судалгаанд ашиглах эх сурвалжаа тодорхойлох, түүнчлэн конвенцийн нэрийг монгол хэлнээ зөв орчуулан хэрэглэх, тухайн конвенцийн агуулга, хэлбэрийг товч байдлаар танилцуулах нь дэлгэрүүлэн судлахад ач холбогдолтой юм. Нэмж хэлэхэд олон улсын эрх зүйн хамгийн нийтлэг хэм хэмжээ болох *Pacta sunt servanda* зарчимд агуулагддаг “Гэрээний нэр, хэлбэр нь түүний биелэлтэд сөргөөр нөлөөлөх ёсгүй” гэсэн тодорхой хэм хэмжээг хангах зорилготой шалгуур юм. Манай улс нэгдэн орох шаардлагатай гэгддэг олон улсын хүний эрхийн гэрээ конвенц болох “Дүрвэгсэдийн эрх зүйн байдлын тухай конвенц”, “Бүх цагаач ажилчин ба тэдний гэр бүлийн эрхийг хамгаалах тухай

⁸ “МУ-ын нэгдэн ороогүй олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн судалгаа”-ны ажлын үр дүнд гаргасан нэгдэн орох шаардлагатай хүний эрхийн гэрээний жагсалт: НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол, Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын Хоёр дахь Нэмэлт Протокол (хугацааны хувьд хязгаарлагдаж болно гэсэн тайлбартай), Бүх цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийн эрх зүйн хамгаалах тухай конвенц, Дүрвэгсэдийн эрх зүйн байдлын тухай конвенц, Аархусын конвенц - Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай конвенц

конвенц"-ийг хооронд нь андуурах, эсвэл нэг конвенц мэтээр ойлгох асуудал гарч байсан байна.

Жишээ, Конвенцийн албан ёсны нэр: Aarhus Convention Convention on Access to Information, Public Participation in Decision-making and Access to Justice in Environmental Matters

Конвенцийн монгол нэр: Аархусын конвенц-Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай конвенц

Батлагдсан огноо : 1998.7.25

Хүчин төгөлдөр болсон огноо: 2001.10.30

Товч танилцуулга: Дани Улсын хот болох Аархуст зохиогдсон хурлаар нэрлэгдсэн конвенц юм.

Аархусын Конвенц:

- Гомдол хүлээн авах механизмтай;
- Бохирдуулагч төлөх зарчим;
- Нэгтгэлийн зарчим ;
- Шударга байдлын зарчим агуулсан.

Хүний эрхийн агуулга:

- Мэдээлэл авах эрх;
- Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох эрх;
- Зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах эрх тусгагдсан.

Энэ конвенц нь байгаль орчны асуудлаар мэдээллийн нээлттэй байдлыг хангах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцоог нэмэгдүүлэх, хөндөгдсөн эрхийг шүүхээр хамгаалах асуудлыг баталгаажуулах зорилготой.

2. Гэрээнд нэгдэн орох улс төр, эдийн засаг, нийгмийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Олон улсын гэрээнд оролцогч этгээдийн улс төр, эдийн засаг, нийгэм соёлын ашиг сонирхол тусгагдсан байдаг. Хэлэлцэн тохирогч этгээдүүдийн бүрэн тэгш, харилцан ашигтай байх, тэдгээрийн сайн дурын үндсэн дээр байгуулсан гэрээг орчин үеийн олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн тэгш эрхийн гэрээ гэж үзнэ.

Энэхүү шалгуур нь тухайн конвенцийн товч танилцуулга буюу шалгуур 1-ээс улбаалан МУ-ын нэгдэн орох шаардлагатай гэрээ конвенцоор сонгон судлах болсон чухал алхам байх зайлшгүй хүчин зүйл мөн. Аливаа конвенцид нэгдэн ороход дотоод гадаад хүчин зүйлүүдээр нөхцөлдсөн улс төр, эдийн засаг, нийгмийн үндэслэл байх бөгөөд тэдгээр үндэслэл бүрийг тусгайлан судлах шаардлагатай.

Жишээ: "Бүх цагаач ажилчин ба тэдний гэр бүлийг хамгаалах тухай

конвенц"-д нэгдэн ороогүй байгаагийн шалтгааныг тус гэрээнд манай улс нэгдэн орвол цагаач ажилчин олноороо ирснээр үндэсний аюулгүй байдалд харшилна гэж тайлбарладаг. Энэ нь тухайн конвенцийг зөвхөн гаднын цагаач ажилтнуудын эрх ашгийг хамгаалах мэтээр ойлгон үзэж, нэг талыг баримталсан хандлага юм. Гэтэл манай улс өөрөө гадаадад ажиллах хүч гаргагч улсын тоонд аль хэдийн багтах болсон. Түүгээр зогсохгүй гадаадаас ажиллах хүч олноор нь хүлээгээд авчихсан байгаа өнөөгийн тохиолдолд тус конвенцид нэгдэн ороогүйн улмаас зохицуулалтгүй харилцаа үүсээд байгаа юм.

3. Хууль зүйн үндэслэл (Үндсэн хууль болон бусад хуультай нийцэж буй эсэх)

2 дугаар шалгуур болох улс төр, эдийн засаг, нийгмийн үндэслэл, хэрэгцээ шаардлагад тулгуурлан сонгосон конвенц хууль зүйн хувьд үндэслэл бий эсэх асуудал хамгийн чухал шалгуур билээ. "Олон улсын гэрээ байгуулахад Монгол Улсын хувьд баримтлах онцгой зарчим бол Үндсэн хуулийн давуу байдал (примат)-ыг хангах явдал юм. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 4-т заасан "Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй" гэж заасан нь үүний баталгаа болдог."⁹

Олон улсын гэрээний тухай хуулийн 27 дугаар зүйлд олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хууль, хууль тогтоомжийн бусад актад хэрхэн нэмэлт, өөрчлөлт оруулах талаар заасныг Монгол Улс олон улсын олон талт гэрээнд нэгдэж ороход мөн холбогдуулан судлах ёстой.

Олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарлын талаархи онолын үүднээс авч үзвэл, эдгээр нь нэг салбар бөгөөд бүх эрх зүй нь нийтлэг нэг норматив шинжтэй гэж ойлгодог "монизм" гэсэн онолд манай улс хамаардаг. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн тодорхой заалт үүнийг батална. Иймд олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжид тусгах шаардлагагүй болж байгаа юм.

Гэвч зарим олон улсын олон талт гэрээнд дотоодын хууль тогтоомждоо тусгахыг шаардсан заалт байх ба тэдгээр нь голчлон хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хариуцлагатай холбоотой заалт байдаг.¹⁰ Тухайлбал, Монгол Улсын нэгдэн орсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг (Палермогийн) конвенцийн хөрөнгө албадан хураахтай холбоотой 12 дугаар зүйлд "оролцогч

⁹ "МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуульд шинжлэх ухаан, практикийн тайлбар хийх" судалгааны тайлан дахь доктор, профессор Б. Чимидийн тус хуульд хийсэн тайлбар. 2009 он.

¹⁰ Мөн судалгааны тайлан дахь докторант А.Төмөрийн тус хуульд хийсэн тайлбар. 2009 он.

улс бүр өөрийн дотоодын эрх зүйн тогтолцооны хүрээнд боломжийн хэрээр тусгаж батална” гэж заажээ. Ингэснээр энэхүү конвенцийг соёрхон батлахдаа Монгол Улсын Эрүүгийн болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

Тэгэхээр Үндсэн хуульд нийцэж байгааг судалж тогтоох нь тухайн гэрээнд нэгдэж орохыг тодорхойлох гол шалгуур, үндсэн зарчим байх бол бусад хуулийг хэрхэн нийцүүлэх асуудал бас чухалд тооцогдох учиртай. Үүнийг судалж тогтоох нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ ба үндэсний хууль тогтоомжийн зөрчилдөөний асуудал үүсэхгүй байх, үүсэхээр тохиолдлыг урьдаас мэдэж, ул суурьтай судалж, оновчтой зохицуулалт хийхэд суурь ач холбогдол оршино.

Жишээ: (Аархусын конвенцийн хувьд)

МУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”; 16 дугаар зүйлийн 12-т “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”; 16 дугаар зүйлийн 14-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...”, 16 дугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй...” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай Аархусын конвенц бүрэн нийцэж байгааг илтгэж байна. Түүнчлэн Үндсэн хуулиа сахин биелүүлж, иргэн бүр байгаль орчноо хамгаалах журамт үүргээ гүйцэтгэхэд ч тус конвенц чухал ач холбогдол өгнө. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалттай Аархусын конвенц нийцэж байгаа ба Үндсэн хуулийн дээрх заалтуудыг хэрэгжүүлэхэд тус конвенцид нэгдэх хэрэгцээ, шаардлага байгаа нь улам бүр харагдана.

Аливаа шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог хангах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх тодорхой механизмыг аль ч холбогдох хуульд суулгаагүй тул энэ эрх хэрэгждэггүй билээ. Байгаль орчны хохирлыг төр нэхэмжлэх зохицуулалттай ч ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалан нэхэмжлэл гаргадаггүй. Хувь хүн болон төрийн бус байгууллагад нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргах эрх

олгогдоогүй тул байгаль орчныг хамгаалах механизм, эрх зүйн орчин бүрдээгүй байна. Иймд байгаль орчны холбогдох хуулиудад энэ эрхийг сууриллуулж, хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

4. Гэрээнд нэгдэн орсноор үүсэх үр дагавар, ач холбогдол

Гэрээнд нэгдэн ороход авах арга хэмжээ өргөн юм. Энд хамгийн гол нь имплементаци хийх асуудал чухал. Өөрөөр хэлбэл хууль тогтоомжид суулгах асуудал. Энэ нь эргээд олон улсын эрх зүйн дагуу үүргээ биелүүлж байгааг илэрхийлэх болно. Иймд гэрээнд нэгдэн орохоос өмнө урьдчилаад нэгдэн орсноор үүсэх үр дагаврыг тооцоолоход судалгааны ач холбогдол оршино.

Гэрээнд нэгдэн орсноор үүсэх нөхцөл байдлууд олон талтай бөгөөд нэгдэн орох талаас судалж тогтооход үр дагавар нь голдуу ач холбогдолтой тал байх боловч гарч болзошгүй сөрөг үр дагаврыг бас илрүүлэхэд тустай байх болно. Жишээ: Дүрвэгсэдийн эрх зүйн байдлын тухай конвенцийг 2 удаа УАВЗ-өөр оруулаад хүлээж аваагүй. Шалтгаан нь нэгдэн орсноор үүсэх үр дагавар нь олон дүрвэгсдийг хүлээн авах үүрэгтэй болно, энэ нь үндэсний аюулгүй байдалд харшилж болзошгүй гэсэн байна. Гэхдээ үүнээс гадна тухайн конвенцид нэгдсэнээр манай улсад ач холбогдолтой тал бас үүсч болохыг үгүйсгэх аргагүй юм.

Жишээ: (НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдсэнээр) Энэхүү нэмэлт протоколд зааснаар хорих газарт шалгалт хийх явдал нь зөвхөн нөхцөл байдалтай өөрийн биеэр танилцаад зогсохгүй, шалгалт хийж байгаа мэргэжилтнүүдэд хоригдож байгаа этгээдтэй хэрхэн харьцаж байгаа мөн тэдгээрийг ямар орчин нөхцөлд хорьж байгаад үнэлэлт өгөх бололцоог олгодог. Хорих газарт шалтгалт хийх мэргэжилтнүүд нь шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх талаар зөвлөмж гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагуудтай илэрсэн алдаа дутагдлыг арилгахад туслалцаа үзүүлэх талаар хэлэлцээ өрнүүлж болдог.

МУ-ын тухайд энэ ажиллагааг явуулах үндэсний байгууллагуудын хэлбэр, статус, эрх хэмжээний асуудлыг бусад ойролцоо чиг үүрэг бүхий байгууллагаас (тухайлбал прокурорын байгууллагаас) ялгаж салгах болон хамтын ажиллагааг уялдуулах замаар оновчтой зөв шийдвэрлэх явдал бол энэхүү нэмэлт протоколд нэгдэн ороход зайлшгүй тулгарах асуудал мөн. ХЗҮХ-ийн ЭЗКСС-ын эрдэм шинжилгээний ажилтан Г. Оюунболд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протоколд МУ нэгдэн орох шаардлагатай эсэх талаар гаргасан санал¹¹-даа “Хүний эрхийн Үндэсний комиссын удаа дараа хийгдсэн шалгалтын дүнгээс үзэхэд эрүүдэн шүүх явдал хууль сахиулах байгууллагад амь бөхтэй,

¹¹ “МУ-ын нэгдэн ороогүй олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн судалгаа” сэдэвт судалгааны ажлын тайланд тусгагдсан санал. 2010 он.

нууц далд хэлбэртэй оршсоор байгаа нь бодитой бөгөөд үүнийг таслан зогсоохын тулд энэхүү нэмэлт протоколыг батлах хэрэгтэй юм. Харин хорих газруудад шалгалт хийх үндэсний байгууллагыг байгуулах тал дээр ... хуулийн байгууллагуудын тэр тусмаа прокурорын байгууллагаас гарч байсан саналаас үзэхэд "ажил үүргийн хуваарь давхардах, хийх ажилд нь нөлөөлөх магадлалтай, прокурорын бүрэн эрхийн нэг хэсгийг авч хэрэгжүүлэх гэж байна" гэсэн хандлага байсан бөгөөд үүнийг сайтар харгалзах хэрэгтэй байна" гэжээ.

Практик дээр "тус нэмэлт протоколд нэгдсэнээр манай улсын шоронгийн байдалтай олон улсын зүгээс танилцсанаар шоронгийн орчин нөхцөл муу гэдгээ таниулах талтай гэсэн болгоомжлол байгааг дурьдахад харамсалтай байна. Энэ нь нэгдэн орох асуудлын сөрөг тал биш харин ч эерэг тал буюу манай улсын тухайд, хорих, саатуулах газруудын орчин нөхцөл сайжрахад нөлөөлөх, дэмжлэг үзүүлэх хүчин зүйл болж чадах юм. Ингэснээрээ манай улсын хүний эрхийг хангах, хамгаалах талын орчин сайжирна.

5. Гэрээнд нэгдэн ороход гарах зардал, санхүүгийн асуудал

МУ-ын Олон улсын гэрээний тухай хуулийн 29 дүгээр зүйлд "Монгол Улсын Их Хурлаас олон улсын гэрээг соёрхон батлах, нэгдэж орох Засгийн газраас олон улсын гэрээг батлах шийдвэр гаргахдаа тухайн олон улсын гэрээг орчуулах, хэвлэхтэй холбогдсон зардлыг тухайн байгууллага хариуцан төсөвтөө тусган санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж байна" гэж заасан байдаг. Үүнээс харахад олон улсын гэрээг соёрхон батлах, нэгдэж ороход гарах зардал нь орчуулга болон хэвлэхтэй холбоотой зардлыг Олон улсын гэрээний тухай хуульд ийнхүү тусгажээ. Гэвч түүнээс өөр зардал гарахыг үгүйсгэхгүй юм.¹²

Олон улсын гэрээний тухай хуульд бусад зардлыг, ялангуяа аливаа гэрээнд нэгдэн ороход судалгаа хийх, түүнд зориулсан төсвийн талаар заагаагүй, зөвхөн гэрээний орчуулга, хэвлэн нийтлэх ажлын зардал төдийгөөр хязгаарласан байгаа нь өнөөдөр манай улс олон улсын гэрээнд нэгдэн орохдоо судалгаатай ханддаггүйн бас нэг шалтаг, шалтгаан гэж үзэж байна.

Түүнчлэн олон улсын гэрээ конвенцид нэгдэн орох асуудлаар хэлэлцсэн протоколуудыг судлан үзэхэд зардал, төсвийн асуудал, мөн гэрээ конвенцид нэгдэн орсноор төлөх татварын асуудлыг байнга асуусан байх боловч нарийн хариулт өгөөгүй нь харагддаг.

Мөн олон улсын гэрээнд нэгдэхэд өндөр хэмжээтэй татварын асуудал тулгардаг гэсэн ойлголт байдаг ба тэр нь буурай хөгжилтэй оронд дарамт болно гэсэн болгоомжлол бас анзаарагддаг. Гэвч

¹² МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуульд шинжлэх ухаан, практикийн тайлбар хийх судалгааны тайлан дахь докторант А.Төмөрийн тус хуульд хийсэн тайлбар. 2009 он.

хүний эрхийн конвенцийн хувьд ингэж ярих нь утгагүй юм. Олон улсын байгууллага, гэрээ конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай ЗГ-ын тогтоолоор улсын төсвөөс татварыг нь төлж байх олон улсын байгууллагын жагсаалт, улсын төсвөөс хандив төлөх олон улсын гэрээ конвенцийн итгэмжит сангийн жагсаалтыг тус тус хавсралтаар баталсан байна. Эдгээр жагсаалттай танилцахад Халимны менежментийн тухай олон улсын конвенцийн итгэмжит санд хандив төлдөг нь сонирхол татаж байгаа юм. Тэгэхээр хүний эрхийн аливаа гэрээ конвенцид нэгдэн ороход татварын асуудал саад болох учиргүй боловч судалж зохицуулахгүй байх үндэсгүй чухал зүйл мөн.

6. МУ-ын Гадаад Харилцааны Яамны баримталж буй чиглэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1-д Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна, Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэж заасан байдаг. Энхийг эрхэмлэсэн бодлого явуулах зарчим нь төрийн гадаад бодлого, тэр дундаа олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсийг илэрхийлж байгаа юм. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх явдлыг аливаа гадаад харилцаанд суурь зарчим болгон баримтална.¹³ Үндсэн хуулийн энэхүү үндэслэлийн дагуу МУ-ын Их хурал 1994 онд “МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг баталсан нь олон улсын гэрээний талаар баримтлах бодлогын үндэс билээ.

Гадаад харилцааны яам бол төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлж буй байгууллага учир тухайн конвенцид нэгдэн орох талаар ямар байр суурьтай хандаж байна, тухайн конвенцид нэгдэж ороогүйн шалтгаан эсвэл нэгдэж орох талаар ямар бодлого, чиглэлтэй ажиллаж байгааг тодруулж судалгааг баяжуулах, судалгааны үр дүнтэй харьцуулах зорилготой. Гэхдээ энэ нь өөрөө судалгааны ажил учир судалгааг бие даасан, хараат бус байдлаар явуулах зарчмыг баримтлах нь зүйтэй.

7. Бусад орны жишиг

Энэ нь тухайн конвенцид нэгдэн орсон, соёрхон баталсан, гарын үсэг зурсан болон нэгдээгүй байгаа улс орнуудын талаархи мэдээллийг агуулах бөгөөд МУ тухайн конвенцид нэгдэхдээ харгалзах шалгуурт тооцогдох, МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалд тусгагдсан зүйл

¹³ “МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуульд шинжлэх ухаан практикийн тайлбар хийх” судалгааны тайлан дахь доктор, профессор Б. Чимидийн тус хуульд хийсэн тайлбар, 2009 он

юм. Тус үзэл баримтлалд "Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь тус улс хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэн, бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мөн" гэж заасныг үндэс болгохын сацуу "Монгол Улс гадаад улс төрийн бодлогодоо энхийг эрхэмлэж, улс гүрэнтэй сөргөлдөхгүй байхыг аль болохоор чухалчилж, олон тулгуурт бодлого явуулна. Үндэснийхээ ашиг сонирхлыг ямагт дээдлэхийн хамт бусад улс, түншийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ. Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг шууд хөндөөгүй хөрш хоёр орныхоо маргаанд хөндлөнгөөс үл оролцоно...", "ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлднэ..." зэрэг улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ баримтлах чиглэлүүдийг ч харгалзах хэрэгтэй юм. Жишээлбэл, 2 хөрш орон тухайн конвенцид ямар байр сууринаас хандаж байна; "Бүх цагаач ажилчин ба тэдний гэр бүлийн эрхийг хамгаалах тухай конвенц"-ийн тухайд манай улсын иргэд олноороо цагаачлан ажиллаж амьдардаг БНСУ, АНУ гэсэн орнууд нэгдэж ороогүй байгаа тохиолдолд манай улс нэгдэж орох ашигтай эсэх маргаан өрнөж болох юм.

Нэмж хэлэхэд тухайн гэрээ конвенцид нэгдэж орсон улс орнуудын зөвхөн элсэлтийн тооноос гадна элсэж орсноос хойшхи гэрээний хэрэгжилтийн байдал, гарч буй зөрчлийн шийдвэрлэлт зэрэг практик туршлагыг судалж үзэх хэрэгтэй. Мөн бусад улс орнууд олон улсын гэрээ конвенцид нэгдэн орохдоо ямар шалгуураар харгалзан үздэг болохыг тухайлан судлах шаардлага бас анхаарал татаж байна.

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандахад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай санал

Энэхүү өгүүлэлд дурьдсан шалтгаан, нөхцөл байдлуудыг харгалзан олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандахад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тал дээр зарим саналыг дараахь байдлаар гаргаж байна. Үүнд:

1. 1993 оны Олон улсын гэрээний тухай хуулийг боловсронгуй болгох хүрээнд:

1) МУ-ын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасан Үндсэн

хуульдаа харшилсан олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй байх тухай заалтыг хангах зохицуулалтыг нарийвчлах;

2) Гэрээнд нэгдэхтэй холбоотой зардал, санхүүгийн асуудалд судалгаанд холбогдох зардлын талаар нэмж тусгах;

3) Хүчин төгөлдөр бус гэрээ буюу хүчингүйд тооцогдох(шудрага бус гэрээ) олон улсын гэрээ байгуулсан, байгуулахад хүргэсэн, нөлөөлсөн, урьдчилан сэргийлээгүй болон бусад хэлбэрээр алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох тухай заалт оруулах;

2. “Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль”-ийн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд:

1) Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөлд тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлох;

2) Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хялбаршуулсан, шуурхай байдлаар хийхийн тулд тухайн олон улсын гэрээнд нэгдэхтэй холбоотой судалгааг тодорхой шалгуур, аргачлалын дагуу чанартай хийж, хуулийн төсөлд хавсарга байдлаар танилцуулж байх зохицуулалтыг тусгах;

Тухайлбал, МУ-ын нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзан үзэх наад захын жишиг гэж үзэх шалгуурыг санал байдлаар гаргаж байна.

Монгол Улс нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзах шалгуур

1. Гэрээний албан ёсны нэр, монгол нэр, товч танилцуулга, батлагдсан огноо;

2. Гэрээнд нэгдэн орох улс төр, эдийн засаг, нийгмийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага;

3. Хууль зүйн үндэслэл (Үндсэн хууль болон бусад хуультай нийцэж буй эсэх);

4. Гэрээнд нэгдэн орсноор үүсэх үр дагавар, ач холбогдол;

5. Гэрээнд нэгдэн ороход гарах зардал, санхүүгийн асуудал;

6. МУ-ын Гадаад Харилцааны Яамны баримталж буй чиглэл;

7. Бусад орны жишиг.

Дүгнэлт


Энэхүү өгүүллээр, олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудалд анхаарлаа хандуулж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар зарим саналыг дурдсан

болно.

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудлыг хэрэгжүүлж ажиллавал :

- Олон улсын эрх зүйн зохицуулалтад амжилттай оролцох, олон улсын харилцаанд зөв алхам хийх;
- Улс төр, эдийн засаг, нийгмийн харилцаанд зөв бодлого боловсруулах, оновчтой шийдвэр гаргах;
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээ ба дотоодын хууль тогтоомжийн уялдаа, холбоог нийцүүлэх;
- Олон улсын гэрээг хэрэглэх, сургалт, сурталчилгаа явуулахад ашиглах эх сурвалж бэлтгэгдэх;
- Олон улсын гэрээг хэрэгжүүлэх, биелэлтийг шалгах, тайлагнах зэрэг шат шатны үйл ажиллагаанд харгалзан үзэх шинжлэх ухааны үндэстэй шалгуур үзүүлэлт бий болох;
- Олон улсын эрх зүйн үүргээ биелүүлэх зэрэг тал бүрийн ач холбогдлыг бий болгох болно.

ГАДААД ОРНУУД ДАХЬ ДОТООД ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДАЛ



ХЗҮХ-гийн Олон улсын
эрх зүйн секторын
эрдэм шинжилгээний
ажилтан Ж.Соёлмаа

Монгол Улсын хувьд дотоод худалдааны салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, жижиг, дунд үйлдвэрлэл хүчээ авч байгаа нь улс орны эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах үзүүлэлт юм. Гадаад хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсанаар удаж байгаа хэдий ч дотоодын худалдааны салбарыг зохицуулах тусгайлан хууль байхгүй нь дотоодын худалдаа эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэдний үйл ажиллагааг зохицуулах зайлшгүй шаардлагыг төрүүлж байна. “Дотоод худалдаа” хэмээх нэр томъёо бүхий Монгол Улсын 28 хууль байдаг хэдий ч тусгайлан цогц зохицуулалт шаардлагатай байна. Гадаадын олон орны хувьд дотоод худалдааг зохицуулсан тусгайлан хуультай бөгөөд ийнхүү орнуудын тус эрх зүйн зохицуулалтын нийтлэг болон давуу талуудыг

үзүүлэхийг эрмэлзэв.

Гадаадын зарим орны (Швейцари, Итали, Испани, Франци, Их Британи, Герман, Польш, АНУ, Бразил, Энэтхэг, Япон, Хятад, Солонгос г.м.) дотоод худалдааны эрх зүйн зохицуулалтыг судлан авч үзэхэд, төрийн их хэмжээний нөлөөлөл ажиглагдаж байна. Дотоод худалдааны эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд ижил төстэй олон зүйл байгаа нь харагдаж байна. Энэхүү зохицуулалт нь ихэвчлэн гурван үндсэн чиглэлтэй. Энэ нь:

- Худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд, тэдгээрийн зохион байгуулалтын хэлбэрт тавигдах шаардлага;
- Худалдааны үйл ажиллагаа эрхлэх нөхцөл байдал, дүрэм журамд тавих шаардлага;
- Хэрэглэгчдийн эрх ашиг, бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, шудрага бус өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг баримталж байгаа эсэх асуудлуудад тавигдах шаардлага зэрэг.

Олон улс оронд “худалдаа” хэмээх ойлголтыг өөр өөрөөр ойлгодог. Хэд хэдэн улсад дотоод худалдааны эрх зүйн зохицуулалтын зөвхөн бараа, бүтээгдэхүүн солилцох процессод хамааруулан авч зохицуулдаг байхад (Италид), харин зарим улс оронд (Швейцари, Солонгос) худалдаатай амарваа нэгэн байдлаар холбоотой бүхий л харилцааг зохицуулна.

Ихэнх улс оронд худалдааг бөөний болон жижиглэнгийн хэмээн ангилдаг. Тухайлбал, Италийн хууль тогтоомжоор бөөний худалдаа гэдэг нь дундын борлуулагч эсхүл мэргэжлийн хэрэглэгчдэд бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж, тэдгээр нь цаашид борлуулахыг ойлгоно. Харин Японд бөөний худалдаа гэдэг нь худалдах-худалдан авах гэрээний дагуу үйлдвэрлэгч нарын хооронд үүсэх харилцааг хэлнэ. Үүнтэй адилаар жижиглэнгийн худалдааны хувьд ч гэсэн шууд хэрэглэгчид хүрэх худалдаа, дамжин өнгөрөх худалдаа гэсэн байдлаар улс улсад өөр байдаг байна. Мөн зарим улсад бөөний болон жижиглэнгийн худалдааны ялгааг худалдагдаж буй бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээнээс хамаарч ялгаварладаг. Энэ тохиолдолд хуулиар жижиглэнгийн болон бөөний худалдааны тоо хэмжээг тогтоож, үүний дагуу ялгадаг байна.

Дийлэнх улс оронд бөөний худалдааны эрх зүйн зохицуулалтыг тусгайлан авч үзэж, тусгайлсан хууль байдаггүй бөгөөд ихэнхдээ худалдааны ерөнхий хуулиараа зохицуулалт хийдэг. Тухайлбал, Франц болон Германд бөөний худалдааг зөвхөн тусгайлсан байгууллагууд (махны, загасны, хүнсний ногооны тусгайлсан үйлдвэрүүд) хэрэгжүүлдэг байна.

Олон орны худалдааны хуулийг судлахад дараах ерөнхий зохицуулалтыг агуулсан байдаг. Тухайлбал:

- Худалдаа эрхлэгчийн улсын бүртгэлийн асуудал, худалдаа эрхлэгчийн зохион байгуулалтын хэлбэрийн талаар;

- Зарим төрлийн бараа, бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийн асуудал;

- Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага;
- Шудрага бус өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт;
- Төрийн эрх бүхий байгууллагын оролцоо, эрх үүрэг;
- Бараа, бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, гадаад шинж тэмдэг болон агуулгад тавигдах шаардлагууд;

- Худалдаа эрхлэгчийн эрх, үүрэг;
- Худалдаа эрхлэлттэй холбоотой газар, барилга байгууламжийн асуудал;

- Худалдан авагч, худалдагчийн хоорондын харилцаа, эрх ашгийн хамгаалалтын асуудал;

- Хариуцлагын асуудал.

Дээрх ерөнхий нийтлэг зохицуулалтаас нь зарим орны худалдааны зохицуулалтыг дараах байдлаар авч үзье.

1. Худалдааны төрөл, ангилал, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт

Байнгын бус буюу хөдөлгөөнт худалдаа эрхлэлтэд лангуу, яармаг

худалдаа зэрэг орно. Жишээ нь, Германд жижиг, дунд, том худалдаа эрхлэлтийг ялгаварлах ба энэ нь жилийн ашиг орлогын эргэлтээс хамаарч ангилна. Ийм байдлаар мөн бусад орнууд ч худалдаа эрхлэлтийг хувааж авч үздэг бөгөөд энэ нь, 1. маш том хэмжээний; 2. том хэмжээний; 3. дунд; 4. жижиг хэмжээний хэмээн ангилагддаг. Мөн тодорхой төрлийн бараагаар дагнасан дэлгүүр эсхүл “дискаунт” дэлгүүрүүд хэмээн ангилагддаг.

Дээр хэлсэнээр, Германд ашиг орлогын хэмжээгээр ангилдаг бол Францд тус худалдаа эрхлэгчдийг худалдаа эрхлэлтийн талбайн хэмжээгээр нь ангилдаг байна. Тухайлбал, маш том хэмжээний худалдаа эрхлэлтэд 2500 кв.м бүхий талбайтай дэлгүүрийг, том хэмжээний худалдаа эрхлэлтэд 400-2500 кв.м бүхий талбайтай дэлгүүрийг тус тус ангилна. Харин Италид том хэмжээний (2500 кв.м буюу түүнээс дээш хэмжээний талбайтай), дунд (250-2500 кв.м), жижиг (250 кв.м хүртэл) зэрэг ангилдаг.

Мөн олон орны худалдааны эрх зүйг судлахад худалдаа эрхлэлтийн төрлөөр нь ангилж болно. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улсад томоохон хэмжээний дэлгүүр, худалдааны төвүүдийг улсаас дэмжих бодлогыг баримталдаг. Харин Их Британий хувьд жижиг үйлдвэрлэгч нарыг дэмжих бодлого төрөөс хэрэгжүүлдэг, тухайлбал, амралтын өдрүүдэд бүтэн цагаар болон ажлын өдрүүдэд уртасгасан цагааражиллах эрхийг жижиг үйлдвэрлэгч нарт олгож, том дэлгүүр, худалдааны төвүүдэд ийнхүү эрхийг нь хязгаарладаг байна. Японд ч гэсэн жижиг үйлдвэрлэгч нарыг дэмжиж, том худалдааны субъектуудын хувьд маш хатуу шаардлагуудыг тавьдаг байна. Тухайлбал, хотын газар зүйн төлөвлөлтийг харгалзан томоохон худалдааны төвүүдийг хотын нягтрал ихтэй газруудад байрлахыг зөвшөөрдөггүй бөгөөд шинээр байгуулагдаж буй томоохон худалдааны төвүүд газрын зөвшөөрөл авах нь маш хэцүү байдаг байна. Энэ нь нэг талаасаа жижиг худалдаа эрхлэгчдэд давуу эрх олгож, нөгөө талаасаа оршин суугч ихтэй газарт томоохон худалдааны төв байгуулахыг зөвшөөрөхгүйгээр тэдгээрийн тайван амьдрал, олон хүний чимээ, шуугианаас хамгаалж буй явдал юм. Мөн томоохон худалдааны төвүүдэд зам зохицуулалт, автомашины зогсоолын асуудлыг шийдвэрлэсэн байх ёстой гэсэн шаардлага тавьсанаар худалдааны төвийн гадаа болон ойр орчимын замын түгжрэлээс урьдчилан сэргийлж байна. Японы Засгийн газрын баталсан журмын дагуу тусгайлсан төрийн байгууллага нь эдгээр худалдааны төвүүдэд тавигдах шаардлагыг биелүүлсэн эсэхийг нарийвчлан шалгаж, бүх талаас нь судалсны эцэст худалдааны төв барих зөвшөөрөл олгоно. Харин Германы хувьд жижиг, дунд үйлдвэрлэгч нарыг дэмжих үүднээс худалдааны салбарт жижиг, дунд үйлдвэрлэгч нарт зориулсан улсын сан бүхий санхүүгийн тусалцаа

үзүүлэх хөтөлбөр үйлчилдэг байна.

Франц, Англи, Италид гудамж, талбай, олон нийтийн газруудад худалдаа эрхлэхийг зөвшөөрч, үүнийг зохицуулсан хуультай. Эдгээр эрхлэгч нар нь тусгай зөвшөөрөл авч (бусад зөвшөөрлийг бодвол илүү хялбар процессоор дамждаг) худалдааны объект байгуулах шаардлаггүй байдгаараа хялбар байдаг.

II. Худалдаа эрхлэлтэд тавигдах шаардлага

Гадаад орнуудын эрх зүйг судлан авч үзэхэд хоёр чиглэл ажигдагдаж байна. Зарим оронд худалдааны үйл ажиллагаа эрхлэхийн тулд “зөвшөөрөл” улсын бүртгэлийн байгууллагаас авахаар хуульчилдаг байна. Ихэнхдээ энэхүү бүртгэлийг орон нутгийн өөрөө удирдах байгууллага хэрэгжүүлдэг байна. Жишээ нь, Италийн хуулиар томоохон хэмжээний худалдааны төв байгуулахын тулд хот зохион байгуулалт хариуцсан албанаас зөвшөөрөл авах шаардлагатай байна. Харин Их Британид ийм төрлийн зөвшөөрлийг зөвхөн орон нутгийн бус мөн төвийн байгууллагаас давхар зөвшөөрөл авахыг шаарддаг. Энэтхэгт мужийн эрх бүхий байгууллага худалдаа эрхлэх зөвшөөрлийг олгодог байна. Мөн тус худалдаа нь хэд хэдэн мужид байрладаг бол муж болгоноос зөвшөөрөл авах хэрэгтэй.

Худалдааны үйл ажиллагаа эрхлэх хоёр дахь чиглэл бол зарим оронд хэрэглэх “мэдүүлгийн арга”, өөрөөр хэлбэл, өмнөх чиглэлээр зөвшөөрөл авах хэрэгтэй бол энэ чиглэлийн дагуу төрийн эрх бүхий байгууллагад худалдааны үйл ажиллагааныхаа талаар холбогдох мэдээллийг өгөхөд болно. Энэ чиглэлийг Их Британи, Герман, Польш зэрэг улсад хэрэглэдэг. Германд мэдүүлгийн аргыг зарим төрлийн худалдаа эрхлэлтийн хувьд хэрэглэдэг бол Польшид зарим төрлийн бараа, бүтээгдэхүүн (дэлбэрэх бодис, буу, цэргийн хэрэгсэлүүд, эрчим хүч, түлш зэргийн худалдаа)-ий хувьд тусгай зөвшөөрөл авч, бусад тохиолдолд мэдүүлэхэд хангалттай байдаг. Их Британид согтууруулах ундааны жижиглэнгийн худалдаа, баар, цэнгээний газруудыг согтууруулах ундаагаар хангахад тусгай зөвшөөрөл авах ёстой. Энэтхэгт мах, согтууруулах ундаа, эм, гоо сайхны бүтээгдэхүүн, үнэртэн худалдаалахын тулд тус бараа болгоноор тусад нь тусгай зөвшөөрөл авах ёстой.

Худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй субъектуудад тавигдах шаардлагуудыг тоймлон авч үзэхэд:

1. Бөөний худалдааны субъектуудад тусгайлсан зохицуулалт байхгүй. Францад бөөний худалдааг хуулийн этгээдийн адилаар хувь этгээдүүд ч эрхлэх эрхтэй;

2. Жижиглэнгийн худалдааны субъектуудад мөн тусгайлсан

зохицуулалт байхгүй. Солонгост бизнес-ID буюу худалдаа эрхлэгчийн хувийн бүртгэлийн дугаартай байх ёстой байдаг бол Италид ял шийтгэлгүй, дампуурлын хэрэгт холбогдож байгаагүй хэн боловч худалдаа эрхлэх эрхтэй;

3. Худалдаа эрхэлж буй этгээдүүдэд тавигдах (жишээ нь, нас, хүйс, боловсролын хэмжээ) шаардлагууд байхгүй.

Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлого явуулж буй Хятад улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалт бүхий худалдааны байгууллагуудад хязгаарлалт тавьж, үндэсний үйлдвэрлэл, борлуулалтыг зэрэг эрхэлдэг үндэсний үйлдвэрлэгчид хүчээ авч байна.

III. Худалдааны салбар дахь хэрэглэгчдийн эрх, ашгийг хамгаалах асуудал

Олон орны хуулиар худалдааны салбар дахь хэрэглэгчдийн эрх, ашгийг хамгаалах асуудалд чухал ач холбогдол өгдөг төдийгүй ихэнхдээ тусгайлсан хуультай байдаг. Энэ салбарт дараах хуулиуд нийтлэг байдаг:

- Хэрэглэгчдийн эрх, ашгийг хамгаалах тухай хууль тогтоомж;
- Шудрага бус өрсөлдөөн, монопольт эрхийг таслан зогсоох хууль тогтоомж;
- Барааны тэмдэгтэй холбоотой хууль тогтоомж;
- Зарим төрлийн барааны худалдаанд тавигдах онцгой шаардлагууд

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар худалдагч, худалдан авагчийн хоорондын харицлаа, худалдах-худалдан авах тухай гэрээний нөхцөлүүд, бараа, бүтээгдэхүүний чанар, шаардлага, хариуцлага хүлээлгэх асуудал зэргийг хуульчилдаг.

Шудрага бус өрсөлдөөн, монопольт эрхийг таслан зогсоох хууль тогтоомж нь хөгжингүй, хөгжилтэй орнуудад өөр өөрөөр байх ба өөрийн орны онцлогоос шалтгаалан монопольт эрхт худалдааны байгууллагыг хүлээн зөвшөөрөх, таслан зогсоох гэсэн хандлагууд ажиглагддаг.

Энэтхэгт зайлшгүй хэрэглээний бараа, бүтээгдэхүүн болох 14 төрлийн нэр төрлийн бараа: будаа, гурил, вандуй, цай, элсэн чихэр, давс, төмс, сонгино, ургамалын тос, сүү болон бусад барааны тээвэрлэлт, хувиарлалт болон үнэд улсаас зохицуулалт хийдэг байна.

Зарим оронд (Итали, Герман) хямдарсан үнээр буюу хямдралтайгаар (sale) худалдаа эрхлэхийг тусгайлан зохицуулж, энэ тохиолдолд бараа, бүтээгдэхүүний чанарын доголдолд хяналт тавьдаг.

Дээрх зохицуулалтаас үзэхэд, худалдааны салбар бол нарийвчлан зохицуулах тусгайлсан хуультай байх зайлшгүй хэрэгцээтэй салбар

юм. Ингэснээр дотоод худалдааны салбарыг дэмжиж, энэхүү салбарт үйл ажиллагаа явуулж буй худалдаа эрхлэгчид, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж, худалдааны нэр төрлийн ангилалтыг явуулж, улмаар тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулж, мөн худалдааны салбар дахь төрийн оролцооны түвшинг тодорхойлох шаардлагатай.

ХҮҮЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ТАРИФ ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ БОЛОХ НЬ

Өнөөдөр дэлхий дахинд олон улсын хамтын ажиллагаа нийгмийн бүхий л салбарыг хамран, цаашид улам бүр гүнзгийрэн хөгжиж байгаа билээ. Манай улсын хувьд ч энэхүү үйл явц маш эрчимтэй явагдаж байна. Тухайлбал, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хувьд Монгол Улс 1990-ээд оноос өмнө зөвхөн социалист гэгдэх цөөн тооны улс оронтой хамтран ажилладаг байсан бол өнөөдөр дэлхийн аль ч улс оронтой худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа явуулах эрх нь нээлттэй болжээ.

Дээрх сэдвийн хүрээнд юуны түрүүнд олон улсын эрх зүйн ойлголтын талаар авч үзье.

ОУЭЗ-н зохицуулах зүйл нь ОУЭЗ-н субъектуудын хоорондын харилцаа болон Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын харилцаа, түүнтэй холбоотой бусад харилцаа байдаг. ОУЭЗ-н тогтолцоог нийтийн ба хувийн эрх зүйд хуваарилдаг. Энэ нь нийтийн бодон хувийн ашиг сонирхолыг гол болгосонтой холбоотой юм. Субъектуудын хоорондын харилцаа нь талуудын эрх тэгш байдалд үндэслэж байвал хувийн эрх зүй, харин төр түүний байгууллагаас бусад субъекттэй захирах захирагдах зарчмын дагуу ажиллаж байвал нийтийн эрх зүй болно гэж үздэг онол бий.

Тэгэхээр ОУХЭЗ нь нийтийн эрх зүйгээсээ хэрхэн ялгархыг авч үзэх хэрэгтэй болж байна.

Олон улсын хувийн эрх зүй гэдгийг гадаадын элемент оролцсон иргэний эрх зүйн хэргийг зохицуулж буй хэм хэмжээг бүхэлд нь ойлгож болох бөгөөд энэ утгаараа ЗЭЗ нь ОУХЭЗ-н нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж байгаа юм.¹

Хувийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараахь онцлог шинжүүд ажиглагдаж байдаг. Үүнд:

- Диспозитив хэм хэмжээ голлодог;
- Субъектуудын хүсэл зоригийн илэрхийлэл нээлттэй байдаг;
- Харилцаанд оролцогчид хийсэн үйлдлийнхээ төлөө өөрсдөө хариуцлага хүлээдэг;
- Шүүхийн хамгаалалтаар баталгаажсан байдаг;
- Амин хувийн эрх ашгийг хангах хандлагатай байдаг.



ХЗҮХ-гийн Олон улсын
эрх зүйн секторын
эрдэм шинжилгээний
ажилтан Г.Халиунаа

¹ Т. Мэндсайхан. "Олон улсын хувийн эрх зүйн үндэс". УБ. 2002он.

Ихэнх эрдэмтэн, судлаач олон улсын гэрээг олон улсын хувийн эрх зүйн эх сурвалж мөн гэж үздэг.

ОУНЭЗ болон ОУХЭЗ хоёр нь хоорондоо нягт уялдаа холбоотой юм. Энэ хоёр эрх зүйн системийн хэм хэмжээ нь адил нэгэн зорилгод үйлчилдэг байна. Тэр нь янз бүрийн салбарт олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн орчинг төлөвшүүлж хөгжүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, аливаа нэг улсаас гадаад тал дахь нэг буюу түүнээс дээш улстай харилцах харилцааг зохицуулах үүрэгтэй.

Эдгээр эрх зүйн уялдаа нь юуны өмнө олон улсын гэрээгээр тогтоосон журам нь анхлан томъёолон тодорхойлогдсон хэм хэмжээний хувьд олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээ болж төлөвшсөний дараа дотоодын хууль тогтоомжид шилжүүлэн буулгасан хэм хэмжээний утгаар илэрдэг.

Үүнээс үзвэл ОУХЭЗ-н хэм хэмжээний үндэс нь дотоодын эрх зүйн хэм хэмжээ байдаг нь тодорхой байна.

ОУХЭЗ ба ОУНЭЗ хоёрын хоорондын нягт уялдаа, ялангуяа олон улсын эдийн засгийн харилцааны салбарт тод илэрч байна. Худалданы гэрээ, санхүү, татварын хэлэлцээр нь гадаад эдийн засаг, худалдааны талаар улс хоорондын харилцан хүлээх үүргийг тогтоодог. Эдгээрийн үндсэн дээр байгуулсан гадаад худалдааны хэлэлцээр бараа тээвэрлэх, хүлээн авах, төлбөр хийх зэрэг ажиллагаанд иргэний эрх зүйн харилцаа үүсдэг. Улс хоорондын худалдааны гэрээг зөрчвөл олон улсын нийтийн эрх зүйн дагуу Засгийн газрын хэмжээнд яригдаж, цаашид дипломат шугамаар эсэргүүцэл илэрхийлж, хариу арга хэмжээ авах бололцоотой болдог.

Тэгвэл хуулийн этгээдийн хооронд байгуулсан гэрээ, хэлцлийг зөрчих нь иргэний эрх зүйтэй холбоотой учраас түүнээс үүдэн гарах гомдлыг холбогдох улсын шүүхээс, эсвэл арбитраар шийдвэрлүүлдэг нь ОУХЭЗ арга хэрэгсэл болж байгаа юм.

Дээрхээс дүгнэвэл ОУНЭЗ ба ОУХЭЗ нь тус тусдаа зохицуулах зүйл, арга, харилцаатай онцлог систем боловч хоорондоо нягт уялдаатай, бие биенээсээ харилцан хамааралтай үзэгдэл мөн болох нь харагдаж байна.

Дэлхий даяаршиж байгаа өнөө үед улс хоорондын харилцаа улам бүр нарийсаж байгаа бөгөөд үүний дотор худалдаатай холбоотой хамтын ажиллагаа нь илүү өргөн цар хүрээг хамарч байгаа билээ.

Дээр дурдсанчлан хуулийн этгээдийн хооронд хийгдэж байгаа харилцаа нь иргэний эрх зүйн хэм хэмжээ байдаг учраас олон улсын худалдааны салбарын хэм хэмжээг ОУХЭЗ хэм хэмжээнд хамруулан ойлгож болох юм.

Ингээд олон улсын худалдаанд хэрэглэгдэж буй ТХЕХ-ийн тухай товч дурдъя:

ТХЕХ олон улсын худалдааны эрх зүйн эх сурвалж болох нь:

Олон улсын худалдааг өргөжүүлэн гаалийн тарифын хэмжээг харилцан бууруулахын тулд 23 орон 1947 оны 10 дугаар сард "Тарифын Худалдааны Ерөнхий Хэлэлцээр"-т (GATT) гарын үсэг зурсан байна. Энэхүү хэлэлцээр анх "түр зуурын" хэмээн зурагдсан авч, 1948-1994 оны хооронд олон улсын худалдааны ерөнхий эрх зүйн хүрээг тодорхойлж байсан. GATT нь доорхи 4 дүрэмд үндэслэн байгуулагдсан. Үүнд:

1. Үндэсний нэн тааламжтай нөхцөл буюу тэгш эрх (Most Favoured Nation Clause, Non-discrimination). Энэ нөхцөл нь гишүүн орнуудын хоорондох ялгаварлан гадуурхах асуудлыг арилгах зорилго агуулсан. Энэ дүрмийн дагуу гишүүн орон нь бусад ямар нэгэн оронд худалдааны тааламжтай нөхцөл байдлыг бий болгон өгсөн бол GATT-ын бусад гишүүн орнуудад ижил нөхцөлийг олгох ёстой;

2. Үндэсний харьцаа (National Treatment). Үндэсний харьцааны дүрэм нь дотоодын зах зээлийн худалдааны хууль дүрмүүд дотоодын бүтээгдэхүүн болон импортын бүтээгдэхүүн аль алинд адилхан үйлчлэх ёстойг тусгасан байна. Энэ дүрэм нь бараа, үйлчилгээ ба оюуны өмчийг улсын хилээр нэвтрэн зах зээлд орсны дараа үйлчилнэ. Тийм болохоор энэхүү дүрэмд гаалийн татвар хамаарахгүй;

3. Гаалийн татваруудыг бууруулан тогтворжуулах. GATT-ын хүрээнд хамгийн түрүүнд гаалийн татваруудыг бууруулахаар хэлэлцээрийг дэс нбайна. Гишүүн орон бүрт доорх гаалийн татварын хэмжээг нээсн эс илүү гар галгүйгээр (bound rates) гаалийн татвараа тогтоох ёстой;

4. Гаалийн тарифаар хамгаалах. Худалдаанд дотоодын зах зээлийг хамгаалах хамгийн нилт дарга бол гаалийн тарифаар хамгаалах явдал юм. GATT-ын хүрээнд тарифын бус ихэнх худалдааг хязгарлах хууль дүрэмг аргахыг гишүүн орнуудад хориглодог.

Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн агуулга (ТХЕХ-1994)

Олон улсын худалдааны гааль тарифын асуудлыг зохицуулдаг олон улсын байгууллага болох ТХЕХ нь 1947 онд Женевт байгуулагдсан. ТХЕХ нь түүнд оролцогч улс орнуудын хооронд хийх худалдаанд удирдлага болгох зарчим, хэм хэмжээ, дүрэм журмыг агуулсан олон талт хэлэлцээр юм. Энэхүү хэлэлцээр нь 4 бүлэг, 38 зүйл, хавсралтаас (A-I) бүрдэнэ. ТХЕХ нь:

- Өөрийн боловсруулж гаргасан хэлэлцээрүүдийн биелэлтэд хяналт тавих;

- ОУХ-ны чухал асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах;

- ОУХ-ны эрх зүйн үндсийг тавихтай холбоотой шийдвэр гаргадаг худалдааны асуудал хариуцсан ОУ-ын байгууллага юм.

ТХЕХ-ийн ерөнхий нөхцөл, хэм хэмжээг дараах байдлаар

тодорхойлсон. Үүнд:

1. Бараа үйлчилгээг улс орны гарал үүсэл, үндэсний нөхцөлөөр ялгаварлан гадуурхахгүй байх;

2. Үндэсний зах зээлийг хамгаалах зорилгоор тоон хязгаарлалт болон түүнтэй адил арга хэмжээ авахгүй байх;

3. Гишүүн орнуудын зах зээлд нийлүүлэх бараа үйлчилгээг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор харилцан худалдааны буулт хийх;

4. Худалдаанд гарсан маргааныг зөвлөлдөх, хэлэлцээ хийх замаар шийдвэрлэх.

Брөнхий нөхцөлд:

1. Гишүүн орнуудад “үндэсний нэн тааламжтай нөхцөл” олгох тухай заалт нь худалдааны эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхах явдлыг хаах үндсэн заалт болно. Импортын бараанд дотоодын үйлдвэрлэлийн бараанд олгодогтоос дутуугүй нөхцөл олгож байх нь үндэсний нөхцөлд хамаарна;

2. ТХЕХ-ийн 11 дүгээр зүйлд заасны дагуу гишүүн орнууд нь зөвхөн гаалийн татвар хураамжаар зохицуулах үүрэгтэй бусад хориг хязгаарлалтыг хэрэглэж болохгүй бөгөөд хэрэглэсэн тохиолдолд энэ нь түр хугацааны шинжтэй байна.

ТХЕХ-ийн зарчим нь:

1. Худалдаанд тааламжтай нөхцөл үзүүлэх;

2. Олон талт хэлэлцээрийн үндсэн дээр гаалийн татварыг бууруулах;

3. ОУХ-ны хөгжлийн дунд шудрага өрсөлдөөнийг хамгаалах;

4 Үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифийн аргаар хамгаалах;

5. Хөгжиж байгаа орнуудад хөнгөлөлттэй тариф үзүүлэх.

ТХЕХ нь өөрийн гишүүн орнуудын гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой асуудлаар олон талт уулзалт, раундууд явуулж байсан бөгөөд ДХБ байгуулах хүртэл 8 раунд хуралджээ.

ГАТТ-ын хүрээнд хийгдсэн хэлэлцээнүүд:

Жил	Хэлэлцээ	Хэлэлцээний гол асуудлууд	Орнуудын тоо
1947	Женев	Гаалийн тариф	23
1949	Аннеси	Гаалийн тариф	13
1951	Торквей	Гаалийн тариф	38
1956	Женев	Гаалийн тариф	26
1960-1961	Диллоны хэлэлцээ	Гаалийн тариф	26
1964-1967	Кенедиын хэлэлцээ	Гаалийн тариф болон анти дампингийн хэмжээ	62
1973-1979	Токио хэлэлцээ	Гаалийн тариф, тарифын бус хязгаарлалт, “бүтцийн” хэлэлцээрүүд	102

1986-1994	Урагвайн хэлэлцээ	Гаалийн тариф, тарифын бус хязгаарлалт, худалдааны дүрмүүд, үйлчилгээ, оюуныөмч, арбитрын асуудал, ойдол, сүлжмэл, хөдөө аж ахуй, ДХБ-ыг байгуулах гэх мэт	123
2001-	Д о х а г и й н хэлэлцээ	Хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбар, үйлчилгээ, оюуны өмч	

Эдгээр хуралдаанаар ихэнхдээ гаалийн тарифыг бууруулах асуудлыг авч хэлэлцэж байжээ.

ТХЕХ-ээс:

- Гаалийн зорилгоор барааг үнэлэх хэлэлцээр;
- Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр;
- Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрүүдийг баталсан.

Токиогийн хуралдаанаар:

- Тарифын бус зохицуулалтад хамаарах импортын лицензийн дүрэм;
- Техникийн хориг саадын тухай дүрэм зэргийг баталсан.

“Гаалийн зорилгоор барааг үнэлэх хэлэлцээр”-ийг боловсруулж 1981 оноос хүчин төгөлдөр болсон. Энэхүү хэлэлцээрт гаалийн татвар ногдуулах үнийг тухайн барааг худалдсан хэлцлийн бодит үнээр тогтоохыг заасан байдаг. Мөн бусад нэмэлт зардлыг энэхүү бодит үнээр нэмэх асуудлыг хэлэлцээрт оролцогч улс орнууд өөрсдөө шийдвэрлэхээр тогтоосон байдаг. Гаалийн үнэлгээний хэлэлцээрийн зорилго нь:

1. Гаалийн зорилгоор барааг үнэлэх нэгдмэл, шударга, дундыг барьсан тогтолцоог бүрдүүлэх;
2. Хэлцлийн үнэ нь гаалийн үнийг тогтоогч анхдагч суурь болох;
3. Гаалийн үнэ нь арилжааны практиктай нийцсэн хялбар, ижил шалгуурт тулгуурласан байх;
4. Үнэлгээний журмыг демпингтэй тэмцэх хэрэгсэл болгохгүй байх зорилготой байдаг.

Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр:

Демпингийн арга хэмжээг дотоодын ердийн үнээс бага үнээр худалдсан импортын бараанд хэрэглэдэг. Демпингийн татварын хэмжээ нь ердийн болон жинхэнэ экспортлосон үнийн хоорондын ялгаанаас хэтэрч болохгүй бөгөөд үүнийг демпингийн хэмжээ гэдэг.

Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр:

Импортын лицензийн дүрэмд Лиценз олгох журам нь худалдаанд

саад тотгор учруулах ёсгүй бөгөөд лиценз олгоход шинэ экспортлогчоос авахуулаад үндэсний лиценз хүсэгчдэд адил нөхцөл олговол зохино гэж заасан байдаг. Мөн лицензийн дүрэм журам нь товч, шударга байж, түүнийг бүх талуудад шударга хэрэглэх лицензийг хууль тогтоомжийн шаардлага хангасан аливаа пүүс, байгууллага, этгээдэд олгох, лицензийн холбогдолтой дүрэм журам, мэдээллийг хэвлэн нийтэлж өргөн олонд хүртээл болгох ёстой байдаг.

Импортын лиценз нь тодорхой хугацаанд тоон хязгаарлалт тогтоох эсвэл тоо хэмжээ, үнийн дүн заасан тодорхой бараа оруулахад хязгаарлалт тавихад чиглэгддэг. (1жил)

Экспортын лицензийг тодорхой нэрийн барааны экспортыг хянах, барааны урсгалыг статистик бүртгэлд хамруулах зорилгоор олгодог.

Лицензийг олон улсын худалдаанд хоёр зорилгоор хэрэглэдэг. Үүнд:

1. Эдийн засагтай хамааралгүй эсвэл хөндлөнгийн хамааралтайгаар үндэсний сонирхлыг хамгаалах;

2. Дотоодын зах зээлийг экспорт ба импортын зохисгүй байдлаас хамгаалах мөн импортын хүсээгүй хэмжээг түр хугацаагаар хязгаарлах зорилгоор хатуу хяналт тавих замаар хэрэгжүүлдэг түр арга хэмжээ юм.

Лицензийн хэлбэр нь:

1. Байнгын;

2. Нэг удаагийн гэсэн үндсэн хоёр хэлбэрийг өргөнөөр хэрэглэж байна.

- Байнгын лиценз нь нэр бүхий орноос тодорхой тоо хэмжээ, үнийн дүн бүхий бараа импортлох эрх бүхий пүүс, этгээдүүдэд олгосон байнгын зөвшөөрөл юм.

- Нэг удаагийн лиценз нь тодорхой нэг эсвэл 2-3 нэрийн (барааны нэг группт хамаарах) барааны нэг удаагийн хэлцэлд олгодог нэг удаагийн зөвшөөрөл юм. Энэ зөвшөөрөлд бараа хүлээн авагч, тоо хэмжээ, өртөг, гарал үүслийн орны талаарх мэдээллийг бичсэн байдаг. Бусдад дамжуулж болохгүй. 1 хүртэл жилийн хүчинтэй байдаг.

Шууд лиценз нь бараа худалдан авагч нь лиценз хүссэн өргөдлийг өгснөөр шууд зөвшөөрөл олгогддог, үйл ажиллагааг хялбаршуулсан онцлогтой юм.

Шууд бус лиценз нь барааны тооны хязгаарлалт урьдчилан тогтоогоогүй нөхцөлд импортлогчийг хязгаарлах зорилгоор хэрэглэдэг.

Техникийн хориг саадын тухай дүрэм:

Худалдаан дахь техникийн саад тотгор гэдэг нь стандарт, чанартай холбоотой хэмжил зүйн систем, барааны гэрчилгээ, баглаа боодол,

маркларлын дүрэм, барааны талаарх мэдээллийг агуулсан түүнийг дагалдах бичиг баримт зэрэг техникийн бодлогын томоохон бүлэг арга хэмжээг багтаадаг. Эдгээр нь олон улсын худалдаанд саад учруулах ёсгүй байдаг.

Хэлэлцээрт оролцогчид стандарт, техникийн үзүүлэлтийн хэм хэмжээг олон улсын стандарт, техникийн үзүүлэлт, хэм хэмжээн дээр үндэслэн боловсруулах үүрэгтэй байдаг.

Дээрхээс дүгнэж үзвэл гадаад худалдаанд оролцож байгаа улс орнууд харилцан ашигтай хоорондоо ижил түвшинд оролцох сонирхолтой байдаг ба энэ харилцааг зохицуулахын тулд энэхүү ТХЕХ нь гадаад худалдааны үндсэн эх сурвалж болж өгдөг байна.

Аливаа худалдааны үйл ажиллагаа нь иргэний эрх зүйтэй шууд холбогдож иргэний эрх зүйн субъектууд болох иргэн, хуулийн этгээдүүдийн хооронд үүсэж өөрчлөгдөж дуусгавар болж байдаг учраас улс орнуудын хооронд ч мөн адил хийгддэг гадаад худалдаа нь эдгээр субъектуудын хооронд хийгддэг гэж үзэж болох юм.

Иймээс харилцаанд оролцогч субъектуудынхаа хувьд ч зохицуулалтынхаа хувьд ч олон улсын худалдаатай холбоотой үйл ажиллагаа нь ОУХЭЗ-н хэм хэмжээ болж байна.

“ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ОНЦ ХҮНД ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ”

ХЗҮХ-ийн судалгааны тайлан

Судалгааны зорилго: Монгол Улсын Хил хамгаалах байгууллагад гарч буй гэмт явдал, түүний дотор хүнд, онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан дүгнэж, офицер, ахлагч, цэргийн хугацаат албан хаагчийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хилийн отряд, заставт зохион байгуулах талаар санал, зөвлөмж, богино, дунд хугацааны хөтөлбөр боловсруулах

Судалгааны хамрах хүрээ: Судалгааны ажлыг хил хамгаалах байгууллагын хэмжээнд сүүлийн 10 жилд гарсан хүнд, онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг цэргийн болон харуулын алба хаахтай холбогдсон дүрэм, бусад журмын биелэлтийн байдалтай уялдуулан авч үзэв.

Судалгааны хугацаа, зохион байгуулалт: Судалгааны баримт материалыг цуглуулах, шинжлэн судлах, хил хамгаалах байгууллагын анхан шатны нэгжид очиж хилийн алба хаагчидтай уулзаж ярилцах зэрэг судалгааны үндсэн ажлыг 2010 оны 1 дүгээр сарын 18-наас 4 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хийв. Удирдамжид заасан зарим ажил, тухайлбал: хүнд, онц хүнд гэмт хэргийг шалгаж шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн материалыг Улсын Ерөнхий прокурорын архиваас авч судлах зэрэг ажил судалгааны багаас үл хамаарах шалтгаанаар төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх боломжгүй байв.¹


Судалгааны баг: ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрлэхгч Ж.Энхнасан удирдаж, эрдэм шинжилгээний ажилтан докторант Г.Оюунболд, Г.Батчимэг, Хил хамгаалах ерөнхий газрын Улсын хил судлалын секторын судлаач, хошууч Н.Даваадорж нар хийж гүйцэтгэв.

**Нэг. Монгол Улс дахь гэмт явдлын өнөөгийн байдал
(товч мэдээлэл)**

Монгол Улсад сүүлийн 10 жилд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг тогтмол өсч, нийт хэрэгт эзлэх хувийн жин нь нэмэгдэхийн зэрэгцээ гэмт хэргийн улмаас болон золгүй байдлаар нас барах, амиа хорлох явдал буурахгүй байна. ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын 2008-2009 онд хийсэн судалгаануудын


¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторт төвлөрүүлэн, баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн бөгөөд сэтгэл зүйчийг татан оролцуулж зарим аймаг, нийслэлийн дүүргийн цэргийн штаб, Хил хамгаалах байгууллагад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн ялтуудтай ШШГЕГ-ын харьяа 409. 427 дугаар ангид уулзаж, ярилцлагын судалгаа хийв.

дүнгээс үзвэл хүн амын ядуурал, архидалт, ажилгүйдэл, тэдгээрийг тойрсон нийгмийн бухимдал, төрийн байгууллагыг хэрсэн хүнд суртал, авилга, салан задгай байдал зэрэг улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан олон асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа нь нийгэмд хүч хэрэглэсэн гэмт хэрэг өсөх гол шалтгаан болсоор байна. Энэ байдлыг Монгол Улсад гарч буй гэмт хэргийн статистик тоо баримтаар илэрхийлэн харуулбал:



Хүснэгт № 1. Монгол Улсын хэмжээнд 2000-2009 онуудад бүртгэгдсэн гэмт хэргээс үзэх эд ерөнхийдөө буурах хандлага


ажиглагдаж байна.



2009 онд Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн 20373 гэмт хэргийн 1.1 хувь нь хүнийг санаатай алах, 28.3 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 1.6 хувь нь хүчиндэх, 31.2 хувь нь хулгайлах, 0.8 хувь нь булаах, 3.7 хувь нь дээрэмдэх, 3.9 хувь нь залилан мэхэлж авах, 1.7 хувь нь бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, 7.0 хувь нь танхайрах, 4.9 хувь нь тээврийн

хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэг тус тус эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас нас барсан хүмүүсийн тоон үзүүлэлтийг авч үзвэл:



Дээрх үзүүлэлтээс харвал гэмт хэргийн улмаас амь насаа алдаж байгаа хохирогчдын тоо буурч байгаа мэт харагдавч “Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг” тогтвортойгоор өсөх хандлага ажиглагдаж байна. Энэхүү статистик үзүүлэлтэд харгалзах бас нэг зүйл бол тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын улмаас амь насаа алдсан хүмүүсийн тоо багтаж байгааг анхаарна уу.

Төрийн тусгай албан хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг:

2009 онд Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн мэдээнээс² үзвэл Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдал, тагнуул, цагдаагийн байгууллагын офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн 292 алба хаагч гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны дотор цагдаагийн байгууллагын 148, зэвсэгт хүчний 44, онцгой байдлын албаны 31, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 29, хилийн цэргийн 25, дотоодын цэргийн 10, тагнуулын 5 алба хаагч байна. Үүнд:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт 128, (үүнээс бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах хэрэгт 121, хүнийг санаатай алах хэрэгт 5, бусдыг болгоомжгүй алах, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэгт тус бүр 1);

- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт 36, (үүнээс хулгайлах хэрэгт 15, завших, үрэгдүүлэх хэрэгт 7, залилан мэхэлж авах хэрэгт 6, булаах хэрэгт 3, дээрэмдэх болон хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших хэрэгт тус бүр 2);

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт 29, (үүнээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэгт 22, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй, зугтаах хэрэгт 7);

- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 26, (үүнээс танхайрах хэрэгт 24, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар олж авах хэрэгт 2);

- Албан тушаалын хэрэгт 25, (Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах хэрэгт 15, Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх хэрэгт 3, хээл хахууль авах хэрэгт 3, хээл хахууль өгөх, албан үүрэгтээ хайнга хандах хэрэгт тус бүр 2);

- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт 4, (үүнээс хүчиндэх хэрэгт 3, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах хэрэгт 1);

- Шүүн таслах ажиллагааны эсрэг хэрэгт 17, Цэргийн алба хаах журмын эсрэг хэрэгт 19, Захиргааны журмын эсрэг хэрэгт 4, Хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэгт 2, Эд зүйлийг хууль бусаар хил

² Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл, дүн шинжилгээний төвөөс гаргасан “2009 оны гэмт хэргийн байдал” албан хэрэгцээнд зориулсан мэдээнээс.

нэвтрүүлэх, Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх хэрэгт тус бүр 1 алба хаагч холбогдон шалгагдсан байна.

Үүнээс үзвэл төрийн тусгай алба хаагчид, түүний дотор офицер, ахлагч, гэрээт болон цэргийн хугацаат алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна. Тэр тусмаа хүч хэрэглэсэн гэмт хэргийг илүүтэй үйлдэж, бусдын бие махбодид гэмтэл учруулах, амь насыг нь хохироох гэмт хэрэг буурах төлөвгүй байна.

Дүгнэлт: Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг хууль болон дүрмээр хатуу тогтоосон дэг журмаар зохион байгуулах хэдий ч тус байгууллага, түүний нийт алба хаагч нь монголын нийгмийн нэгээхэн хэсэг болохын хувьд тухайн нийгэмд бодитой оршиж буй гэмт явдал, сөрөг үзэгдлийн нөлөөнөөс ангид байх боломжгүйг анхааралдаа авч, дээрх сөрөг үзэгдлийн нөлөө, тааламжгүй үр дагаврыг хязгаарлахад чиглэсэн цогц бодлого, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байх шаардлагатай.

Хоёр. Хил хамгаалах байгууллагад гарсан гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн бүртгэл судалгаа

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд сүүлийн арван жилд гарсан гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн тухай судалгаа үзвэл:

- 1999-2009 онд бусдын амь насыг бүрэлгэсэн хэргийн судалгаа;
- Хилийн цэргийн хэмжээнд 1993-2009 онд гарсан хүний амь нас, эрүүл, мэндийг хохироосон гэмт хэргийн судалгаа (отряд-анги);
- Хил хамгаалах байгууллагын хэмжээнд гарсан ноцтой гэмт хэргийн судалгаа (2000-2009он);
- Хэрэг ослын мөрөөр дээд байгууллагаас томилсон ажлын хэсгийн шалгалтын танилцуулга, схем болон фото зураг, эрүүгийн хэргийн материалаас хуулбарласан гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг зэргийг эмхтгэсэн хавтас материал 11, “нотломж”, “илтгэх хуудас” зэргийн хамт.

Ирүүлсэн дээрх мэдээ материал нь хилийн отряд, заставт цэргийн албан хаагчдын үйлдсэн хүнд, онц хүнд гэмт хэрэг (бусдыг галт зэвсэг хэрэглэн санаатайгаар алсан, хүнд гэмтэл учруулсан зэрэг)-үүд, түүнчлэн хүний амь нас хохирсон золгүй учрал, ослын тохиолдлыг шалгасан тухай илтгэх хуудас, тайлан зэрэг захиргааны шалгалтын материал, цэргийн алба хааж байхдаа бусдад зодуулж, улмаар бэртэж гэмтсэн тухай цэргээс халагдсан хойноо гаргасан гомдол, эмчилгээний зардал олгохыг хүссэн өргөдөл, аймгуудын цэргийн штабтай харьцсан албан бичгүүд, эдгээрт тулгуурлан хил хамгаалах байгууллагын

судалгааны нэгж, судлаачийн гаргасан ноцтой хэрэг, учралын тухай судалгаа зэргээс бүрдэж байв.

Гэмт хэргийн тухай нэгдсэн мэдээг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрч, Цагдаагийн ерөнхий газраас улсын хэмжээнд нэгтгэн гаргадаг гэмт хэргийн бүртгэл мэдээний жишгийн дагуу Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүлэг, зүйлээр, мөн гэмт хэрэг гарсан анги байгууллага (отряд, застав, газар орны онцлог)-аар гэхчлэн гаргаж ирүүлээгүй учраас сүүлийн 10 жилд хил хамгаалах байгууллагад ямар төрлийн, хэдэн хэрэг, хаана гарсан, түүний өсөлт, бууралт, шалтгаан нөхцөлийн динамик ямар болохыг бүрэн судлах боломжгүй байв (судалгааны багийн ажилласан хилийн отряд, заставуудад гэмт хэргийн бүртгэл мэдээ мөн байгаагүй). Түүнчлэн нэгэнт гарсан хэргийг шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага эцэслэн хянан хэлэлцэж гаргасан шийдвэрүүд байхгүй учраас хэргийн шалтгаан нөхцөлийн талаар дээрх эрх бүхий байгууллагууд ямар дүгнэлт хийсэн нь тодорхой бус байна.

Иймд ХХЕГ-аас ирүүлсэн гэмт хэргийн түүвэр судалгааны материалын хэмжээнд, тэдгээрийг голчлон ашиглаж сүүлийн 10 жилд гарсан гэмт хэргийн тоог тоймлон гаргав.

Үүнд: Сүүлийн 10 жилийн хугацаанд нийт 15 онц хүнд буюу хилчид нэг нэгнийхээ амь насыг хөнөөсөн гэмт хэрэг гарчээ. Эдгээр хэргүүдэд хүнд гэмтэл учруулсан хэргүүдийг оруулаагүй болно. Уг 15 гэмт хэрэг үйлдэгчдийг цол, албан тушаалаар нь ангилвал нийт 15 байлдагч буюу хугацаат цэргийн алба хаагчид, ахлагч 3, үүнээс харуулын дарга 2, жолооч 1, дэслэгч 1, заставын сургалт эрхэлсэн орлогч, хурандаа 1, отрядын дарга, хохирогчийн албан тушаал, цолоор ангилвал хугацаат цэргийн албан хаагч 4, гэрээт цэргийн албан хаагч 3, дэд хурандаа 1, ар талын дарга, ахлагч 8, харуулын дарга, заставын дарга хошууч 1, отрядын албаны дарга ахмад 1, заставын орлогч, дэслэгч 1, энгийн ажилчин 1 байна.

Дээрх 15 гэмт хэргийн улмаас нийт 22 хүний амь нас хохирч 4 хүн хүнд гэмтсэн байна. Судалгаанаас ажиглахад 15 хүнд гэмт хэргийн 8 нь хилийн харуулд, 4 нь заставт, 3 нь отрядын төвд үйлдэгджээ.

Мөн эдгээр гэмт хэргийн 9 нь захирах захирагдах ёсыг зөрчсөн зүй бус харьцаанаас, 2 нь цэрэгт ирэхийн өмнө хулгайн болон танхайн хэргээр ял шийтгүүлж байсан хугацаат цэргийн алба хаагчдаас, 3 нь архидалтаас, нэгийг нь шалтгааныг хууль хяналтын байгууллага хараахан тогтоогоогүй байна. Захирах захирагдах ёсыг зөрчсөн хүнлэг бус харьцаанаас үүдэн гарсан хэргүүд нь голчлон хилийн харуул дээр хугацаат цэргийн албан хаагч харуулын дарга нарын хооронд гарсан байна

Дүгнэлт: Хилийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан,

нөхцөлийг судлан тогтоох, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байх зорилгоор хил хамгаалах байгууллагын хэмжээнд нэгдсэн журмаар хөтлөх гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн анхан шатны бүртгэл мэдээний тогтолцоо үгүйлэгдэж байна. Байгууллагын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, сахилгын зөрчлийг үнэн зөв бүртгэж тооцогүйгээр түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх боломжгүй юм.

2.1. Эрүүгийн хэргийн материалд хийсэн судалгаа

Хил хамгаалах байгууллагад гарсан буюу хилийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн нэгдсэн бүртгэл судалгаа байхгүй, түүнчлэн эрүүгийн хэргийн талаар шүүх, прокурор зэрэг эрх зүйн байгууллагын эцэслэн гаргасан шийдвэр, тухайлбал: шүүхийн шийтгэх тогтоол, прокурорын яллах дүгнэлт, эсхүл эрүүгийн хэргийг хэргэсэхгүй болгосон тогтоол, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн тухай мэдэгдэл зэрэг эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны албан ёсны баримт бичгүүдийг нэхэж бүрдүүлээгүй зэргээс хилийн алба хаагчид холбогдох хэргийн талаархи шийдвэрийг олж судлахад ихээхэн хүндрэлтэй байв.

Иймд, судалгааны тойм мэдээг үндэслэн Дорноговь, Дорнод, Хөвсгөл, Увс зэрэг аймгийн шүүхэд зарим хэргийн талаар лавлагаа ирүүлэхийг хүсч хандсан боловч ажлын ачаалаас шалтгаалан судалгааны багийн хүсэлтийг хангах боломжгүй болохоо шүүх хариу мэдэгдсэн ба харин Ерөнхий прокурорын газрын эрүүгийн хэргийн архивт хадгалагдаж байгаа Б.Г, Л.Д, Н.Т нарт холбогдох эрүүгийн 3 хэргийн материалыг ихээхэн хөөцөлдөж байж олж судлав.

ХЭРЭГ 1. Гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөл: Хэрэг гарах болсон гол нөхцөл нь цэргийн анги байрлалд гадны хүн оруулж, “дарга, цэрэггүй хамт архи дан согтуурч” албаны дотоод дэг журмыг ноцтой зөрчсөнөөс үүдэлтэй байна. Түүнээс гадна хохирогч (заставын дарга)*-Б-гийн захирагдаж буй алба хаагчидтайгаа дүрмийн бус байдлаар байнга харьцаж, эрх чөлөөнд нь удаа дараа халдаж, олон удаа гэмт хэрэг үйлдсэн байхад түүнд эрүүгийн хариуцлага ногдуулахын оронд сахилгын арга хэмжээ авсан төдийгөөр хязгаарлан өнгөрүүлж, ял завшуулж байсан нь хэрэг гарахад нөлөөлжээ. Түүнчлэн заставын бие бүрэлдүүний ар гэрийнхний дунд ахуйн шинжтэй ужигрсан хэрүүл маргаан нь гэмт хэрэг гарах өөр нэг шалтаг болсон байна.

Энэхүү хэргийг шалгах явцад хилийн хориотой бүсэд малчин айл байлгах (айлд архи дан согтуурах явдал олонтаа гардаг), нутгийн иргэдээс цэргийн албанд улируулахдаа олигтой шилж сонгодоггүй зэрэг зөрчил, дутагдал илэрсэн байна.

ХЭРЭГ 2. Гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөл 2: Архивт байгаа

эрүүгийн хэргийн материалаас үзэхэд энэ гэмт хэрэг гарах болсон үндсэн шалтгаан цэргийн алба хаагчдын хоорондын зүй бус харилцаа байжээ. Ялангуяа хилийн харуулд гарах үед заставын удирдлагын хараа хяналт суларч, харуулын даргалах алба хаагч буюу түрүүч, ахлагч нараас цэргийн хугацаат алба хаагчдыг цохиж зодох, хэл амаар доромжлох явдал байнга гардаг байжээ.

Гэтэл анги байгуулагаас гаргасан тодорхойлолт, хилийн албаны шалгалтын материал зэрэгт хэрэг гарах болсон шалтгааныг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн алба хаагчийн хувийн зан чанар, зүй бус харьцаанаас үүдсэн мэтээр өрөөсгөл дүгнэлт хийжээ.

Хавтаст хэргийн болон хилийн албаны шалгалтын материалд харьцуулан дүгнэлт хийхэд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаархи төсөөлөл илт зөрүүтэй байна. Отрядын бэлтгэл заставт байсан цэргийн хугацаат алба хаагчид хилийн заставт хуваарилагдан ирэхдээ сэтгэл зүйн бэлтгэлгүй, ямар нэг байдлаар “дарамт-дэглэлт” амсана гэсэн хүлээлттэй байдаг болох нь сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгээс тодорхой байна.

Анги байгууллага харуулын даргалах бүрэлдэхүүнийг томилохдоо тэдгээрийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагын талаар сайтар ойлгуулж чадахгүй байна.

Энэ хэргийн материалаас хилийн цэргийн албанд хэрэглэж буй зэвсэг хэрэгсэл, ахуйдаа өдөр тутам хэрэглэдэг эд зүйлсэд алба хаагчид хайр гамгүй хандаж, эвдэж хэмхлэх, бусдад худалдах, үргэдүүлэх зэргээр ашиглан шамшигдуулах явдал цөөн бус гардаг атал дарга нараас тэр бүрд нь тохирсон арга хэмжээ буруутай этгээдэд ногдуулдаггүй болох нь ажиглагдлаа.

ХЭРЭГ 3. Гэмт гарсан шалтгаан, нөхцөл: Энэ хэрэг ХХЕГ-аас ирүүлсэн онц хүнд хэргийн судалгаанд байхгүй байна. Магадгүй хувийн таарамжгүй харьцаанаас шалтгаалсан иргэд хоорондын гэж үзсэн учраас оруулаагүй байж болох ч гэмт хэрэг үйлдэгч, хохирогч нь хоёул хилийн цэргийн алба хаагч, тодруулбал, нэг нь албаны жолооч, нөгөө нь хилийн цэргийн офицер байв.

Хавтаст хэрэгт авагдсан баримтаас үзэхэд хувь хүмүүсийн хоорондын гэмээр үйл ойлголцлоос үүдэлтэй маргаанаас шалтгаалсан тохиолдлын шинжтэй хэрэг мэт боловч хэрэг гарахад нөлөөлсөн дараахь хүчин зүйлийг анхаарахгүй байж болохгүй байна.

Нэгдүгээрт, зарим офицерын бусадтай дэндүү бүдүүлэг, дээрэнгүй харьцдаг явдал, хоёрдугаарт, архи дан согтуурах явдал. Түүнчлэн жолооч-ахлагч, энгийн жолооч зэрэг бага тушаалын бие бүрэлдэхүүнийг албаны болон хүмүүжил, ёс зүйн чиглэлтэй бусад сургалтад хамруулж байх шаардлагатай болох нь хэргийн материалаас тодорхой байв.

2.2. Санал асуулгын судалгаа

Удирдамжийн дагуу ХХЕГ-ын харъяа зарим анги салбарт анкетийн болон санал асуулгын судалгаа хийв. Үүнд: Монгол Улсын хойд хил дээр үүрэг гүйцэтгэж буй хоёр отряд (0101, 0243 дугаар анги)-ын нийт 251 алба хаагчаас анкетийн судалгаа, өмнөд хил дээр үүрэг гүйцэтгэж буй мөн хоёр отряд (0108, 0168 дугаар анги)-ын нийт 144 алба хаагчаас анкетийн болон санал асуулгын судалгаа авчээ. Судалгаанд оролцсон алба хаагчид алба, ажил үүрэг гүйцэтгэх үед тулгарч буй бэрхшээл, захирах, захирагдах ёс журмын биелэлт, илэрч буй зөрчлийн хэлбэр, түүний шалтгааны талаарх асуултад хариулт өгчээ.

Анкетийн судалгааны үндсэн асуултын нэг нь хилийн цэргийн алба хаагчдын дунд “зүй бус харилцаа” буюу захирах, захирагдах ёсыг зөрчих явдал ямар түвшинд байгааг тодруулах явдал байв. Санал асуулгын болон анкетийн судалгаагаар³ дээрх зөрчил “гөдийлөн их бус” гэсэн агуулгатай хариу гарсан байх бөгөөд энэ нь бодит байдалд хэр нийцэж буй нь эргэлзээтэй. Учир нь судалгаанд оролцсон цэргийн хугацаат алба хаагч болон гэрээт алба хаагчид илүү “хаалттай” буюу “гадагш нь” мэдээлэл өгөх дургүй байдал ажиглагдав.

1. Ажил үүргээ гүйцэтгэхэд тохиолдож буй бэрхшээл гэсэн асуултад 8% нь “ар гэрийн”, 40% нь “төсөв-санхүүгийн”, 43% нь “цалин хангамжийн”, 10% нь “удирдлагын арга барилын” гэж хариулсан байна.

2. Таны ажиллаж буй ангид зөрчил, маргаан хэр гардаг вэ? гэсэн асуултад 50% нь “зөрчил, маргаан гардаггүй”, 40% нь “бага” гэж хариулсан байна.

3. Зөрчил ихэвчлэн ямар хүмүүсийн хооронд гардаг вэ? гэсэн асуултад “энгийн ажилчдын дунд”, “энгийн ажилчид, офицеруудын хооронд”, “ахлагч нар офицеруудын хооронд”, “цэргийн хугацаат алба хаагч, ахлагч нарын хооронд” гэж хариулснаас үзвэл бүхий л бие бүрэлдэхүүн ямар нэг байдлаар зөрчил, маргаанд татагдан орж байдаг ажээ. Мөн дээрх хариултаас офицерууд хоорондоо, цэргийн хугацаат алба хаагчид хоорондоо зөрчилд бага ордог гэсэн дүгнэлт хийж болохоор, өөрөөр хэлбэл захирагдах ямар нэг хамааралтай хүмүүсийн хооронд ихэвчлэн зөрчил үүсч байдаг ажээ.

4. Та цэргийн албанд байх хугацаандаа сахилгын зөрчил гаргаж шийтгүүлж байсан уу? гэдэгт 80% нь “үгүй” гэж хариулсан байна.

5. Зөрчил, маргаан үүсгэж буй шалтаг, шалтгааныг 100 хувь гэж үзвэл, судалгаанд оролцогсдын үзэж буйгаар дор дурдсан шалтаг шалтгаанаар хэрүүл маргаан үүсч, улмаар хэрэг зөрчил болон даамжирдаг ажээ. Үүнд:

- Хувийн асуудал 10%;
- Үл ойлголцол 33%;

³ Хавсралт 1-ээс үзэх

- Санхүү 16%;
- Хэт ачаалал 8%;
- Үүргийн тэгш бус хуваарилалт 7%;
- Удирдлагын буруу арга барил 10%;
- Шударга бус үнэлгээ 8%;
- Матаас, хов жив 5%;
- Нэгдсэн ойлголт, мэдээлэлтэй байдаггүй 3%.

6. Хил хамгаалах байгууллагад гарч буй ноцтой гэмт хэргүүдэд та ямар дүгнэлт хийх вэ? гэсэн асуултад:

- Цэргийн хугацаат албанд ирэгсдийн талаар цагдаагийн байгууллагаас тодорхойлолт авдаггүй;
- Цэргийн албан хаагчдын хоорондын харилцаанд цэргийн дүрмийг хатуу баримталдаггүй;
- Цэргийн албан хаагчдын сэтгэл зүйг бүрэн судалж чаддаггүй;
- Ажил үүргийн хуваарийг зөв зохицуулж, ажлын хэт ачааллыг багасгах, ахуйн хангалтыг сайжруулах;
- Удирдлагын тогтолцоог сайжруулах, хүнтэй ажиллах арга барил эзэмшээгүй;
- Харуулын даргын бүрэлдэхүүний боловсрол бага, мэдлэг сул, тэдгээрийг сонгон шалгаруулдаггүй;
- Удирдлагын буруу үйл ажиллагаанаас. Энэ нь дарга нарын харьцааны соёл сул, хувийн сонирхол ихтэй, захирагдагсдын ажлыг шударга дүгнэж чаддаггүй;
- Манааны тохироог сайн тохируулж чадаагүйгээс;
- Хүнд суртал, нээлттэй бус байдлаас;
- Хамт олонч үзлийг төлөвшүүлээгүйгээс;
- Нэгэн хэвийн хэвшмэл бугшмал байдлаас;
- Танил тал, ах дүүс нэг дор олноор ажиллаж байгаагаас шат дараалсан хариуцлага тооцох боломжгүй болдог;
- Сүүлийн үеийн залуус сэтгэлийн тэнхээ муу, хэт мөрөөдөмтгий, тэвчээргүй, сэтгэл зүйн бэлтгэл дутмаг, шантрамтгай, үг даадаггүй, зан араншингийн хувьд буруу төлөвшсөн, бусдыг хүндлэх чанаргүй, хувийн зохион байгуулалт муу, хэнэггүй;
- Цэргийн албанд ирэхээс өмнө эрхэлж байсан ажил, сонирхож байсан зүйл (рс тоглоом, кино);
- Офицер, ахлагчдын нийгмийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй, тэдгээрийн сэтгэл зүйн тогтворгүй байдлаас;
- Ерөнхий газрын удирдлагын арга барилаас (тушаал, бусад шийдвэрийн биелэлтэд хяналт тавьдаггүй) гэхчлэн хариулсныг анхаарч үзэх шаардлагатай.

2.3. Цэргийн штабын дарга нартай хийсэн ярилцлагын болон

санал асуулгын судалгаа

Жил бүрийн цэргийн ээлжит татлагаар Зэвсэгт хүчин, дотоодын цэрэгт боловсрол, хүмүүжил сайтай цэргийн үүрэгтнийг шилж хуваарилаад үлдсэнийг нь хил хамгаалах байгууллагад хуваарилдаг гэх шүүмжлэлийн дагуу энэхүү судалгааг Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг, Дорноговь аймгийн цэргийн штабын ажилтнуудын дунд явуулав.

Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цэргийн штабын дарга хурандаа Готовдорж, дэд хурандаа Ц.Эрдэнэбаатар нар: “цэргийн алба хаахаар татагдан ирсэн залуусыг цэргийн штабаас хуваарилахдаа зөвхөн тэдний өөрсдийнх нь хүсэл сонирхлыг харгалзан үздэг. Түүнээс ямарваа нэгэн байдлаар хилийн цэрэгт үлдсэн хэдийг нь тогтоосон тоонд нь өгнө гэх ч юм у эсвэл зэвсэгт хүчин арай дөнгүүрийг нь шилээд авна гэсэн зүйл байхгүй. Харин ч хилийн цэрэг алба хаахаар гайгүй гэсэн залуус нь саналаа өгч явдаг. Шаардлагатай гэвэл манайд татагдан ирсэн хүмүүсийн материалыг үзүүлж болно” гэсний дагуу цэрэг татлагын материалтай танилцахад боловсролын түвшин доогуур, эсхүл өөр бусад байдлаар тааруу гэхээр хүмүүсийг хил хамгаалах албанд ялган хуваарилсан гэх зүйл илэрсэнгүй.

Цэргийн штабын дарга нар цааш нь ярихдаа:

- Цэргийн байгууллага нь өөрөө дарамтын байгууллага. Идэж уух, хэвтэж амрах, унтах, ажиллах нь бүгд нарийн цагийн хуваарьтай. Үүнийг цэргүүд дарамт гэж ойлгодог. Учир нь дуртай цагт босч, дуртай зүйлээ хийж болдог нарийн зохион байгуулсан ажлын хуваарь байдаггүй орчноосоо цагийн хуваарь, тусгай журмаар амьдардаг орчинд ирэхээр дасан зохицож чадахгүй нэг хэсэг цаг хугацааны дарамтанд ордог. Иймд дамжин өнгөрүүлэх сургалтын бааз дээр тэдгээрийн сэтгэл зүйн бэлтгэлд анхаарах нь зүйтэй;

- Хилийн цэргийнхэн хүнтэйгээ ажиллаж чаддаггүй. Хилчин дайчид шат дараалсан олон даргатай. Гэрээт цэрэг, ахлагч нар нь боловсролын хувьд дэндүү сул. Зэвсэгт хүчин ахлагч нараа БХИС дээр 3 жилийн сургалтад хамруулж бэлтгэдэг байхад хилчид тухайн орон нутгаас улируулаад томилчихдог;

- Цэргийн штабын дарга, ХХЕГ-ын хооронд ажлын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй байна. Цэргийн штабын дарга нарын дунд хилийн застав, харуулын байр, хилийн зурвасыг үзээгүй хүн олон бий, тэдгээр нь хилийн цэргийнхний амьдралыг сайн мэдэхгүй;

- Цэрэг татлагын сонгон шалгаруулалт. Үнэндээ ирж байгаа цэргүүдийг л хуваарилдаг. Тийм шилмэл цэрэг авах бол оюутнуудыг цэрэгт татдаг байх хэрэгтэй. Оюутнуудыг цэргийн албанаас чөлөөлөх хуулийн зохицуулалтыг хүчингүй болговол цэрэгт боловсролтой, сайн хүмүүс илүү ихээр явах болно.

2.4. Хорих ял эдэлж буй ялтнуудтай хийсэн ярилцлагын судалгаа

Хилийн цэрэгт алба хааж байх үедээ гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн 11 ялтнаас Улаанбаатар хотын ойролцоо ял эдэлж байгаа 3 ялтантай уулзав. Тэднээс гэмт хэрэг үйлдэх болсон шатгаан, нөхцөлийн талаар асууж, харилцан ярилцав.

ШШГЕГ-ын харъяа 407 дугаар анги буюу Тоосгоны хорих ангид Өмнөговь аймгийн хилийн заставт алба хааж байх үедээ бусдын амь насыг санаатайгаар хөнөөсөн гэмт хэрэг үйлдсэн Тэ, ТҮ нартай өөрсдийнх нь үйлдсэн хэргийн талаар ярилцахад өөр өөр шалтгаан хэлж байсан ба тухайн үедээ хугацаат цэргийн албан хаагч байсан Б.Т нь ахлагчаа унтаж байхад нь толгой руу нь алхаар дохиж хөнөөсөн хэрэгт холбогджээ. Тэрбээр цэрэгт татагдан ирээд удаагүй байхдаа (14 хоног болоогүй байсан) дээрх гэмт хэргийг үйлдсэн бөгөөд өөртэй нь “нэг бус удаа таарамжгүй харьцаж шинэ цэргийг сургаж өгнө гэж бусадтай нийлэн хэлж байсан. Үүнд нь дургүй хүрээд унтаж байхад нь цохисон” гэж байв. Тухайн үедээ авсан дарамт шахалт, зодуур, дэглэлт зэрэг байсан уу гэхэд “Тийм зүйл байгаагүй” хэмээн хариулж “Жаахан дургүй хүрээд хүнд дээрэлхүүлээд баймааргүй санагдсан учраас дээрхи хэргийг үйлдсэн” гэв.

Харин ахлагч полтой алба хааж байсан Тэ нь яг харуулын пост руу явах гэж байх үедээ Заставын даргаа гэдсэн тус газар нь буудан хөнөөсөн хэргийг үйлджээ. Тухайн үед гаднаас ирсэн хуучин хамт алба хааж байсан ахлагчтай хамт архи уун даргатайгаа муудалцаж улмаар харилцан зодолдож гарч зугтаасан байна. Түүний ярьснаас үзвэл заставын дарга нь бусадтай зүй бус харьцдаг, зоддог нэгэн байсан бөгөөд хэрэг гарахын өмнөхөн хугацаат цэргийн алба хаагчдыг зодож хэд хэдэн шүдийг хугалсан авч үүндээ ямар нэг хариуцлага хүлээгээгүй, заставын бие бүрэлдэхүүн түүнээс их эмээдэг байжээ.

Тэ-тэй ярилцах явцад заставын анги байранд гадны хүнтэй ирж архи уусан, даргатайгаа маргасан зэрэг зүй бус үйлдэл байгаа боловч шууд захирах даргын дүрмийн бус харилцаа хамгийн ихээр нөлөөлсөн нь илэрхий байв. Түүнчлэн ял эдэлж байгаа хоригдол онцгойлон дурдахдаа “Газар орны онцлог их шалтгаалдаг. Ер нь манай застав ч гэлтгүй бусад заставт заримдаа ноцтой хэрэг давтамжтай гардаг. Нэн ялангуяа цэрэг халагдах, татагдах үеэр цэргүүдийн сэтгэл санаа ч гэсэн сонин болдог” гэж ярьсныг цаашид анхаарууштай.

Хил хамгаалах байгууллагын алба хаагчидтай хийсэн ярилцлагын судалгааны үеэр ахмад хилчид энэхүү судалгааг явуулахдаа зарим газар орны онцлог хүний сэтгэл зүйд хэрхэн, яаж нөлөөлдөг, гэмт хэрэг гарах давтамжийн магадлал зэргийг судлахыг санал болгож байсныг энэхүү судалгааны явцад хэрэгжүүлэх боломжгүй байв.

2.5. Хилийн цэргийн алба хаагчдын сахилгын зөрчил

Хил хамгаалах албаны офицер, ахлагч, түрүүч, байлдагчийн дүрмээр тогтоосон дэг журмын зөрчил буюу сахилгын зөрчлийн бүртгэлийг нэгдсэн журмаар хөтөлдөггүй байна. Гэтэл сүүлийн жилүүдэд гарсан хүнд, онц хүнд гэмт хэргийн дийлэнх нь сахилгын зөрчлөөс үүдэлтэй болохыг урьд хийсэн болон энэ удаагийн судалгааны дүнгээс олж үзэж болно. Ер нь хүний амь настай холбоотой л бол хэрэг зөрчлийг бүртгээд бусдыг нь тэгэхийгээд орхидог буруу арга барил хил хамгаалах байгууллагад тогтсон гэж дүгнэхээр байна.

Хил хамгаалах байгууллагад гарч байгаа дүрмийн бус харилцаа, сахилгын бусад зөрчлийн талаархи бүртгэл мэдээлэл хангалтгүй, хэрэг зөрчил нь нуугдмал байдгаас шалтгаалан хүнд, онц хүнд гэмт хэрэг үүдэн гарах нөхцөл, шалтгааныг үндэслэлтэй, бүрэн тогтоож чадахгүй байна. Аливаа ноцтой гэмт хэрэг ялимгүй зөрчлөөс үүдэн гарах нь маш элбэг тул тэрхүү зөрчлийн нөхцөл байдлыг судлаж, буруутанд зохих цээрлэл хүлээлгэж байх нь гэмт хэрэг гарахгүй байх нэг гол нөхцөл болно. Сахилгын хэрэг зөрчлийн талаар туршлагатай хилчидтэй санал солилцоход:

Энэ салбарт гарч байгаа зөрчил, гэмт хэргийг ерөөсөө хэдхэн зүйл дээр тогтож анхаарах хэрэгтэй⁴ байна.

• Тухайн гэмт хэрэг, зөрчил цэргийн албаны аль цаг, минутад гарсан гэдгийг тогтоох нь ихээхэн ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл алба хаах үедээ харуулд гарахын өмнө үү, хойно уу, эсхүл харуул дээр алба хааж байхдаа юу, заставын байранд уу, амралт чөлөөт цагийн үед үү, шөнө оройн цагаар гэмт хэрэг, зөрчил их гаргаж байна уу гэдгийг нарийвчлан тогтоох нь тухайн цаг үед авах арга хэмжээг зөв сонгох, тийм үед сургалт хүмүүжлийн арга хэмжээг зөв зохион байгуулах ач холбогдолтой төдийгүй тухайн тэр үед нь завгүй байлгах, ажил үүргийг нь зөв хувиарлах гэх мэт янз бүрийн арга хэрэглэн хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж чадах юм;

• Цэргийн алба хаагчид алба хааж байх үедээ албаны бэлтгэл, аж ахуйн ажил, цэргийн бэлтгэл гэх мэт өдөр тутмын зүйлсээс илүү ар гэрийнхэнтэйгээ байнга холбоотой байх нь тэдний хэт их анхаарал халамжид автах, эсхүл гэр бүлд учирсан бэрхшээлийг мэдсэнээр стресст орох, уурлаж бухимдах, улмаар цэргийн албанаас шантрах бэрхшээх, оргох, амиа хорлох, гэмт хэрэг үйлдэх гэх мэт сөрөг үр дагаварт хүргэж байна.

⁴ Хурандаа Д.Дамдин (ХЗДХЯ-ны мэргэжилтэн)-тай хийсэн ярилцлагаас

PS: Сүүлийн үед цэргийн алба хааж байх үедээ амиа хорлох явдал өсөх хандлагатай байна. Сэтгэцийн гэм судлаачид “Хүн амиа хорлох нь сэтгэл гутралын хамгийн эцсийн үе шат (депресс) бөгөөд энэ шат хүртлээ хүн тодорхой үе шатыг дамждаг” гэжээ Тиймээс зөвхөн амиа хорлох талаас нь биш онц хүнд гэмт хэрэг үйлдэж болох байсан тэр эрсдэлийг ч гэсэн харах хэрэгтэй юм. Тухайлбал, хүний сэтгэл зүйн янз бүрийн темпераментээс хамааран зарим нь амиа хорлох тухай боддог байхад нөгөө хэсэг нь ямар нэг байдлаар түүнийгээ гадагш гаргадаг байна. Амиа хорлох болсон шалтгааныг бодитойгоор тогтоож, нэг удаа болоод өнгөрсөн хэрэг явдал мэтээр орхигдуулахгүй байх хэрэгтэй”.

Нийгэмд цэргийн алба хаагч амиа хорлож байгаа тохиолдлыг илүү соргоогоор хүлээн авдаг. Нэн ялангуяа ийм тохиолдол бүрийн ард “дэглэлт” буюу дүрмийн бус харилцаа байдаг гэсэн өрөөсгөл ойлголт тогтжээ. Зөвхөн судалгааны ажлын 4 сарын хугацаанд гэхэд зэвсэгт хүчин, дотоодын, хилийн цэргийн салбарт нийтдээ 4 цэрэг, албан хаагч амиа хорлосон тохиолдол гарчээ. Энэ нь алба хаагчийн хооронд даамжирч, ужгирсан нуугдмал дүрмийн бус харилцаанаас гадна тэдгээрийн хоорондын хувийн таарамжгүй харилцаа, гэр бүлийн шинжтэй маргаанаас үүдэлтэй байгааг анхаарах хэрэгтэй байна. Дурдсан тохиолдолд хилийн алба хаахад гэр бүлийнхээ хамт байдаг, тэдгээрийн отряд, заставын алба хаагчийн бүрэлдэхүүн хэсэгт орж явдаг онцлогийг мартаж болохгүй юм. Энэ нь зөвхөн амиа хорлох шалтгаан болоод зогсохгүй өөр бусад гэмт хэрэг үүдэн гарах шалтгаан болдог тухай үйл баримтууд чамгүй олон байна.

Хардалт, маргаан, хов живийн шинжтэй зүйлсээс улбаалан онц хүнд гэмт хэрэг гардаг онцлог нь зөвхөн цэргийн албаны гэхгүйгээр нийгэмд гардаг гэмт хэргийн нийтлэг шалтгаан болдог тул цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн бодлого боловсруулахдаа анхаарах хэрэгтэй байна.

Хил хамгаалах салбарт гарсан гэмт хэргийн статистик үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээ:

“Хилийн 17 отрядад 31 удаа гэмт хэрэг гарснаас бусдын амь насыг байлдааны зэвсэг хэрэглэн хөнөөсөн буюу шархдуулсан гэмт хэрэг 19 удаа гарсан байна. Тодруулбал, захирагчийнхаа эсрэг зэвсэг хэрэглэн амь насыг нь хөнөөсөн гэмт хэрэг давамгайлсан байна. Үүнд: байлдагч нь ахлагчийг хөнөөсөн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 20 хувь, офицерыг хөнөөсөн 12.5 хувь, түрүүчийг хөнөөсөн гэмт хэрэг 12.5 хувь байгаа⁵ нь захирах, захирагдах ёс журмыг зөрчих нь онц хүнд гэмт хэрэг үүдэн гарахад хүргэдэг болохыг нотлож байна.”⁶

Гэмт хэрэг гарсан цаг: Хилийн отрядад гарсан гэмт хэрэг ихэвчлэн шөнийн цагаар гарсан байх бөгөөд тодруулбал, шөнийн эхний хагас буюу 00 цагаас 03 цагийн хооронд үйлдэгдсэн байна.

⁵ ХХЕГ-ын Мэдээлэл, соёл, сурталчилгааны хэлтсээс авсан сахилга зөрчлийн мэдээ, судалгаанаас.

⁶ Ахмад хилчин А.Батсайхан 2009 онд хийсэн судалгааны дүгнэлтээс.

Гэмт хэрэг үйлдэгсэд: Гэмт хэргийн үйлдэгсдийн 19 нь хилчин байлдагч, 3 нь тасгийн захирагч, 7 нь харуулын дарга, 3 нь заставын орлогч, 1 нь отрядын дарга байна. Үүнээс үзвэл байлдагч буюу цэргийн хугацаат алба хаагчдаас онц хүнд гэмт хэрэг илүүтэй үйлдэж байгаа бөгөөд тэдэн рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил байхгүй, зөвхөн ангийн удирдлага, заставын даргын хооронд бичиг, тоот явуулах, албан даалгаварт хариу өгөх зэргээс хэтрэхгүй байна.

Хохирогч: гэмт хэргийн улмаас 9 хилчин байлдагч, түрүүч 6, ахлагч (гэрээт хилчин) 19, офицер 10 амь насаа алдаж шархадсан байна. Дээрхээс үзэхэд шадар захирах дарга буюу ахлагч, түрүүч офицерууд гэмт хэргийн хохирогч болж байгаа нь өөрсдийн нь буруутай үйлдлээс шалтгаалсан байж болохоор байна. Тухайлсан судалгаанаас⁷ үзэхэд “цэргийн алба хаагчдыг зодож дарамтлах, айлган сүрдүүлэх зэргээр хууль, дүрмийн бус хүрээнд харьцах зөрчил багагүй байна. Цэргийн алба хаагчдыг “дэглэдэг” бөгөөд энэ тухай мэдээлэл ангийн удирдлагад тэр бүр хүрч чадахгүй, далд, нууц оршиж байна. Шалгалт судалгаанд хамрагдсан ангиудын удирдах албан тушаалтнууд дүрмийн бус харилцаатай холбоотой зөрчил гардаггүй гэж байгаа нь нэг талаас ийм зөрчил далд хэлбэртэй байдаг, нөгөө талаас эдгээрийг илрүүлэх, арилгах арга хэмжээг хангалттай зохион байгуулаагүйтэй холбоотой байна “гэжээ. Дээрх дүгнэлтүүдийг хүлээн зөвшөөрөх үндэслэлтэй гэж үзэв.⁸

Дүгнэлт: Ангийн хэмжээнд алба хаагчдаас гаргасан дүрмийн бус харилцаа, сахилга зөрчлийн талаар ХХЕГ-т тэр бүр мэдээлээд байхыг хүсдэггүй, учир нь гэмт хэрэг, сахилгын зөрчлөөс сэргийлэх талаар анги байгуулагдааа зохиож буй ажлыг сонирхохоос илүүтэй хэн нэгэн албан тушаалтаныг буруутгаж, хариуцлага тооцохыг урьтал болгодог удирдлагын хэвшсэн арга барил дээрх зөрчил, гэмт хэргийн нууц дарагдуулах гол шалтгаан болж байна.

ХХЕГ харъяа анги, байгууллагын цэргийн сахилгын байдал дүгнэлт хийх, удирдах албан тушаалтны ажлыг үнэлэн дүгнэхдээ тухайн нэгжид зохиосон эрх зүйн сурталчилгаа, соёл, хүмүүжлийн ажил, хүн нэг бүртэй ажилласан байдал, зөрчлийг илрүүлж, буруутныг хууль, дүрмийн дагуу цээрлүүлсэн эсэх, гэмт хэрэг, сахилгын зөрчлийн бүртгэл мэдээг үнэн зөв гаргаж ирүүлдэг тогтолцоог бий болгосон эсэхийг ажлын гол үзүүлэлт, үр дүн болгодог арга барилд шилжих нь зүйтэй юм.

Цэргийн алба хаагчдын хувийн байдал: Судалгааны дүнгээс үзвэл анги байгууллагад гарсан хүнд, онц хүнд гэмт хэргийн шалтгаан нь нийгмийн шинжтэй байхаас гадна хувь хүнээс өөрөөс нь шалтгаалсан

⁷ ХҮЭМ-оос 2006-2007 онд хийсэн “Цэргийн алба хаагчдын эрхийн төлөө байдал” судалгаа. 5 дахь тал.

⁸ Судлаачдын баг Сэлэнгэ болон Дорноговь аймагт анкетийн болон ярилцлагын, бичиг баримтын судалгаа хийх явцад дүрмийн бус харилцаа “дэглэлт”-ийн талаар олж мэдэхэд ихээхэн бэрхшээлтэй байсан бөгөөд цэргийн алба хаагчдаас ийм асуулгад хариулахаас ямар нэг байдлаар зайлсхийж, эсхүл ор тас үгүйсгэж байв.

үйл баримтууд нэлээдгүй тогтоогдов. Үүнийг дурдвал:

Цэргийн алба хаахдаа ухарч няцдаг, гэр бүлийн болон суурь хүмүүжлийн доголдлоос шалтгаалан бусдын үг даах чадваргүй байх, цэргийн амьдралд дасахгүй байх, тэсвэр хатуужил багатайн улмаас үл ялих зүйлд гомдож өширхөх, хонзогнох, оргох улмаар бусдынхаа амь насанд галт зэвсэг хэрэглэн халдах, гэмтээх зэрэг гэмт хэргийг үйлдсэн үйл баримтууд байна.

Тухайлсан ярилцлагын судалгааны явцад⁹ гудамжны тэнэмэл амьдралаар өссөн нэгэн этгээдийг зан харьцааны доголдол болон өөртөө харьцаагүй үйлдэл хийж улмаар гэмт хэрэг үйлдэх боломжтой байсан учир цэргийн алба хаахаар хуваарилагдан ирэхэд нь застав руу шууд явуулаагүй байна. Гэвч тэрээр алба хааж байсан газраасаа оргож нэлээдгүй хүндрэл бэрхшээл учруулж, хөрөнгө мөнгөний зардал гаргасан жишээ байна.

Нэмж дурдахад, хүний амь нас хохироосон О нарын хэргээс судлан үзэхэд “хэрэгт холбогдогчид бүгдээрээ хагас өнчин, нэг дор өссөн, ямар нэг бүлэг хэмээн өөрсдийгөө ярьдаг байсан” гэх зэрэг байдлыг илүү анхаарч, яаран дүгнэлт хийхийн оронд дээрх байдлыг яагаад судалж тогтоогоогүй, урьдчилан мэдсэн юм бол яагаад нэг заставт хуваарилсан, харуулд яагаад нэг дор томилсон гэх зэрэг асуултад хариулт хайх хэрэгтэй байсан болов уу.

2.6. Хилийн алба хаагчдын сэтгэл зүйн судалгаа

Судалгааны багт мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж, удирдамжийн хүрээнд дараахь судалгааг явуулжээ.

Судалгаанд офицер 26, ахлагч 22, цэргийн хугацаат алба хаагч 71, энгийн ажилтан 25 нийт 144 хүн хамрагдсан байх ба тэдгээрийн насны хувьд 19-51, боловсролын хувьд дээд-21%, тусгай дунд-2%, бүрэн дунд-69%, бүрэн бус дунд-8%-ийг эзэлжээ.

Судалгаагаар цэргийн хугацаат алба хаагчид албандаа бүхэлдээ эерэг хандлагатай, удирдлагадаа хэвийн буюу эерэг, сөрөг хариултын аль илйг өгч, зарим тохиолдолд үл ойлголцсон, харилцааны асуудал гардаг гэж хариулжээ.

Айдас, түгшүүрийн хувьд судалгаанд оролцогчдын 53% нь хэрэг зөрчилд холбогдохоос, 13% нь ганцаардлаас, үлдсэн хувь нь харуул манаанд гарах, эрүүл мэнд, найз нөхөд, гэр бүлийнхэнтэй холбоотой асуудлууд давамгайлжээ. Ялангуяа халагдах хугацаа нь дөхсөн хүмүүсийн хувьд хэрэг зөрчилд холбогдохгүй эсэн мэнд буцах эсэх, мөн халагдаад очиход ар гэрийн байдал ямар байгаа бол гэх зэрэг асуудалд илүүтэй санаа зовдог байна.

Нийт бие бүрэлдэхүүний хувьд удирдлага болон хамт олноосоо хамгийн их хүсдэг зүйл нь “ээлдэг, соёлтой харилцаа, дэмжсэн,

⁹ 247 дугаар ангийн захирагч хурандаа Батсүхтэй хийсэн ярилцлагын явцад.

бахархсан, сайшаасан урмын үгнүүд" байдаг аж.

Заримдаа ажлаа цаг хугацаанд нь биелүүлж чадаагүйгээс болж бухимдах, стресст өртөх нь элбэг ч үүнээс гарах аргуудыг мэддэггүй, бие махбодь, сэтгэл санааны хувьд туйлдаж ядрах, ажлаасаа шантрах няцах үе заримдаа тохиолддог хэмээн хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 80-аас илүү хувь нь бие бүрэлдэхүүний харилцааны дутагдалтай талыг ярьж, дэлгэнгүйгээр бичсэн байжээ. Үүндээ, дан ганц захирагч, дарга нарын харилцааны соёлын дутагдал бус, нийт бие бүрэлдэхүүнийг хамааруулсан байжээ.

Энгийн албан хаагчдын дийлэнх нь гэр бүлийн хүний (нөхөр)-г даган томилогдсон газарт нь очиж янз бүрийн ажил хийхэд хүрдэг, хүүхдийн цэцэрлэг, сургууль хомсдолтой гэх зэргээр нийгмийн олон асуудал шийдвэрлэгдээгүйд сэтгэл дундуур, ирээдүйдээ түгшиж байдаг ажээ.

ХХЕГ-аас ирсэн албаны хүмүүс анги, заставын үйл ажиллагаа, ахуй амьдралтай танилцаж шалгахдаа хүмүүсийн хийж бүтээсэн зүйлд дэндүү шүүмжлэлтэй, заримдаа доромжилсон өнгө аясаар ханддаг байна.

Хувь хүн болон гэр бүлдэх сэтгэл зүйн асуудлуудаа шийдвэрлэж чадаагүйгээс болж бие өвчлөх, архи тамхийг хэтрүүлэн хэрэглэх нь элбэг. Ялангуяа хүн цөөтэй, шинэ мэдээ мэдээлэл авах боломж хязгаарлагдмал газруудад ихээхэн тохиолддог. Нийт бие бүрэлдэхүүний хувьд стрессээ тайлах аргыг мэддэггүйгээс удаан хугацааны буюу сэтгэлийн гүн шаналал, зовиуртай байх нь элбэг.

Ажлын ачаалал их байх (ээлжгүй олон цагаар ажиллах) нь ажлын хариуцлага алдах, ажлын бүтээмж багасах, ажилдаа дур сонирхолгүй болох, цаашилбал ажлын байрыг орхих хүртэл үйлдэл хийхэд хүргэдэг. Мөн ажлаа явуулах тав духтай нөхцөл муу, харуул манаанд явахад унаа уналга асуудалтай байдаг зэргээр үүргээ гүйцэтгэх таатай орчин нөхцөл бүрдээгүйгээс ажил, цэргийн албанаас залхах, орхих үндсэн нөхцөлүүд болдог.

Тус байгууллагад гарч буй онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл:

а) цэргийн болон хил хамгаалах албыг холбогдох хууль тогтоомж, дүрмээр хатуу тогтоосон дэг журмын дагуу зохион байгуулж тэр бүр чадахгүй байгаа,

б) офицер, ахлагч, цэргийн хугацаат алба хаагчийн харилцааг захирах, захирагдах ёс журмын дагуу хэвшүүлэн төлөвшүүлж чадахгүй байгаа,

в) ангийн байрлалд, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэх үедээ архидан согтуурах явдлыг таслан зогсоож чадаагүй,

г) байлдааны зэвсэг, галт хэрэгслийн ашиглалт, хадгалалт

хамгаалалтын байдалд тавих хяналт хангалтгүй,

д) хил хамгаалах албанд жил бүр хүлээн авч буй бие бүрэлдэхүүн, ялангуяа цэргийн хугацаат алба хаагчийн тайван цагт галт зэвсэг агсан байдлааны үүрэг гүйцэтгэх сэтгэл зүйн болон цэргийн хэргийн бэлтгэл бүрэн хангагдахгүй байна.

Ажилгүйдэл, ядуурал, сургууль завсардах зэрэг нийгэм дэх олон сөрөг үзэгдлийн нөлөөлөл ихсэж, хүч хэрэглэн үйлдсэн гэмт хэргүүд, түүний дотор хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг улсын хэмжээнд сүүлийн арван жилд өсөх хандлагатай байгаа нь хил хамгаалах байгууллагад хүнд, онц хүнд гэмт хэрэг гарахад шууд бусаар нөлөөлж буй гадаад хүчин зүйл байхыг үгүйсгэж болохгүй юм.

Гурав. Судалгааны санал, зөвлөмж

Судалгааны сэдвийн хүрээг хэдийгээр Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд гэмт хэргийн гаралт, түүний шалтгаан нөхцлийг судлах явдлаар хязгаарласан ч хил хамгаалах байгууллага, түүний үйл ажиллагааны болон алба хааж буй бие бүрэлдэхүүний онцлогийг харгалзан бүхэлд нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөх нь зүйтэй гэж үзсэн. Үүнд:

1. Хил хамгаалах ерөнхий газар, түүний харъяа нийт анги байгууллагад хөтлөх гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн бүртгэл мэдээллийн тогтолцоог юуны өмнө бий болгох. Энэхүү бүртгэл мэдээ нь хилийн застав, отрядад гарсан хэрэг зөрчлийг бүрэн илрүүлэх, түүний шалтгаан нөхцлийг судалж дүгнэх, гэм буруутай этгээдэд хууль, дүрэмд заасан хариуцлага ногдуулах, цаашид дахин гаргуулахгүйн тулд ямар ажил зохион явуулах шаардлагатайг тодорхойлох зорилготой тул түүнийг үнэн зөв бүртгэж мэдээлсэн шат дараалсан дарга, захирагч нарт шийтгэл ногдуулахыг урьтал болгох ёсгүй. Гэмт хэрэг, сахилгын зөрчил, ялангуяа захирах, захирагдах ёсны эсрэг хэрэг, зөрчил нь нуун дарагдуулсан тохиолдолд маш ноцтой үр дагавартай хүнд гэмт хэрэгт хүргэдэг учир хэрэг зөрчлийг нуун дарагдуулсан дарга, захирагчид нарт харин хариуцлага тооцож байх шаардлагатай.

2. Гарсан гэмт хэрэг, зөрчлийг хэн гаргасныг үл хамааран их, бага гэлгүй буруутай этгээдэд сахилгын хариуцлага ногдуулж, энэ тухай хамт олонд нь ил мэдээлж, хүмүүжлийн ажил зохиож хэвшүүлэх.

3. Хилийн отряд, заставт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулах, салбар зөвлөлд хэн, ямар үүрэгтэй оролцох, нөхцөл байдлын, социологийн болон бусад судалгааг яаж хийх, сахилгын байдалд дүн шинжилгээ хийх аргачлал, гарын авлага

зэргийг боловсруулж сургалт зохион явуулах.

4. Гэмт хэрэг, сахилгын зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажил хэдийгээр нийт нэгж, албан тушаалтанд хамаатай албаны үүрэг боловч энэ ажлыг хариуцан зохион байгуулах мэргэшсэн нэгжийг бий болгож, мэргэжлийн ажилтныг яаралтай бэлтгэж ажиллуулах шаардлагатай.

5. Хил хамгаалах байгууллагын анхан шатны нэгжүүдийг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний алба хаах, ажиллах, аж төрөх нөхцлийг улам сайжруулах шаардлагатай. Ноцтой хэрэг осол чухамхүү хилийн застав, харуул манааны байр, харуулын цэг дээр гол төлөв гарсаар байгааг судалгаа харуулж буй тул анхаарлыг үүнд л төвлөрүүлэх нь зүйтэй.

6. Сургалт, хүмүүжлийн ажилд хэлбэрдэж хандаж огтхон ч болохгүйг анхаарах, судалгаанаас үзэхэд хилийн заставт цэрэг дайчидтай явуулж байгаа сургалт, эрх зүйн сурталчилгаа цэргийн дүрэм, Эрүүгийн хуулийн тусгай ангиас цэргийн гэмт хэргийн хэдэн зүйлийг уншиж өгөхөөс хэтрэхгүй байна. Иймд бие бүрэлдэхүүний эрх зүйн ухамсарын түвшин, ажил мэргэжлийн онцлогт тохирсон сургалт зохион байгуулах нь үр дүнтэй. Хялбарчилсан гарын авлагууд боловсруулах, “сургагч багш”-ийг бэлтгэх нь юу юунаас чухал байна.

7. Хил хамгаалах төв, орон нутгийн байгууллага тухайн орон нутгийн шүүх, прокурор, цагдаагийн байгууллагатай гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр харилцан ажиллах журмыг боловсруулж мөрдөх. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг зөв тогтоохын тулд орон нутгийн хуулийн байгууллагатай нягт ажиллаж, хэрэг бүрийн араас хөөцөлдөж, түүнтэй холбоотойгоор гарсан тогтоол, шийдвэр, мэдэгдэл зэргийг авч, түүнд дүгнэлт хийж хэвшүүлэх.

8. ХЦДС-ийн дэргэд “Мэргэжлийн хилчин-ахлагч” бэлтгэх сургууль (дамжаа) байгуулж, төгсөгчдийг хилийн анги отрядад томилон ажиллуулдаг болох. Нэн ялангуяа, сайн судлаагүй хүмүүсийг хил хамгаалах албанд ажиллуулахаас зайлсхийх хэрэгтэй.

9. Хилийн отряд, заставын удирдах, гүйцэтгэх албан тушаалд томилон ажиллуулах офицеруудыг бэлтгэх систем (журам) тогтоож мөрдөх. Энэхүү бэлтгэл нь албаны бэлтгэлээс гадна хүнтэй ажиллах чадвар эзэмшүүлэх, ёс зүйтэй байхад сургах, алба хаагчдынхаа хувь онцлогийг шинжиж сурах, сэтгэл санааны хямралд автсан үедээ, эсхүл ийнхүү хямралтай байгаа хүний талаар зөв шийдвэр гаргадаг байх зэрэгт сургахад чиглэсэн байвал илүү үр дүнтэй байхаар байна.

10. ХХЕГ-ын урьд хийсэн (Улсын хил судлалын сектор) судалгааны дүгнэлт, дэвшүүлсэн саналуудыг дахин авч үзэх.

ХУУЛИЙН ХАРИУЦЛАГАД ҮНДЭСЛЭЛГҮЙ ТАТАГДСАН, ЦАГДАН ХОРИГДСОН, ХИЛС ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН, ЭДЭЛСЭН ХҮМҮҮСИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ

ХЗҮХ-ийн судалгааны тайлан

Нэг. Удиртгал

Судалгааны зорилго: Судалгааг хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, энэ чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад харгалзан үзэх мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж, санал боловсруулах зорилгоор хийсэн бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

Судалгаа явуулсан хугацаа, чиглэл: ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор нь Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны ажлын албаны захиалгаар 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2010 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд энэхүү судалгааны ажлыг секторын эрхлэгч, Ж.Энхнасан, эрдэм шинжилгээний ажилтан Ц.Одончимэг, Г.Оюунболд, Ц.Баттуяа, Г.Батчимэг, Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир, Ц.Одмаа нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэлээ.

Судалгаа явуулсан арга, хэлбэр: Судалгааг аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон судалгааны сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, арилцлага авах, санал асуух, сурвалжлах зэрэг аргаар явуулав.

Судалгааны чиглэлд дурдсан байдлыг тогтоохын тулд дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийг судлах ажлын хүрээнд үндэсний 10 хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын 29 гэрээний зохицуулалтыг судлав;

2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг тогтоохын тулд сүүлийн 4 жилд буюу 2006-2009 онд иргэний журмаар шийдвэрлэгдсэн 5 хэргийн материалыг уншиж, хууль бусаар эрх нь зөрчигдсөн

хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг шүүх юуг үндэслэн, хэрхэн тогтоож үнэлэн шийдвэрлэж буй өнөөгийн байдлыг тогтоов;

3. Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоож, үнэлж, шийдвэрлэхтэй холбогдуулж гаргасан

тайлбар, журам, заавар, зөвлөмжийн чанартай баримт бичгүүдийг хуулийн эх заалтынх нь утга агуулгатай тулган судалж, дүн шинжилгээ хийв;

4. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж, ярилцах замаар хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг шийдвэрлэж буй байдлын талаарх хандлагыг тодорхойлсон бөгөөд уг судалгаанд давхардсан тоогоор 9 шүүгч, 12 прокурор, 8 хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, 9 өмгөөлөгч, 3 хохирогчийг хамруулсан;

5. Гадаадын 8 улсын “Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоож, үнэлж, шийдвэрлэх талаархи эрх зүйн зохицуулалт”-ыг харьцуулан судалсан;

6. Олон улсын эрх зүйн баримт бичгийн зохицуулалт, үзэл баримтлалыг мөн судалсан.

Хоёр. Судалгааны дүн

2.1 Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх талаархи эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт:

2.1.1. Үндэсний эрх зүйн зохицуулалт

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүс үүний улмаас өөрийн сэтгэл зүйд учирсан хохирлоо шаардах эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн “...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...эрхтэй” хэмээн тусгалаа олсон бөгөөд өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй ЭБШХ-ийн 44 дүгээр бүлэгт мөн ЭБША-ны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай зохицуулсан юм. Гэвч ийнхүү Үндсэн хуулиар бататгаж, ЭБШХ-д хохирол арилгуулах эрх, үндэслэл, шийдвэрлэх журмыг заасан боловч хохирлын хэмжээг хэрхэн тогтоож, нөхөн төлбөрийн хэмжээг хэрхэн тооцох талаар эрх зүйн тодорхой зохицуулалтгүйн улмаас хохирсон иргэнд Үндсэн хууль болон ЭБШХ-иар олгосон эрх бүрэн хэрэгжихгүйд хүрч байгаагийн зэрэгцээ хуулийн хэм хэмжээг практикт харилцан адилгүй байдлаар хэрэглэж байгаа нь Үндсэн хуулиар бататгасан “хууль, шүүхийн өмнө

эрх тэгш байх зарчим"-ыг алдагдуулж байгаа юм. Иймээс хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан иргэнд хуулиар олгосон эрхийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхийн тулд тус улсад өмнө нь эрх зүйн ийм зохицуулалт байсан эсэхийг болон эрх зүйн одоогийн зохицуулалтыг дараахь хуулийн хүрээнд харьцуулан судалсан юм. Үүнд:

А) Үндсэн хууль

• БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн 83 дугаар зүйлд төрийн албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанд иргэд өргөдөл, гомдол гаргаж түүнийгээ зохих журмын дагуу шийдвэрлэх үүрэгтэй болохыг хуульчилсан байсан бол БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн 85 дугаар зүйлд зааснаар хууль бус ажиллагаанаас гадна чирэгдэл, хүнд суртал гаргасан албан тушаалтны үйл ажиллагаанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй байжээ. Энэхүү өргөдөл, гомдлыг төрийн байгууллага, албан тушаалтан нэн даруй шийдвэрлэх үүрэгтэй гэж хуульчилсан байна. Эдгээр хуулиудаар төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаанд иргэн зөвхөн өргөдөл, гомдол гаргах эрхтэй болохыг хуульчилсан бөгөөд харин төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах, иргэн уг хохирлоо нэхэмжлэх эрхийг хуульчлаагүй нь нэлээд учир дутагдалтай байжээ.

• Хамгийн анх БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1974 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 510 дугаар тогтоолоор “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлийн 1,2-т¹ заасан үндэслэлээр холбогдолгүй болсон хүмүүсийг хохирлыг арилгах тухай” журам² батлагдсан явдал юм. Энэхүү журмаар эрүүгийн хариуцлагад татагдаж шалгагдаад тухайн үеийн ЭБШХ-ийн 6 дугаар зүйлд заасан үндэслэлээр холбогдолгүй болсон хүмүүст учирсан зөвхөн материаллаг хохирлыг арилгах зорилгоор тэдний ажиллаагүй байсан хугацааны дундаж буюу албан тушаалын цалинг зохих тогтоол, баримт бичгийн үндсэн дээр ажиллаж байгаа газар, байгууллагаас 2 сарын цалингаас хэтрэхгүй хэмжээгээр нөхөн олгож байхаар тогтоож байв. Энэ нь тухайн үедээ хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан хүмүүст нөхөн олговор олгох талаарх хамгийн анхны эрх зүйн зохицуулалт байсан төдийгүй нөхөн олговрын хэмжээг тогтоож өгсөнөөрөө дэвшилтэт алхам болж байжээ. Хэдий тийм ч энэхүү журамд заасан нөхөн олговрыг ажил эрхэлдэггүй иргэд авах боломжгүй байв.

• Харин Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс

¹ Гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болсон

² Үндэсний төв архив.. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хууль тогтоомжийн лавлагааны сангаас

хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" хэмээн Үндсэн хуулиар бусдын хууль бусаар учруулсан хохирол буюу хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүс өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг тунхаглаж, улмаар уг эрхийг хангах үүргийг төрд хариуцуулсан нь чухал бөгөөд дэвшилттэй зохицуулалт болжээ. Үндсэн хуулийн энэхүү заалтаар бусдын хууль бусаар учруулсан хохирлыг эдийн болон эдийн бус гэж хязгаарлаагүй бөгөөд энэ нь хохирсон этгээдэд өөрт учирсан эдийн бус хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хамгаалсан дэвшилттэй зохицуулалт болсон юм. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх зорилгоор 2002 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн баталж мөрдсөн бөгөөд уг хуулиар хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас иргэнд учирсан эдийн бус хохирлыг арилгах асуудлыг хуульчилсан юм.

Б) Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг зохицуулсан бусад хууль

1. Монгол Улсын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль³. Шинэ Үндсэн хууль батлагдан мөрдөгдөхөөс өмнө хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэнд учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг зохицуулсан энэхүү хууль үйлчилж байжээ. Уг хуулиар иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан сэргийлэх арга хэмжээ болгон цагдан хорьсон, мөн захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ оногдуулсныг шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагаа гэж үзэж, түүний улмаас учирсан хохирлыг арилгуулах эрхийг зохицуулсан байна. Харин хуульд заасан субъектуудын хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирол болон аваагүй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж зэргийг хохирол хэмээн тооцож гаргуулах тухай заасан ба энэ нь хууль бус ажиллагааны улмаас учирсан эдийн хохирлыг нөхөн төлүүлэхээр хязгаарлагдсан байна. Өөрөөр хэлбэл, уг хуулиар иргэнд учирсан эдийн бус буюу сэтгэл зүйн хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх тухай зохицуулаагүй байснаас "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль"

³ 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр батлагдаж, 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр хүчингүй болсон.

-ийг эс тооцвол 2002 онд ЭБШХ батлагдан мөрдөгдөх хүртэл “сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлүүлэх” практик байгаагүй юм.

2. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор тухай хууль-аар хилс хэрэгт шийтгүүлсэн хэлмэгдэгчид нөхөн олговор олгохоор зааж, цаазаар авах ял шийтгүүлсэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүдэд болон хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд 1000000 төгрөгийн, бусад хэлмэгдэгчид 500 000 төгрөгийн нэг удаагийн нөхөн олговор олгож байжээ. Хуулийн энэ зохицуулалт хилс хэрэгт шийтгүүлснээс учирсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн олговор хэлбэрээр төрөөс нөхөн төлж буй хэрэг боловч тухайн этгээдэд учирсан хохирлын хэмжээг бодитой тогтоосон гэхэд учир дутагдалтай зохицуулалт ажээ.

3. Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Харин Монгол Улсад 2002 онд батлагдан мөрдөгдөж буй ЭБШХ-ийн⁴ 44 дүгээр бүлгэлт “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах” тухай зохицуулсан бөгөөд мөн хуулийн 388 дугаар зүйлд “... иргэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан ..., сэтгэл санааны үр дагавраа арилгуулах ... эрхтэй” гэж заасан ба мөн хуулийн 391 дүгээр зүйлийн 391.1-т зааснаар:

- Эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө;

- Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно;

- Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах ажээ.

Өөрөөр хэлбэл, ЭБШХ-д эдийн бус хохирол буюу сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрх болон шаардлага гаргах үндэслэлийг заасан боловч хохирлын хэмжээг тогтоох болон нөхөн төлөх журмыг Иргэний хуульд зохицуулахаар заасан байна.

4. Иргэний хууль

- 1926 онд батлагдан мөрдөгдөж байсан БНМАУ-ын Иргэний хуулиар нийгмийн халамжийн харилцаа болон зарим эдийн эрхийг голчлон зохицуулсан байсан бөгөөд харин зөрчлийн улмаас үүсэх үүргийн тухай буюу бусдын хууль бус үйлдэл, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг шаардах, арилгуулах асуудлыг зохицуулаагүй байжээ.

- 1952 онд батлагдан мөрдөгдсөн Иргэний хуулиар гэм хор гэсэн

⁴ 1998 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан.

⁵ 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан.

ойлголтыг шинээр хуульчилсан бөгөөд уг хуулийн 6 дугаар бүлгийн 253 дугаар зүйлд “Гэм хорыг учруулснаас үүсэн гарсан нэхэмжлэл”-ийн тухай, 17 дугаар бүлэгт “Бусдад хор хүргэснээс үүсэх үүргүүд”-ийн тухай тусгайлан авч үзсэн боловч бусдын хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас учирсан хохирлыг зөвхөн хүний бие болон түүний хөрөнгө хэмээн явцуу хүрээнд тодорхойлжээ.

• 1963 оны Иргэний хуулиар эд хөрөнгийн болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус харилцаа (хуульд заасан бол эд хөрөнгийн бус амины бусад харилцаа)-г зохицуулахаар тусгасан, 3 дугаар зүйлд “бусдад гэм хор хүргэх нь иргэний эрх, үүрэг үүсэх үндэслэл болох”-оор, мөн 6 дугаар зүйлд “Хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах” тухай, 18 дугаар бүлэгт “Гэм хор учруулснаас үүсэх үүрэг”-ийн тухай, 319 дүгээр зүйлд “Албан байгууллагын ажилчин, албан хаагчид үүргээ гүйцэтгэж байгаад өөрийн буруугаас бусдад учруулсан гэм хорыг уул байгууллага хариуцах үүрэг”-ийн тухай тусгайлан зохицуулсан ба эдгээр зохицуулалтаар “сэтгэл зүйн хохирол”-ыг авч үзээгүй байна. Өөрөөр хэлбэл, уг хуулиар эдийн бус хохирлыг “бусдын нэр төр, алдар хүндэд учирсан хохирол”-оор хязгаарлан хуульчилсан байна.

• 1994 оны Иргэний хууль нь Монгол Улсад 1992 онд батлагдсан Үндсэн хуульд нийцэж гарсан хууль бөгөөд эдийн бус хохирлын тухайд өмнөх Иргэний хуульд байсан зохицуулалттай үндсэндээ ижил зохицуулалттай байжээ.

• 2002 оны Иргэний хуулийн⁶ 230 дугаар зүйлд “Эдийн бус гэм хорыг арилгах” тухай заасан бөгөөд энэхүү заалтаар эдийн бус хохирлыг шаардах эрх, эдийн бус хохирлыг нөхөн төлөх хэлбэр, гэм хорыг арилгах болон гэм хорын хэмжээг тогтооход харгалзах зүйл зэргийг, мөн хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хорыг арилгах тухай заасан боловч “эдийн бус гэм хор”-ыг зөвхөн “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирол”-оор хязгаарлан хуульчилсан байна. Уг хуулиар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлд “Эдийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө”, “Эдийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно” гэж заасан боловч Иргэний хуулиар дурдсан журмыг нарийвчлан заагаагүй учир хохирлын хэмжээг ЭБШХ-д заасанчлан тогтоох боломжгүй байна.

2.1.2. Олон улсын гэрээний зохицуулалт

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох, уг хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох талаархи олон улсын эрх зүйн

⁶ 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан.

зохицуулалтыг судлах хүрээнд Монгол Улсын нэгдэн орсон дараахь Олон улсын гэрээг судаллаа. Үүнд:

1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц⁷. Энэ конвенцийн 14 дүгээр зүйлд “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй” гэж заажээ.

2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁸-ын 9 дүгээр зүйлд “Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй. Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй” гэж, 14 дүгээр зүйлд “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ” гэж заасан байна.

Дээрх баримт бичгүүдийн зохицуулалтаар хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн этгээдийн өөрт учирсан хохирлоо арилгуулахаар шаардах, нөхөн төлбөр авах эрхийг хуульчлан зохицуулжээ. Харин судлагдсан олон улсын гэрээний аль ч зохицуулалтаар хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг болон уг хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох тухай тусгайлан зохицуулаагүй байна.

2.1.3. Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт

Англи⁹

• Английн Эрүүгийн хэрэг шүүн таслах тухай хууль (1988 он)-ийн 133 дугаар зүйлийн 133.1-д “Аливаа этгээд эрүүгийн хариуцлагад

⁷ Төрийн мэдээлэл” эмхтгэл. Тусгай дугаар I боть. 2004. 109-120 дахь тал. Энэ конвенц 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо батлагдаж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэж орсон.

⁸ Төрийн мэдээлэл” эмхтгэл. Тусгай дугаар I боть. 2004. 11-28 дахь тал. Ерөнхий Ассемблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

⁹ Stephanie Roberts. 'Unsafe' Convictions: Defining and Compensating Miscarriages of Justice. London, 2003. at 2

татагдан шийтгүүлсэн боловч хожим шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хилс ял эдэлсэн нь тогтоогдон түүнийг шийтгэсэн шүүхийн шийдвэр өөрчлөгдсөн, цагаатгагдсан бол Төрийн нарийн бичгийн дарга тухайн үйлдлийн улмаас хохирсон этгээдэд нөхөн төлбөр олгоно” гэж заажээ. Уг хуульд зааснаар Төрийн нарийн бичгийн дарга нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг шийддэг боловч түүний үнэлгээг Төрийн нарийн бичгийн даргын томилсон бие даасан үнэлгээчин тогтоодог¹⁰ бөгөөд үнэлгээчин үнэлгээ тогтоохдоо дараахь нөхцөл байдлыг харгалзан үздэг байна. Үүнд:

А. тухайн хүнийг эрүүгийн хариуцлагад татсан гэмт хэрэг болон түүнд оногдуулсан ялын хүнд, хөнгөн байдал;

Б. тухайн гэмт хэргийн мөрдөн байцаалт, яллах үйл ажиллагаа явагдсан байдал;

В. түүнээс үүдэлтэйгээр хохирогч бусад гэмт хэрэг үйлдсэн эсэх болон түүнд оногдуулсан ялын хэмжээ.¹¹

Эрүүгийн хэрэг шүүн таслах тухай хууль (1988)-ийн 133 дугаар зүйлийн 133.1-д зааснаар нөхөн төлбөрийн үнэлгээг иргэний эрх зүйн зөрчлийн улмаас учирсан хохирлын үнэлгээтэй ижил байдлаар хийдэг байна. (тухайн харилцаатай холбоотой зарчмууд 2008 оны Эрүүгийн хэрэг шүүн таслах болон Цагаачлалын тухай хуулийн хүрээнд ихээхэн өөрчлөгдсөн байна).

• Эрүүгийн хэрэг шүүн таслах болон Цагаачлалын тухай хууль (2008 он)-ийн 61 дүгээр зүйлд гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг 2 жил байхаар заасан бөгөөд нөхөн төлбөрийн дээд хэмжээг тогтоож өгсөн. Хэрвээ Төрийн нарийн бичгийн дарга онцгой нөхцөл байдал байна гэж үзвэл гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг сунгах боломжтой. Нөхөн төлбөрийн ердийн хэмжээг 500000 паунд, 10-аас дээш жилээр хоригдсон бол 1000000 паунд байхаар хуульчилсан байна.

Шотланд¹²

Шотландын Эрүүгийн хэргийг хянах хороог (ШЭХХХ) 1999 оны 4 дүгээр сард Парламентийн шийдвэрээр байгуулсан бөгөөд эрүүгийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, хилс ял эдэлсэн гэж үзэж байгаа хүн энэхүү хороонд гомдол гаргаж болно.

• Нөхөн төлбөрийн төлөлт. Одоогийн байдлаар нөхөн төлбөрийг төлөх 2 төрлийн тогтолцоо байдаг байна:

- “хуулиар тогтоосон”;

- “Ex Gratia”¹³.

Нөхөн төлбөрийг шаардах, гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг хязгаарлаагүй бөгөөд уг гомдлыг Шотландын төрийн эрх бүхий албан

¹⁰ Stephanie Roberts, ‘Unsafe’ Convictions: Defining and Compensating Miscarriages of Justice, London, 2003, at 2

¹¹ Sally Broadbridge, Compensation for Acquitted Defendants, 2009

¹² <http://www.scotland.gov.uk/Topics/Justice/law/miscarriages/Compensation-Scheme/ExGratiaScheme/Q/edit-mode/on/forceupdate/on>

¹³ Хуулиар олгогдсон эрх гэхээсээ илүүтэйгээр төрөөс үзүүлж байгаа тусламж, дэмжлэг

тушаалтанд гаргаж, тэрээр гомдол гаргагч нөхөн төлбөр авах эрхтэй эсэхийг шийдвэрлэнэ.

Нөхөн төлбөрийн хэмжээг Шотландын төрийн эрх бүхий албан тушаалтны томилсон бие даасан үнэлгээчин тогтоох ба бие даасан үнэлгээчин үнэлгээ хийхдээ иргэний эрх зүйн зөрчлийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу нөхөн төлбөрийн үнэлгээг хийхтэй адил зарчмаар хийнэ.

• Нөхөн төлбөрийн хэмжээ. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохын тулд бие даасан үнэлгээчин нь иргэний эрх зүйн гэм буруугийн нөхөн төлбөрийг үнэлэхтэй адил зарчмыг баримтална.

Үнэлгээг тогтоохдоо хилс ял шийтгүүлсэн, гэмт хэрэгт үндэслэлгүй татагдсан болон эрх чөлөөг нь хязгаарласнаас үүдэлтэй эдийн болон эдийн бус хохирлын аль алийг нь харгалзан үзэх ба “амьжиргааны хэмнэсэн зардал” (хоригдох хугацаандаа зарцуулаагүй амьдарлын өртөг)-ыг эдийн гэм хорын нөхөн төлбөрөөс хасахгүй.

Хуулийн дагуу нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нь цэвэр үнэлгээчний бүрэн эрхийн асуудал байдаг ба Шотландын төрийн эрх бүхий албан тушаалтан тухайн үнэлгээчний хэмжээг өөрчлөх эрх байхгүй.

Австрали¹⁴

Эрүүгийн хэрэгт үндэслэлгүй шийтгэгдсэний нөхөн төлбөр. Австралийн муж улсууд болон газар нутгуудад *ex gratia* төлбөрийг олгодог боловч нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох арга нь тодорхойгүй байна. Австралид эрүүгийн хэрэгт үндэслэлгүй шийтгэгдсэний хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ нь зөрчлийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөр шиг өндөр үнэлгээтэй байдаггүй. Одоогийн нөхөн төлбөрийн *ex gratia* тогтолцоо нь дур зоргын шинжтэй байна. Нөхөн төлбөрийг олгох талаар Австралийн шүүх эрх мэдлийн эрх хэмжээ нь өгөөжтэй ч биш, ил тод ч биш. Хууль бусаар эрүүгийн хариуцлага хүлээсэн ихэнх хүмүүс ямар нэгэн нөхөн төлбөр авдаггүй. Хууль тогтоомжоос харахад нөхөн төлбөрийн хэмжээ хэд байх, түүнийг хэн тогтоох нь тодорхойгүй байна.

Австралид “*ex gratia*” нөхөн төлбөрийг олгодог ба түүнд эдийн болон эдийн бус гэм хорын нөхөн төлбөр аль аль нь багтсан шинжтэй байдаг. Шүүхээс олгож байгаа “*ex gratia*” нөхөн төлбөр нь дур зоргын шинжтэй байгаа учраас төлж байгаа дүвгийн албан болон албан бус хэмжээг гаргаж ирэхэд бэрхшээлтэй.

Шинэ Зеланд¹⁵

Шинэ Зеландад Эрүүгийн хэрэгт үндэслэлгүй татагдаж ял шийтгэгдсэн этгээдэд нөхөн төлбөр болон *ex gratia* төлбөр олгох удирдамжийг баталсан. Нөхөн төлбөр авах нь *ex gratia* тогтолцоо

¹⁴ http://www.aic.gov.au/publications/current%20series/landi/341-360/landi356/view_20paper.aspx

¹⁵ http://www.aic.gov.au/publications/current%20series/landi/341-360/landi356/view_20paper.aspx

учраас үүнийг тогтсон эрх гэж ойлгох боломжгүй. Гэхдээ, нөхөн төлбөр олгох эсэх болон түүний хэмжээг удирдамж маягаар тогтоон нийтэд нээлттэй болгосон. Хууль зүйн сайд асуудлыг Хатан хааны зөвлөлд танилцуулах бөгөөд тэд нөхөн төлбөр олгох эсэхийг шийдвэрлэнэ. Түүний дараагаар төрийн эрх бүхий албан тушаалтан олгох нөхөн төлбөрийн хэмжээг тогтоодог.

Гомдол гаргагч өөрийгөө гэм буруугүй гэдгээ батлах үүрэгтэй. Мөн шаардаж байгаа үнийн дүнгийн саналаа гаргаж болно. Удирдамжид эдийн болон эдийн бус гэм хорыг тодорхойлох үзүүлэлтийг гаргаж, хоригдсон жил тутамд олгох нөхөн төлбөрийн доод хэмжээг 100 000 шинэ зинландын доллар байхаар тогтоосон.

Польш¹⁶

• Хууль бусаар ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг Төрөөс арилгах тухай асуудлыг өөр өөр хуулиар зохицуулдаг бөгөөд Польшийн хууль тогтоочид Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар зохицуулахаар сонгосон билээ.

Польш улсын 1928 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хууль бусаар ял шийтгүүлсэн тохиолдолд Төрийн сан хариуцлага хүлээнэ гэж заасан бол 1956 онд тус улсад улс төрийн үймээн, хөдөлгөөн гарсаны улмаас 1958 оны 11 дүгээр сарын 15-нд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан юм.¹⁷ Уг нэмэлтээр “хууль зөрчсөн ажиллагааны улмаас хохирсон иргэнд Төрийн сангаас хохирлыг нөхөн олгох” тухай нэмж зохицуулсан байна. 1989 онд тус улсын улс төрийн тогтолцоо өөрчлөгдөж, шинэчлэл бий болсноор 1969 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд¹⁸ нэмэлт, өөрчлөлт оруулсан ч “Хууль бусаар баривчлагдсаны улмаас иргэнд учирсан хохирлыг Төрийн сангаас нөхөн төлнө” гэх зохицуулалт өөрчлөгдөөгүй байна.

• Хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн тухай асуудлыг зохицуулахдаа 1991 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн “Улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль”¹⁹-ийг үндэслэл болгож байсан ба

¹⁶ Por. J. Wąszyński. Odszkodowanie za niesłuszne skazanie i bezzasadne aresztowanie w polskim procesie karnym, Warszawa 1967, s. 18; A. Bulsiewicz, Proces o odszkodowanie za niesłuszne skazanie lub oczywiste bezzasadny areszt tymczasowy, Toruń 1968, s. 10 i n.

Проф. Вашичньский. Пу-ын Эрүүгийн байцаан шийтгэх явцад хууль бусаар ял шийтгүүлэх болон үндэслэлгүйгээр баривчлах, түүний улмаас үүссэн хохирлыг арилгуулах тухай, Торунь 1968, 10 дугаар тал.

¹⁷ Ustawa o odpowiedzialności państwa za szkody wyrządzone przez funkcjonariuszy państwowych (Dz. U nr. 54, poz. 243)

Төрийн албан хаагчдын хууль бус ажиллагааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцах тухай хууль /Хууль тогтоомжийн мэдээлэл/ сэтгүүлийн дугаар 54/

¹⁸ Ustawa z 29 maja 1969r. o zmianie niektórych przepisów prawa karnego, prawa o wykroczeniach oraz innych ustaw (Dz. U nr. 34, poz. 180)

Эрүүгийн хууль, захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай 1969 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хууль.

¹⁹ Dz. U nr. 34, poz. 149. W. Daszkiewicz. Problem rehabilitacji i odszkodowania za bezprawne represje karne, PiP, 1990, nr. 2, s. 16 i n.

энэхүү хуульд улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийн бие махбодь болон сэтгэл санааны хохирлыг Төрийн сангаас нөхөн олгох тухай тодорхой зааж өгсөн.

• Польш Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар бүлэгт “Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай” зохицуулсан бөгөөд мөн хуулийн 552 дугаар зүйлд “... улмаас өөрт учирсан эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлоо Төрийн сангаас нөхөн төлүүлнэ” гэж, мөн “Гарцаагүй хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон бол эдийн болон эдийн бус хохирлоо нөхөн төлүүлнэ” хэмээн заасан боловч хохирлын хэмжээ болон хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох талаар тодорхой зохицуулаагүй байна.

• Польш Улсын Дээд шүүхээс “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ (хилсээр хоригдсон хоног тутамд ногдох)-г тогтооход дараах шалгуур үзүүлэлтийг баримтална” гэж тайлбарлажээ.²⁰ Үүнд:

1. Хохирол нь нөхөн төлүүлэх шинжтэй бөгөөд бэлгэдлийн чанартай байх бус эдийн засгийн хувьд мэдрэгдэхүйц байх;

2. Нөхөн төлбөр нь нийгмийн тухайн цаг үеийн өмчийн харилцаанд нийцсэн ухамсартай хэмжээтэй байх;

3. Нөхөн төлбөрийн хэмжээ нь хэт их, хэт бага байж болохгүй;

4. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн нөхцөл байдлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай. Тухайлбал, сэтгэл санааны шаналалын хэмжээ, шаналалын эрчимтэй байдал, хэвийн байдлаа алдсан шинж төлөв гэх зэрэг.

Оросын холбооны улс

• ОХУ-ын Иргэний хууль. Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд зааснаар сэтгэл санааны хохирол гэдэг нь иргэний хувийн эдийн бус эрх эсвэл түүнд хамааралтай эдийн бус баялагийг зөрчсөн үйлдлийн улмаас учирсан болон бусад хуульд заасан тохиолдолд биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал байна. Мөн хуулийн 1100 дугаар зүйлд “дараахь тохиолдолд сэтгэл санааны хохирлыг гэм хор учруулагчийн гэм буруугаас үл хамааран нөхөн төлнө:

- Аюул ихтэй зүйлсийн улмаас иргэний амьдрал, эрүүл мэндэд учирсан хохирол;

- Иргэнийг хууль бусаар шүүсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар хэрэглэсэн, баривчлах болон засан хүмүүжүүлэх хэлбэрээр захиргааны шийтгэлийг хууль бусаар ногдуулснаас учирсан

В.Дашкевич. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хууль бус ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирол арилгах болон нөхөн сэргээх арга хэмжээний тухай асуудал. “Прокурор болон хууль ес” сэтгүүлийн 1990/2. 2 тал

²⁰ <http://www.lublin.są.gov.pl/26/213/>

хохирол;

- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааснаас учирсан хохирол;

- Хуульд заасан бусад тохиолдол” гэж заажээ.

ОХУ-ын Иргэний хуулийн 1101 дүгээр зүйлд зааснаар сэтгэл зүйн хохирлыг нь мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх ба сэтгэл зүйн хохирлыг хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар, хэрэв гэм буруу нь гэм хорыг нөхөн төлөх үндэслэл болж байгаа тохиолдолд гэм буруутай этгээдийн гэм буруугийн зэргийг үл харгалзан шүүх тогтоох ба гэм хорын хэмжээг тодорхойлохдоо ухаалаг байдал ба шударга ёсны шаардлагыг тооцон үзэх ёстой ажээ. Мөн биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар нь сэтгэл санааны хохирол учруулсан тухайн нөхцөл байдлын үйл баримт, хохирогчийн хувийн онцлогийг харгалзан шүүх үнэлнэ.

• ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тайлбар. Сэтгэл санааны хохирол гэдэгт иргэний төрөхөөс болон хуульд заасан эдийн бус баялагт (амьдрал, эрүүл мэнд, хувийн үнэлэмж (достоинство), ажил хэргийн нэр хүнд, хувийн халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц) үйлдэл (эс үйлдэхүй)-ээр учруулсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал болон иргэний хувийн эдийн бус эрх (нэр төрөө ашиглах эрх, зохиогчийн эрх болон бусад оюуны үйл ажиллагааны үр дүнд хуулийн дагуу бий болсон эрх) эсвэл эдийн эрхийг ойлгоно.²¹ Түүнчлэн “шүүх нь хохирогчид учирсан сэтгэл санааны болон бие махбодийн зовлон шаналал нь хэрхэн нотлогдож байгаа, ямар нөхцөл байдалд ямар үйлдэл (эс үйлдэхүй)-ээр учирсан, гэм хор учруулагчийн гэм буруугийн зэрэг, хохирогч ямар сэтгэл санааны болон бие махбодийн зовлон шаналлыг даван туулсан, хэдий хэмжээнд бусад материаллаг хэлбэрээр нөхөн төлбөрийг үнэлж байгаа болон тухайн маргааныг шийдвэрлэхэд хамааралтай бусад нөхцөл байдлыг зайлшгүй нягтлан шалгах ёстой” гэж Дээд шүүхийн бүгд хурлаас тайлбарласан байна.

ОХУ-ын Иргэний хууль болон Дээд Шүүхээс сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөхөөр тодорхой хэмжээгээр зохицуулалт хийж байгаа боловч бүрэн төгс гэж үзэх боломжгүй юм. Мөн ОХУ-ын хууль тогтоомжид биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын зэрэглэл, шинж чанарын тухай ойлголтыг тодорхой заагаагүй байдаг.²²

ОХУ-ын хууль тогтоомж болон хууль хэрэглэх практикт сэтгэл санааны хохирлыг тогтоох тогтоосон тодорхой шалгуур, нийтлэг арга байхгүй харин түүнийг шүүх өөрийн үзэмжээрээ тодорхойлж байгаа юм.²³

²¹ “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх тухай хууль тогтоомжийн хэрэглээний зарим асуудал”. ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тогтоол. 1994.12.20. №10.

²² Варпаховская Е.М. Вопросы компенсации морального вреда потерпевшему в российском уголовном судопроизводстве. Иркутск-2004. С., 143.

²³ Дурдсан бүтээл 136 дахь тал.

• Судлаачдын байр суурь. Зарим судлаачид сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх хэмжээг тогтоох аргачлал боловсруулсан байдаг боловч түүнийг шүүхээс хэрэглэн хэрэг маргаан шийдвэрлэсэн тохиолдол байдаггүй байна. Судлаач Эрделевский сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх хэмжээг тогтоохдоо дараахь томъёог боловсруулан, ашиглахыг санал болгосон байна.

$$D=d*fv*i*c*(1-fs)$$

- D-сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх бодит хэмжээ;
- d-сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх нийт хэмжээ;
- fv-гэм хор учруулагчийн гэм буруугийн зэрэг (энэ тохиолдолд $0 < fv < 1$ байна);
- i-хохирогчийн хувийн онцлогийн коэффициент (үржүүлэгч тоо) (энэ тохиолдолд $0 < i < 2$ байна);
- c-анхаарал татсан нөхцөл байдлыг тооцоолсон коэффициент (энэ тохиолдолд $0 < c < 2$ байна);
- fs-хохирогчийн гэм буруугийн зэрэг (энэ тохиолдолд $0 < fs < 2$ байна).²⁴

Судлаач дээрх томъёоны d тоог авч үзэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээтэй холбогдуулан авч үзсэн байна. Жишээлбэл, хүний биед хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэгт оногдуулах хамгийн хүнд ял нь 12 жилийн хугацаагаар хорих ял бөгөөд энэ тохиолдолд сэтгэл санааны хохирлыг гэмт хэрэг үйлдэгдэх үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 720 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байхаар тооцсон байна. Энэ хөлс нь иргэний 10 жилийн дундаж цалин хөлстэй тэнцэнэ (судлаач энэхүү хэмжээг татварын хууль тогтоомжтой уялдуулан дундаж хөлс гэж тооцоолон авч үзсэн байна).²⁵

2.2. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоож, үнэлж, шийдвэрлэж буй байдал (өнөөгийн практик)

2.2.1. Монгол Улсад

Монгол Улсад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоож, шийдвэрлэж буй өнөөгийн практикийг Нийслэлийн хэмжээнд 2006-2009 онд шийдвэрлэгдсэн 6 хэргийн материалыг судлах замаар авч үзлээ.²⁶

Судлагдсан 6 хэргийн хувьд хууль бусаар эрх нь зөрчигдсөний

²⁴ Эрделевский А.М. Моральный вред и компенсация за страдания... С.69.

²⁵ Варлаховская Е.М. Вопросы компенсации морального вреда потерпевшему в российском уголовном судопроизводстве. Иркутск-2004.. С.150.

²⁶ Тайлангийн Хавсралтаас судлагдсан хэргийн шийдвэрийг харна уу.

улмаас хохирол нэхэмжилсэн нэхэмжлэгчийн 3 нь прокурорын хяналтын шатанд хэрэг нь хэрэгсэхгүй болгосон, 2 нь шүүх хэргийг нь цагаатгасан, 1 нь эдлэх ёстой ялаас илүү ял эдэлсэн байв.

Нэхэмжлэгч нар өөрт учирсан ямар төрлийн хохирлыг хэрхэн тооцож нэхэмжилсэн байдлыг судалж үзэхэд:

№	Нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн байдал	Эрх зөрчигдсөн хугацаа, хэрэг нь аль шатанд хэрэгсэхгүй болсон	Сэтгэл зүйн хохирол нэхэмжилсэн байдал	Шүүх шийдвэрлэсэн байдал
1.	Х ү н и й г санаатайгаар алах гэмт хэрэгт хамжигчаар оролцсон хэмээн шалган цагдан хорьж, яллагч ялласан ¹ .	- Шалгагдсан-5 жил - Цагдан хоригдсон-266 хоног - Яллагч 25 жилээр ялласан (шүүхийн шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон)	Эдийн бус хохирол 100.000.000 төгрөг (сэтгэл зүйд болон нэр төрд учирсан хохирол)	Сэтгэл санаанд учирсан хохиролд 15.000.000 төгрөг
2.	Албан тушаалын болон бусдын эд хөрөнгийг завших хэрэг үйлдсэн хэмээн шалгаж, цагдан хорьсон ² .	- Шалгагдсан-9 сар - Цагдан хоригдсон-17 хоног. (мөрдөн байцаалтын шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон)	Эдийн бус хохирол 100.000.000 төгрөг (сэтгэл зүйд болон нэр төрд учирсан хохирол)	Сэтгэл санаанд учирсан хохиролд 10.006.078 төгрөг

¹ Л.Хажидмаагийн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн Баянзүрх дүүргийн шүүхийн 2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 496 тоот шийдвэр.

² Н.Энхзэгийн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн Баянзүрх дүүргийн шүүхийн 2008 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 700 тоот шийдвэр.

3.	Хүнийг санаатай алах, дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн хэмээн шалгаж, цагдан хорьсон ³ .	-Шалгагдсан-4 жил 5 сар -Цагдан хоригдсон-1252 хоног -Цаазаар авах ялаар шийтгүүлсэн.	Сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирол 50.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 20.000.000 төгрөг
		-Шалгагдсан-4 жил 5 сар -Цагдан хоригдсон-1115 хоног -Цаазаар авах ялаар шийтгүүлсэн.	Сэтгэл санаа, бие эрхтний хохирол 39.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 17.000.000 төгрөг
		-Шалгагдсан-4 жил 5 сар -Цагдан хоригдсон-315 хоног. (анхан шатны шүүхэд хэрэг нь хэрэгсэхгүй болсон)	Сэтгэл санаа, бие эрхтний хохирол 20.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 6.600.000 төгрөг
		-Шалгагдсан-4 жил 5 сар -Цагдан хоригдсон-201 хоног. (анхан шатны шүүхэд хэрэг нь хэрэгсэхгүй болсон)	Сэтгэл санаа, бие эрхтний хохирол 15.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 5.000.000 төгрөг
		-Шалгагдсан-4 жил 5 сар -207 хоног цагдан хорьж, эрүүдэн шүүж, амь насыг нь хохироосон.	Сэтгэл санааны хохиролд 35.000.000 төгрөг	Хохирогчийн эхийн сэтгэл санаанд учирсан хохиролд 8.000.000 төгрөг
4.	Шүүхээс оногдуулсан ялаас илүү хугацаагаар хоригдсон буюу хуульбусаар хорих ял эдэлсэн. ⁴	-4 жил 19 хоног хууль бусаар (илүү) хоригдсон.	Сэтгэл санаа, эрүүл мэндийн хохиролд 60.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 5.000.000 төгрөг

³ Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөн нэхэмжлэлтэй (Б.Баатарцогт, Д.Одонтулга, Д.Одонбаяр, Ц.Хүрэлбаатар, Г.Саранцэцэг нарыг төлөөлж) хэргийг шийдвэрлэсэн Хан-Уул дүүргийн шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 07 тоот шийдвэр.

⁴ Ц.Батзоргийн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн Баянгол дүүргийн шүүхийн 2009 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 556 тоот шийдвэр.

5.	Бусдын эд хөрөнгийг завших хэрэг үйлдсэн хэмээн шалгаж, цагдан хорьсон. ⁵	-Шалгагдсан -1 жил 4 сар -Цагдан хоригдсон -15 хоног (мөрдөн байцаалтын шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон)	Нэр төр, алдар хүнд, бие эрхтэн, сэтгэл санааны хохиролд 6.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 1.000.000 төгрөг
		-Шалгагдсан -1 жил 4 сар (мөрдөн байцаалтын шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон)	Нэр төр, алдар хүнд, бие эрхтэн, сэтгэл санааны хохиролд 9.500.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 1.000.000 төгрөг
		Шалгагдсан -2 жил 1 сар (шүүхийн шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон)	Нэр төр, алдар хүнд, бие эрхтэн сэтгэл санааны хохиролд 6.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 300.000 төгрөг
		Шалгагдсан -2 жил 1 сар (шүүхийн шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон)	Нэр төр, алдар хүнд, бие эрхтэн сэтгэл санааны хохиролд 4.500.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 300.000 төгрөг

Дээрх хэргүүдийг шийдвэрлэсэн байдалд дүгнэлт хийхэд шүүх сэтгэл зүйд учирсан хохирлыг шийдвэрлэхдээ хохирлын хэмжээг хэрхэн тооцсон, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ямар үндэслэлээр багасгаж буюу зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн талаараа хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүйгээс гадна хохирлын хэмжээ болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хэрхэн тооцож буй нь тодорхойгүй байна. Судлагдсан хэргийн хүрээнд шүүхээс хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тооцсон байдлыг сэжигтэн, яллагдагчаар тооцож, шалгасан хугацаа болон цагдан хоригдсон хугацаа (хоног), сонссон болон шийтгүүлсэн ялын төрөл зэрэгтэй харьцуулж үзэхэд харьцангуй зөрөөтэй байсан бөгөөд хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг энэхүү шалгуурыг цогцоор нь харгалзан дүгнэх боломжгүй тул жишээ болгон эрүүгийн хэрэгт шалгагдсан болон цагдан хоригдсон хугацаанд харьцуулах замаар 1 хоногт тооцогдох нөхөн төлбөрийн хэмжээг тооцож үзлээ.

№	Шүүхээс сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоосон байдал	Нэг хоногт тооцогдох нөхөн төлбөрийн хэмжээний тооцоо (төгрөгөөр)			
		Шалгагдсан Хоног	Н ө х ө н тө л б ө р и й н хэмжээ	Ц а г д а н х о р и г д с о н хоног	Н ө х ө н тө л б ө р и й н хэмжээ
1.	15.000.000 төгрөг	1825	8219	266	56 391
2.	10.006.078 төгрөг	270	37000	17	588 235

⁵ Өмгөөлөгч Ц.Алимагийн төлөөлөн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн Хан-Уул дүүргийн шүүхийн 2009 оны 10 дугаар 9-ний өдрийн 930 тоот шийдвэр

3.	20.000.000 төгрөг	1590	12 579	1252	15 974
4.	17.000.000 төгрөг	1590	10 692	1115	15 247
5.	6.600.000 төгрөг	1590	4 150	315	20 952
6.	5.000.000 төгрөг	1590	3 145	201	24 876
7.	8.000.000 төгрөг (Амь нас нь хохирсон)	1590	5 031	207	38 647
8.	1.000.000 төгрөг	480	2 083	15	66 666
9.	1.000.000 төгрөг	480	2 083	-	-
10.	300.000 төгрөг	750	400	-	-
11.	3.000.000 төгрөг	750	400	-	-
12.	5.000.000 төгрөг (Хорих ял илүү эдэлсэн)			1479	3 380

Дээрх байдлаас харахад өнөөдөр шүүх хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тодорхой шалгуур, үндэслэлгүйгээр, зөвхөн нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын хэмжээтэй харьцуулж буюу уг шаардлагын тодорхой хувийг багасгах замаар шийдвэрлэж байгаагаас эрүүгийн хариуцлагад татагдсан буюу шалгагдсан нэг хоногт тооцогдох нөхөн төлбөрийн хэмжээ 400-37000 төгрөг, цагдан хоригдсон нэг хоногт тооцогдох нөхөн төлбөрийн хэмжээ 3380-588235 төгрөг байна (дээрх хүснэгтийн аргаар харьцуулахад).

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн сэтгэл зүйн хохирлын төрөл, хэмжээг тогтоож буй байдлын талаар хуульчдаас ярилцлагын аргаар судалгаа авахад судалгаанд оролцсон хуульчид:

- Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас сэтгэл зүйн хохирол нэхэмжилдэг боловч энэхүү хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал байхгүйгээс хохирлын болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох тодорхой ажиллагаа хийдэггүй;

- Сэтгэл зүйн хохирол гэдэгт юуг ойлгох, яаж тодорхойлох талаар онол, практикийн түвшинд тайлбар байхгүйгээс энэ төрлийн хохирлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдаг;

- ЭБШХ-д “сэтгэл зүйн хохирлыг нэхэмжлэх” эрхийг хуульчилсан боловч Иргэний хуульд хохирлын хэмжээг хэрхэн тогтоох, үнэлэх арга замыг хуульчлаагүй учир шийдвэрлэхэд төвөгтэй байдаг гэж хариулжээ.

Харин хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан хэмээн хохирол нэхэмжилж, шүүхэд хандсан хохирогчоос ярилцлагын аргаар судалгаа авахад хохирогчид:

- Шүүх учирсан сэтгэл зүйн хохирлыг маань бодитой үнэлсэнгүй,

хохирол болон нөхөн төлбөрт олгосон мөнгө нь бодитой тогтоогдоогүй. Шоронд хоригдож байх үед ямар хэцүү байсныг бодолцон нөхөн төлбөрийг тогтоох шаардлагатай;

- Сэтгэл зүйн хохирлыг харилцан адилгүй байдлаар буюу заримыг нь өндөр, заримыг нь багаар тогтоодог юм байна лээ. Яагаад ингэж шийдвэрлэдэг нь ойлгомжгүй;

- Сэтгэл зүйд учирсан хохирлыг хэмжих, тогтоох эрх зүйн боломж байдаггүй нь туйлын учир дутагдалтай байна гэж хариулсан юм.

Судалгаанаас шүүх хохирсон хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг харгалзан үзэх боломжтой, бодитой, тодорхой үзүүлэлтийг харгалзан үздэггүй, ийнхүү тооцож үзэх эрх зүйн зохицуулалт, арга, аргачлал байхгүйн улмаас тухайн хэргийг ийнхүү харилцан адилгүй байдлаар шийдвэрлэж байна гэх дүгнэлтэд хүрлээ.

2.2.2. Гадаадын зарим улсад

Монгол Улсад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх тухай эрх зүйн зохицуулалт байгаа боловч уг ажиллагааны улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох, тооцох талаар тусгайлсан зохицуулалт байхгүй учраас гадаад улсын туршлага, олон улсын чиг хандлагыг судалсан юм.²⁷ Үүнд:

Англи

Дээр дурдсан судалгаанаас харахад Англид хууль бусаар хоригдсон хүнд олгох эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээ 13 000-14 000 паунд байна. Эрүүгийн хэрэгт үндэслэлгүй татагдаж 25 жил хоригдсон цэрэгт 350 000 паунд олгож байсан бөгөөд энэ нь жилд дунджаар 14 000 паунд болж байгаа юм.²⁸

- 1973 онд Анди Эванс хэмээх 17 настай цэрэг хуарангийн хажууханд байрладаг сургуулийн сурагч Жудит Робертс гэх охины амийг хөнөөсөн хэрэгт шийтгэгдэж, 25 жилийн хорих ял эдэлсний дараа цагаатгагдсан байна. 2000 онд түүнд олгох нөхөн төлбөрийг үнэлгээчин 945000 паундаар тогтоосон бөгөөд түүний 356000 паунд нь эдийн бус гэм хорын нөхөн төлбөрт, 35000 паунд нь хохирогч амьдралынхаа үлдсэн хугацаанд санхүүгийн зөвлөх ажиллуулах төлбөрт зориулагдсан байв.

- 1990 оны 10 дугаар сард Матрикс Черчил фирмийн 2 захирлыг Ирак дахь цэргийн ажиллагаатай холбогдуулан баривчилсан бөгөөд тэр өдрөөс хойш 2 жилийн дараа сулласан байна. Энэ хугацаанд баривчлагдсан этгээдүүдийн бизнесийн нэр хүнд унаснаас үйл

²⁷ Minnesota law review, 2007.

²⁸ <http://www.aic.gov.au/publications/current%20series/landi/341-360/landi356/view%20paper.aspx>

ажиллагаа нь бүрэн зогсонги байдалд оржээ. Эрүүгийн хэрэгт үндэслэлгүй татагдаж, цагдан хоригдсоныхоо нөхөн төлбөрт тэд 4 сая паунд гаргуулжээ.

Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хуулийн дагуу олгох нөхөн төлбөр эсвэл *ex gratia*²⁹ нөхөн төлбөр гэдгээс нь үл хамааран иргэний эрх зүй дэх гэм хорын үнэлгээтэй адилхан арга хэрэглэнэ.

• Карл Брижвотерийг хөнөөсөн хэрэгт хилсээр шийтгэгдсэн Винсент Хикэй болон Майкл Хикэй нарт олгох нөхөн төлбөрийг үнэлэхдээ “амьжиргааны хэмнэгдсэн зардал” гэсэн ойлголтыг харгалзан үзсэн байна. Энэ нь хохирогч хоригдож байх хугацаандаа амьжиргааны ямар нэгэн зардал гаргах шаардлага гараагүй учраас хоригдоогүй бол зайлшгүй гарах байсан зардлаа хэмнэсэн гэсэн үг юм.

Нөхөн төлбөрийн үнэлгээнд ийнхүү амжиргааны хэмнэгдсэн зардлыг харгалзан үзсэнээр олон эсэргүүцэлтэй тулгарсан байна. Ноён Хилл хилсээр 16 жил хорих ял эдэлсэн бөгөөд түүнийхээ нөхөн төлбөрөөс 50 000 паундыг хэмнэсэн амжиргааны зардалд хасуулжээ. Тэрээр үүнийг эсэргүүцэн “хоригдож байхдаа идсэн хоол, унтаж байсан өрөөний төлбөрийг надаас авч байгаа нь намайг анхнаасаа хилсээр энэ хэрэгт холбогдуулан хорьсонтой дүйцэхүйц шударга бус явдал. Намайг шоронд хоригдож байх хугацаанд миний гэр бүл орон байраа алдсан боловч тэдэнд ямар нэгэн нөхөн төлбөр олгоогүй. Гэсэн ч, төр өөрийн мөнгөө буцаан авахыг санаархаж байна. Ингэснээрээ аль хэдий нь үхлүүт болтлоо зодуудаад байгаа хүний толгой руу нэмж өшиглөж байгаатай адил хэрэг болж байна” гэжээ.

Австрали

• 4 жил хилс ял эдэлсэн Линди Чамберли 1.3 сая долларын *ex gratia* нөхөн төлбөр, 366000 доллар хууль зүйн туслалцаа авсаны төлбөрт гаргуулсан байна.

• 2000 онд хилс хэрэгт 16 жил хорих ялаар шийтгүүлсэн 3 холбогдогч 7 жил хоригдсоныхоо эцэст цагаадан хүн нэг бүр 100 000 долларын “*ex gratia*” нөхөн төлбөр авсан.

• Эхнэрээ алсан хэрэгт ял шийтгүүлэн 8 жил хорих ял эдэлсэн Доглас Рендел 100 000 долларын *ex gratia* нөхөн төлбөр авсан.

Польш

• Польш Улсын Краков хотын давж заалдах шатны шүүхийн 2008 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн шийдвэрийг судалж үзэхэд шүүх нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо харгалзан үзвэл зохих нөхцөл байдлын талаар дараахь дүгнэлтийг хийжээ. Үүнд:

1. Хилсээр хоригдсон хугацаа;

2. Тухайн ялыг эдэлж байхад амссан шаналал;

3. Байгалиас заяагдсан хувь хүний ёс зүйг зөрчсөн хэлбэр (сэтгэлийн

²⁹ Compensation payments are often made *ex gratia* when a government or organisation is prepared to compensate victims of an event such as an accident or similar, but not to admit liability to pay compensation, or for causing the event.

зовиур, нөр төрөө алдах гэх мэт);

4.Хилсээр ял эдлэх явцад албадлага дор байсан байдал;

5.Тухайн орчны онцгой нөлөөлөл;

6.Суллагдсаны дараахь байдал зэрэг багтана.

Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо аль аль талыг нь харсан ултай суурьтай, тухайн нийгмийн бодит нөхцөлтэй харьцуулсан, иргэдийн амьжиргааны өртөг, мөнгөний үнэ цэнэ зэргийг бодолцон тогтоох нь зүйтэй бөгөөд хамгийн гол нь хохирогчийн сэтгэл санааны хохирлыг арилгах, нөгөөтэйгүүр тухайн шүүхийн шийдвэр нь эргээд хохирогчид ямар нэгэн байдлаар ашиг олох арга хэрэгсэл болохгүй байх нь чухал гэж үзжээ.³⁰

• А.Петрт 33 сарын турш хилсээр цагдан хоригдсоны төлөө 144 мянган злотын нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн (3 злот=1 ам.доллар) анхан шатны шүүх 24 мянган злотыг эдийн хохиролд, 120 мянган злотыг эдийн бус хохиролд тооцож шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг Польш Улсын Дээд шүүхээс хэвээр үлдээн шийдвэрлэсэн байна. А.Петр нь төрсөн эхийгээ алуулахаар Якубов гэгч этгээдэд захиалга өгсөн тухай 2001 оны 11 сард Прокуророос яллах дүгнэлт гаргасан. Тухайн дүгнэлтийг гаргахдаа Петрын эх түүнд мэдэгдэлгүйгээр хувийн байшинг нь зарж, зарсан мөнгийг хуваалцаагүйн улмаас тухайн гэмт хэргийг үйлдсэн гэж үзжээ. Анхан шатны шүүхээс Петрыг бусдыг захиалгаар алахыг завдсан хэрэгт 4 жилийн хорих ял оногдуулсан байна. Улсын Дээд шүүх Петрийн гомдлоор хэргийг хянаж, тус шүүхийн тогтоолыг хүчингүй болгон, Петрт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дээрх процесс нийтдээ 33 сарын турш үргэлжилсэн ба энэ хугацаанд А.Петр цагдан хоригдож байсан байна.³¹

2.3. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох шалгуур, боломж, нөхөн төлөх мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох асуудал

Хуулийн үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоохын тулд түүнд харгалзах үзүүлэлт буюу шалгуур, боломж, мөн мөнгөн төлбөр төлөх төлбөрийн хэмжээг хэрхэн тогтоох асуудлыг олон улсын чиг хандлага, туршлагатай харьцуулан авч үзэх шаардлагатай юм:

1. Сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтооход харгалзах үзүүлэлт. Судлагдсан хэргийн хүрээнд авч үзэхэд сэтгэл зүйн хохирлын

³⁰ <http://www.zielona-gora.p.o.gov.pl/index.php?id=27&idx=2&idp=1521>

³¹ http://prawo.gazetaprawna.pl/artykuly/30893.sn_ulrzymal_odszkodowanie_z_niesluszny_areszt.html

хэмжээ, нөхөн төлөх мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо ямар үзүүлэлт, нөхцөл байдлыг харгалзан, хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, шүүх ямар хэмжээний хохирол учирсан болох, нөхөн төлбөрийн хэмжээг юуг үндэслэн, хэрхэн тогтоосон талаар хууль зүйн үндэслэлтэй, бодитой дүгнэлт хийгээгүй байна. Ийм учраас эхний ээлжинд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоохын тулд дараахь үзүүлэлтийг зайлшгүй харгалзан үзвэл зохино. Үүнд:

- а) Гэмт хэрэгт шалгагдсан хугацаа;
- б) Баривчлагдсан, цагдан хоригдсон хугацаа;
- в) Сэрдэгдэн шалгагдсан гэмт хэргийн ангилал;
- г) Гэмт хэрэгт шалгагдах хугацаанд эрүүдэн шүүлтэд өртсөн эсэх;
- д) Хэргийг хэрэгсэхгүй болгосон шат;
- е) Хилсээр шийтгүүлсэн ялын төрөл;
- ж) Хилсээр шийтгүүлсэн тоо;
- з) Хилсээр ял эдэлсэн хугацаа;
- л) Хилс ял эдэлсэн дэглэм;
- м) Эрүүл мэндэд нь нөлөөлсөн байдал;
- н) Ажил хэрэг, хувийн амьдралд нь нөлөөлсөн байдал.

Дээрх нөхцөл байдал, үзүүлэлт нэг бүрт тодорхой үнэлэлт өгсний эцэст сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг зэрэглэх замаар тогтоох боломжтой бөгөөд ийнхүү тогтоох нь хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тал талаас нь бүрэн бодитой тогтоох ач холбогдолтой юм.

2. Сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох боломж.

Судалгаагааны үр дүнд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг бодитой тогтоох дараахь арга, аргачлал, боломж байж болох юм. Үүнд:

- Дээр дурдсан харгалзах үзүүлэлт тус бүрт үнэлэлт өгөх замаар хохирлын хэмжээг зэрэглэн тогтоох;

- Хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг мэргэшлийн шинжээч томилох замаар тогтоох;

- Сэжиглэгдэн шалгагдсан гэмт хэргийн ангиллаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харгалзан тарифлах замаар сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох.

Дээрх боломжийг нэг бүрчлэн авч үзэхэд сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтооход харгалзах үзүүлэлт бүрт үнэлэлт өгөх замаар сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох нь илүү бодитой байх шинжтэй юм. Учир нь энэхүү харгалзах үзүүлэлтийг баримтлан хохирлын хэмжээг тогтоохын ач холбогдол нь хууль бус ажиллагааганы улмаас учирсан

сэтгэл зүй, бие махбод, эрүүл мэнд зэрэгт зайлшгүй нөлөөлөхүйц үзүүлэлтийг зөв тогтоон үнэлэлт өгснөөр сэтгэл зүйн хохирлын хэмжээ олон талаасаа, бодитой тогтоогдох боломжтой юм.

Харин хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг мэргэшлийн шинжээч томилон Олон улсын 10 дугаар ангилалыг³² баримтлан тогтоолгох нь нэг талаас илүү шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой тогтоогдох боломжтой юм. Энэ ангиллыг баримтлан хуулийн хариуцлагад үндэслэлгүйгээр татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас үүссэн сэтгэл гутралын зэргийг бие болон сэтгэл зүйд үүссэн эмгэг өөрчлөлтийг үндэслэн тогтоох боломжтой боловч энэ нь тухайн хүний онцлог гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул энэхүү судалгааны сэдвийн хүрээн дэх сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтооход учир дутагдалтай байж болно.

Хуулийн хариуцлагад үндэслэлгүйгээр татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас үүссэн сэтгэл зүйн хохирлын хэмжээг хохиргчийн сэжиглэгдсэн, шалгагдсан, шийтгүүлсэн гэмт хэргийн зүйлчлэл буюу хэргийн төрлөөр авч үзэн хэргийн төрөл бүрт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлэх замаар тогтоож болох боловч энэ нь хохиролд харгалзах үзүүлэлт нэг бүрийг хамрахгүйгээс гадна автомат байдлаар тогтоогдох, мөн хохирлын хэмжээ, түүнийг төлөх нөхөн төлбөрийн хэмжээг нэг мөр байдлаар тогтоох (эдгээр нь хууль зүйн хувьд ялгаатай ойлголт) сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй юм.

Ийм учраас судлаачид сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох хамгийн боломжтой арга нь “хохирогчид нөлөөлөхүйц нөхцөл байдал, үзүүлэлтийг маш зөв тогтоохын зэрэгцээ харгалзах үзүүлэлт тус бүрт үнэлэлт өгөх замаар хохирлын хэмжээг зэрэглэн тогтоох” гэж үзсэн болно.

3. Сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалын хувьд судлаачид дараахь саналыг онолын хувьд дэвшүүлж байгаа ажээ. Үүнд:

1. Жирийн хүн тухайн төрлийн хохироос зайлсхийхийн тулд хэдэн төгрөг төлөхөд бэлэн байна вэ гэдгийг судалгаагаар гарган нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох.³³

2. Хохирогчийн сэтгэл зүйн байдлыг засахын тулд түүнд сэтгэлийн таашаал өгч чадах зүйлийг худалдан авах хэмжээгээр тогтоох.³⁴

³² Өвчний олон улсын ангилал. Нэгдүгээр боть. ДЭМБ. Женев хот. 224-237 дахь тал.

³³ Remedies in international human rights law (second edition). Dinah Shelton. 2005. p-343

³⁴ Andrew J. Oswald and Nattavudh Powdthavee. Death, Happiness, and the Calculation of Compensatory Damages. 2007. Germany. p-1

3. Хоригдсон 1 жилд тооцогдох мөнгөний үнийн дүнг тогтоож нийт хоригдсон жилээр үржүүлэх замаар хохирлын хэмжээг тогтоох.³⁵

4. Тусгайлсан хууль гаргах замаар олгож болох нөхөн төлбөрийн дээд, доод хэмжээг тогтоох.

5. Сэтгэл зүйд учирсан хохирол нь объектив байдлаар үнэлэгдэх боломжгүй учраас энэ талаар мэргэшсэн үнэлгээчнийг томилон нөхөн төлбөрийн хэмжээг тухайн тохиолдол (хэрэг) тус бүр дээр тогтоох.

6. Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа ижил төсөөтэй хэргүүдийг судлан нийтлэг жишгийг хэргийн төрөл бүрээр гаргах замаар сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох.

Дээрх байдлаар сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох нь тухайн хохирсон этгээдийн амьдралын буюу санхүүгийн чадварт эсвэл хэт автоматаар, харилцан адилгүй байдлаар тогтоогдох боломжтой тул хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг зэрэглэх байдал (I-IV)-аар тогтоосноор тухайн зэрэглэл бүрт харгалзуулан, сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох нь илүү боломжтой болох юм.

Гурав. Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д заасанчлан төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах үүргийнхээ дагуу хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас хохирол хүлээсэн этгээдийн эрхийг хэрхэн хангаж буйг судалсны үндсэн дээр дараахь дүгнэлтийг хийв.

Судалгаагаар байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал, журам байдаггүй, эрх зүйн зохицуулалт нь боловсронгуй биш учраас хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас учирсан хохирлын болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох ажиллагаа бэрхшээлтэй, шийдвэрлэхэд төвөгтэй тулгамдсан асуудлын нэг болох нь тодорхойлогдсон.

Иймээс хуулийн хариуцлагад үндэслэлгүйгээр татагдсан сэтгэл зүйд учирсан хохирол, түүний нөхөн төлбөрийн хэмжээний үнэлгээ тогтоогүй байгаад зохих түвшинд анхаарч, хохирогчид учирсан

³⁵ <http://www.aic.gov.au/publications/current%20series/land%20341-360/land%20356/view%20paper.aspx>

хохирлыг арилгах, эрхийг нь нөхөн төлбөр төлөх замаар сэргээхэд зориуд анхаарал хандуулж, энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авах нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг бодитой эдлүүлэх баталгааг хангахад нэн чухал байна. Өнөөдөр хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал байхгүй байгаа нь иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд төр хайнга хандаж байгаагийн илрэл бөгөөд хүний эрхийн эрх зүйн баталгааг хэлбэрээс агуулгад шилжүүлэх шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Шүүхийн практик судалгаанаас харахад хохирсон этгээд-нэхэмжлэгчийн сэтгэл зүйн хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг нь хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгах гэх мэтээр шийдвэрлэдэг ажээ.

Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоос харвал зөвхөн эд хөрөнгийн бодит хохирлыг нөхөн төлүүлэх журмыг хуульчилжээ. Харин сэтгэл зүй, бие эрхтэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар үндэсний болон судалсан бусад улсын хууль тогтоомжид төгс байдлаар тусгагдаагүй боловч улс бүр иргэний эрх зүйн хүрээнд сэтгэл зүйн хохирлыг тодорхой тохиолдлуудад нөхөн төлөх нь шударга ёсонд нийцнэ гэдэг дээр санал нэгтэй байгаа нь судалгаанаас харагдахын зэрэгцээ сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ, түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоож буй гадаад улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт, практикийг сайшаан дүгнэх боломжгүй байна.

Судалгааны явцад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас сэтгэл зүйд учирсан хохирол, түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хуулиар тогтоох, хохирсон этгээдийн санхүүгийн чадвар, чадавхийг харгалзан хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, мөн жишиг үнэлгээг нэг тарифаар тогтоох гэх мэт нэлээд санал дэвшүүлсэн байдаг боловч судлагдаж буй сэдвийн хүрээнд авч үзэхэд дурдсан аргаар хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нь учир дутагдалтай, харин сэтгэл зүйд учирсан хохирлыг тооцох харгалзах үзүүлэлтийг үндэслэлтэй тогтоон, түүнийг баримтлан хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нь зүйтэй юм гэх дүгнэлтийг хийж, энэ талаар тодорхой санал боловсрууллаа.

Дөрөв. Санал

Судалгааны удирдамжид заасанчлан судалгааны үр дүнд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэнд учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, энэ чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал энэхүү судалгааны гол

зорилго байлаа.

Судалгааны үр дүнгээс харахад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас иргэнд учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох ажиллагааг нэгдүгээрт, сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ тогтоох, хоёрдугаарт, сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох гэсэн үндсэн хоёр шаттайгаар гүйцэтгэх нь илүү бодитой болно гэж үзэж, дурдсан чиглэлээр санал боловсрууллаа. Өөрөөр хэлбэл, дор дурдсан чиглэлээр санал боловсруулсан болно.

1. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох;

2. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох.

Нэг. Сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоохдоо уг хохиролд хамаарах буюу харгалзах бүх үзүүлэлтийг шинж чанараар нь нарийвчлан тогтоож, тэдгээрийг нэг бүрчлэн үнэлэх замаар тогтоох, улмаар уг хэмжээг зэрэглэн тогтоох нь хохирлыг бодитой, мөн хохирогчийн хохирсон байдалд нь нийцэхүйц байдлаар тодорхойлох хамгийн боломжтой арга зам гэж үзсэний үндсэн дээр дараахь үзүүлэлтийг гаргалаа. Үүнд:

- Сэтгэл зүйн хохирлыг тодорхойлоход харгалзах үзүүлэлтийг уг хохиролд нөлөөлж болохуйц үзүүлэлтийг ерөнхийгөөс нарийвчилсан үзүүлэлтээр тодорхойлов. Энэхүү үзүүлэлтийг судлагдсан хэргийн материал, шийдвэр (2006-2008 онд шийдвэрлэгдсэн)-ийг харьцуулан, тэдгээрт дүн шинжилгээ хийх замаар гаргасан болно;

- Уг үзүүлэлт бүрт харгалзах үнэлгээг дараахь аргачлалаар тогтоолоо:

- Хилсээр эдэлсэн ялын дээд хэмжээнд харгалзах “үнэлгээ буюу тоо”-г эхлэн оноов;

- Дээрх “үнэлгээ буюу тоо”-той жиших замаар бусад үзүүлэлтэд харгалзах үнэлгээг “харгалзах үзүүлэлт бүрийн сэтгэл зүйд үзүүлэх нөлөөлөл”-ийг харгалзан гаргав.

- Дээрх байдлаар тогтоосон үнэлгээний дүнг харгалзан сэтгэл зүйн хохирлын хэмжээг зэрэглэн тогтоох аргачлалын талаархи саналыг дараахь хүснэгт хэлбэрээр боловсрууллаа.

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ (зэрэглэл)-г тогтоох аргачлал (Хүснэгт-1)

Д/д	Хохирлыг тооцоход харгалах үзүүлэлт		Үнэлгээ	Дүн
	Ерөнхий	Нарийвчилсан		
1.	Шалгагдсан хугацаа ³ⁿ	1 хоног	1	
2.	Баривчлагдсан буюу цагдан хоригдсон хугацаа	1 хоног	4	
3.	Холбогдон шалгагдсан гэмт хэргийн ангилал	Онц хүнд гэмт хэрэг	2000	
		Хүнд гэмт хэрэг	1500	
		Хүндэвтэр гэмт хэрэг	1000	
		Хөнгөн гэмт хэрэг	500	
4.	Эрүүдэн шүүлт хэрэглэсэн байдал	Эмнэлгийн эрүү шүүлт ¹⁷	700	
		Бие махбодийн эрүү шүүлт ¹⁸	600	
		Сэтгэл санааны эрүү шүүлт ¹⁹	500	
5.	Хэргийг хэрэгсэхгүй болгосон шат	Хяналтын шатны шүүх	700	
		Давж заалдах шатны шүүх	600	
		Анхан шатны шүүх	500	
		Прокурорын хяналт	300	
		Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт	200	
6.	Шийтгэгдсэн ялын төрөл	Цаазаар авах ял	700	
		10-25 жил хорих ял	500	
		5-10 жил хорих ял	400	
		1-5 жил хорих ял	300	
		Хорихоос өөр төрлийн ял	200	
7.	Ял шийтгүүлсэн тоо (хэдэн удаа ял шийтгүүлсэн болох)	5-е дээш удаа	300	
		3-5 удаа	200	
		1-3 удаа	100	
8.	Хилсээр эдэлсэн ял (ял эдэлсэн дэглэм, хоногоор)	Цаазаар авах ялыг гүйцэтгэсэн	90000	
		Гянданд (1 хоног)	10	
		Онцгой дэглэмтэй хорих ангид (1 хоног)	18	
		Чанга дэглэмтэй хорих ангид (1 хоног нь)	6	
		Жирийн дэглэмтэй хорих ангид (1 хоног)	4	
		Баривчлах ял (1 хоног)	2	
		Албадан ажил хийлгэх ял (1 цаг)	0.2	

9.	Эрүүл нөлөөлсөн байдал	мэндэд	Үхэлд шууд хүргэх өвчин	60000
			Үхэлд шууд хүргэхгүй боловч эдгэрэлт удаан (1 жилээс дээш)-тай өвчин	20000
			Удаан хугацаанд шаналал үүсгэх өвчин (1-12 сар)	5 000
			Хурдан эдгэрэх хөнгөн өвчин (1сараас бага)	1000
Сэтгэл зүйн хохиролд харгалзах үзүүлэлтийн үнэлгээний дүн				

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ (зэрэглэл)-г тогтоох аргачлал (Хүснэгт-2)

Сэтгэл зүйн хохирлын зэрэглэл (хэмжээ)	Сэтгэл зүйн хохиролд харгалзах үзүүлэлтийн үнэлгээний дүн
I	705-10 000
II	10 001-25 000
III	25 001-40 000
IV	40 000-с дээш

Ийнхүү судалгааны үр дүнд үндэслэн хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг хөнгөнөөс хүнд рүү зэрэглэх хэлбэрээр I-IV зэрэгт ангилан тогтоох аргачлалын саналыг боловсрууллаа.

Хоёр. Сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоохдоо сэтгэл зүйн хохирлын зэрэглэл буюу хэмжээнд үндэслэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлэх замаар тогтоосон бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх хэмжээг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд заасан торгох ялын дээд, доод хэмжээг харгалзан тогтоосон болно. Өөрөөр хэлбэл, сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн доод хэмжээг торгох ялын доод хэмжээ буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, дээд хэмжээг мөн торгох ялын дээд хэмжээ буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тогтоосон болно.

Сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг ийнхүү хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон торгох ялын доод, дээд хэмжээтэй уялдуулан тогтоосон нь нөхөн төлбөрийн хэмжээг хэт их буюу хэт бага тогтоохгүй байх, тухайн цаг үеийн эдийн засгийн харилцаа, мөнгөний ханшид нийцсэн, бодитой байх баталгааг хангах ач холбогдлыг харгалзан үзсэн юм.

Дээрх үндэслэлийг харгалзан сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг дараах хүснэгтийн аргаар тогтоолоо.

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учиосан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал (Хүснэгт 3)

Сэтгэл зүйн хохирлын зэрэглэл (хэмжээ)	Сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх хэмжээгээр)
I	5-80
II	81-150
III	151-300
IV	301-500

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг дээрх хүснэгтийн аргаар тооцож үзэхэд 540000-54000000 төгрөг болж байгаа юм.

Судалгааны явцад судлагдсан хэргийн хүрээнд нэхэмжлэгч нарын сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ, түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг дээрх аргачлалаар тооцож үзэхэд нэлээд бодитой дүн гарч байсныг хэлэх хэрэгтэй.

Иймд судалгааны үр дүнд боловсруулагдсан аргачлалыг туршиж, түүнийг улам бүр боловсронгуй болгон улмаар зохих эрх бүхий бйагууллага, албан тушаалтнаар батлуулан мөрдүүлэхийн зэрэгцээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн заалтыг хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтооход харгалзах үзүүлэлт, түүнийг үнэлэх, нөхөн төлбөрийн хэмжээг хэрхэн тооцох асуудлыг журамласан зохицуулалтыг нэмэх замаар боловсронгуй болгох шаардлагатай байна.

ӨВ ХҮЛЭЭН АВАХ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ



ХЗҮХ-ийн Иргэн,
эдийн засгийн эрх
зүйн секторын эрдэм
шинжилгээний ажилтан
Д.Тамир

Өв залгамжлалын эрх зүйн харилцааг үндсэнд нь Монгол Улсын иргэний хуулиар¹ зохицуулж байна. Уг харилцаа нь эд хөрөнгө болон эрхийг хууль болон гэрээний үндсэн дээр олж авч байгаа хэлбэр юм. Тодорхойлж хэлбэл, өв залгамжлалын харилцаа нь гэрээслэл, хэрэв гэрээслэл байхгүй бол хуульд заасан үндэслэлээр үүсч байдаг.

Гэхдээ манай орны хувьд зан заншил, уламжлал соёлоос шалтгаалан гэрээслэлийн үндсэн дээр өв залгамжлалын харилцаа үүсэх нь ховор байдаг. Мөн чанартаа бол өв залгамжлуулагчийн хүсэл зоригийн илэрхийлэл нь тухайн харилцаанд тэргүүн ач холбогдолтой байх нь ойлгомжтой юм. Тийм ч учраас Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хуульд заасан өв залгамжлалыг

гагцхүү өвлүүлэгч гэрээслэлээр өөрчлөх эрхтэй” байхаар заасан. Мөн үүнийг иргэний эрх зүйд нэг талын хэлцэл ч гэж нэрлэдэг.

Хэрэв өв залгамжлалын харилцаа нь гэрээслэлээр үүсч байгаа бол түүнд дараах 2 шаардлага тавигдана.

- Агуулгын;
- Хэлбэрийн.

Гэрээслэлийн агуулга

Өв залгамжлуулагч нь гэрээслэл үйлдэхдээ Иргэний хуулийн 55 дугаар бүлгийн² зохицуулалтад нийцүүлсэн байна гэсэн үг. Жишээ нь: Өвлөгдөх эд хөрөнгийн хоёрны нэгээс доошгүй хэсгийг хууль ёсны өв залгамжлагчид зайлшгүй өвлүүлнэ г.м. Үүнийг өв залгамжлагчдын эрх ашгийг хамгаалах зарчим³ гэж ном зохиолд тэмдэглэсэн байх нь бий.

Гэрээслэлийн хэлбэр

Гэрээслэлийг эрх бүхий этгээдээр зайлшгүй гэрчлүүлсэн байх нь хэлбэрийн шаардлага бөгөөд үүнийг Иргэний хуулийн 523 дугаар зүйлд толорхойлсон байдаг. Гэвч хуулийн уг зохицуулалт нь зарим талаар хэт ерөнхий байдаг тул Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Нотариатынүйлдэлэ рхлэнхийхзаавар”-ыг баримтална. Уг зааврын 4.9-т гэрээслэлийг гэрчлэх талаар нарийвчлан зохицуулсан байдаг. Энэ нь хэлбэрийн шаардлагад тавигдах эрх зүйн эх сурвалж болно. Хэрэв гэрээслэл нь

¹ “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2002 он, №8

² Гэрээслэлээр өвлөх.

³ Т.Мөнхжаргал, “Өв залгамжлалын эрх зүй”, УБ., 2009 он 12 дахь тал.

хэлбэрийн шаардлагыг хангаагүй тохиолдолд хүчин төгөлдөр бус гэж тооцогдон өв залгамжлалын харилцааг хуульд заасан журмын дагуу зохицуулна.

Өмнө нь дурдсаны дагуу өв залгамжлалын харилцаа ихэнхдээ хуульд заасан үндэслэлээр үүсч байдаг. Энэ тохиолдолд хууль ёсны өвлөгчдийг зөв тогтоон, өв хүлээн авах, татгалзах журмыг баримтлахдаа сайтар анхаарах нь туйлын чухал байдаг. Өв нээгдсэн үеэс эхлэн хууль ёсны өвлөгчдийн хувьд өв хүлээн авах талаар хоёр ялгаатай хугацаа тоологддог. Ихэнх өвлөгчид хуулийн энэхүү нарийн зохицуулалтыг мэдэхгүйн улмаас өвлөх эрхээ алддаг. Хууль ёсны өвлөгчдийн хувьд Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.1-т заасан “өвлүүлэгчтэй нас барах хүртэл хамт амьдарч байсан” гэсэн объектив талын зайлшгүй байх шинжийг иш үндэс болгон өв хүлээн авах талаар өөр өөр хугацаанд үйлдэл, эс үйлдэл хийхийг шаардаж байдаг. Өвлүүлэгчдийг нас барах хүртэл түүнтэй хамт амьдарч байсан өвлөгчийн хувьд өв нээгдсэнээс хойш 3 сарын хугацаанд өв хүлээн авахаас татгалзах талаар ямар нэг үйлдэл хийгээгүй (эс үйлдэл) бол өвийг хүлээн авсан гэж үздэг⁴ бол хууль ёсны боловч өв нээгдэх үед өвлүүлэгчээс тусдаа амьдарч байсан өвлөгч өвийг хүлээн талаар хуульд заасан ямар нэг үйлдэл хийгээгүй тохиолдолд түүнийг өв хүлээн авахаас татагалзсан гэж үздэг⁵.

Иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар төдийлэн хангалттай бус байгаагаас шалтгаалан өв хүлээн авах талаар хуульд заасан журмыг зөрчих нь бий. Практикт үүнээс болж маргаан үүсдэг. Өвлөгчдийн энэхүү маргааныг шийдэхийн тулд дээр дурдсан хамт амьдарч байсан гэдгийг тогтоох шаардлага тулгарч байдаг. Үүнд дараах “гарц” байж болох юм гэж судлаачийн хувьд үзэж байна. Засаг захиргааны хамгийн анхан шатны нэгж болох баг, хороонд “Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр”⁶, “Өрхийншуурхай дэлгэц”-д гэр бүлийн гишүүдийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг тэмдэглэж байдаг. Энэхүү баримт бичиг нь дээрх нөхцөл байдлыг тогтоох нотлох баримт болж байдаг. Гэвч энэ нь мал аж ахуй эрхэлдэг, нүүдлийн соёл иргэншилтэй манай орны хувьд нөхцөл байдлыг бүрэн дүүрэн тодорхойлох боломж биш юм. Тодруулж хэлбэл, орон нутагт өвлүүлэгчтэй хамт амьдарч байгааг ийм байдлаар тодорхойлох боломжгүй байх нь бий. Учир нь өвлөгч нь өвлүүлэгчтэй хамт амьдарч байгаа боловч төрийн захиргааны байгууллагад бүртгүүлээгүй байх нь элбэг байдаг. Энэ тохиолдолд хэрэг маргааныг гэрчийн мэдүүлгийн тусламжтайгаар шийдвэрлэх боломжтой байдаг. Энд гэрчийг сонгож авах асуудал гарч ирдэг. Ингэхдээ өвлөгч өвлүүлэгч хоёрын харилцааг хамгийн удаан хугацаанд мэдэж болох талаас нь сонгож авах нь хамгийн дөхөмтэй байдаг. Гэхдээ нэг зүйлийг онцлон хэлэхэд эдгээр аргуудыг тус тусад нь хэрэглэнэ гэж ойлгож болохгүй. Хамтад нь хэрэглэх нь мөн л нээлттэй юм.

⁴ Иргэний хуулийн 528.1

⁵ Иргэний хуулийн 528.3

⁶ УСГ-ын даргын 2006 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 1103 тоот тушаалаар батлагдсан.

БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХТОЙ ХОЛБОГДСОН АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. ...Ямар ч нөхцөлд ... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэжээ. Иймээс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь баривчлах, цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлэх явдал мөн.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 2002, 2007 оны нэмэлт, өөрчлөлтүүдээр баривчлах, цагдан хорих тухай прокурорын саналыг үндэслэн шүүгч захирамж гарган тухайн асуудлыг шийдвэрлэх болсон нь “Улс төрийн ба иргэний эрхийн талаархи олон улсын пакт”-ын шаардлагад төдийгүй “... хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэнийг ч ...баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” гэж хүний халдашгүй чөлөөтэй байх эрх-ийг баталгаажуулан тунхагласан Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн эрх зүйн шинэтгэлийн чухал арга хэмжээ болсон юм.

Иймээс бид Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн энэхүү шинэчилсэн хэм хэмжээг тус орон нутагт шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас хэрхэн хэрэгжүүлж буй явц байдлыг Төв аймаг дахь Сум дундын шүүхүүдийн 2009-2010 оны практикт түшиглэн судалгаа хийх, дүгнэлт гаргах, түүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон билээ.

Энэ хугацаанд “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих” талаар шүүгчийн нийт 531 захирамж гарган түүнийг хэрэгжүүлж иржээ.



Төв аймгийн шүүхийн
шүүгч Д.Гансүх

Нэг. Сэжигтнийг баривчлах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих, өөр газар шилжүүлэн цагдан хорих талаар

Баривчлах, цагдан хорих нь хүний эрхийг тодорхой хугацаанд хязгаарлаж буй төрийн онцгой ажиллагаа тул түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихдаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу туйлын нягт нямбай хандах нь чухал юм.

Хөнгөн гэмт хэрэгтнийг цагдан хорьсон, хорьж мөрдөх хугацааг хэтрүүлсэн зэрэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг ноцтой зөрчсөн дутагдал гаргаагүй нь тус аймаг дахь хууль сахиулах байгууллагуудын энэхүү үйл ажиллагаанд тавих хяналтын үр дүнг тодорхойлж байна.

Гэвч шүүгчийн захирамж, холбогдох материалд хууль хэрэглээний хийгээд бичвэр техникийн шинжтэй зарим дутагдал гарчээ. Тухайлбал, баривчлах, цагдан хорих тухай мөрдөн байцаагчийн зарим тогтоолд түүнийг хянасан прокурор тэмдэглэл хийгээгүй, уг тогтоол бүртгэлд авагдаагүй, шүүгчийн захирамжид тухайн этгээд өмнө нь ямар хугацаагаар баривчлагдсан болон цаашид хэд хоног цагдан хорихоор тогтоосныг тодорхой заахгүй байх, захирамжийн үндэслэх болон тогтоох хэсэгт хуулийн холбогдох заалтыг буруу сонгож хэрэглэсэн, огт хамааралгүй заалт оруулсан, Эрүүгийн хуульд заасан нэр томъёог буруу бичсэн зэрэг дутагдал байна.

Үүнээс зөвхөн нэг зөрчлийг онцлон тэмдэглэхэд “Мөрдөн байцаагч хорьж мөрдөх хугацааг сунгах тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор шүүхэд хүргүүлнэ.” гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5 дахь хэсэгт заасныг шүүгчийн захирамжид бүхэлд нь хуулбарлан дурьдаж ирсэн нь хүний эрхийг хамгаалах үүрэг бүхий шүүхийн байгууллагын зорилтод төдийлөн нийцэхээргүй байна.

Иймээс энэ бүхэн нь цагдан хорих, баривчлах ажиллагааг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд нэн тэргүүнд анхаарах асуудлууд болж байна.

Хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийг цагдан хорихдоо тийнхүү хорих болсон хууль зүйн үндэслэлийг үнэн зөв тогтоох, түүнд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх нь хүний эрхийг бодитой хангахад туйлын чухал ач холбогдолтой. Судалгаанаас үзэхэд сэжигтэн, яллагдагчаар 123 этгээдийг цагдан хорьсоноос 62 буюу 50.4 хувийг хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч эзэлж байна. Эдгээрээс 60 буюу 77.4 хувийг мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан, оргон зайлж болзошгүй гэх үндэслэлээр, 4 буюу 6.4 хувийг өмнө авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн гэх үндэслэлээр, 8 буюу 12.9 хувийг дахин гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэлээр тус тус цагдан хорьжээ. Ийнхүү хүндэвтэр гэмт хэрэгт цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагчийн 48 буюу 77.4 хувийг мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан, оргон зайлж болзошгүй гэх үндэслэлээр цагдан хорьсон нь анхаарал татаж байна. Оргон зайлж болзошгүй гэх үндэслэлээр цагдан хоригдсон этгээдийн нэлээд нь байнгын оршин суух хаягтай, сум, дүүрэг, баг хорооны тодорхой харъяалал бүхий, мөн гэр бүлтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг байжээ.

Цагдан хорьсон үндэслэлийн тухай судалгаа

Үзүүлэлт	Сэжигтэн	Яллагдагч	Бүгд
Цагдан хорьсон бүгд	69	54	123
Цагдан хорьсон үндэслэл:			
- Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн (ЭБШХ 68.1)	9	9	18
- Хүнд гэмт хэрэг үйлдсэн (ЭБШХ 68.1)	26	17	43
Бүгд	35	26	61
- Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн бүгд (ЭБШХ 68.2) үүнээс:	34	28	62
- Өмнө авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн (ЭБШХ 68.2.1)	3	1	4
Эзлэх хувь	-	-	6.4%
- Оргон зайлсан, оргон зайлж болзошгүй (ЭБШХ 68.2.2)	20	28	48
Эзлэх хувь	-	-	77.4%
- Дахин гэмт хэрэг үйлдсэн (ЭБШХ 68.2.3)	5	3	8
Эзлэх хувь	-	-	12.9%

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүнийг өөрчлөхөд мөрдөн байцаагчид 4-5 төрлийн өөр өөр маягт баримтаар тогтоол үйлдэн ирүүлдгийг нэг мөр цэгцлэх, эдгээр маягтыг хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдэд нийцүүлэн шинэчлэж батлах шаардлагатай байна. Үүнээс зөвхөн сэжигтэн, яллагдагчийг цагдан хориход:

1. ЭБША-41 маягт (прокурорын хяналт шаардсан);
2. Баталгагүй маягт (прокурорын зөвшөөрөл шаардсан);
3. ЭБША-39 маягт (прокурорын хяналт шаардсан);
4. ХБМБ-22 маягт (прокурорын зөвшөөрөл шаардсан) зэргийг ашиглаж байна.

Хоёр. Хорьж мөрдөх хугацааг сунгах, татгалзах ажиллагааны талаар

Судалгаанаас үзэхэд шүүгчийн зарим захирамжид тухайн этгээд өмнө нь ямар хугацаагаар цагдан хоригдож байсан, хорьж мөрдөх хугацааг дахин сунгах болсон үндэслэл болон цаашид хэд хоногоор сунгахыг тодорхой заахгүй орхих, мөрдөн байцаагчийн зарим тогтоол огноогүй, тамгагүй зэрэг дутагдал гарчээ. Түүнчлэн, мөрдөн байцаагчийн тогтоол болон прокурорын саналд тухайн этгээд аль ангиллын ямар хэрэгт яллагдаж буй нь тодорхой бус бөгөөд удирдлага болгох хуулийн зүйл, хэсгийг ч оновчтой хэрэглэхгүй байгаа тохиолдол гарчээ.

Баривчлах, цагдан хориход хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь энэ тухай үндэслэлийг тодорхой заасан тогтоол үйлдэж прокурорт танилцуулах бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулахаар зохицуулсан бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох, өөрчлөх, хорьж мөрдөх хугацааг сунгах, татгалзах, сэжигтэн, яллагдагчийг өөр газарт шилжүүлэн цагдан хорих зэрэг асуудлыг өмгөөлөгчийн хүсэлт, хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн саналыг харгалзан хяналт тавьж байгаа прокурор шүүхэд санал гарган хэрэгжүүлэхээр ялгамжтай зохицуулсныг зөв ойлгож хэрэглэх нь чухал юм.

Гэвч тухайн тохиолдолд прокурор тийнхүү саналаа ямар хэлбэрээр ирүүлэхийг хуульд нарийвчлан заагаагүйгээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох тухай мөрдөн байцаагчийн тогтоолд прокурор хянасан гарын үсэг зурсан төдий баримтад үндэслэн түүнийг практикт хэрэгжүүлж иржээ.

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд баривчлах цагдан хорих ажиллагааг шүүхээс хэрэгжүүлэх, түүнд тавих прокурорын хяналтын үр нөлөөг дээшлүүлэх гэдэг ухагдахууныг сэжигтэн яллагдагчийн эрхийг хамгаалах гэдэг ойлголтоос салган авч үзэх ямар ч боломжгүй юм.

Иймээс цагдан хорих, хорьж мөрдөх хугацаа сунгах ажиллагааг шүүхээс хэрэгжүүлэх, түүнд прокуророос хяналт тавихдаа хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг бодитой хангахад анхаарах хамгийн гол асуудал бол олон холбогдогчтой хийгээд гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэл нь тухайн этгээдийн бусдад учруулсан хохирлын хэмжээнээс хамаардаг зарим гэмт хэрэгт холбогдогч нэг бүрийн үйлдэл, оролцоог шуурхай шалгаж тогтоох, материаллаг хохирлын үнэлгээг үнэн зөв, бодитой гаргах явдал туйлын чухал ач холбогдолтой.

Шүүхийн практикт олон холбогдогчтой хулгайн хэрэгт холбогдогч этгээд нэг бүрийн үйлдэл оролцоо хийгээд бусдад учруулсан хохирлын хэмжээг шуурхай бодитой тогтоогоогүйгээс тухайн этгээд олон сар хоногоор цагдан хоригдож эрх нь зөрчигдөх, эцэст хэргийн зүйлчлэлийг зөвтгөснөөр тухайн таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилсөн тохиолдол цөөнгүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар баривчлах, цагдан хорих ажиллагааг шүүхээс хэрэгжүүлэх, түүнийг хянах арга журмыг улам нарийвчлан зохицуулж өгсөн нь түүнд тавих прокурорын хяналтын үр нөлөөг үгүйсгэсэн хэрэг биш, харин ч шүүх, прокурорын эрх бүхий ажилтнуудын нэгдмэл ажиллагаагаар хүний халдашгүй эрхийг илүү бодитой хангахад чиглэсэн төрийн бодлогын бодит илэрхийлэл гэж үзэх ёстой.

Гэтэл төрийн бодлого, хуулийн энэхүү зорилго, өөрчлөлтийн ач

холбогдлыг тэр бүр ойлгохгүй, хүний эрхийн энэхүү эмзэг нарийн асуудалд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорууд бие биедээ хэт найдаж хайхрамжгүй хандах дутагдал гаргаж байгааг анхаарах шаардлагатай.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсэгт сэжигтнийг баривчлахдаа шүүгч тогтоолыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор шийдвэрлэхээр, мөн хуулийн 68 дугаар зүйлийн хуулийн 68.3 дэх хэсэгт сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тогтоолыг прокурорын танилцуулснаар шүүгч тухайн асуудлыг шийдвэрлэж нэн даруй захирамж гаргахаар, 68 дугаар зүйлийн 68.4 дэх хэсэгт сэжигтэн, яллагдагчийг цагдан хориход прокурор тогтоолыг баривчлах хугацаа дуусахаас 6 цагийн өмнө шүүхэд хүргүүлэхээр, мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5, 69.6 дахь хэсэгт хорьж мөрдөх хугацааг сунгуулахдаа үндэслэл бүхий тогтоол үйлдэж хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор шүүхэд хүргүүлэх, шүүгч цагдан хорих хугацаа сунгах саналыг 72 цагийн дотор шийдвэрлэж байхаар тус тус зохицуулжээ.

Үүнээс зөвхөн “хорьж мөрдөх хугацаа сунгах тухай мөрдөн байцаагчийн тогтоол үйлдсэн, түүнийг прокурорт танилцуулсан, шүүхэд хүргүүлсэн, шүүхээр шийдвэрлэсэн хугацааны байдал”-д дүгнэлт өгөх зорилгоор судалгаа хийхэд (2009 оны баримт) хорьж мөрдөх хугацааг сунгах тухай мөрдөн байцаагчийн 89 тогтоол гаргаснаас дийлэнхийн хугацаа дуусах тухайн өдрөө үйлдэж прокурорт шилжүүлсэн, прокурор түүнийг хянаад 74 буюу 83.1 хувийг тухайн өдөрт нь шүүхэд санал гарган шилжүүлсэн, шүүх тогтоол, саналыг хүлээн аваад 60 буюу 67.4 хувийг тухайн хүлээн авсан өдөрт нь шийдвэрлэсэн байх юм. Үүнээс үзэхэд мөрдөн байцаагчид цагдан хорих, баривчлахтай холбогдсон эрхийн акт үйлдэх, түүнийг прокурор, шүүхэд танилцуулахдаа хуулиар нарийвчлан зохицуулсан хугацааг зөрчдөг, ингэснээр түүнд хяналт тавих үүрэг бүхий субъектуудын үйл ажиллагаанд бэрхшээл учрах, цаг хугацаагаар хавчигдах зэрэг зөрчил үүсэж байгааг зогсоох шаардлагатай.

Зарим тохиолдолд мөрдөн байцаагч, прокурорууд шүүгчийг хэргийн материалтай судалж танилцахыг хүлээлгүй өрөөнд нь сахиж байгаад захирамж гаргуулдаг практик ч тогтсон нь туйлын зохимжгүй байна. Шүүгч ч энэ байдлаас эрс татгалзах ёстой.

Баривчлах, цагдан хорих талаар гарсан шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхийг хуульд нарийвчлан зохицуулаагүй гэж Хүний эрхийн комисс болон зарим байгууллага шүүмжлэлтэй ханддаг.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 114.2 дахь хэсэгт “Гомдлыг Ерөнхий шүүгч, эсхүл түүний томилсон шүүгч 48 цагийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ хугацаанд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр

үйчилнэ" гэжээ. Тэгвэл Ерөнхий шүүгч гомдлыг хэрхэн ямар журмаар шийдвэрлэх вэ?, тухайн тохиолдолд ямар төрлийн эрхийн актыг хэрхэн гаргах вэ? гэдгийг хуулиар тусгайлан зохицуулаагүй байна. Энэ тохиолдолд мөн хуулийн 113 дугаар зүйлийн 113.6 дахь хэсэгт зааснаар Ерөнхий шүүгч тухайн гомдлыг хянан шийдвэрлээд гомдлыг хангаж шүүхийн шийдвэрийг өөрчлөх, гомдлыг хангахгүй орхих шийдвэрийн аль нэгийг гаргаж болох юм. Гэвч УДШ-ээс энэ талаар нарийвчлан зохицуулсан тайлбар, зөвлөмж гаргаагүйгээс шүүхүүд хуулийн тухайн зүйл, заалтыг өөр өөрөөр ойлгон хэрэглэх сөрөг үр дагаварт хүргэж байна.

Гурав. Дүгнэлт, санал

Баривчлах, цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлж буй ажлын явц байдлын талаар тэмдэглэгдсэн зөрчил, дутагдлыг таслан зогсооход зохион байгуулалтын доорхи арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн өмнө тэмдэглэгдсэн зарим заалтад УДШ-ийн тайлбар, зөвлөмж гаргуулах саналыг эрх бүхий байгууллагад уламжлах;

2. Цагдаагийн байгууллагаас энэ талаар гаргадаг олон төрлийн өөр өөр маягтыг шинэчлэн цэгцэлж, нэгдмэл стандарт мөрдүүлэх;

3. Шүүгчийн захирамжийн хууль ёсны үндэслэлийг сайтар хангуулах (эрх зүйн акт хууль ёсны үндэслэл бүхий бөгөөд агуулга нь товч, тодорхой, бичвэрийн алдаа засваргүй байх шаардлагыг хангах);

4. УДШ-ийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан захирамж, тушаалаар 2008 онд батлагдсан "Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам", Сэжигтнийг баривчлах, сэжигтэн яллагдагчийг цагдан хориход анхаарах зарим асуудлын тухай УДШ-ийн 2008 оны 01 тоот Зөвлөмж зэрэг эрх зүйн актыг нийт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч, түүнчлэн шүүгчдээр сайтар судлуулж, хэрэгжилтийг хангах;

5. Хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийг цагдан хорихдоо тийнхүү хорих болсон хуулийн үндэслэлийг холбогдох нотлох баримтуудад нь тулгуурлан сайтар нягталж хэвших;

6. Баривчлах, цагдан хорихтой холбогдсон ажиллагааг зөв хэрэгжүүлэхэд өмгөөлөгчдийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх;

7. Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг аялдан дагаж зарим үед чанаргүй эрхийн акт

гаргаж буй дутагдлыг таслан зогсоож, түүний зорилго, агуулгыг зөв ойлгох;

8. Хууль сахиулах байгууллагууд энэ чиглэлээр сургалт семинарыг тус тусдаа болон шаардлагатай гэж үзвэл хамтарсан хэлбэрээр зохион байгуулж хэвших;

9. Олон холбогдогчтой болон материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих, хорьж мөрдөх хугацаа сунгахад прокуророос тавих хяналтын үр нөлөөг улам сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ТӨРИЙН АЛБА ДАХЬ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХҮҮЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ



“Авлигын эерэг сан”-
гийн захирал, хууль
зүйн доктор, профессор
Л.Батжав

Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчилд орохоос хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд төрийн албаны боловсон хүчин шилж сонгох, төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэх, хэн нэгэн албан хаагч төрийн албанаас гарсаны дараа эргэж харилцах гэсэн гурван үе шатны харилцааг зохицуулна гэж үзэж байна.

2007 оны байдлаар Монгол Улсын төрийн албанд 120 мянга гаруй албан хаагч ажилладаг гэсэн судалгаа бий. Эдгээрээс Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2-т заасан улс төрийн албан

тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан төрийн тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хамруулах хэрэгтэй. Түүнээс гадна Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшигчийг хамруулах нь зүйд нийцнэ.

Харин төрийн үйлчилгээний албан хаагчийг энэ хуульд хамруулах эсэх талаар өөр бодолтой хүмүүс бий. Миний хувьд Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон асуудлыг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмээр зохицуулж болно гэж үзэж байна. Түүнээс гадна төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн албан хаагч, төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын холбогдох ажилтан зэргийн ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг хэрхэх талаар нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

Энд хамгийн их анхаарал татах ёстой зүйл бол төрийн албанд шинээр орж ирж байгаа боловсон хүчнийг зөвшилж сонгох асуудал юм. Хувийн ашиг сонирхол нь тодорхой хүнтэй хамт байдаг зүйл учраас тэрхүү

сонирхол эзнээ дагаад дуртай ч, дургүй ч байсан төрийн албанд сайн дураар орж ирдэг. Иймд төрийн албаны орчинг цэвэр байлгаж төрийн албыг шударга боловсон хүчнээр бэхжүүлэхийн тулд шинээр ажилд орж ирж байгаа залуусын хувийн ашиг сонирхлыг эхнээс нь хяналтад авч, сургалтад хамруулж, улмаар тухайн этгээд төрийн тодорхой ажил, албан тушаалд тэнцэх эсэхийг нийтлэг шалгуураар шигшин сонгож, өөрийн мэдлэг боловсрол, мэргэжил чадвараар гарч ирснийг нь томилдог журмыг чанд мөрдөх шаардлагатай. Одоогийн байдлаар энэ хяналтын зарчим алдагдаж хэн танил ихтэй, хөрөнгө мөнгөтөй нь албан тушаал дэвших, албан тушаал захиалах, албан тушаал сорчлох зэргээр боловсон хүчинд тавих шаардлагыг сулруулж, төрийн албаны нэр төрийг унагаж байна. Ийм арчаагүй байдлыг арилгахын тулд төрийн албанд шинээр орох хүмүүсийг сонгох шалгуур, тэдэнд тавих шаардлага босго өндөртөй байваас хэн чадалтайнь, өөртөө итгэлтэй нь давж гарах болно. Ийнхү үнэнч шударгаар гарч ирсэн боловсон хүчин төрийн албанд хоёргүй сэтгэлээр ажиллаж, түмэн олонд ойр дотно үйлчилж чадах учраас ашиг сонирхлын зөрчлийн асуудал ард хоцрох бүрэн боломжтой юм. Иймд Төрийн албаны зөвлөл боловсон хүчний асуудалд чухал үүрэг гүйцэтгэх ёстойг хэлэх хэрэгтэй.

Төрийн албаны зөвлөл их, дээд сургууль төгссөн залуусаас яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн жил бүр төрийн албаны шалгалт авч тэнцсэн хүмүүсээ захиалсан газарт нь ажилд томилуулж, үлдсэн хүмүүсийг нөөцөд бүртгэдэг. Тус зөвлөл ажилд орж чадаагүй хүмүүсээ зөвхөн бүртгээд орхих бус тэдэнтэй байнга ажиллах ёстой. Тухайлбал, юуны өмнө тэдэнд төрийн албаны тухай, албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлагын тухай, төрийн албаны ажлын дэг жаяг, зохион байгуулалтын тухай хичээл зааж энэ чиглэлийн тодорхойлолтод, мэдлэгтэй болгохоос гадна амьдрал ахуйг нь судлах, цаашид төрийн албанд ажиллах боломжтой, найдвартай эсэхийг нь тогтоож байх хэрэгтэй. Ингэж хөрөнгө, хөдөлмөр зарцуулж бэлтгэсэн боловсон хүчнээсээ сонгож дараагийн жилд нь төв, орон нутгийн захиалгын дагуу ажилд томилуулах арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байвал хэн нэгний татаа түлхээсээр чадвар муутай явуулын хүн төрийн албанд шургалж чадахгүй, шалгалт өгч тэнцээд нөөцөд бүртгүүлсэн хүмүүс тул илүү итгэл найдвар төрүүлэх бодит жишээ болох юм. Энэ хэмжээгээр төрийн албаны шалгалтын нэр хүнд, үр дүн сайжирч, төрийн алба чадварлаг, шударга боловсон хүчнээр жил тутам сэлбэгдэж байх нөхцөл бүрдэнэ.

Төрийн албан хаагч ажил, үүргээ гүйцэтгэж байхдаа ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж үнэнч шударгаар төр, ард түмэндээ үйлчлэхийн тулд, төрийн албыг элдэв бусармаг үйлдлээс

хамгаалахын тулд дор дурдсан зарчмыг баримталж ажиллах ёстой. Тухайлбал, нэгдүгээрт, Үндсэнхууль, Төрийн албаны тухай хуульд зааснаар ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх ёс, ил тод байх, ард түмэнд чин үнэнчээр үйлчлэх, хоёрдугаарт, албан тушаалын бүрэн эрхээ мэргэшлийн өндөр түвшинд үр ашигтай хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх, гуравдугаарт, өөрийгөө ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс цаг ямагт урьдчилан сэргийлэх, дөрөвдүгээрт, өөртөө болон бусдад ашиг хонжоо олгоход албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахаас татгалзах, тавдугаарт, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар өөрт нь болон гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн, харилцагч этгээд ашиг хонжоо бүхий эдийн бус ашигтай, давуу байдлыг бий болгоход ашиглахаас татгалзах, зургадугаарт, албан үүргээ биелүүлэх явцад олж авсан албаны болон бусад мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх, бусад этгээд ашиглахаас урьдчилан сэргийлэх, долдугаарт, төрийн өмч хөрөнгө болон төсвийн санхүүжилт, тэрчлэн хандивын хөрөнгийг албан үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд шууд ба шууд бусаар хувьдаа ашиглахгүй, мөн түүнчлэн бусад этгээд ашиглахаас урьдчилан сэргийлэх, наймдугаарт, албан тушаалынхаа байдлыг ашиглаж өөртөө болон бусдад хууль бусаар ашиг хонжоо олох, давуу байдал олгох зорилготой бусад үйлдэл хийхгүй байх, есдүгээрт, албан үүргээ гүйцэтгэх явцадаа олж мэдсэн ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагад өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгөх зарчмыг мөрдөж ажиллахыг төрийн албан хаагч бүр хэрэгжүүлэх ёстой.

Ашиг сонирхлын зөрчлийн нэг сөрөг илрэл бол төрийн албанд ажиллаж байгаа албан хаагч өөрийн давуу талыг уг албанаас гарсны дараа үргэлжлүүлэн ашиглах явдал байдаг. Энэ нь нэгдүгээрт, төрийн албанд байхдаа дараагийн “нүх” (тэтгэвэрт гараад ажилд орох гэх мэт)-ээ бэлтгэх, албаны мэдээллийг нөөцлөх (ямар нэгэн байдлаар ашиглах), ашигтай бизнесийн түншүүдтэй болох, төрийн албан хаагчдаас цаашдаа хамтран ажиллах хүнийг бэлтгэх (ирээдүйд нэг чиглэлээр хоршиж үйл ажиллагаа эрхлэх), хоёрдугаарт, төрийн албанаас гарсны дараа олж авсан албаны мэдээллийг овжиноор ашиглаж хэн нэгэн ашиг сонирхлын зөрчилтэй этгээдэд наймаалах, хамт ажиллаж байсан багийн гишүүддээ зүй бусаар нөлөөлөх, бусдад идэвхитэй зуучлах байдлаар илэрдэг, ийм практик ч байна

Иймд дээр дурдсан зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд Төрийн албанаас гарсан хүний үйл ажиллагаа (эргэж холбоотой байх харилцаа)-нд тодорхой хязгаарлалтуудыг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тогтоож өгөх зайлшгүй шаардлагатай.

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙ БА ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШАЛГУУР

Үндиртгал

Нийгмийн харилцааг зохицуулагч хуулийг бүтээгч нь парламентын гишүүд буюу хууль тогтоогчид юм. Хууль тогтоох үйл ажиллагааны эцсийн үр дүн болсон хууль нь иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, хамгаалснаар, хуулийн хүчин чадал нь оршдог билээ.


Харин сүүлийн үед хүмүүс дээд удирдлагыг авлига, хээл хахуулиас ангид, өөрийн ашиг сонирхлыг хэт бөөцийлэхөөс салгахыг хүсч, Монголын нийгэм, Улсын Их Хурал, намуудыг хэт улс төржиж байгаа нь ажил хохироож, асуудал шийдэхгүй байгааг шүүмжилж байна.¹ Төлөөлөл болгон сонгож, өөрийнх нь эрх ашгийг хамгаалах этгээд дур зоргоороо авирлан, хувийн ашиг сонирхол, эрх ямбын асуудал давамгайлаад ирэхээр асуудлыг шийдэхээсээ илүү өөрийн эрх ашгийг тэргүүн ээлжинд тавьж эхэлнэ. Энэ асуудлыг ард иргэдийн зүгээс илүүтэй зохицуулж чадах арга нь дахин сонгохгүй байх, эсхүл Ёс зүйн хорооны зүгээс гишүүдийн ёс зүйн харилцааг зохицуулсан дүрмийг мөрдүүлэх явдал гэж ойлгодог байна. (Манай улсын парламентын түүхэнд анх удаа парламентын гишүүний ёс зүйн дүрмийг баталсан билээ)². Тэгвэл энэ дүрмийн хэрэгжилт нь парламентын гишүүдэд хэрхэн нөлөөлж буй тэдэнд хүрч үйлчилж чадах эсэх?, парламентын гишүүний ёс зүйн шалгуур үзүүлэлт эрх зүйн хувьд хэрхэн яаж хангагддаг болох?, Монгол Улс болон дэлхийн улс орнуудад хууль тогтоомж, дүрмээр парламентын гишүүний ёс зүйг хэрхэн зохицуулж, шийдвэрлэдэг болохыг харьцуулсан эрх зүй³ болон танин мэдэхүйн хүрээнд онолын маргаан өрнүүлэх⁴ үүднээс энэхүү өгүүллийг бичихийг зорилоо.

¹ Д.Дэмбэрэл, УИХ-ын анхдугаар чуулган дээр хэлсэн үгнээс дам ишлэв. Эх сурвалж: ТУ5 телевиз, www.news.mn

² Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм. (Монгол Улсын Их Хурлын 2009 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан.)

³ Харьцуулсан эрх зүй судлал-Англиар "Comparative law", германаар "Rechtsvergleichung", Оросоор "Сравнительное правоведение". Францаар "Droit compare" гэж нэрлэгдэх энэхүү ойлголт манайд 2000 оноос эхлэн идэвхитэй хэрэглэгдэх болсон юм. Бие даасан салбар эрх зүй биш, хууль зүйн шинжлэх ухааны системд бие даасан тогтолцоо болж хараахан чадаагүй хэдий ч эрх зүйн үнэт зүйлс, онол, философи, институт тогтолцоо, мэдээллийг дэлхийн хэмжээнд харьцуулж нэгтгэн судалж, тодорхойлсон хавсарсан буюу хосолсон мэдлэгийн цогц бүрдэл мөн. Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010 он. 86 дахь тал.

⁴ Академик түвшинд маргаан өрнүүлэх. Прискриптив-байх ёстой буюу байж болох зүйлийн хүрээнд



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V ангийн оюутан Б.Төрболд

Парламентын гишүүний ёс зүй ба түүний эрх зүйн шалгуур үзүүлэлтийн талаар судлагдсан ном¹, сурах бичиг, илтгэл өгүүлэл² одоогоор харьцангуй бага бөгөөд огт хөндөгдөөгүй чухал сэдвүүдийн нэг байгаа тул судлаач оюутан миний сонирхлыг ихэд татаж судлах шалтгаан, нөхцөл болсон.

Нэг. Ардчилсан ёс³ ба хууль тогтоох эрх мэдэл⁴

Бидний олонхи нь ардчиллыг ард түмэн өөрсдийнхөө тусын тулд өөрсдөө засаглаж буй өөрсдийнх нь засаг гэж ойлгодог⁵. “Ард түмний тусын тулд” гэснийг хэн нэг захирагчид бус, гагцхүү иргэдэд өөрсдөд нь үйлчилдэг хэмээн тайлбарладаг. Английн эрх зүйн онолч Жэрэми Бентамын үзлээр ардчилсан төр нь “Засаглуулагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд”⁶ эрх мэдлийг хэрэгжүүлдэг байна. Үүний эсрэг Вольтер “гэгээрсэн эзэн буюу буянлаг дарангуйлагч нь тэртэй тэргүй ард түмнийхээ тусын тулд үйлчилдэг тул ард түмэнтэй зөвлөлдөх шаардлагагүй”⁷, Абрахам Линкольн дурдахдаа “Ард түмний, ард түмнээр, ард түмний төлөө үйлчлэх” гэсэн зарчим мөн бөгөөд Ардчилал гэдэг ард түмний санал бодлоор төрийн эрхийг хэрэгжүүлэх ёстой⁸ гэсэн үзэл санаа дэвшүүлсэн. Парламент засаглалтай ардчиллыг Ханс Кельзен “Шууд бус, парламентын зарчимт ардчилал”⁹ мөн. Парламент¹⁰ бол нийтийн эрх ашгийг илэрхийлсэн ард түмний хянах байгууллага юм. Тэнд аль нэг зах хязгаарын ашиг сонирхол, туйлширсан үзэл бодол захирах (давамгайлах) ёсгүй ба бүх

¹ Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан. “Парламент ёс”. УБ., 2005 он.

Иргэдийн оролцооны ардчилал төсөл. “Парламентын ёс зүйн дэг” УБ., 1998 он.

Бүгд найрамдахчуудын Олон улсын хүрээлэн. Монгол Улсын Их хурал. “Парламентийн гишүүний ёс зүй”. УБ., 2006 он.

² Л.Өлзийсайхан. “Парламентат ёс хэмээхийн учир”. Эрх зүй сэтгүүлийн №01, УБ., 87 дахь тал.

³ Хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хуульчлан хамгаалж, төрийн эрх мэдлийг хуваарилж, иргэний чөлөөт сонгууль, иргэнлэг ёс, эрх зүйт төр, нийгмийн тэгш эрх, шударга ёсыг тогтоон бэхжүүлсэн байдал, хүн, нийгмийн хөгжлийн эрхэм дээд сонголт, эрх зүйт ёсны дэг журам, зарчим, үнэт зүйлс зэрэг багтана.

⁴ Эрх мэдэл хуваарилах зарчмын хувьд ойлгох нь. Төрийн эрх мэдлийн хуваарилалт агуулгын болон хэлбэрийн талтай. Хэлбэрийн хуваарилалтыг Үндсэн хуулиар хийдэг бол агуулгын хуваарилалтыг төрийн албан хаагчдын итгэл үнэмшил, ухамсар, үлс төрийн болон албаны соёлд нь хийх ёстой. Монгол Улсын хувьд хэлбэрийн хуваарилалт буюу Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалана.” 38 дугаар зүйлд “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.” 47 дугаар зүйлд “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэснээс харагдана.

Н.Лүндэндорж. “Төрийн онол”. УБ., 2008 он, 215 дахь тал.

⁵ Ч.Өнөрбаяр. “Ардчилалын суурь философи ба түүний хязгаар” (Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд).

⁶ A Fragment on Government, Ed. Ross Harrison. Cambridge University Press. 1988.

⁷ Мөн тэнд

⁸ Хосей Норота. Япон Улсын Парламентын төлөөлөгчдийн танхимийн гишүүн. “Парламентын засаглалын тухай эргэцүүлэл”. “Эрх зүй” сэтгүүл. 2004/12. 6 дахь тал.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Парламент гэдэг нь Герман, Францаар *parlament*, Англиар *parliament* гэсэн үг бөгөөд “ярих” гэсэн утгатай. “Хууль тогтоох төлөөлөгчдийн байгууллага” гэдэг түгээмэл агуулгаар анх XII зууны Англид бий болсон нэр томъёо гэдэг. Парламент гэдэг нь нийтлэг нэр боловч зарим улс үүнийг орон оноосон нэр хэрэглэдэг. Тухайлбал. Альтинг (Исланди), Бундестаг (Герман), Конгресс (АНУ), Риксдаг (Швед), Сейм (Польш), Стортинг (Норвег). Улсын Их Хурал (Монгол), Фолькетинг (Дани) гэх мэт.

нийтийн ерөнхий оюун санаанаас гарах ерөнхий сайн сайхан зүйл давамгайлах ёстой гэж үзсэн байна.

Харин орчин үеийн ардчиллын онолоор насанд хүрсэн бүх иргэд өөрт хамаатай асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байдаг бөгөөд энэхүү эрх нь тэгш боломжоор хангагдсан байхыг хэлдэг.¹¹ Дэлхий дээр оршин буй улс төрийн дэглэмүүдийг хууль ёсны мөн бишийг нь ардчиллын үзүүлэлтүүдээр шалгах болсон нь үүнтэй холбоотой.

Харин манай улсад энэ шалгуурыг Үндсэн хуулиар баталгаажуулж "...шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй..."¹² гэж эрх олгосон байна. Эндээс Үндсэн хууль гэдэг хүн төрөлхтний түүхэнд гарч байсан хүний эрхийн төлөө тэмцлийн үр дүнд буй болсон соёлын үнэт зүйл бөгөөд юуны өмнө хүн төр хоёрын хоорондын харилцааг зохицуулах үндсэн чиг үүрэгтэй хууль зүйн үйлчилгээний хувьд хамгийн дээд хүчинтэй эрх зүйн хэм хэмжээний цогц.¹³ Мөн хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг юуны өмнө төрийн засаглалын дүр зоргоос хамгаалахад оршдог¹⁴ бамбай ч гэж хэлж болох юм.

Тэгвэл энэхүү асуудлыг Шарль Монтескьегийн төрийн эрх мэдэл хуваарилах онолоор эрх мэдлийг хэрэгжүүлэгч аливаа этгээд түүнийгээ урвуулан ашиглах хандлагатай байх ажээ (*C'est une experience eternelle, que tout homme, qui a du pouvoir, est porte a en abuser*). Төрийн эрх мэдлийг нэг этгээдийн гарт төвлөрүүлсэн тохиолдолд түүнийг урвуулан ашиглах аюул үүснэ гэх Монтескьегийн болгоомжлол юм. Тиймээс хүний эрх чөлөөний ашиг сонирхолд нийцүүлж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг бие биенээс нь салгах шаардлагатай¹⁵ гээд хууль тогтоох эрх мэдэл¹⁶ гэж салгаж тусад нь авч үзсэн.

Мөн Монтескьегийн адилаар И.Кант ч гэсэн төрийн засаглалын абсолют (*absolute*)¹⁷ шинжтэй аливаа хэлбэрийг шүүмжилсэн байдаг.

Засаглалын эрх мэдлийг өөр хооронд нь салгаад зогсохгүй эрх

¹¹ Ч.Өнөрбаяр. "Ардчилалын суурь философи ба түүний хязгаар" (Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд). Өгүүлэл, 1 дэх тал.

¹² 2 дугаар бүлэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалт, Монгол Улсын Үндсэн хууль 1992 он. Төрийн мэдээлэл сэтгүүл, №01.

¹³ Г.Совд. Монгол Улсын Үндсэн хууль. Хүний эрх (харьцуулсан судалгаа). УБ., 1999, 9 дахь тал.

¹⁴ Конституционное (государственное) право зарубежных стран. Общая часть. Москва 1996, 104 дэхь тал.

¹⁵ Юрген Харбих. "Орчин үеийн үндсэн хууль төрийг тодорхойлох нь". УБ., 2005.06.15, Монгол Улсын Шилжилтын үе дэх эрх зүйн шинэтгэл. Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Ханс-Зайделгийн сангийн хооронд хамтын ажиллагаа хэрэгжүүлж эхэлсний 10 жилийн ойд зориулсан олон улсын симпозиум. 5 дахь тал.

¹⁶ Montesquieu, The Spirit of the laws. 1748, N.Y harpers, 1949, II(3). "Хуулийн амин сүнс" бүтээлийнхээ арван нэгдүгээр номын "Английн төрийн байгууламжийн тухай" гэсэн зургадугаар бүлэгт эрх мэдэл хуваарилах замаар төрийн дүр зорыг хязгаарлаж болох тухай онолоо боловсруулав. Тэрээр төрийн тогтолцоо зөв мэргэн зохимон байгуулагдсан цагт л хүний эрх чөлөө жинхэнэ есоор оршино гэдгийг Английн улс төрийн амьдралаас олж харжээ. Н.Лүндэндорж. "Төрийн онол". УБ. 2008 он. 207 дахь тал.

¹⁷ E. Chinbat. English Mongolian dictionary second edition. UB., 2003, p.7.

Absolute-Бүрэн дүүрэн, гарцаагүй, маргаангүй үнэмлэхүй, туйлын маргаангүй гэж орчуулсан.

чөлөөны эрх ашигт нийцүүлэх үүднээс нэг этгээдийн гарт төвлөрүүлж болдоггүй. Төрийг И.Кант: “Хууль эрх зүйд захирагддаг хэсэг хүмүүсийн нэгдэл” гэнэ. Хууль тогтоомж нь төрийн эрх мэдлийг хязгаарлахын зэрэгцээ хувь хүний эрх чөлөөг хамгаалахад чиглэгдэнэ. “Хууль нь ямарваа нэгэн этгээдээс хамаарахгүйгээр дангаар оршин тогтнох нь төрийн үүрд үйлчлэх үндсэн хууль мөн.” Кантын үзэл санаа нь төрийн эрх мэдлийг хуулиар хязгаарлахад оршино.

Энэ нь төрийн эрх мэдлийг гурван эрх мэдэлд хуваагаад¹⁸ хууль тогтоогчийн баталсан хууль нь нийт иргэдийн эрх ашгийг хамгаалан, нийгмийн харилцааг нь зохицуулах явдал бөгөөд хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан хуулийг иргэд дээдлэн, сахин биелүүлэх явдал юм. Гэхдээ хууль дээдлэгдэх нь хууль өөрөө хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстойг нэг талаас илэрхийлж байгаа хэрэг юм. Хуулийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд батлан гаргах¹⁹ нь хууль тогтоогчдын ухаан бодол, үр чадвараас ихээхэн шалтгаалах учиртай бөгөөд хууль нийгмийн харилцааг зохицуулж чадаж байгаа тохиолдолд чөлөөт ардчилсан нийгмийн суурь зарчим хангагдаж байна гэж үзэж болох юм.

Хоёр. Ёс зүйн тухай ойлголт

Аливаа төрийн байгууллага албан тушаалтны хувьд ажил үүргээ гүйцэтгэхдээ ёс зүйг сайтар анхаарч ажиллах ёстой болдог. Ёс зүй гэдэг нь “ΕΘΙΚ” *ethes* (зан заншил, ёс суртахуун)²⁰ гэсэн грек үгнээс гаралтай ухагдахуун.

Ёс зүй нь тухайн орчинд буй хүмүүст тавих шаардлага, дагаж мөрдөх зан үйлийн журам²¹ гээд Ёс зүй нь ёс суртахууны мөн чанар ба түүний олон янзын шинж ба илэрлийг шинжлэн судалдаг шинжлэх ухаан²².

Энэ нь ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахихын зэрэгцээ албан тушаал, ажил мэргэжлийн онцлогоос хамаараад ёс зүйн тусгайлан хэм хэмжээг мөрдөх шаардлагатай болдог. Анх төр үүсэх шалтгаан нь нэг талаас хүний өөрийнх нь мөн чанартай нөгөө талаас хамтын амьдралын хэрэгцээнээс үүдэлтэй.²³ Ийнхүү хүмүүсийн нэгдэл нь захирах захирагдах ёсгүйгээр хэвийн орших боломжгүй болж иргэд хооронд болон төр иргэний хооронд төрөөс тогтоосон эрх зүйн хэм

¹⁸ Кант төрийн эрх мэдлийг үндсэн гурван хэсэгт хуваан авч үзсэн бөгөөд хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл гэж хуваан үзэж шүүх эрх мэдлийг нөгөө хоёр эрх мэдлээс хараат бусаар ажиллах тэднийг хянах механизм байдлаар хуулиар эрх олгосон байх.

¹⁹ Ц.Шаравдорж. Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа. “Хууль дээдлэх ёс”. УБ., 2008 он, 28 дахь тал.

²⁰ Хууль зүйн нэр томъёо-УНТК-ын мэдээ., 1978 он.

²¹ Ёс зүйн гарын авлага. УБ., 2006 он. 6 дахь тал.

Мөн *Oran's dictionary of the law*.

²² С.Нарангэрэл. Монголчуудын зан суртахууны гарвал. УБ., 2010 он, 15 дахь тал.

²³ Аристотель. “Улс төр”. Орч. Б.Даш-Ендон. УБ., 2003. 1 дүгээр бүлэг 8 дугаар хэсэг.

хэмжээнээс гадна хүмүүсийн бий болгосон ёс суртахууны хэм хэмжээ үйлчилж, хүний биеэ хэрхэн зөв авч явахыг заадаг сургаал²⁴ гэж өдий хүртэл тодорхойлогдож байна.

Ёс зүй нь зарим тохиолдолд эрх зүйгээс ч илүү хүчтэй байдаг нь хүмүүс түүнийг ямар нэгэн албадлагагүйгээр өөрсдөө тогтоож, урт удаан хугацааны туршид зан үйлээрээ журамлан зохицуулж ирсэнд оршдог. Харин ёс зүй нь нөлөөллийн хүрээгээрээ ерөнхий, тусгай, онцгой гэсэн төрлүүдтэй байдаг бөгөөд парламентын гишүүний ёс зүй нь тусгай төрөлд хамаарагддаг²⁵. Мөн ёс зүй цэвэр байвал нийгэмд эерэг нөлөө үзүүлж, хөгжин бэхжихийн нөхцөл болж, хэрэв доройтвол сөрөг нөлөө үзүүлж, нийгэм уруудахын үндэс болно²⁶ гэх үзэл сургаал ч бий. Энэ нь нэг талаас Парламентын гишүүн өөрөө хуулиа дээдлэн ёс зүйн эрхэм чанарыг баримтлан ажиллах нь нийт ард иргэдэд үлгэр дууриал үзүүлэх сайн талын илрэл гэдэгтэй утга нэг ойлголт юм. Тиймээс парламентын гишүүний ёс зүй болон түүний эрх зүйн шалгуур үзүүлэлтийг онолын түвшинд²⁷ дарааж байдлаар судлан үзвэл:..

Гурав. Парламентийн гишүүний ёс зүй,²⁸ түүний шалгуур үзүүлэлт

УИХ-ын гишүүн “намч үзэл сурталчаараа биш” харин хүнлэг, үнэнч шударга, хууль дээдлэх хийгээд төрт ёсны үнэлэмжид нийцсэн иргэнлэг ёс зүйтэй байх нь нэн чухал.²⁹ Мөн түүнчлэн ард түмэн юу хүсэж байгааг парламентын гишүүн мэдрэх чадвартай байхаас бус нам, эвслийн эрх ашгийг эхний ээлжинд тавих ёсгүй³⁰ юм.

Парламентын гишүүний ёс зүй³¹ нь парламентат ёсны³² үр дагавар төдийгүй, шударга ёс, ёс суртахуунт байдлын үлгэр дууриал болж байдаг учраас ёс суртахууны шаардлагыг төгс баримталж цаг ямагт

²⁴ Ёс зүйн онолын үүсэл.. 3 дахь тал.

²⁵ С.Амардэлгэр. Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн өнөөгийн байдал, чиг хандлага. Монголын төр, эрх зүй сэтгүүл. 2007 он. №01, 12 дахь тал. Дам ишлэв.

²⁶ A.MacIntyre, "After Virtue" (A study in moral theory). London: Duckworth, 1981, p.244.

²⁷ Манай улсад одоогоор ёс зүйн дүрмээр хориглосон хэм хэмжээг зөрчсөн УИХ-ын гишүүн байхгүй тул энэхүү асуудлыг онолын хүрээнд хэрхэн яаж ойлгох болохыг Прискриптив хүрээнд судлав. Б.Т.

²⁸ Парламентын гишүүдийн парламент дахь дотоодын харилцааны ёс суртахуун ба зан суртахууны хэм хэмжээний нийлбэр цогц.

Парламентын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх үүрэг ёс суртахууны төдийгүй парламентын гишүүн бүрийн хууль зүйн үүрэг болж, олон нийтийн ба сахилгын нөлөөллийн хэрэглүүрээр хангагдана. Ийм хэрэглүүр хэрэглэхийн тулд Парламентын ёс зүйн тусгай хороо байгуулж ажиллуулдаг.

Парламентын ёс зүйг зөрчсөний төлөө хүлээлгэх хариуцлагыг парламент буюу түүний танхимын дэгээр тодорхой болгоно. С.Нарангэрэл. "Эрх зүйн эх толь бичиг". УБ., 2008 он, 355-356 дахь тал.

²⁹ Б.Чимид. "Үндсэн хуулийн мэдлэг". УБ., 2008 он, 207 дахь тал.

³⁰ С.Төмөр. "Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй – Монгол Улсад Парламентын ёсыг төлөвшүүлэх асуудал". УБ., 2006 он, 25 дахь тал.

³¹ Narangerel.S. "English-Mongolian Jurisdictional dictionary". 2006. parliamentary ethics-Англи, парламентская этика-Орос.

³² Нийгмийн шударга ёс хүний эрх түүний объектив дүр хууль ёс бодитой орших хийгээд бататган хөгжүүлэх зорилгоор төрийн эрх мэдлийн бүтэц ба чиг үүргээр нь тэнцвэржүүлэн хуваарилж, нийтээр дагаж мөрдөх хуулийг тогтоох тэргүүн үүргийг парламентад (ард түмний төлөөллийн байгуулалд) олгосон өөрөөр тогтолцооны шинж чанарыг Парламентат ёс гэнэ. Л.Өлзийсайхан. "Эрх зүй" сэтгүүл. 2000 он. №01, 87 дахь тал.

ёс суртахуунт үйл эрмэлзэж байхыг шаарддаг хийгээд парламентын гишүүний хийж буй үйлдэл өөрсөд нь бус бусдад ач тустай байдаг учир ёс суртахууны мэргэжил буюу “ариун гэгээн” зан үйлтэй байхыг шаарддаг. Парламентын гишүүн ард түмнээс олж авсан эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон үйл ажиллагааг бусдын явцуу ашиг сонирхол, өөрсдийнх нь хувийн нөлөөллөөс ангид байлгах үүднээс мөн ард түмний ашиг сонирхол, итгэлийг даалгах үүднээс ёс суртахууны хууль-нийгмийн үр дагавартай болгон “Ёс зүй”³³ хэмээх шалгуурыг тавьж өгдөг.³⁴

Бусдын өмнөөс, тэдний эрх ашгийн үүднээс үйл ажиллагаа явуулахад эрх, эрх мэдэл олж авсан этгээд эрх олгосон бүтцийн сонирхлыг өөрийн болон бусад хөндлөнгийн сонирхлоос дээгүүр тавьж энэ байдлаа уг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож буй тэр зан суртахууныг “Парламентын гишүүний ёс зүй”³⁵ гэнэ. Энэ нь албан үүрэгтэйгээ харьцаж буй харилцаанд агуулагдаж, төрийн эрх ашгийн хүрээнд хэрэгжинэ.

Парламентын гишүүний ёс зүйн алдаанд төрийн ашиг сонирхлын дээр хувийн ашиг сонирхлоо тавих, парламентын хэлэлцүүлгийн үеэр зүй бус үг хэлэх, зодолдох, бусдыг дайрч давших, хуралдааны даргыг юмуу хэсэг бүлэг гишүүдийг үг хэлээр доромжлох, эрх мэдэл албан тушаалаа хатруулж мөнгө зарцуулах, албаны унаа тэргийг хувийн зорилгодоо ашиглах, бусдыг албан тушаалаа ашиглан хохироох, сүрдүүлэх, хээл хахууль авах, хууран мэхлэх, хутган үймүүлэх зэргийг ёс зүйн зөрчил гэж үздэг.³⁶

Гэхдээ эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдлыг парламентын гишүүний ёс зүйг зөрчлөө гэж үзэх үү? эсхүл нийтийн зан суртахууны хэм хэмжээг зөрчсөнийг ёс зүйгээ зөрчлөө гэж үзэх үү? гэх парламентын гишүүний ёс зүйн хувьд баримтлах ёстой тогтсон үнэлэмж байдаггүй, өөрөөр хэлбэл ямар гишүүнийг ёс зүйтэй гишүүн гэх тодорхойлолт одоогоор манайд алга байна.

Харин манай улсын парламентын гишүүний хувьд ёс зүйн дүрмээр³⁷ даарах ерөнхий зарчмыг баримталдаг болох нь харагдаж байна:

- Хууль дээдлэх;
- Алагчлалгүй хандах;
- Шударга байх, бусдыг хүндэтгэх, нэр төр, алдар хүндэд халдахгүй байх зэргийг ёс зүйн дүрэмд ерөнхийлөн тусгасан байна.

Тэгвэл энэхүү асуудлыг хууль тогтоомжид хэрхэн тусгаж,

³³ Парламентын гишүүний ёс зүйн дүрмийг Монгол Улсын хууль тогтоомжид тусгахдаа “Улс төрийн”. “Төрийн тусгай” албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжид тогтооно гэж заасан байна. Төрийн албаны тухай хуулийн 10.2 дугаар зүйл.

³⁴ Д.Лүндээжанцан. Л.Өлзийсайхан. “Парламент ёс”. УБ., 2005 он, 126 дахь тал.

³⁵ Д.Лүндээжанцан. Л.Өлзийсайхан. “Парламент ёс”. УБ., 2005 он, 127 дахь тал.

³⁶ Мөн тэнд.

³⁷ УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийг (Монгол Улсын Их Хурлын 2009 оны 34 дугаар тогтоолын хавсралтаар баталсан.) 2009 оны 04 дүгээр сарын 20-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

нийцүүлсэн болохыг судлан үзвэл:

Монгол Улсын Их хурлын тухай хуульд зааснаар хууль, гишүүний ёс зүйг чанд сахих,³⁸ чуулганы хуралдаанд үг хэлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд халдахгүй байх,³⁹ хөрөнгө, орлогын мэдүүлгийг тогтоосон журмын дагуу үнэн зөв гаргах,⁴⁰ мөн тус хуулиар Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээнд гишүүний ёс зүй⁴¹ хамаарагдсан бөгөөд Ёс зүйн дэд хороо гэж нарийвчлан салгаад түүний эрхлэх ажил нь гишүүний ёс зүй, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэгийг сахиулах асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

УИХ-ын тухай хуульд гишүүний хориглох үйл ажиллагаа гэдэг нь ёс зүйн зөрчил гаргахгүй байх гэдэг утгаар зохицуулсан байна.

Үүнд⁴²:

Ноогдсон төсвийг хэтрүүлэх, зориулалтын бусаар зарцуулах, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулж бусдаас шан харамж авах, гишүүний нэр хүнд, бүрэн эрхийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, эрх мэдлээ ашиглан давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулах, иргэний зардлаар гадаадад зорчих, хууль бус шийдвэр гаргуулахаар бусдад нөлөөлөх, шахалт үзүүлэх, авлига хээл хахууль авах, аж ахуйн нэгжийн төлөөлөх болон хяналтын зөвлөлд сонгогдох зэргийг хориглосон байна. Энэ нь УИХ-ын гишүүний ёс зүйн асуудлыг хуулиар зохицуулсан болох нь харагдаж байна.

Эндээс ёс зүйтэй байх нь парламентын гишүүний хувьд төлөөлөх бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж байна гэх үнэлэмжийн гол шалгуур үзүүлэлтийн нэг байх нь яах аргагүй харагдаж байна. Энэ нь ёс зүйн дүрмийн зохицуулалтыг сайтар хийж, боловсруулах нь зүйтэй гэсэн санаа юм.

Дөрөв. Харьцуулсан судалгаа

Төгс төгөлдөр, бүрэн боловсруулсан дүрэм гэж байдаггүй. Тиймээс Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг Канад, АНУ, Унгар улсын парламентын гишүүний ёс зүйн дүрмийн зарим зүйлтэй харьцуулан авч үзвэл.

Ихэнх улс оронд бэлэг, санхүүжүүлсэн аялал, давхар ажил эрхлэх, цалин хангамж эдлэх зэргийг ёс зүйн дүрмээр зохицуулсан ба тухайн

³⁸ Монгол Улсын Их Хурлын тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 7.1.23 дугаар зүйл. Төрийн мэдээлэл сэтгүүл.

³⁹ Мөн хуулийн 7.1.24 дүгээр зүйл.

⁴⁰ Мөн хуулийн 7.1.26 дугаар зүйл.

⁴¹ Мөн хуулийн 20.4.11 дүгээр зүйлд заасан бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарагддаг. Тус хороо нь дэд хороонд харьяалагдаж Ёс зүйн, Нутгийн удирдлага, Улсын Их хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо гэсэн бүтэцтэй. Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 24.1.3 дугаар зүйлд заасан.

⁴² Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1–37.1.7 дугаар зүйлд тусгасан.

парламентын гишүүнд хариуцлага⁴³ оногдуулан гаргасан ёс зүйн алдааг нь эрх зүйн зөрчил⁴⁴ гэж үзэж хийсэн үйлдэлд нь тохируулан сахилгын шийтгэл оногдуулдаг.

КАНАД УЛС

Канад улсын Сенатын ёс зүйн хэм хэмжээ нь “Сонирхлын зөрчлийн код”⁴⁵ нэртэй ба байнгын хорооны нэр нь мөн “Сонирхлын зөрчлийн хороо” байна. Түүнчлэн, Сенатдаа ёс зүйн байнгын ажилтантай ба дээрх удирдлагад ажилладаг. Энэхүү код нь сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аливаа зөрчил гарсан тохиолдолд хянан хэлэлцэх процедурыг зохицуулсан байна. Мөн сенатор нь ёс зүйн кодоор тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой байдаг. Авлига болон сонирхлын зөрчилдөөн, харшлах албан тушаал (хавсарч, сонгогдож болохгүй ажил, албан тушаал, бэлэг, шагнал, төрөөс санхүүжүүлээгүй томилолтын гэх мэт) зэрэг асуудлыг тухайн ёс зүйн хэм хэмжээгээр хязгаарлаж өгсөн.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-ын Конгресс өөрийн ёс зүйн дүрэмтэй ба бэлэг, санхүүжүүлсэн аялал, давхар ажил эрхлэх, цалин хангамж эдлэх, сонгуулийн үеийн үйл ажиллагаа зэргийг маш нарийн зохицуулсан байдаг. Жишээлбэл, Конгрессийн гишүүд үнэ төлбөргүй урлагийн тоглолт, цайллага, урилгыг хэрхэн хүлээн авахыг зохицуулсан бөгөөд ямар төрлийн үйл ажиллагаанд оролцох гэж буйгаа урьдчилан мэдэгдэх ёстой байдаг. Конгрессийн гишүүн урамшуулал бусад хангамжтай холбогдсон ёс зүйн үндэслэлүүд (унаа тэрэг, томилолт, утас холбоог хувийн зорилгод ашиглахгүй байх) хүртэл тусгасан байдаг⁴⁶.

БҮГД НАЙРАМДАХ УНГАР УЛС

Эрх зүйн тогтолцооны хувьд манай улстай төстэй бөгөөд Үндсэн хуулийнхаа 2 дугаар бүлгийн 19.1 дүгээр зүйлд Төрийн эх барих дээд байгууллага нь парламент ба Бүгд Найрамдах Унгар улсын нийтлэг ашиг сонирлыг төлөөлнө⁴⁷ гэж хуульчилсан. Парламентын гишүүний дүрэмтэй бөгөөд тухайн дүрэм⁴⁸ нь парламентын гишүүний албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүй, ашиг сонирхлын зөрчлтийн холбоотой

⁴³ Парламентын гишүүн нь парламентын дэгийн хэм хэмжээ, эсхүл парламентын гишүүний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн бол холбогдох төлөөлөгчдийн байгууллагын дэгээр жагсаалтыг тогтоосон сахилгын нөлөөллийн арга хэмжээг парламентын гишүүнд хэрэглэх явдалар илэрхийлэгддэг сонгууль албан тушаалтан болох парламентын гишүүний хууль зүйн хариуцлагын өвөрмөц төрөлд хамаарагддаг. С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг”. УБ., 2008 он. 355 дахь тал.

⁴⁴ Эрх зүйн зөрчил гэдэг нь эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн. хууль, эрх зүй, ёс зүйн эсрэг чиглэсэн. нийгэмд хор аюул. хор уршиг бий болгосон, хууль зүйн болон ёс суртахууны хариуцлага хүлээлгэхээр заагдсан, гэм буруутай үйлдэл, эс үйлдлүүд мөн гээд 1. Гэмт хэрэг. 2. Эрх зүйн бусад зөрчил. 3. Хэрэг, үчрал гэж ангилсан. Эрх зүйн бусад зөрчилд нь Сахилгын зөрчил гээд "...ёс зүйн журмыг зөрчсөн буюу биелүүлээгүй хууль бус үйлдэл" гэжээ. Д.Баярсайхан. “Эрх зүйн онол”. УБ., 2010 он. 179-180 дахь тал.

⁴⁵ Code of Interests of Senators of the Canada www.law.cornell.edu

⁴⁶ АНУ-д муж улсын түвшинд 38 ёс зүйн хороо, орон нутгийн түвшинд 12 комисс. Гүйцэтгэх засаглалын байгууллагад ёс зүйн асуудал хариуцсан 150 мянган ажилтан байдаг. Конгрессийн ёс зүйн дүрэм нь 200 гаруй хуудаснаас бүрддэг гэхээр хэр зэрэг нарийвчлан зохицуулсан болох нь харагдаж байгаа юм.

⁴⁷ Code of legal status of Members of Parliament of the Hungary. April 2006.

ёс зүй, парламентын гишүүний эдлэх эрх, дархан эрхтэй холбоотой ёс зүй, мэдээлэл олох эрх, орлогын мэдүүлэг, албан томилолтой холбогдсон ёс зүй, шагнал, бэлэг дурсгал хүлээн авахтай холбогдсон ёс зүйн хэм хэмжээ зэргийг зохицуулдаг. Мөн ёс зүйн дүрмээр ёс зүйн зөрчил гаргасан парламентын гишүүнд хариуцлага оногдуулдаг. Уг хариуцлага нь тухайн асуудлаар хуралд үг хэлэхгүй байх, хурлын танхимаас гаргах, цалинг 25 хүртэл хувиар бууруулах арга хэмжээг тус тус авдаг байна.

Дээрх орнуудын парламентын гишүүний ёс зүй дүрмийн зохицуулалтаас харвал гол асуудал нь хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц буюу Байнгын хорооны үйл ажиллагааны зохицуулалт байдаг.⁴⁹ Тухайлбал, намуудын ижил төлөөлөл байх гэх мэт заалт байдаг. Мөн Байнгын хорооны гол үүрэг нь урьдчилан сэргийлэх буюу гишүүдэд мэдээлэл өгөх, зөвлөх, сургалт хийх гэх мэт. Хороо гишүүдийн мэдээллээр эсвэл өөрийн санаачилгаар, түүнчлэн иргэдээс зөрчил мэдээллийг хүлээж авах ба дүрэмд заасан нарийн журмын дагуу асуудлыг хянан шийдвэрлэдэг. Мөн тайлангаа улирал бүр хэлэлцүүлдэг⁵⁰ байна. Манай улсын хувьд ёс зүйн асуудлыг хянах байгууллага нь Ёс зүйн дэд хороо хуульд заасан үндэслэлээр ажиллаж байна. Түүний бүрэн эрхийг одоогоор тусгайлан заагүй бөгөөд Улсын Их Хурлын тухай хуульд заасан нийтлэг зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Дүгнэлт

Эрх зүйт ёс тогтсон улс орнуудад төрийн эрх мэдлийг Үндсэн хуулиар хуваарилж бэхжүүлэх нь зүй ёсны ойлголт болж, эрх мэдэл хуваарилах онол ёсоор Парламентад хууль тогтоох бүрэн эрхийг олгож, тэрхүү хууль тогтоож байгаа парламентын гишүүний дархан эрх, ямбыг хуулиар тогтоож, мөн хориглох ёс зүйн шалгуурыг дүрмээр зохицуулж, тусгай хороо хянах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Гэвч хоёр далавчтай нисэх байтал нэг далавчтайгаар манай улсад одоогоор тэнгэрт дүүлэн ниссээр л... Энэ нь парламентын гишүүний ёс зүйн дүрмийг баталсан боловч түүнийг хянах, шалгах байгууллагын хяналтын чиг үүргийг тусгайлан зохицуулж өгөөгүйтэй шууд холбоотой юм. Тиймээс анх удаа хэмээх тодотголтой парламентын гишүүний ёс зүйн дүрэмд судлаачийн зүйгээс дараах саналыг дэвшүүлж, ёс зүйн дүрэмд тусгахыг хүсэж байна.

⁴⁹ Манай улсын хувьд Ёс зүйн дэд хороо юм.

⁵⁰ www.forum.mn УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийн төсөлд өгөх Нээлттэй Нийгэм Форумын санал, зөвлөмж.

Санал

Ёс зүйн дэд хорооны хяналт тавих эрхийг Улсын Их Хурлын тухай хуульд заасан нийтлэг зохицуулалтаар бус тусгай дүрмээр тогтоох⁵¹ шаардлагатай байна.

1. Манай улсын парламентын гишүүний ёс зүйн дүрэмд ёс зүйгээ зөрчсөн гишүүнд оногдуулах ёс зүйн хариуцлагын асуудлыг дүрэмд тусгаагүй байна. Энэ нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн хэдий ч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй байх нь шударга ёсонд нийцэхгүй юм.⁵² Дэлхийн улс орнуудын парламентын гишүүний ёс зүйн дүрэмд сахилгын хариуцлагыг оногдуулах байдлаар зохицуулсан байдаг. Гэвч манай улсад байхгүй. Тиймээс дараах сахилгын хариуцлагыг ёс зүйн дүрэмд тусгах нь зүйтэй.

а. Үг хэлэх эрхийг хасахаар сануулах, хэлэлцэж буй асуудлаар үг хэлэх эрхийг нь хасах, танхимаас гаргах, парламентын гишүүний сарын цалингаас тодорхой хувь хэмжээгээр суутгал хийх, олон нийтэд мэдээлэх гэх мэт.

2. Парламентын гишүүн нь төлөөллийн үндсэндээ үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Гэтэл тус дүрэмд сонгогдсон төлөөлөгчийн хувьд баримтлах ёс зүйг тусгаагүй байна. Тиймээс дараах зүйлийг тусгах шаардлагатай.

а. Албан үүргийн дагуу олж авсан мэдээллийг хувийн болон бусад явцуу сонирхлын дагуу ашиглахгүй байх.

3. Парламентын гишүүний ёс зүйн дүрмээр дархан эрх болон хувийн харилцаанд мөрдөгдөх зүйлсийг нь тодорхойлж Улсын Их Хурлын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжуудад парламентын гишүүний ёс зүйн дүрмийн заалтуудыг тусгаж, нийцүүлэх.

⁵¹ УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийн 7.1-д “Энэ дүрмийн биелэлтэд Ёс зүйн дэд хороо хяналт тавин ажиллах бөгөөд уг дэд хорооны ажиллах журмыг тусгай дүрмээр тогтооно.” гэж заасан хэрнээ одийг болтол тусгайлан зохицуулаагүй байна.

⁵² Бид ёс зүйн зорчил гаргасан хараат бус шүүгчийг ёс зүйгээ зөрчсөн тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлөх хүртэлх арга хэмжээг авдаг хэдий ч, ард түмний төлөөлөл болж сонгогдсон парламентын гишүүн ёс зүйн зорчил гаргахад түүнд оногдуулах хариуцлагыг ёс зүйн дүрмээр нь тусгаагүй байгаа нь учир дутагдалтай зүйл юм.

**2010 ОНЫ ЭХНИЙ 7 САРД УЛСЫН ХЭМЖЭЭНД
БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН
МЭДЭЭЛЭЛ**

Нэг. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

1. Цагдаагийн байгууллага, 2010 оны эхний 7 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 53927 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсаны 30000 буюу 55.6 хувийг гэмт хэргийн, үүний дотор Эрүүгийн цагдаагийн албанаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд шалгуулахаар шилжүүлсэн 594 материал, 18348 буюу 34.0 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл тус тус эзэлж байна.

Гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийн 11545 буюу 38.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 17472 буюу 58.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, үүний дотор 93.1 хувийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлжээ.

Шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, 51.0 хувийг 5 хоногт, үүний дотор нийслэлийн Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс 95.3, Дундговь аймгийн цагдаагийн хэлтэс 98.0, Увс аймгийн цагдаагийн газар 96.6 хувийг дээрх хугацаанд багтаан шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн 12.7 хувийг баривчлах, 41.2 хувийг шийтгэврээр, 32.3 хувийг торгуулийн хуудсаар тус тус торгох, 9.8 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасч, 4.0 хувийг зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулаагүй үндэслэлээр тус тус шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл, бүх захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн 84.4 хувийг 14 хоногт, 8.9 хувийг нь 15-28 хоногт, 6.8 хувийг 29 ба түүнээс дээш хоногт хянаж, шийдвэрлэжээ.

Хоёр. Гэмт хэргийн байдал

1. Улсын хэмжээнд энэ оны эхний 7 сард 11245 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 927 хэргээр буюу 7.6 хувиар буурчээ.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 54.4 хувь нь нийслэл хотод, 43.1 хувь нь аймгуудад, 0.9 хувь нь Төмөр замын салбарт, 1.6 хувь нь бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн гаралт Архангай, Говь-Алтай, Орхон, Сэлэнгэ, Увс аймагт 1.8-39.0 хувиар, нийслэлийн Баянгол, Налайх дүүрэгт 0.1-

26.1 хувиар, Төмөр замын салбарт 23.2 хувиар, бусад газарт 5.0 дахин тус тус өсөв.

Харин Сүхбаатар, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Өвөрхангай, Хэнтий, Дорноговь, Төв, Говьсүмбэр, Ховд, Дундговь, Хөвсгөл, Дорнод, Булган, Завхан аймагт 4.9-40.7 хувиар, нийслэлд 8.4, Баянзүрх, Багануур, Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Багахангай дүүрэгт 4.3-50.0 хувиар, Иргэний агаарын тээврийн салбарт 81.8 хувиар тус тус буурч, Баян-Өлгий аймагт өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 40.6 хувийг хөнгөн, 46.7 хувийг хүндэтэр, 10.7 хувийг хүнд, 2.0 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байгаа ба хөнгөн ангиллын гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 1.1 хувь өсч, хүндэтэр ангиллын гэмт хэрэг 13.9, хүнд ангиллын гэмт хэрэг 9.1, онц хүнд ангиллын гэмт хэрэг 3.4 хувиар тус тус буурсан байна.

Энэ оны эхний 7 сарын байдлаар 18 ба түүнээс дээш насны 10 000 хүн тутамд улсын дунджаар 63 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 7 хэрэг буюу 7.0 хувиар буурсан байна.

Дээрх үзүүлэлт Дорноговь аймагт 82.3, Говьсүмбэр аймагт 79.7, Хэнтий аймагт 73.4, Сэлэнгэ аймагт 68.6 байгаа нь улсын дунджаас 5.6-19.3 хувиар, нийслэлд 83.6 байгаа нь 20.6 хувиар илүү, Дорнод аймагт 62.8, Төв аймагт 60.4, Өмнөговь аймагт 56.0, Дархан-Уул аймагт 55.9, Увс аймагт 52.7, Орхон аймагт 50.9, Баянхонгор аймагт 47.5, Архангай аймагт 46.5, Дундговь аймагт 43.5, Баян-Өлгий аймагт 38.4, Ховд аймагт 38.1, Булган аймагт 32.8, Хөвсгөл аймагт 29.8, Говь-Алтай аймагт 30.1, Өвөрхангай аймагт 27.8, Сүхбаатар аймагт 27.4, Завхан аймагт 22.5 байгаа нь улсын дунджаас 0.2-40.5 хувиар бага байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 416 дугаар зүйлд заасны дагуу хялбаршуулсан хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан хөнгөн ангиллын 377 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 34.7 хувиар өсөв.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй (БҮСТЗЭТ-гүй) 3691 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 9.1 хувиар, үүнээс 1554 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, өмнөх оны мөн үеийнхээс 5.4 хувиар тус тус буурчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 42.1 хувьтай, өмнөх оны мөн үеийнхээс 1.7 пунктээр, нийслэлийн хэмжээнд 42.5 хувьтай, өмнөх оны мөн үеийнхээс 4.5 пунктээр тус тус өссөн статистик үзүүлэлттэй байна.

Говьсүмбэрт 57.7, Говь-Алтайд 55.6, Завхан, Ховдод тус бүр 53.8,

Өмнөговьд 53.1, Дорноговьд 51.4, Увсад 50.0, Баянхонгор 49.5, Өвөрхангайд 44.4, Дархан-Уулд 43.9, Дундговьд 38.9, Архангайд 36.8, Дорнодод 30.9, Баян-Өлгийд 30.4, Орхонд 29.3, Сэлэнгэд 29.4, Булганд 28.6, Төвд 19.5, Хөвсгөлд 4.4, нийслэлийн Налайхад 58.0, Баянголд 53.9, Баянзүрхэд 47.4, Сүхбаатарт 45.8, Хан-Уулд 43.6, Багануурт 37.3, Чингэлтэйд 32.4, Сонгинохайрханд 30.9, Төмөр замын салбарт 41.7 хувьтай байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийг ангиллаар нь тооцож үзвэл: Хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 38.8, хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 40.6, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 56.2, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 73.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс хүнд хэргийн илрүүлэлт 6.2, хөнгөн хэргийн илрүүлэлт 3.0, хүндэвтэр хэргийн илрүүлэлт 1.7 пунктээр тус тус өсч, онц хүнд хэргийн илрүүлэлт 5.0 пунктээр буурчээ.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр авч үзвэл: албан тушаалын хэрэг 1.7, нийгмийн аюулгүй байдлын эсрэг хэрэг 5.4, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 8.1, захиргааны журмын эсрэг хэрэг 10.2, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг 12.6, иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг хэрэг 16.7, хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэг 19.1, хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг хэрэг 78.6 хувиар тус тус өсөв.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг 1.2, өмчлөх эрхийн эсрэг хэрэг 16.9, аж ахуйн эсрэг хэрэг 21.7, байгаль хамгаалах журмын эсрэг хэрэг 33.9, үндэсний аюулгүй байдлын эсрэг хэрэг 49.4, шүүн таслах ажиллагааны эсрэг хэрэг 50.8, цэргийн албаны эсрэг хэрэг 62.5 хувиар тус тус буурсан байна.

Тодорхой зарим төрлийн гэмт хэргийн хувьд: бусдыг болгоомжгүй алах хэрэг 14.3, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 3.3, хүчиндэх хэрэг 1.0, танхайрах хэрэг 3.8, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэг 4.1, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах хэрэг 37.6, хээл хахууль авах 37.5, хээл хахууль өгөх 40.0 хувиар тус тус өссөн ба банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 7.0 дахин, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх борлуулах хэрэг 3.0 дахин тус тус өсчээ.

Хүнийг санаатай алах хэрэг 11.9, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 19.6, хүн худалдаалах хэрэг 85.7, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 50.0, бусдын эд

хөрөнгийг хулгайлах хэрэг 17.5, булаах хэрэг 15.0, дээрэмдэх хэрэг 35.7, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэг 7.8, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх хэрэг 5.6, татвар төлөхөөс зайлсхийх хэрэг 12.5, банкны тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 30.8, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэг 22.5, ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 38.1, ойн тухай хууль тогтоомж зөрчих хэрэг 32.9, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох хэрэг 50.0 хувиар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 11245 гэмт хэргийн 119 буюу 1.1 хувь нь хүнийг санаатай алах, 3347 буюу 29.8 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 200 буюу 1.8 хувь нь хүчиндэх, 3217 буюу 28.6 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлах, 96 буюу 0.9 хувь нь булаах, 324 буюу 2.9 хувь нь дээрэмдэх, 471 буюу 4.2 хувь нь залилан мэхлэх, 218 буюу 1.9 хувь нь завших, үрэгдүүлэх, 895 буюу 8.0 хувь нь танхайрах, 486 буюу 4.3 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэг байна.

Мал хулгайлах хэрэг 485 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 34.9 хувиар буурч, нийт хэргийн 4.3 хувийг, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 15.0 хувийг, тээврийн хэрэгсэл хулгайлах хэрэг 59 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байгаа ба хулгайлах хэргийн 1.8 хувийг, халаасны хулгайн хэрэг 102 бүртгэгдэж, хулгайлах хэргийн 3.1 хувийг тус тус эзэлж байна.

3. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн болон зохион байгуулалттай бүлэг үйлдсэн хэрэг тус бүр 3.0 дахин, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 1.1, урьдчилан үгсэж, тохиролцсон бүлэг үйлдсэн хэрэг 14.3 хувиар тус тус өсч, эмэгтэй хүн оролцсон хэрэг 14.8, хүүхэд оролцсон хэрэг 31.4, бүлэглэн гүйцэтгэсэн хэрэг 29.0, галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэг 40.7 хувиар тус тус буурав.

4. Гэмт хэрэгт 10277 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 4.7 хувиар буурч, нийт шалгагдсан хүний 12.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.7 пунктээр өсч, 4.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.8 пунктээр тус тус буурчээ.

Насны ангиллаар авч үзвэл, 18-24 насны 2817, 25-29 насны 1945, 30-34 насны 1589, 35-39 насны 1275, 40-44 насны 1014, 45-49 насны 601, 50-54 насны 321, 55-59 насны 136, 60-64 насны 58, 65-69 насны 22, 70 ба түүнээс дээш насны 35 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдав.

Гэмт хэрэг үйлдэгчдийн 5.0 хувийг төрийн албан хаагч эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 1.3 пунктээр, 14.5 хувийг ажилчин,

малчин эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 9.4 пунктээр, 57.2 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 5.7 пунктээр, 0.3 хувийг сургууль завсардсан хүүхэд эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 пунктээр, 0.2 хувийг хоригдол эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.1 пунктээр тус тус буурч, 3.6 хувийг оюутан эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.7 пунктээр, 3.5 хувийг сурагч эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.5 пунктээр, 0.4 хувийг тэнэмэл амьдралтай хүн эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.1 пунктээр тус тус өссөн байна.

Дээрх хүмүүсийг нийгмийн байдал, боловсролоор нь авч үзвэл, 5 нь хугацаат цэргийн алба хаагч, 23 нь хоригдол, 32 нь сургууль завсардсан, 39 нь тэнэмэл, 140 нь төрийн бус байгууллагын ажилтан, 356 нь сурагч, 369 нь оюутан, 509 нь төрийн албан хаагч, 680 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 754 нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 1489 нь ажилчин, малчин, 5881 нь ажилгүй, 7.1 хувь нь боловсролгүй, 12.7 хувь нь бага, 14.1 хувь нь суурь, 46,7 хувь нь бүрэн дунд, 1.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 2.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 15.9 хувь нь дээд боловсролтой хүн байна.

Гэмт хэрэг үйлдэгчдийн 4.9 хувийг урьд ял шийтгэгдсэн хүмүүс эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.9 пунктээр, 20.1 хувь нь гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэсэн нь 2.9 пунктээр, 27.1 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдэж, 2.0 пунктээр, 0.1 хувь нь галт зэвсгээр үйлдсэн нь 0.2 пунктээр тус тус буурч, 0.9 хувь нь урьдчилан үгсэж, тохиролцсон бүлэг үйлдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 0.2 пунктээр өссөн статистик үзүүлэлт гарав.

Гэмт хэрэг үйлдэх үедээ эрэн сурвалжлагдаж байсан 59, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд шалгагдаж байсан 503, эрх хязгаарлах арга хэмжээ авагдсан 19 хүн дахин гэмт хэрэг үйлдэж, гадаадын 45 иргэн (үүнээс: БНХАУ-ын 25, ОХУ-ын 13, БНСУ-ын 2, бусад улсын 5 иргэн) тус тус бүртгэгджээ.

5. Нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг 34.1, гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 35.0, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 17.5, гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 1.0 хувиар тус тус өсч, хилийн бүсэд үйлдэгдсэн хэрэг 9.2, бэлчээрт үйлдэгдсэн хэрэг 42.1, гаальд үйлдэгдсэн хэрэг 74.5 хувиар тус тус буурав.

Гэр, орон сууцанд 4053 хэрэг үйлдэгдсэний дотор гэрт 1627, орон сууцны байранд 905, хувийн байшинд 841, зуслангийн байшинд 58, хауст 10, гражид 86, амбаарт 64, агуулахад 52, орцонд 162, подвальд 51, бусад газарт 197;

Гудамж талбайд 2218 хэрэг үйлдэгдсэний дотор гэр, хорооллын

гудамжинд 1238, орон сууцны хорооллын гудамжинд 562, тоглоомын талбайд 17, ил зогсоолд 188, цэцэрлэгт хүрээлэнд 22, автобусны буудалд 87, төмөр замд 4, бусад газарт 100;

Олон нийтийн газарт 1494 хэрэг үйлдэгдсэний дотор, үзвэрийн газар 39, нийтийн захад 197, бөөний худалдааны төвд 95, дэлгүүрт 383, ТҮЦ-т 13, зочид буудалд 156, саунд 5, бааранд 334, ресторан, зоогийн газарт 67, амралтын газарт 32, сувиллын газарт 13, жуулчны баазад 4, нисэх онгоцны буудалд 8, төмөр замын вокзалд 22, авто вокзалд 5, бусад газарт 121;

Нийтийн тээвэрт 120 хэрэг үйлдэгдсэний дотор, нисэх онгоцонд 1, галт тэргэнд 27, том оврын автобусанд 14, дунд оврын автобусанд 7, микро автобусанд 6, таксинд 53, бусад газарт 12;

Төрийн байгууллагад 330 хэрэг үйлдэгдсэний дотор, захиргааны байгууллагад 76, элчин сайдын яаманд 1, шүүхэд 9, прокурорт 3, тагнуулын байгууллагад 1, зэвсэгт хүчинд 7, цагдаагийн байгууллагад 43, дотоодын цэрэгт 1, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 29, онцгой байдалд 4, хилийн цэрэгт 6, гаальд 14, татварт 2, нийгмийн даатгалд 4, халамж үйлчилгээний газарт 50, газрын албанд 3, мэргэжлийн хяналтын байгууллагад 5, бүртгэлийн албанд 12, музейд 1, бусад газарт 59;

Төрийн бус байгууллагад 245 хэрэг үйлдэгдсэний дотор, шинжлэх ухааны 2, боловсролын 117, соёлын 17, эрүүл мэндийн 51, спортын 8, орчин ахуйн хөгжлийн 2, энэрлийн байгууллага, улс төрийн намд тус бүр 4, сүм хийдэд 16, бусад газарт 24;

Аж ахуйн нэгжид 670 хэрэг үйлдэгдсэний дотор, үйлдвэрийн газарт 138, арилжааны банкинд 54, хадгаламж зээлийн хоршоонд 4, валют арилжааны цэгт 3, банк бус санхүүгийн байгууллагад 13, тооцооны төвд 16, хамгаалалтын албанд 5, засвар үйлчилгээний газарт 33, ашигт малтмал, геодези, зураг зүйн албанд 14, шатахуун түгээх станцад 29, нотариатад 3, төрийн өмчийн их, дээд сургуульд 17, төрийн өмчийн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвд 3, төрийн өмчийн коллежид 9, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 40, төрийн өмчийн хүүхдийн цэцэрлэгт 8, төрийн өмчийн эмнэлэгт 33, төрийн өмчийн өмчийн оношлогооны төвд 1, хувийн өмчийн коллежид 1, хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 3, хувийн өмчийн их, дээд сургуульд 9, хувийн өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2, хувийн өмчийн эмийн санд 4, хувийн өмчийн оношлогооны төвд 1, хувийн өмчийн цэцэрлэгт 4, хувийн өмчийн эмнэлэгт 17, бусад газарт 206;

Бусад газарт 1430 хэрэг үйлдэгдсэний дотор, хилийн бүсэд 99, хөдөө хээр 293, бэлчээрт 474, ойн сан бүхий газарт 88, гол усны ай сав газарт 47, ашигт малтмалын орд газарт 11, траншейнд 15, хууль

бусаар алт олборлож байгаа газарт 22, ашиглаж байгаа уурхайд 25, баригдаж байгаа барилгад 33, бусад газарт 323 хэрэг тус тус үйлдэгдсэн байна.

Авто замд 685 хэрэг үйлдэгдсэнийг замын харьяаллаар авч үзвэл, олон улсын замд 5, улсын замд 29, орон нутгийн замд 240, хотын замд 404, хувийн замд 4, аж ахуйн нэгж, байгууллагын замд 3, замын хэсгээр авч үзвэл, уулзвар дээр 17, явган хүний гарцан дээр 11, автобусны буудалд 1, төмөр замын гарам, гүүрэн дээр тус бүр 2, замын ангиллаар авч үзвэл, ердийн замд 339, хорооллын замд 51, тууш замд 46, хурдны замд 2, замын хучилтаар авч үзвэл, асфальтан замд 398, цементэн замд 13, бетон замд 19, сайжруулсан замд 31, хөрсөн замд 55, хайрган замд 14, замын гадаргуугаар авч үзвэл, хуурай замд 364, нойтон замд 18, мөстэй замд 27, цастай замд 43, эвдрэлтэй замд 5, бохирдсон замд 1, замын онцлогоор авч үзвэл, тэгш замд 302, хазгай замд 10, шулуун замд 107, өгсүүр замд 18, уруу замд 29, огцом эргэлттэй замд 9, үзэгдэх орчин чөлөөтэй 379, хязгаарлагдмал 34, ханагалтгүй 3, зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй 23, гэрэлтүүлэггүй 17, цаг агаарын таатай үед 328, үүлэрхэг үед 25, бороотойд 3, цастайд 16, шуургатайд 5 хэрэг тус тус үйлдэгджээ.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 1831 нь Даваа, 1676 нь Мягмар, 1743 нь Лхагва, 1717 нь Пүрэв, 1687 нь Баасан, 1292 нь Бямба, 1299 нь Ням гарагт, 16.9 хувь нь 06-14 цагт, 26.3 хувь нь 14-19 цагт, 16.9 хувь нь 19-22 цагт, 39.9 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна.

6. Гэмт хэргийн улмаас 10804 иргэн хохирсоны 37.3 хувь нь эмэгтэй, 0.8 хувь нь 7 хүртэлх, 1.4 хувь нь 8-13, 3.4 хувь нь 14-17, 15.7 хувь нь 18-24, 15.5 хувь нь 25-29, 14.7 хувь нь 30-34, 13.6 хувь нь 35-39, 11.4 хувь нь 40-44, 9.2 хувь нь 45-49, 6.3 хувь нь 50-54, 3.4 хувь нь 55-59, 1.7 хувь нь 60-64, 1.1 хувь нь 65-69, 1.7 хувь нь 70 ба түүнээс дээш насны хүн байна.

Хохирогч иргэдийн дотор төрийн албан хаагч 780, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 1208, төрийн бус байгууллагын ажилтан 239, хувиараа хөдөлмөр эрхлэгч 1284, ажилчин, малчин 1942, оюутан 522, сурагч 523, сургууль завсардсан хүүхэд 15, тэнэмэл 18, хоригдол 21, эрхэлсэн тодорхой ажилгүй 4252 хүн байгаа ба хохирогчийн буруугаас 680, архи дан согтуурсан үедээ 337 иргэн гэмт хэргийн халдлагад өртөж хохирчээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд 195 иргэн өртсөнийг хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзвэл, 162 нь бие махбодын, 49 нь сэтгэл санааны, 16 нь бэлгийн, 2 нь эдийн засгийн, хүчирхийлэлд өртсөн хугацаагаар авч үзвэл, 0-1 жилд 102, 1-3 жилд 30, 3-5 жилд 16, 5-8 жилд 3, 8-

аас дээш жилд 3, хүчирхийллийн давтамжаар авч үзвэл, жилд 1-2 удаа 74, улиралд 1-2 удаа 17, сард 1 удаа 12, 14 хоног тутам 5, 7 хоног тутам 4, 3 хоног тутам 1, байнга өртдөг 8 хүн, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор хохирогч нь эхнэр 106, нөхөр 21, хамтран амьдрагч 12, төрсөн эцэг, эх 3, хадам эх 1, төрсөн 7, үрчилж авсан 1, дагавар 11 хүүхэд тус тус бүртгэгдсэн байна.

Энэ оны эхний 7 сард Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын 81 иргэн гэмт хэргийн халдлагад өртсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 9.5 хувиар өссөн ба 38 нь БНХАУ-ын, 14 нь ОХУ-ын, 6 нь тус бүр БНСУ, Япон улсын, 17 нь бусад улсын иргэд байна.

Энэ хугацаанд гэмт хэргийн халдлагад 245 байгууллага өртсөнөөс 64.5 хувь нь төрийн байгууллага, 23.3 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, 12.2 хувь нь төрийн бус байгууллага байна.

Гэмт хэргийн улмаас төр, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 22.8 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 4.1 тэрбум төгрөг буюу 17.9 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Хэрэг бүртгэлтийн шатанд 5.4 сая, мөрдөн байцаалтын шатанд 26.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг тус тус битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас 743 хүн нас барж, 3931 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеийнхээс нас барсан хүний тоо 25.7, гэмтсэн хүний тоо 19.6 хувиар тус тус буурав.

Нас барсан хүмүүсийн 29.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.3 пунктээр өсчээ.

Нас барсан хүмүүсийн дотор 7 хүртэлх насны 27, 8-13 насны 17, 14-17 насны 12, 18-24 насны 80, 25-29 насны 82, 30-34 насны 99, 35-39 насны 94, 40-44 насны 93, 45-49 насны 97, 50-54 насны 63, 55-59 насны 40, 60-64 насны 13, 65-69 насны 6, 70 ба түүнээс дээш насны 20 хүн байна.

Гэмтсэн хүмүүсийн дотор эмэгтэйчүүд 36.4 хувийг эзэлж, 7 хүртэлх насны 36, 8-13 насны 75, 14-17 насны 175, 18-24 насны 821, 25-29 насны 731, 30-34 насны 594, 35-39 насны 471, 40-44 насны 377, 45-49 насны 268, 50-54 насны 181, 55-59 насны 90, 60-64 насны 49, 65-69 насны 18, 70 ба түүнээс дээш насны 45 хүн байна. Гэмтсэн хүмүүсийн 74.7 хувь нь хөнгөн, 16.7 хувь нь хүндэвтэр, 8.6 хувь нь хүнд хэлбэрээр гэмтжээ.

7. Бүртгэгдсэн бүх хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байгууллагын харьяаллаар нь тооцвол: Хэрэг бүртгэлтийн харьяаллын 4565 хэргийн 99.6 хувийг Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, 0.1 хувийг Авлигатай тэмцэх байгууллага, 0.3 хувийг Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч бүртгэсэн байна.

Мөрдөн байцаалтын харьяаллын 6680 хэргийн 97.8 хувьд Цагдаагийн байгууллагын, 0.7 хувьд Тагнуулын байгууллагын, 0.8 хувьд Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны, 0.6 хувьд Аалигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч тус тус мөрдөн байцаалтын ажиллагаа явуулжээ.

Нийгмийн хэв журам хамгаалах албаны мэдээгээр энэ оны эхний 7 сард улсын хэмжээнд 315388 захиргааны эрх зүйн зөрчил бүртгэгдэж, 66466 хүн эрүүлжүүлэгдэж, 6543 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс захиргааны эрх зүйн зөрчил 38.0, эрүүлжүүлэгдсэн хүн 18.3, баривчлагдсан хүн 16.1 хувиар тус тус буурчээ.

Дүгнэлт: Статистикийн мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд гэмт хэргийн гаралт 7.6 хувиар, 16 аймаг, нийслэл хот, нийслэлийн 7 дүүрэг, иргэний агаарын тээврийн салбарт тус тус буурч, гэмт хэргийн илрүүлэлт өссөн, гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүний тоо, учирсан хохирлын хэмжээ буурсан зэрэг үзүүлэлт харагдаж байгаа боловч хоног тутамд 54 гэмт хэрэг, 1502 захиргааны зөрчил үйлдэгдэж, 4 хүн нас барж, 19 хүн гэмтэж, нэг гэмт хэргийн улмаас 2,0 сая төгрөгийн эдийн хохирол учирч байгаа нь эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал тайван бус байгааг харуулж байна.

Архидан согтуурч танхайрах, бусдын бие махбодид хөнгөн, хүнд хэлбэрээр гэмтэл учруулах, улмаар амь насыг нь хөнөөх, хүчиндэх болон хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих гэмт хэрэг багагүй үйлдэгдэж, иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох, ялагууа бага насны хүүхэд гэмт хэргийн халдлагад өртөж, хохирох явдал их байна. Тухайлбал: Энэ оны эхний 7 сарын байдлаар 7 хүртэлх насны 27, 8-13 насны 17, 14-17 насны 12, нийт 56 хүүхэд гэмт хэргийн улмаас нас барж, 286 хүүхэд хөнгөн, хүнд хэлбэрээр гэмтсэн статистик үзүүлэлт гарчээ.

Амралт, баяр ёслол, аялал зугаалгын идэвхтэй цаг үе үргэлжилж байгаагаас үүдэн гудамж талбай, олон нийтийн газарт танхайрах, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг есөх хандлагатай байна.

Хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн тоо, замын ачаалал ихэссэн төдийгүй замын хөдөлгөөнд оролцогчид үүрэг хариуцлагаа ухамсарлаагүй, тээврийн хэрэгслийн аюулгүй, найдвартай байдлыг хангаагүй зэргээс үүдэн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг өссөн байна.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ ТӨВ**

БОГДЫН ХИШИГ ТАРААХ ЗАРЛИГ

1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр Монгол Улсын тулгур төрийг нээн, тусгай улс байгуулж, бүхний багш Богд Живзундамба хутагтыг Улсын эзэн хаанд өргөмжлөн, Шашин төрийн бүрэн эрхийг хослон бариулж, улсын нэрийг "Монгол", оны цолыг "Олноо өргөгдсөн" гэж нэрийдэж, Их Хүрээг улсын төв нийслэл болгон, дотоод, гадаад, цэрэг, сан, шүүх таван яамыг байгуулж, засгийн хэргийг хуваан шийтгүүлсэн билээ.

Богд Живзундамба хутагт Монгол Улсын хаан эзнээр суугаад Монголын төрийн үндсэн таван яамыг байгуулж, сайд нарыг тохоон томилсон зарлигийг УТА-ын сан хөмрөгөөс толилуулж байна.

Шашныг мандуулах, амьтныг жаргуулагч Олноо өргөгдсөн Монгол Улсын эзэн Шашин төрийг хослон баригч Наран гэрэлт Богд хааны зарлиг

Би олны өргөмжлөхийг хүлээж, Монгол Улсын хааны сууринд суусан нь, бурхны шашныг буман нарны гэрэл мэт хир үгүй мандуулан хаан төрийг сүмбэр уул мэт бат болгож, олон монгол албатыг үүрд энх түвшний соёлд учруулахыг үргэлжид шамдан хичээхүйн дээр, ялангуяа танай олон хан, ван ноёдоос дараалан түмэн албатад хүртэл төв шударга хичээнгүй үнэнийг сүслэн эрхэмлэж, бүгд нэгэн сэтгэлээр шашин төрд сайнаар зүтгэхийг тус тус ухуулан хишиг тараах зарлиг буулгасан нь:

Тулгар төр байгуулах тухайн хэрэгт онц хүчин зүтгэж явсан Түшээт хан аймгийн засаг хошой чин ван Ханддоржид үе улиран Эрдэнэ дайчин цол, ханы ямба, давхар пүнлүү, шар хүрэм, улбар шар жолоо, нэгэн үед ногоон жууз шагнаж, Шадар сайд, бүгд захирах сайд, Гадаад хэргийг эрхлэн шийтгэгч яамны тэргүүн сайдын тушаалд тохоон талбигтун...

... Ямагт хотол төгсөөр хослон хүртээж басхүү төрөл тутамд агшин төдий ч салалт үгүйгээр эзлэн барьж жолоодон удирдсаар ахуйг бүгдээр зүрхний төвөөс чин бишрэлээр, түмэнтээ хүсэн ерөөж, өлзий бэлгэтэй бурхан шүтээн хийгээд эд эрдэнэ есөн бэлэг лүгээ сэлтийг зэрэгцүүлэн жагсааж хичээнгүйлэн өргөж, ёслон мөргөмүй.

Их нигүүлсэнгүйгээр энэрэн таалж, зөвшөөн соёрхож, өршөөн тогтоож, заалхийлэн Зарлиг буулгахыг

Айлдан

Айлдагтун

Айлтга.

Их баяр бүрдсэн Шинийн есний сайн өдрөө.

Шашныг мандуулах, амьтныг жаргуулагч Олноо өргөгдсөн Монгол Улсын эзэн шашин төрийг хослон баригч Нарангэрэлт Богд хааны зарлиг

Би олны өргөмжлөхийг хүлээж, Монгол Улсын хааны сууринд суусан нь, бурхны шашныг буман нарны гэрэл мэт хир үгүй мандуулан хаан төрийг сүмбэр уул мэт бат болгож, олон монгол албатыг үүрд энх түвшний соёлд учруулахыг үргэлжид шамдан хичээхүйн дээр, ялангуяа танай олон хан ван ноёдоос дараалан түмэн албатад хүртэл төв шударга хичээнгүй үнэнийг сүслэн эрхэмлэж бүгд нэгэн сэтгэлээр шашин төрд сайнаар зүтгэхийг тус тус ухуулан хишиг тараах зарлиг буулгасан нь:

... Үеэн санаагаар чармайн зүтгэсэн Сэцэн хан аймгийн хамаарсан жанжин засаг хошууны бэйс Гомбосүрэнд үе улиран эрдэнэ далай цол, төрийн жүн ван, улбар шар жолоо шагнаж Шадар сайд, бүгд захирах сайд, цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд, туслагч жанжны тушаалд тохоон талбигтун...

... Ямагт хотол төгсөөр хослон хүртээж басхүү төрөл тутамд агшин төдий ч салалт үгүйгээр эзлэн барьж жолоодон удирдсаар ахуйг бүгдээр зүрхний төвөөс чин бишрэлээр, түмэнтээ хүсэн ерөөж, өлзий билэгтэй бурхан шүтээн хийгээд, эд эрдэнэ есөн бэлэг лүгээ сэлтийг зэрэгцүүлэн жагсааж хичээнгүйлэн өргөж, ёслол мөргөмүй.

Их нигүүлсэнгүйгээр энэрэн таалж, зөвшөөн соёрхож, өршөөн тогтоож, заалхийлэн Зарлиг буулгахыг

Айлдан

Айлдагтун

Айлтга.

Их баяр бүрдсэн Шинийн есний сайн өдөр.

**Шашныг мандуулах, амьтныг жаргуулагч Олноо өргөгдсөн
Монгол Улсын эзэн шашин төрийг хослон баригч
Нарангэрэлт Богд хааны зарлиг**

Бя олны өргөмжлөхийг хүлээж, Монгол Улсын хааны сууринд суусан нь, бурхны шашныг буман нарны гэрэл мэт хир үгүй мандуулан хаан төрийг сүмбэр уул мэт бат болгож, олон монгол албатыг үүрд энх түвшний соёлд учруулахыг үргэлжид шамдан хичээхүйн дээр, ялангуяа танай олон хан ван ноёдоос дараалан түмэн албатад хүртэл төв шударга хичээнгүй үнэнийг сүслэн эрхэмлэж бүгд нэгэн сэтгэлээр шашин төрд сайнаар зүтгэхийг тус тус ухуулан хишиг тараах зарлиг буулгасан нь:

Түшээт хан аймгийн чуулганы дарга Засаг улсын түшээ гүн Чагдаржавд үе улиран түшээт цол төрийн жүн ван, улбар шар жолоо шагнаж, шадар сайд, бүгд захирах сайд, сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдын тушаалд тохоон талбигтун...

... Ямагт хотол төгсөөр хослон хүртээж басхүү төрөл тутамд агшин төдий ч салалт үгүйгээр эзлэн барьж жолоодон удирдсаар ахуйг бүгдээр зүрхний төвөөс чин бишрэлээр, түмэнтээ хүсэн ерөөж, өлзий билэгтэй бурхан шүтээн хийгээд, эд эрдэнэ есөн бэлэг лүгээ сэлтийг зэрэгцүүлэн жагсааж хичээнгүйлэн өргөж, ёслол мөргөмүй.

Их нигүүлсэнгүйгээр энэрэн таалж, зөвшөөн соёрхож, өршөөн тогтоож, заалхийлэн Зарлиг буулгахыг

Айлдан

Айлдагтун

Айлтга.

Их баяр бүрдсэн Шинийн есний сайн өдөр.

**Шашныг мандуулах, амьтныг жаргуулагч Олноо өргөгдсөн
Монгол Улсын эзэн Шашин төрийг хослон баригч
Наран гэрэлт Богд хааны зарлиг**

Бя олны өргөмжлөхийг хүлээж, Монгол Улсын хааны сууринд суусан нь, бурхны шашныг буман нарны гэрэл мэт хир үгүй мандуулан хаан төрийг сүмбэр уул мэт бат болгож, олон монгол албатыг үүрд энх түвшний соёлд

учруулахыг үргэлжид шамдан хичээхүйн дээр, ялангуяа танай олон хан, ван ноёдоос дараалан түмэн албатад хүртлээ төв шударга хичээнгүй үнэнийг сүслэн эрхэмлэж, бүгд нэгэн сэтгэлээр шашин төрд сайнаар зүтгэхийг тус тус ухуулан хишиг тархаах зарлиг буулгасан нь:

... Мөн аймгийн улсад туслагч гүнгийн зэрэг, засаг тэргүүн зэрэг тайж Намсрайд үе улиран Эрдэнэ цол, төрийн жүн ван, улбар шар жолоо шагнаж, Шадар сайд, Бүгд захирах сайд, Шүүх Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны тэргүүн сайдын тушаалд тохоон талбигтун ...

... Ямагт хотол төгсөөр хослон хүртээж басхүү төрөл тутамд агшин төдий ч салалт үгүйгээр эзлэн барьж жолоодон удирдсаар ахуйг бүгдээр зүрхний төвөөс чин бишрэлээр түмэнтээ хүсэн ерөөж, өлзий бэлгэтэй бурхан шүтээн хийгээд эд эрдэнэ есөн бэлэг лүгээ сэлтийг зэрэгцүүлэн жагсааж хичээнгүйлэн өргөж, ёслон мөргөмүй.

Их нигүүлсэнгүйгээр энэрэн таалж, зөвшөөн соёрхож, өршөөн тогтоож, заалхийлэн Зарлиг буулгахыг

Айлдан

Айлдан

Айлдлаа.

Их баяр бүрдсэн Шинийн есний сайн өдрөө.

**Шашныг мандуулах, амьтныг жаргуулагч Олноо өргөгдсөн
Монгол Улсын эзэн Шашин төрийг хослон баригч
Наран гэрэлт Богд хааны зарлиг**

Би олны өргөмжлөхийг хүлээж, Монгол Улсын хааны сууринд суусан нь, бурхны шашныг буман нарны гэрэл мэт хир үгүй мандуулан хаан төрийг сүмбэр уул мэт бат болгож, олон монгол албатыг үүрд энх түвшний соёлд учруулахыг үргэлжид шамдан хичээхүйн дээр, ялангуяа танай олон хан, ван ноёдоос дараалан түмэн албатад хүртэл төв шударга хичээнгүй үнэнийг сүслэн эрхэмлэж, бүгд нэгэн сэтгэлээр шашин төрд сайнаар зүтгэхийг тус тус ухуулан хишиг тараах зарлиг буулгасан нь:

Хүрээний да лам Цэрэнчимэдэд Чин сүжигт цол, гурван давхар магнар дэвсгэр түшлэг зэрэг улбар шар жолоо, ногоон тэрэг Чин вангийн пүнлүү, үүрд хөрөнгөнөөс алба гаргуулахгүй болгон шагнаж, Шадар сайд, Бүгд захирах сайд, Дотоод Яамны Хэргийг Бүгд Захиран шийтгэгч тэргүүн сайдын тушаалд тохоон талбиад, мөн тус шавийн харъяат эл албан хэргийг хавсран шийтгүүлэгтүн.

... Ямагт хотол төгсөөр хослон хүртээж басхүү төрөл тутамд агшин төдий ч салалт үгүйгээр эзлэн барьж жолоодон удирдсаар ахуйг бүгдээр зүрхний төвөөс чин бишрэлээр, түмэнтээ хүсэн ерөөж, өлзий бэлгэтэй бурхан шүтээн хийгээд эд эрдэнэ есөн бэлэг лүгээ сэлтийг зэрэгцүүлэн жагсааж хичээнгүйлэн өргөж, ёслон мөргөмүй.

Их нигүүлсэнгүйгээр энэрэн таалж, зөвшөөн соёрхож, өршөөн тогтоож, заалхийлэн Зарлиг буулгахыг

Айлдан

Айлдагтун

Айлга.

Их баяр бүрдсэн Шинийн есний сайн өдрөө.

Монгол Улсын Үндэсний төв архив Х-А6, Д-1, ХН-511, 4-р нутагбар бичиг

УТА-ын Лавлагаа, мэдээлэл судалгааны төвийн ажилтан О.Тогосбаяр.

Co-ownership

"Co-ownership" means that two or more co-owners own undivided shares in the whole and each co-owner can dispose of that co-owner's share by acting alone, unless otherwise provided by the parties.

Дундын өмчлөл

Дундаа өмчлөх гэж хоёр буюу түүнээс дээш дундаа өмчлөгчид нэгэн бүхэл хөрөнгийн үл хуваагдах хэсгүүдийг өмчлөх явдал бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол дундаа өмчлөгч бүр өөрт оногдох хэсгийг дангаараа захирам зарцуулах эрхтэй.

Corporeal

"Corporeal", in relation to property, means having a physical existence in solid, liquid or gaseous form.

Биет (хөрөнгө)

Өмчид холбогдуулан хэрэглэх нэр томъёо бөгөөд хатуу, шингэн, хийн төлөвт бодитой оршин буйг биет гэсэн тодотголоор тодорхойлно.

Counter-performance

A "counter-performance" is a performance which is due in exchange for another performance.

Хариу үүргийн гүйцэтгэл

Хариу үүргийн гүйцэтгэл гэж өөр үүргийн гүйцэтгэлийн хариуд бий болох ёстой үүргийн гүйцэтгэлийг хэлнэ.

Creditor

A "creditor" is a person who has a right to performance of an obligation, whether monetary or non-monetary, by another person, the debtor

Үүрэг гүйцэтгүүлэгч

Үүрэг гүйцэтгүүлэгч гэж үүрэг гүйцэтгэгч гэх нөгөө этгээдийн зүгээс мөнгөн төлбөрийн эсвэл бусад үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах эрхтэй этгээдийг хэлнэ.

Damage

"Damage" means any type of detrimental effect.

Хохирол гэж тухайн этгээдийн байдлыг дордуулсан аливаа төрлийн үр дагаварыг хэлнэ.

Damages

"Damages" means a sum of money to which a person may be entitled, or which a person may be awarded by a court, as compensation for some specified type of damage.

Хохирлын төлөөс

Хохирлын төлөөс гэж тодорхой төрлийн хохирлыг нөхөх зорилгоор тухайн этгээд авах эрхтэй эсвэл түүнд шүүхээс олгуулахаар шийдвэрлэсэн мөнгөн дүнг хэлнэ.

Debtor

A "debtor" is a person who has an obligation, whether monetary or non-monetary, to another person, the creditor.

Үүрэг гүйцэтгэгч

Үүрэг гүйцэтгэгч гэж үүрэг гүйцэтгүүлэгч гэх нөгөө этгээдийн өмнө мөнгөн төлбөрийн эсвэл бусад үүрэг хүлээсэн этгээдийг хэлнэ.

Defence

A "defence" to a claim is a legal objection or a factual argument, other than a mere denial of an element which the claimant has to prove, which, if well-founded, defeats the claim in whole or in part.

Хариуцагчийн хамгаалалт

Нэхэмжлэлийн эсрэг хариуцагчийн хамгаалалт гэж нэхэмжлэгчийн нотлох ёстой зүйлийг үгүйсгэх төдий бус харин үндэслэл бүхий бөгөөд нэхэмжлэлийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь няцааж болох хууль зүйн шинжтэй эсэргүүцэл эсвэл баримтын шинжтэй мэтгээнийг хэлнэ.

Delivery

"Delivery" to a person, for the purposes of any obligation to deliver goods, means transferring possession of the goods to that person or taking such steps to transfer possession as are required by the terms regulating the obligation. Delivery of the goods takes place only when the transferor gives up and the transferee obtains possession of the goods: if the contract or other juridical act, court order or rule of law under which the transferee is entitled to the transfer of ownership involves carriage of the goods by a carrier or a series of carriers, delivery of the goods takes place when the transferor's obligation to deliver is fulfilled and the carrier or the transferee obtains possession of the goods.

Хүлээлгэн өгөх

Бараа хүлээлгэн өгөх үүргийн тухайд хэн нэг этгээдэд хүлээлгэн өгөх гэдэг нь барааны эзэмшлийг уг этгээдэд шилжүүлэх эсвэл тухайн үүргийн нөхцөлд шаардсанаар эзэмшлийг шилжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авахыг хэлнэ. Гагцхүү шилжүүлэгч барааны эзэмшлээс татгалзаж, шилжүүлэн авагчийн хувьд барааны эзэмшил үүссэнээр барааг хүлээлгэн өгсөнд тооцно. Хэрэв тухайн гэрээ, бусад төрлийн хэлцэл, шүүхийн захирамж, хуулийн хэм хэмжээний дагуу шилжүүлэн авч байгаа этгээд нь өмчлөх эрхийг шилжүүлэн авах эрхтэй бөгөөд барааг нэг буюу хэд хэдэн тээвэрлэгчээр дамжуулан тээвэрлэх бол шилжүүлэгчийн хүлээлгэн өгөх үүрэг биелэгдэж, тээвэрлэгч эсвэл шилжүүлэн авагчийн хувьд барааны эзэмшил үүссэн тохиолдолд барааг хүлээлгэн өгсөнд тооцно.

Direct physical control

Direct physical control is physical control which is exercised by the possessor personally or through a possession-agent exercising such control on behalf of the possessor (direct possession).

Шууд бодитой хараа хяналт

Шууд бодитой хараа хяналт гэдэг нь эзэмшигч өөрөө эсвэл өөрийн төлөөлөгчөөр дамжуулан (шууд эзэмшил) хэрэгжүүлж буй хараа хяналтыг хэлнэ.

.....

АКАДЕМИЧНИЙН ХҮНДЭТГЭЛИЙН ЛЕКЦИЙН СЭДЭВ “ТАЛ НУТГИЙН ХУУЛЬ” БАЙВ

Монгол Улс нүүдэл суудлын тэнцвэрийг барьсан өвөрмөц соёл иргэншилтэй ард түмэн. Үүний балансыг тал нутгийн хууль их зөв барьж байх хэрэгтэй.

“Тал нутгийн хууль” хурдан хувьсан өөрчлөгдөж байна. Монголчууд нэгдэж амьдрах хэв маягийг илүүд үзэх болжээ. Малчид хоршин малаа маллах болж гэсээр түүний лекц үргэлжилсэн юм.

Хууль зүйн салбарын үе үеийн хуульч эрдэмтэд Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүндэтгэлийн лекцээ тавьдаг уламжлалтай болоод багагүй хугацаа өнгөрч байна. Хүлээлтийг үүсгэдэг түүхэн үйл явдал бол яахын аргагүй хүндэтгэлийн лекцийн арга хэмжээ билээ.



Энэ утгаараа 9 дүгээр сарын 16-ны өдөр Хайртынхан овогт Жүгнээгийн Амарсанаа эмээглэл, эрэлхийллийг илэрхийлсэн сонирхолтой, баялаг санаатай, бодол тээсэн “Тал нутгийн хууль” сэдэвт хүндэтгэлийн лекцээ тавив.

Хууль зүйн салбарт ихийг хийж, бүтээсэн, бүтээсээр ч яваа түүнийг шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн академич, гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор гэдгийг салбарынхан андахгүй биз ээ.

Танхим дүүрэн зочид амьсгаа даран лекцийг анхааралтай сонсоно.

“Нийгмийн бүх харилцааг хуулиар дарангуйлж болохгүй” гэсээр түүний лекц үргэлжлэв.

МУИС-ийн Хууль зүйн сургууль байгуулагдсаны 50 жил, Монголын түүхэн дэх хуулийн анхны 16 боть ном гарсан түүхэн цаг мөчүүд тохиосноороо түүний лекц онцлог болов.

Тэрээр Монголын эрх зүйн тогтолцоо түүхэндээ ямар байсныг, цаашид ёс заншил, уламжлалаа дагаж хэрхэн боловсронгуй болгох талаар үнэтэй санал, бодлоо лекцээрээ илэрхийлэв.

Бид уламжлалаа сайн мэдэх, хууль тогтоогчид чанартай, сайн хууль батлах, хууль дээдлэх ёсыг боловсронгуй болгохын чухлыг “Тал нутгийн хууль”-иар онцлов.

“Эрх чөлөөтэй байхын тулд хуульд захирагдах ёстой” гэсэн үг бүхий түүний хүндэтгэлийн хөрөг уламжлал ёсоор хүрээлэнгийн танхимд байрласан юм.

Үг, үйлдэл, сэтгэлээрээ түүнийг хүндэтгэсэн багш, шавь, анд нөхөд зочид, хамтран зүтгэгчид нь түүний “Эрхэмсэг хүндэтгэл”-ийн үдшийг хамтдаа бүтээж чадсанаараа мартагдашгүй болсон юм.

Б.Цэцэг

.....

**“ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ХАРИУЦЛАГА:
ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ**

ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Цагдаагийн академаас хамтран зохион байгуулсан “Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: харьцуулсан эрх зүйн асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал Хууль зүйн үндэсний хүрээлэнд боллоо. Уг хурал нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 50 жилийн ойн хүрээд явагдаж байгаа юм.

Хурлыг нээж Академич С.Нарангэрэл үг хэлсэн ба Цагдаагийн академийн захирал Ц.Эрдэнэбат мэндчилгээ дэвшүүлэв.

Хурлын эхний хэсэгт Татварын Ерөнхий газрын дарга, докторант Ц.Оюунбаатар “Компанийн татварын эрх зүйн зөрчил, хүлээлгэх хариуцлага”, ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Одонгэрэл “Монгол Улсын хуулийн этгээд болох компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал”, Япон улсын Кокугакуин их сургуулийн профессор Иокаяама Минору “Япон дахь компанийн гэмт хэрэг”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор Д.Баярсайхан “Хуулийн этгээд эрүүгийн гэмт хэргийн субъект болох нь: харьцуулсан эрх зүйн зарим асуудал” сэдвээр тус тус илтгэл тавив.

Хоёрдугаар хэсэгт Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч, “Иргэн та баялаг” сангийн тэргүүн С.Одонтуяа “Компанийн хариуцлага”, Цагдаагийн академийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч Г.Гантөмөр “Монгол Улсын эрүүгийн эрх зүйгээр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлага, хэрэгжүүлэх арга зам”, ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор М.Золзаяа “Бизнесийн ёс зүйн хариуцлага”, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн эрх зүйн тэнхимийн багш, доктор Б.Амарсанаа “Хуулийн этгээдийн удирдлагад хариуцлага хүлээлгэх үндэслэл (Монголын эрх зүйн тогтолцоон дахь компанийн хуулийн жишээн дээр)” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Мөн хуралд ОХУ-ын Алс Дорнодын их сургуулийн Харьцуулсан эрх зүйн төвийн эрдэм шинжилгээний ажилтан Татьяна Борисовна Басова “ОХУ-ын эрүүгийн эрх зүй дэх компанийн хариуцлагын асуудал” сэдэвт илтгэлээ ирүүлсэн юм.

Хурлыг хааж ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал, гавьяат хуульч, Академич Ж.Амарсанаа үг хэлэв.

Хурал бүхэлдээ сонирхолтой, үр дүнтэй болсон гэж оролцогчид дүгнэв.

Бид энэхүү хурлаар хэлэлцүүлсэн илтгэлүүдээс “Хууль дээдлэх ёс” сэтгүүлд цувралаар нийтэлж хүргэнэ.

.....

**“МОНГОЛЫН ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ИРЭЭДҮЙН ХАНДЛАГА”
СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ**

Хууль зүйн үндэсний хүрээлэн, ШУА-ийн Философи социологи, эрх зүйн хүрээлэн, Гадаад харилцааны яам, МУИС-ийн Хууль зүйн сургууль хамтран “Монголын эрх зүйн түүхэн хөгжил, ирээдүйн хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2010 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр зохион

байгуулж, “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл (1206-2009)” 16 боть бүтээлийн нээлтийг хамтатган хийлээ.

Хурлыг нээж Академич Ж.Амарсанаа үг хэлсэн ба Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид талархалын үг дэвшүүлэв.

Нэгдүгээр хуралдааныг Академич С.Нарангэрэл даргалж, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, эрх зүйн түүхийн судалгааны төвийн эрхлэгч, доктор В.Баярсайхан “Монголын эрх зүйн түүхийн судалгаа ба Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл” сэдвээр, ШУА-ийн Философи социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал, Гавьяат хуульч, Академич Ж.Амарсанаа “Монголын эрх зүйн хөгжил ба дэлхийн эрх зүйн газрын зураг” сэдвээр, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид “Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэлийн онол, практикийн ач холбогдол” сэдвээр тус тус илтгэл тавив.

Хоёрдугаар хуралдааныг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, эрх зүйн түүхийн судалгааны төвийн эрхлэгч, доктор В.Баярсайхан даргалж, Улаанбаатар эрдэм судлал дээд сургуулийн ерөнхий захирал, шинжлэх ухааны доктор, профессор И.Дашням “Монгол Улсад дундад үеийн эрх зүйн тогтолцоог калж, шинэ үеийн эрх зүйн тогтолцоо бүрэлдэн тогтсон нь (XX-XXI)” сэдвээр, Улсын дээд шүүхийн Иргэний танхимийн тэргүүн, докторант Ц.Амарсайхан “Монголын эрх зүйн хөгжил ба шүүхийн шийдвэр” сэдвээр, Монголын үндэсний дээд сургуулийн профессор, гавьяат хуульч, шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан “Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн зарим асуудал, чиг хандлага” сэдвээр, Ойготэнгэр их сургуулийн ректор, дэд профессор Д.Наранчимэг “Монгол Улс дахь иргэний эрх зүйн хөгжил, ирээдүйн төлөв” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Хурлыг хааж Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид үг хэлэв.

Хуралдаанд оролцогчдын илтгэлийг Хууль зүйн үндэсний хүрээлэн эрхэлж, эмхэтгэл болгож хэвлүүлэх юм.

.....

ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ БА ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ТУЛГАМДСАН АСУУДАЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ

1960 онд МУИС-д хуулийн анги нээгдсэн нь манай улс эх орондоо дээд мэргэжилтэй хуульчдаа бэлтгэх эхлэл болжээ. МУИС-д хуулийн салбар байгуулагдсаны 50 жилийн ойд зориулсан “Эрх зүйн боловсрол ба хууль зүйн шинжлэх ухааны тулгамдсан асуудал” сэдэвт бага хурал ОХУ, БНХАУ, ХБНГУ Япон, БНСУ зэрэг МУИС-ийн Хууль зүйн сургуультай олон жилийн хамтын ажиллагаатай их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын 20 шахам нэртэй эрдэмтэд, багш нар илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Тус олон улсын эрдэм шинжилгээний бага хурал 2 үндсэн салбар хуралдаанаар явагдсан бөгөөд “Хууль зүйн шинжлэх ухааны тулгамдсан асуудал” сэдэвт 1 дүгээр салбар хуралдаанд Академич С.Нарангэрэл (Монгол Улс) “Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд МУИС-ийн оруулсан хувь нэмэр”, профессор Х.Шоллер (ХБНГУ) “Эрх зүйн төрөөс зүй ёсны төр хүртэлх Монгол Улсын хөгжил”, профессор Х.Шюнеманн (ХБНГУ) “Дэлхий дахинд Америкийн эрүүгийн процессын эрх зүйн давамгайлж чадах уу?”, доктор Ю.Харбих (ХБНГУ) “Захиргааны хэргийн шүүгчгийн ёс зүй”, профессор Э.Зууннасан (Монгол Улс) “БНХАУ ба Монгол Улсын эрүүгийн шүүн таслах ажиллагааны харьцуулсан шинжилгээ” зэрэг олон илтгэлийн

хэлэлцжээ.

"Эрх зүйн боловсролын тулгамдсан асуудал" сэдэвт 2 дугаар салбар хуралдаанаар доктор Н.Лүндэндорж (Монгол Улс) "Эрх зүйн боловсролын хөгжил, шийдвэрлэх асуудал", профессор Ү.Ичиро (Япон улс) "Монгол Улс дахь Японы эрх зүйн боловсрол, судалгааны төсөл: үр дүн", доктор О.С.Намсараевна (ОХУ) "Эрх зүйн боловсролын даяаршил", профессор Д.Наранчимэг (Монгол Улс) "Эрх зүйн боловсрол ба хуийн хэвшлийн их, дээд сургууль" зэрэг олон илтгэлийг тал бүрээс нь хэлэлцжээ.

Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд ХБНГУ-ын Мюнхений их сургууль, ХБНГУ-ын Макс Планкийн институт, Японы Нагоягийн их сургуулийн нэртэй эрдэмтэд оролцсон байна. ОХУ, БНХАУ-аас оролцож байгаа эрдэмтэд нь МУИС-ийн Хууль зүйн сургуульд докторын зэрэг хамгаалсан бөгөөд манай улсын эрх зүйн талаар өргөн мэдлэтэй улс юм.

МУИС-д хуулийн анги нээгдэхээс өмнө манай улс дээд боловсролтой хуульчдаа хуучин ЗХУ-д бэлтгэж байжээ. 1960 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр анхны хичээлээ эхэлсэн хуулийн ангид Улсын Ерөнхий прокурор С.Чойжамц, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга М.Хашгамбай, Улсын дээд шүүхийн дарга Г.Пүрэвдоо, Завхан аймгийн дарга Д.Дамдинсүрэн, Хотын хэвлэлийн хорооны 2 дугаар нарийн бичгийн дарга Я.Тойвгоо нарийн зэрэг өндөр албан тушаал хашиж байсан хүмүүс оюутан болж, элсэн суралцаж байжээ. Монголын хуульч эрдэмтдийн дотроос Монгол Улсын Шинжлэх ухааны академийн жинэхэ гишүүнээр С.Нарангэрэл, Ж.Амарсанаа нар сонгогдсон нь тус сургуулийн төгсөгчид, багш нар юм. Тус сургуулийн төгсөгч, багш, нэртэй эрдэмтэн Б.Чинмид Монголын хуульчдаас анх удаа "Хөдөлмөрийн баатар" цол хүртсэн юм.

МУИС-д хууль зүйн салбар байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан тус сургуулийн профессор, багш, ажилтан, үе үеийн төгсөгчдөд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга Д.Дэмбэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд нар мэндчилгээ дэвшүүлж баяр хүргэсэн байна.

С.Алтантуяа

.....



“Эрх зүйн сурталчилгааны дунд хугацааны хөтөлбөр”

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 67 дугаар тушаалаар “Эрх зүйн сурталчилгааны дунд хугацааны хөтөлбөр”-ийг баталсан.

Иргэдийн бодит хэрэгцээ, орчин үеийн арга зүй, төрийн болон олон нийтийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагаа, олон нийтийн идэвхи, оролцоонд суурилсан эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны тогтолцоог бүрдүүлэх, иргэдийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлж, нийгмийн үнэт зүйлсийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хүртээмжтэй; чанартай, үр нөлөөтэй мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах нь хөтөлбөрийн гол зорилго юм.

“Шударга, хүмүүнлэг” уриан дор гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэх энэхүү хөтөлбөрийг олон нийтэд сурталчилж, хэрэгжүүлэх ажил нь:

- Хууль, шударга ёс;
- Архигүй орчин;
- Амгалан тайван орчин;
- Хүчирхийллээс ангид орчин;
- Гэр бүл;
- Эрүүл мэнд;
- Спорт;
- Хөдөлмөр;
- Байгаль хамгаалал гэсэн нийгмийн үнэт зүйлсэд тулгуурлаж хийгдэх бөгөөд үнэт зүйл тус бүрээр нэрлэгдсэн гурван сарын хугаацаатай аян зохион байгуулагдах юм.

Аян нь дээрх үнэт зүйлээр дамжуулан иргэдийн эрх зүйн ухамсрыг зөв төлөвшүүлж, нийгмийн үнэт зүйлийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хүртээмжтэй, чанартай, үр нөлөө, цар хүрээтэй мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад оршино. Эхнийх нь гурван сарын хугацаанд хэрэгжих “Хууль, шударга ёс” аян байна.

С.Алтантуяа

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn